

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр, Пүрэв гараг

| | |
|--|---------|
| Хуралдааны тэмдэглэлийн агуулга | 1 |
| Хуралдааны товч тэмдэглэл: | 1-27 |
| Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: | 28-143 |
| 1.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ | 30-31 |
| 2.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 31-44 |
| 3.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 44-47 |
| 4.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ | 47-51 |
| 5.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ | 51-55 |
| 6.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 55-83 |
| 7.Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Ухаалаг засаг-II төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/ | 83-85 |
| 8.Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 85-88 |
| 9.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Түр хорооны ажлын дүнг танилцуулах | 88-92 |
| 10.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/ | 92-93 |
| 11.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ | 93-94 |
| 12.“Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлангай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/ | 94-96 |
| 13.“Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл | 96-97 |
| 14.Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 97-112 |
| 15.Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 112-125 |
| 16.Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ | 125-134 |
| 17.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ | 134-136 |
| 18.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ | 136-143 |

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 14 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Б.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: Ш.Адъяашаа, А.Адъяасүрэн, Ж.Батсуурь, Д.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Х.Булгантуяа, Н.Ганибал, Г.Дамдинням, Л.Оюун-Эрдэнэ, Б.Саранчимэг, Ц.Сэргэлэн, Д.Тогтохсүрэн, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, О.Цогтгэрэл;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Баярсайхан, Д.Өнөрболор, Ч.Ундрам;

Хоцорсон: С.Ганбаатар- 2 цаг 08 минут, Ж.Мөнхбат- 31 минут, Х.Нямбаатар- 52 минут, Ж.Эрдэнэбат- 11 минут.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хөгжлийн зорилгот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг татан авах тухай албан бичиг Улсын Их Хуралд ирүүлснийг уншиж танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./10:20/

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адъяашаа нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

Нэг.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Д.Саруул, Улсын ерөнхий прокурорын Туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Батболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ахлах мэргэжилтэн Ё.Отгонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 2 дугаар зүйлийн “тус тус нэмсүгэй.” гэсний өмнө “, 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “6.33” гэсний дараа, 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “6.31” гэсний дараа “, 6.34, 6.35, 6.36, 6.37, 6.38, 6.39, 6.40, 6.41, 6.42, 6.43, 6.44, 6.45, 6.46, 6.47, 6.48, 6.49, 6.50, 6.51, 6.52, 6.53, 6.54, 6.55, 6.56, 6.57, 6.58, 6.59, 6.60, 6.61” гэж” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн “хассугай.” гэсний өмнө “, 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “6.10,” гэснийг тус тус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэмүүлэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, мөн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, М.Оюунчимэг, С.Чинзориг, Ж.Батжаргал, Г.Ганболд, Х.Ганхуяг нарын тавьсан асуултад Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Анандбазар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 17

Бүгд: 43

60.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Баяртуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар үг хэлэв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 20

Бүгд: 44

54.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Анхбаяр, Дотоодын цэргийн штабын дарга Р.Чингис, мөн штабын орлогч, Харуул хамгаалалтын хэлтсийн дарга Н.Мөнх-Итгэл, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Нэг.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Ц.Мөнх-Оргил, Ц.Сандаг-Очир /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.3 дахь хэсгийн “, энхийг дэмжих, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох” гэснийг хасаж, мөн хэсгийн “байна” гэснийг “байж болно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 19

Бүгд: 43

55.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.3 дахь хэсгийн “18-аас” гэснийг “15-аас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.4 дэх хэсгийн “түүнийг” гэсний дараа “энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд” гэж нэмж, мөн хэсгийн “энэ хугацаанд” гэснийг хасаж, мөн заалтын 9.5 дахь хэсгийн “даргад” гэсний дараа “тушаалаар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 36.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.7.Дотоодын цэргийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байх үед албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг нэгжлэг хийх тохиолдолд тухайн алба хаагчийг шууд захирах даргад мэдэгдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 18
Бүгд: 44
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 38.4 дэх хэсгийн “үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглах, мэдээлэл дамжуулах,” гэснийг хасаж, мөн зүйлийн “болно” гэснийг “болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар зүйлийн “4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “тогтоосон” гэсний дараа “улс орны нийгэм, эдийн засаг, стратегийн” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “улсын онц чухал” гэсний дараа “болон шаардлагатай бусад” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 18
Бүгд: 44
59.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

7.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 4.1.1 дэх заалтын “аль нэг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 16
Бүгд: 44
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “8.1.13” гэсний дараа “, 8.1.14” гэж нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн “33.1.1.12” гэснийг “33.1.12” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийн “тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 19
Бүгд: 44
56.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 15 дугаар зүйлийн 15.35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “нэвтрэгчид” гэснийг “нэвтрэх эрх бүхий хүнд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Л.Мөнхбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “6.33” гэснийг “6.62” гэж, Төслийн 2 дугаар зүйлийн “6.33” гэснийг “6.62” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 17
Бүгд: 44
61.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Дамбий, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний газрын дарга З.Буянбадрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргилын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооноос гаргасан Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 21
Бүгд: 42
50.0 хувийн саналаар Байнгын хорооны горимын санал дэмжигдсэнгүй.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 22
Бүгд: 42
47.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 21
Бүгд: 41
48.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 21
Бүгд: 41
48.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Батболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн С.Батболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 21
Бүгд: 40
47.5 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Батболдын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын саналыг дахин гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн С.Батболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Сүрэнхорол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, мөн Комиссын гишүүн Г.Нарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийн талаарх илтгэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Ц.Мөнх-Оргил, Э.Батшугар, М.Оюунчимэг, Г.Ганболд, Д.Цогтбаатар, Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 13 цаг 45 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлээгүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 17

Бүгд: 43

60.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Ухаалаг засаг-II төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батцэцэг, мөн яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Э.Насанбат, Сангийн яамны Санхүү бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн газрын Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Тамир нар байлцав.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хууль санаачлагчийн илтгэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд байгуулсан “Ухаалаг засаг-II төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Далай ашиглалт, усан замын хэлтсийн дарга Д.Жавхлан, мөн газрын ахлах шинжээч Л.Булганхүү, Ц.Наранчимэг, Б.Хулан, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоодын аудитын газрын ахлах шинжээч Х.Итгэлт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн талаарх илтгэлийг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалт явуулах цагийг түр хойшлуулав /14:07/

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 16

Бүгд: 41

61.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв./14:54/

Ес.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Түр хорооны ажлын дүнг танилцуулах

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Гадаад харилцааны дэд сайд Г.Амартүвшин, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн дэд сайд С.Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын захирал Р.Алтангэрэл, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дэд захирал Д.Бямбадорж, Консулын газрын дэд захирал С.Энхцэцэг, Олон улсын гэрээ, эрх зүйн газрын Хилийн хэлтсийн дарга Д.Болд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн зарлагын газрын дарга М.Санжаадорж, Хөрөнгө оруулалт, хөгжлийн санхүүжилтийн газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн дарга П.Бат-Эрдэнэ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Дамбий, мөн яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Алимаа, Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрах, Эрүүл мэндийн сайдын зөвлөх Ц.Эрдэмбилэг, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын дарга Ж.Нарангэрэл, мөн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, Санхүү, эдийн засгийн газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Т.Хонгорзул, мөн газрын Санхүү, даатгалын хэлтсийн мэргэжилтэн А.Мөнхжаргал, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Ц.Билэгтсайхан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга Г.Ариунбуян, мөн газрын Тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга Ж.Чүлтэмсүрэн, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга Т.Баярхүү, Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Ц.Уртнасан, зөвлөх Г.Отгончимэг, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, мөн Комиссын гишүүн Б.Энхболд, Гомдол мэдээлэл шалгах хэлтсийн дарга Г.Ууганбаатар, Судалгаа, дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийн дарга Д.Ёндонжамц, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, мөн зөвлөлийн гишүүн Д.Баатарсайхан, Ажлын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Эрдэнэбат, Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ, Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн газрын ахлах референт Л.Лхамжав, Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч Я.Сарансүх, Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Энхжавхлан, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, мөн газрын ахлах аудитор Д.Цэгмиддорж нар оролцов.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ нар байлцав.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Түр хорооны ажлын дүнг Түр хорооны дарга Б.Батгөмөр танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Түр хороог татан буугдсанд тооцов.

Уг асуудлыг 14 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Анхбаяр, Дотоодын цэргийн штабын дарга Р.Чингис, мөн штабын Харуул хамгаалалтын хэлтсийн дарга Н.Мөнх-Итгэл, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Арван нэг.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Баяртуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалт явуулах цагийг түр хойшлуулав /14:32/

Г.Занданшатар: Байнгын хорооноос Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

| | |
|-------------|----|
| Зөвшөөрсөн: | 24 |
| Татгалзсан: | 17 |
| Бүгд: | 41 |

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв./14:52/

Арван хоёр. “Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг танилцуулав.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

“Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “б” дэд заалтын “нөхөн олгох” гэсний дараа “асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Г.Занданшатар: “Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Арван гурав. “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар төслийн талаар танилцуулав.

Г.Занданшатар: “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 16
Бүгд: 43
62.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцав./14:54/

Уг асуудлыг 14 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Арван дөрөв.Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн, шинжээч А.Амармөрөн, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Д.Оюунхорол нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бад.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Д.Сарангэрэл, Х.Ганхуяг, Г.Ганболд, Л.Мөнхбаатар нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Д.Оюунхорол нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 15 цаг 25 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалт явуулах цагийг түр хойшлуулав /15:51/

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 17

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Бүгд: 42
59.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв./17:21/

Арван тав.Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн, шинжээч А.Амармөрөн, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Д.Оюунхорол нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бад.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Х.Ганхуяг, Д.Сарангэрэл, Г.Ганболд, Ж.Батжаргал нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Д.Оюунхорол нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар хэлэлцэж буй асуудлыг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлэх талаар чиглэл өгөв.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалт явуулах цагийг түр хойшлуулав /16:38/

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Бооцоот морин уралдааны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

57.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв./17:18/

Арван зургаа.Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн, шинжээч А.Амармөрөн, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч Д.Оюунхорол нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бад.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ё.Баатарбилэг нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд үг хэлээгүй болно.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар дараах баталсан хууль, тогтоолуудын эцсийн найруулгыг уншиж танилцуулав. Үүнд:

1.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./17:08/

Дагалдан гарсан:

-Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./17:08/

2.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./17:08/

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Дагалдан гарсан:

-Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./17:08/

3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./17:09/

4.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./17:09/

Холбогдуулан боловсруулсан:

-Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцав./17:09/

5.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Эцсийн найруулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцав./17:10/

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 19

Бүгд: 42

54.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Уг асуудлыг 17 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Арван долоо. “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, С.Ганбаатар, Б.Пүрэвдорж нарын гаргасан, Тогтоолын төслийн 3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнтэй
холбогдуулан хураалгасан санал:

Л.Мөнхбаатар: 2.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 20
Бүгд: 42
52.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

“4.Энэ тогтоолыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, Тогтоолын төслийн 5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.Энэ тогтоолыг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.” гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Уг асуудлыг 17 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Арван найм.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Ж.Эрхэмбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Сүрэнхорол, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, мөн Комиссын гишүүн Г.Нарантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн П.Анужин танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “хууль тогтоомжийн”

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

гэсний өмнө “хүний эрхийг хангах асуудлаарх” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “залилсан” гэсний дараа “, залилахыг завдсан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтын “хүнийг” гэсний өмнө “хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон,” гэж нэмэх гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

Мөн хуралдаан даргалагчаас 4.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.8.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхсан;” гэсэн саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

5.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтыг хасаж, үүнтэй уялдуулан 7.1.2 дахь заалтын “бууруулах” гэсний дараа “, хэрэглэгчийн хаягийг баталгаажуулах” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.1.олон нийтийн сүлжээний зохисгүй хэрэглээ, зан үйл, хор аюул учруулж болзошгүй шалтгаан, нөхцөлийг судлах, түүнээс урьдчилан сэргийлэх арга барилд сургах чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

11.1.2. олон нийтийн сүлжээний зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр мэдээ, мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэх,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 18

Бүгд: 41

56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7. Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 20

Бүгд: 41

51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан, 1.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “үзэл бодлоо” гэсний дараа “чөлөөтэй” гэж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “соён гэгээрүүлэхтэй” гэсний өмнө, 5.1.7 дахь заалтын “соён гэгээрүүлэх” гэсний өмнө “олон нийтийг” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “агуулсан хэрэглэгчийн” гэсний дараа “мэдээллийг гаргуулах” гэж, 7.1.3 дахь заалтын “шийдвэрлэсэн” гэсний өмнө “түүнийг хянан” гэж, 7.1.5 дахь заалтын “утасны” гэсний өмнө “харилцах” гэж, 10.2 дахь хэсгийн “харгалзан” гэсний дараа “хүсэлтийг” гэж тус тус нэмэх;

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “бусдын” гэснийг “хүний” гэж, “зөрчихгүй байх” гэснийг “хүндэтгэх” гэж, 5.1.6 дахь заалтын “байдал, нийгмийн хэв журмыг хангах” гэснийг “байдлыг хангах, нийтийн хэв журмыг хамгаалахад чиглэх” гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “түгээх зорилгоор” гэснийг “хүргэхээр” гэж, 6.1.7 дахь заалтын “хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг болон үндэсний” гэснийг “үндэсний болон хүн төрөлхтний” гэж, 6.1.10 дахь заалтын “хэрэг, зөрчлийн” гэснийг “хэрэг болон зөрчилд тооцогдох” гэж, 6.2.2 дахь заалтын “хувь хүн” гэснийг “хүн” гэж, 6.2.4 дэх заалтын “контентын үүсгэсэн” гэснийг “контентыг нийтэлсэн” гэж, 6.2.5 дахь заалтын “сонирхол,” гэснийг “сонирхолд болон” гэж, 7.1.2 дахь заалтын “хүсэлт шийдвэрийг” гэснийг “хүсэлтийг” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “зөрчилтэй контент нийтэлсэн” гэснийг “зөрчилтэй контентыг олон нийтийн сүлжээнд нийтэлсэн” гэж, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “хүнд” гэснийг “этгээдэд” гэж, 11.1 дэх хэсгийн “хохирох” гэснийг “үүсэх” гэж, мөн хэсгийн “хүн, хуулийн этгээдийг” гэснийг “олон нийтийг” гэж, мөн хэсгийн “нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэснийг “арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 7.1.1 дэх заалт, 10.4 дэх хэсгийн “, тайлбар” гэснийг, 7.1.3 дахь заалтын “байдлын талаарх” гэснийг тус тус хасах гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэв.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хуралдаан даргалагчаас 6.1.1, 6.1.7 дахь заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгч, найруулгын бусад саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулав.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн нэрийн “ӨӨРЧЛӨЛТ” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 23.2 дахь хэсгийн “нийтийн төв” гэснийг “нийтийн төвийн саналыг үндэслэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийг Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 21.2.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

“21.2.8.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн 6.1.7-д заасан агуулга бүхий зөрчилтэй контентыг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах бөгөөд уг арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн Кибер аюулгүй байдлын зөвлөл тогтоох.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 17

Бүгд: 41

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.5.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн 6.1.7-д зааснаас бусад агуулга бүхий зөрчилтэй контентын талаарх хүсэлтийг хүлээн авч, хянан шийдвэрлэхдээ хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах.” гэсэн саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

3.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 20

Бүгд: 41

51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

ХҮНИЙ ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн нэрийн “ӨӨРЧЛӨЛТ” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 17

Бүгд: 41

58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР:**

Л.Мөнхбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалангийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 18 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 8 цаг 13 минут үргэлжилж, 76 гишүүнээс 51 гишүүн хүрэлцэн ирж, 67.1 хувийн ирцтэйгээр 18 цаг 27 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 01 дүгээр сарын 19-ний
өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 14 минут.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Гишүүдийн ирцийг танилцуулъя. Хуралдаанд гишүүдийн 39 гишүүн буюу 51.3 хувь нь хүрэлцэн ирсэн байна. Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдөр 18 асуудал хэлэлцэнэ.

1.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр ТХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

2.Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл Засгийн газар 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх,

3.Монгол Улсын шүүхийн тухай хууль шинэчилсэн найруулга байгаа. Үүнийг Дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газар 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэхийг нь хийнэ.

4.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон

хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлэг хийнэ.

5.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай үед нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл анхны хэлэлцүүлгийг хийнэ.

6.Олон нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт эргэн мэдүүлсэн хуулийн төслүүд хэлэлцэх эсэхийг хийнэ.

7.Монгол Улс, Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын байгуулсан Ухаалаг засаглал-2 төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл хэлэлцэнэ.

8.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, хэлэлцэх эсэх.

9.Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, анхны хэлэлцүүлэг хийнэ.

10.Монгол Улсын Шүүхийн тухай хууль, түүнийг Дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, анхны хэлэлцүүлгийг хийнэ.

11.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, анхны хэлэлцүүлэг,

12.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, эцсийн хэлэлцүүлэг хийнэ,

13.Коронавируст халдвар ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр

хэлэлцэж хяналт тавих, шаардлагатай бол Улсын Их Хуралд холбогдох Байнгын хороогоор хэлэлцүүлэх санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Түр хорооны ажлын дүнг танилцуулна,

14.Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл хэлэлцэнэ, эцсийн хэлэлцүүлэг,

15.Байнгын хорооны бүрэлдэхүүнд нөөцлүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

16.Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт түргэн мэдүүлсэн хуулийн төслүүд хэлэлцэх эсэх,

17.Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх,

18.Бооцоот таавар хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ ээ.

Ийм 18 асуудлыг өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20.3-т хууль, тогтоолын төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль ч шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хууль тогтоолын төслөө татан авах үндэслэлээ тусгасан албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дараагаар чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсан тооцно гэж заасны дагуу Засгийн Засгийн газраас тогтоолын төсөл татан авах тухай албан бичиг ирүүлснийг та бүгдэд уншиж танилцуулъя.

Тогтоолын төсөл татан авах тухай Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөгжлийн зориулалтад төлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг татан авч байгааг үүгээр мэдэгдэж байна. Засгийн газрын 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав. Монгол Улсын ерөнхий сайд Оюун-Эрдэнэ гэсэн байна. Ингээд тогтоолын төслийг татан авсанд тооцлоо.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т зааснаар гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдааны өмнө 17 цагаас өмнө нь үндэслэл бүхий албан бичгээ ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Ширнэнбандийн Адьша нараас тус тус ирүүлсэн албан бичгийг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын дарга Занданшатар танаа

Миний бие Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы хуралдаанд асуудал нэмэх тул үг хэлэх зөвшөөрөл олгоно уу гэсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж гэсэн байна.

Пүрэвдорж гишүүн байна уу? Алга байна.

Дараагийн гишүүний албан бичгийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

заасны дагуу Улсын Их Хурлын 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх хүсэлт хүргүүлж байна. Улсын Их Хурлын гишүүн Адьшаа гэсэн байна. Адьшаа гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалд орёе. Эхний асуудлаа хэлэлцье.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Засгийн газар 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн энэ хуулийн төслийг хэлэлцүүлье.

Эцсийн хэлэлцүүлгийг хийе.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Сандаг-Очир гишүүнийг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулаарай.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2023 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир хуулийн төслийн зарим заалтаар дахин санал хураах шаардлагатай гэсэн санал гаргасан тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан 2 санал хураалт явуулсан бөгөөд зарчмын зөрүүтэй саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-ын саналаар санал хурааж, хуралдаанд оролцсон гишүүдийн 70 хувь нь дэмжсэн болно оо.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусгаж төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулга зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн хуулийн төслийг эцэслэн баталж өгнө үү. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. ЗГХЭГ-ын дэд дарга Барсүрэнгийн Баасандорж, УЕП-ын туслах прокурор Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Цоодолын Батболд, ЗГХЭГ-ын Хууль, эрх зүйн газрын ахлах эрхлээд Доржсүрэнхорлоогийн Саруул, УУХҮЯ-ны ахлах мэргэжилтэн Ёндонгийн Отгонжаргал нар оролцож байна. Байнгын хорооны санал,

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооноос гарсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураах. 2 санал байгаа.

Төслийн 2 дугаар зүйлийн “тус тус нэмсүгэй.” гэсний өмнө “, 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “6.33” гэсний дараа, 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “6.31” гэсний дараа “, 6.34, 6.35, 6.36, 6.37, 6.38, 6.39, 6.40, 6.41, 6.42, 6.43, 6.44, 6.45, 6.46, 6.47, 6.48, 6.49, 6.50, 6.51, 6.52, 6.53, 6.54, 6.55, 6.56, 6.57, 6.58, 6.59, 6.60, 6.61” гэж” нэмэх санал гаргасан Төсвийн байнгын хороо. Бүртгэлийн санал хураалт эхлээд явуулчихъя. 6.56 гэсэн зүйлийг бас нэмэх нэмж байгаа гэдгийг хэлье ээ.

Сая бүртгэлийн хураалт явууллаа. Одоо түрүүн уншиж сонгосон саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтдаа ороорой. 60 хувиар санал дэмжигдлээ.

2 дахь санал хураалт. Төслийн 3 дугаар зүйлийн “хассугай.” гэсний өмнө “, 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “6.10,” гэснийг тус тус” гэж нэмэх. Санал гаргасан Төсвийн байнгын хороо. Санал хураалт. 63.4 хувиар уг санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан зарчим зөрүүтэй саналаар санал хураалт явуулж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

10.26 цаг

Дараагийнхаа асуудалд оръё.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын

ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭЕ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатарт танилцуулна.

Ганбаатар сайдыг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулъя.

Ж.Ганбаатар: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

ОХУ-ын экспортын голлох бүтээгдэхүүн болох байгалийн хий, газрын тос, үр тарианы үнэ дэлхийн зах зээл дээр огцом өсөж, нийлүүлэлтийн тасалдал үүсэх эрсдэл үүссэнээр импортлогч орнуудын шатахуун, эрчим хүч болон хүнсний бүтээгдэхүүний үнэд нөлөөлж байна. БНХАУ-д дотоодын цар тахалтай холбоотой хорио цээрийн дэглэмийг зөөлрүүлж, эдийн засгаа эрчимжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй дэлхийн зах зээл дээр шатахуун, эрчим хүч хүнсний үнэ нэмэгдэх хүлээлтийг бий болгоод байна.

Энэ цаг үед богино хугацаанд ард иргэдийн амьдралд хамгийн том нөлөө үзүүлдэг газрын тосны бүтээгдэхүүний АИ-92 авто бензиний үнийн өсөлтийг бууруулж тогтвортой байлгах, үнэ өсөхөөс сэргийлэх сөрөг нөлөөллийг бууруулж онцгой журмаар зохицуулга хийх эрхийг Засгийн газарт олгох зайлшгүй шаардлага тулгараад байна. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэж Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн тавдугаар хэсэгт Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ гэж тус тус заасныг үндэслэн

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

импортын барааны гаалийн татварын хувь хэмжээг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа. Тогтоолын төсөл батлагдсанаар Засгийн газар олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй гол нэр төрлийн газрын тосны бүтээгдэхүүн АИ-92 авто бензиний үнийн өсөлт сөрөг нөлөөллийг бууруулах боломж бүрдэх юм. Тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Сандаг-Очир гишүүнийг индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2023 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Төсөл санаачлагч цар тахлын цаашдын төлөв байдал болон олон улсын хямралт нөхцөл байдлаас үүдэлтэй эдийн засаг, худалдааны хоригуудын үргэлжлэх хугацаа олон улсын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, тодорхой бус нөхцөл байдал түргэн хугацаанд эрс өөрчлөгдөж байгаа энэ үед ард иргэдийн амьдралд нөлөө үзүүлдэг газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн хомсдол үүсэх, тогтвортой байлгах, үнэ өсөхөөс сэргийлэх зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах, онцгой журмаар зохицуулалт хийх эрхийг Засгийн газарт олгох нь зүйтэй гэж үзэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа 2023 оны төсвийн орлогод хэрхэн тооцсон талаар Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир АИ-92 бензиний нөөц хэдий хэмжээтэй байгаа болон цаашид үнийн өсөлтийг хэдий хугацаанд тогтвортой байлгах боломжтой талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж тогтоолын төслийн 3 дахь заалтад хуурамч шатахуунд хольдог нафта, керосин хамаарч байгаа эсэх талаар асуулт асууж хариулт авсан.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа хэдий ч зөвхөн АИ-92 бензинээс гадна дизель түлшний гаалийн татвар тогтоох эрхийг Засгийн газарт нэмж өгөх, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж хэлэлцэж байгаа тогтоолоор хуурамч шатахуунд гаалийн албан татварыг бүрэн ногдуулахаар төслийг боловсруулсан хэдий ч Улсын Их Хурлын гишүүн Онцгой албан татвараас чөлөөлөх хуулийн төсөл өргөн мэдүүлсэн нь хардлага төрүүлж байгаа тул тогтоолын төслийн 3 дахь заалтыг хасах, Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа Засгийн газраас өргөн мэдүүлсэн төслүүдийг нэн яаралтай журмаар хэлэлцүүлэхээр оруулж ирж байгаа дүгнэлт хийх, цаашид эргэлзээтэй шаардлагагүй асуудлуудыг нухацтай хэлэлцэж байх нь зүйтэй.

Мөн төслийн 3 дахь заалтыг дэмжих боломжгүй гэсэн саналуудыг тус тус хэлсэн болно оо.

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн үз үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 58.3 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар, Сангийн яамны ТНБД Жигжидийн Ганбат, УУХҮЯ-ны Газрын тосны бодлогын газрын дарга Болдбаатарын Анхбаяр, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, УУХҮЯ-ны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Чулууны Хишигдалай нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгье. Хассуурийн Ганхуяг гишүүнээр тасаллаа. Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Мэдээж газрын тосны бүтээгдэхүүн шатах туслах материалын импортын хүрэлцээ хангамж болохоос иргэдийн амьдралд шууд л нөлөөлдөг. Бид шатахуунаа үйлдвэрлэдэг болохоос эхлүүлээд л том зорилгыг Хүрэлсүх Ерөнхий сайдын үеэс тавиад л ингээд л ажиллаж байгаа. Ер нь энэ газрын тосны үйлдвэр маань ер нь хэзээгээр ашиглалтад орох ийм төлөвлөгөөтэй байгаа вэ? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, өчигдөр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу 25 дугаар телевиз шиг санаж байна. ОХУ-д нефтийн бараа бүтээгдэхүүн бол хамгийн доод түвшиндээ хүрсэн байна. Нэг

баррель нефть 40 доллароор зарагдаж байна гэдэг ийм зүйлийг бас хэвлэл мэдээллийн хэрэгслээр яриад зөрүүлээд Монголчууд бол бас их үнэтэй авч байна гэсэн нэг ийм зүйлийг ярьж байна л даа. Тэгэхээр энэ хэр үнэний ортой юм яригдаад байгаа юм бол оо?

3 дахь асуулт бол, энэ тогтоолд орж ирсэн тэр 3 дахь заалт бол энэ хэлэлцэх танилцуулгаас авхуулаад л нэлээн хэл үг татлаа л нөгөө л нэг яригдаж байсан хуурамч шатахууны асуудал дахиж гарч ирж байна. Энэ нь бол Монголчуудын эрүүл мэнд цаашлаад эд хөрөнгө, автомашины насжилт хамаг юм нь л аюултай ийм юмыг бас одоо оруулж ирлээ гэдэг зүйлийг нэр бүхий гишүүд бас хэлж ярьсан. Тэгээд үнэхээр одоо энэ 3 дахь заалтыг нь тэр газрын тосны бараа бүтээгдэхүүн гэдэгт тэр хуурамч шатахуун үйлдвэрлэх шаардлагатай бүтээгдэхүүнүүд нь орж ирэх ийм бололцоог нь бас нээж өгч байгаа юм уу гэдэг дээр бас иргэд маш их анхаарал хандуулж байгаа. Маш их бас ойлголтын зөрүүтэй юмнууд байгаад байх шиг байна. Энэ дээр тодорхой хариулт өгнө үү гэж ингэж хүсэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Идэрбат гишүүний асуултад Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Сүүлийнхээс нь хариулъя. 3 асуулт асуулаа.

Тэр 3 дугаар заалт бол АИ-92-оос бусад дизель түлш 95, 80 тэр таны ярьсан дайвар бүтээгдэхүүнүүдийн татварыг 5 хувь байнгын байлгана л гэсэн санаа. Харин та асуултдаа бол харин эсрэгээрээ хэрвээ яг таны асууж байгаа тэр хардалт байх юм бол харин чөлөөлөх ёстой байхгүй юу? Гэтэл бол Их Хурал өөрөө эрх мэдлийнхээ хүрээнд бусад бүтээгдэхүүний татварыг 5 хувийг байнга байлгана гэдгийг бүр тогтоолоороо заачхаж байгаа юм. Засгийн газарт эрх өгөхгүй гэсэн үг. Харин зөвхөн АИ-92-ыг Засгийн газарт эрх өгч байгаа, 0-5 гээд.

Одоо энэ тогтоолын дараа Засгийн газарт би асуудал оруулаад энэ өнөөдрийг хүртэл үргэлжлээд эхэлсэн. АИ-92-ын гаалийн татвар тэрийг үргэлжлүүлэх л ийм л тогтоол байгаа. Яах вэ тухайн цаг үе давхцаад энэ Адьшаа гишүүн нэг тийм тэр дайвар бүтээгдэхүүнүүдийн татварыг тэглэе гээд нэг хууль санаачилсан юм байна лээ л дээ. Манайх бол эсрэгээрээ 5 хувь гэдгийг засагт эрх өгөхгүй. Их Хурал эрх мэдлийнхээ хүрээнд тогтоож байгаа юм. Тэгээд тийм л ялгаа байгаа гэдгийг Идэрбат гишүүнд хэлье.

Тэр газрын тосны бүтээгдэхүүний үнэ ОХУ-д 40 ам.доллар гэдэг. Ер нь бол бууж байгаа Оросын холбооны бүтээгдэхүүн. Тэгэхдээ түүхий нефтийн үнэ эцсийн бүтээгдэхүүн биш. Монгол Улс бол эцсийн бүтээгдэхүүн худалдаж авдаг эцсийн бүтээгдэхүүнийг бид биржээс авна. Биржийн үнэтэй холбоотой Роснефтиэс авч байгаа ч гэсэн бид биржтэй холбоотой. Гэхдээ өнөөдрийн байдлаар бид нэг 758 ам. доллароор АИ-92-ыг худалдаж авч байна. Нэг тооныг. Энэ бол маш хямд үнэ байгаа. 790-ээс 7 хувийн хямдралтай авч байгаа. Өнөөдрийн байдлаар шүү. 12 сард арай үнэтэй байсан. Өнөөдөр 1 сарын 1-нээс эхлээд манай Ерөнхий сайд бас тодорхой хэлцлүүдийг Роснефьтэй хийсний үр дүнд энэ үнэ бууж байгаа гэдгийг хэлье. Ер нь бол ирээдүйд яах вэ түүхий нефть импортлоод өөрсдөө үйлдвэртэй болсон үед тэр түүхий нефтийн үнэ уначихсан байгаа үед бол бид юу гэдэг юм өөрсдөө өөрсдийгөө хангах зорилт тавьж байгаа.

Хэрвээ ингээд үйлдвэртэй болчихвол гаднаас бас түүхий энэ эд импортлоод эцсийн бүтээгдэхүүн хийгээд шууд ингээд таны яг тэр ямар хүмүүс ярьсан юм тэр хүмүүст нь хариулаад явах бүрэн боломж бүрдэх байх. Одоогоор бид бол бэлэн бүтээгдэхүүн авдаг гэдгийг хэлье ээ.

Нэгдүгээр асуудлын хувьд бол газрын тосны үйлдвэрийн асуудал бол хэвийн гэх юм уу даа явж байгаа. Тендерт

шалгарсан Энэтхэгийн компани ажил нь явж байгаа.

Тэгээд 3, 4 дүгээр тодруулж асуух юм уу. Болсон уу? Хариулт хангалттай юу? Идэрбат гишүүн тодруулж асууя.

Ц.Идэрбат: Тийм. Засгийн газрын тогтоолын 3 дахь заалтыг уншаад ойлгогдохоор л байгаа л даа. 0-5 байсныг 5 хувь болгоно гээд. Тэгээд би зориуд бас энийг асуудаг нь иргэдэд бас зөв мэдээлэл өгөхгүй бол яг одоо Адьшаа гишүүний бариулж орж ирсэн тэр хуулийн төсөлтэй хамтатгаад ийм асуудал орж ирж байгаа нь өөрөө цаг хугацааны давхцал юм шиг хэр нь бас иргэдэд нэлээдгүй төөрөгдөл учруулаад Засгийн газар одоо хуурамч шатахуун хийх асуудлыг дэмжээд тэтгээд байгаа юм шиг. Энэ асуудлыг Улсын Их Хурлын чуулган дээр яригдсан учраас би бас зориуд асууж ийм зүйл байхгүй. 0-5 байсныг нь 5 хувь руу барьж байгаа юм гэдгийг л бас ойлгуулах гэж ингэж байгаа юм. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр явсан тэр тодруулгатай холбогдуулаад бас түүхий нефть эцсийн бүтээгдэхүүн хоёрын хоорондох зөрүү гэдгийг бас зөв ойлгох болсон гэсэн дээ энийг бас асуусан юм гэдгийг бас би зориуд хэлье гэж ингэж бодож байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Орж ирж байгаа асуудлыг зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Яагаад гэвэл энэ нефть бүтээгдэхүүн, бензин шатахуун бол гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ ханшид бол нэлээн чухал нөлөө үзүүлдэг. Энэ утгаараа АИ-92 бензин дээр энэ тэглэх Засгийн газарт өгсөн эрхийг үргэлжлүүлэх санал орж ирж байгаа юм байна. Өмнө нь бол Засгийн газарт энэ эрхийг 6 сарын хугацаатай өгсөн. Тэгээд энэ 6 сарын хугацаанд бол сая 1 сарын 1-нээр дуусгавар болж байгаа байх. Тэгэхээр одоо энэ орж ирж байгаа тогтоолын төслөөр хэдий хугацаатай энэ тэглэх эрхийг үргэлжлүүлэх хүсэлтээр

орж ирж байгаа вэ? Энэ өөрөө бас нөгөө татварын орлого 2023 оны төсөв батлах үед бид нар бас төсөвлөж өгсөн зүйлүүдтэй зөрчилдөх зүйл байгаа юу, үгүй юу гэдэг дээр нэгд хариулт авъя.

Хоёрт нь 0-5-ын интервалын хооронд ингээд хэлбэлзэнэ гэж байгаа шүү дээ. Тэгэхээр яг тэг гэдэг дээр л байлгаад байх юм уу? Эсвэл бас дэлхийн зах зээлийн үнэ ханшийн хэлбэлзлийг хараад цаашид 0 гэдгээ 1, 2 ч юм уу энэ 5 дотроо өөрчлөөд байх бололцоо байгаа. Энэ хэлбэлзэл нь ямархуу байх вэ гэдэг дээр мэдээлэл авах хэрэгтэй байна. Өчигдрийн Сингапурын биржийн үнэ ханшаар бол нэг баррель нь 84-85 долларын хооронд бол хэлбэлзэж байсан. Цаашдаа үнэ өсөх хандлага байна уу. Эсвэл буурах хандлагатай байгаа юу? Бид Сингапурын биржийн үнээр авдаг ч гэсэн ОХУ-аас гэдгээрээ үнэ нь бас ингээд өөрчлөгдөөд ирчихдэг юм байна лээ шүү дээ.

Тэгэхээр эртээд Ганбаатар сайд зөвхөн ОХУ гэлтгүй БНХАУ-аас нефть бүтээгдэхүүн авах гээд хэлэлцээр хийгээд эхнээсээ авч эхэлж байгаа гэсэн. Гэхдээ үнэ ханш нь энэ Сингапурын биржийн үнээс арай илүү үнэтэй байгаа гэж мэдээлэл өгч байсан л даа. Тэгээд одоо ингээд 0 болохоор урд хөрш хойд хөршөөс орж ирж байгаа бензиний баланс ямар байх юм. Хангалт нийлүүлэлт нь ингээд тогтвортой яваад байх уу? Үнэ буурна гэдэг асуудал байхгүй гэж ойлгож болох уу? Яагаад гэвэл тогтворжуулах гээд байна шүү дээ. Тэгэхээр одоогийн байгаа үнэн дээр нь л барих бодлого барьж байна гэж ойлгогдохоор байна. Энэ дээр нэг хариулт авъя.

Хоёрт нь сая бас Идэрбат гишүүн хэлээд байна. Ер нь энийг дагаад нөгөө нэг л дайвар бүтээгдэхүүн, бензин шатахууныг дахиад тэглэх асуудал ороод ирэх вий дээ. Би бол Өргөдлийн байнгын хорооны дарга байхад энэ асуудал бол нь маш ноцтой хөндөгдөөд ийм хуурамч шатахууны асуудал бол Монголын энэ

нефть бүтээгдэхүүний зах зээлд сөрөг нөлөө үзүүлнэ шүү гэдэг асуудлуудыг бол мэргэжлийн хүмүүсээс яриад энэ асуудал бол ингээд буцаж байсан.

Тэгэхээр үүнтэй уялдсан асуудлууд бол байхгүй биз дээ тийм ээ. Энэ дээр бас нэг тодорхой мэдээлэл өгчихсөн нь зөв байх гэж бодож байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад хэн хариулах уу? Ганбаатар сайд хариулъя.

Ж.Ганбаатар: Хугацааны хувьд 2024 оны 1 сарын 1. Тогтоолд тодорхой заасан байгаа. Түүнд тодорхой хариулъя.

Төсвийг төлөвлөхдөө энэ гаалийн татвар орно гэдэг талаар төлөвлөөгүй гэж Сангийн яам хариулж байгаа учраас төсөвт ямар нэгэн орон зай үүсэх юм уу, орлого талд нь тийм баланст нь нөлөө үзүүлэх асуудал бол гарахгүй гэдгийг Оюунчимэг гишүүнд хариулъя.

Тэр 0-5 гэдэг нь байнга үргэлжлээд байх уу гэдэг дээр бол Засгийн газар, Их хурал, Засгийн газарт эрх мэдэл өгчихсөн тохиолдолд Засгийн газар өөрийнхөө эрх мэдлийн хүрээнд мэдээж таны асууж байгаа зөв. Зарим тохиолдолд байнга нолиор нь биш 5, 3, 4 болгоод ингээд явах боломж нь Засгийн газарт хадгалагдаж байгаа. Тэр 2400 төгрөг байгаа. Ойролцоогоо үнэ шүү. Хөдөө орон нутаг арай өөр. Ер нь бол 2400. Яг таны асууж байгаа зөв. Энийг бол зөвхөн тогтворжуулна. Үнэ унана гэдэг ойлголт бол байхгүй. Нэмэгдэхгүй байх. Ард иргэдийн одоо тэр амьжиргаанд гол нь нөлөөлдөг учраас энийг нэмэгдүүлэхгүй байх зорилготой. Энэ ингээд үргэлжлээд ирсэн асуудал. Цоо шинээр энийг чөлөөлж байгаа биш. Нэлээн олон жил үргэлжилчихсэн энэ асуудал сунаж байгаа учраас шинэ зүйл биш гэдгийг хэлье. Тийм учраас үнэ бол тогтвортой байлгахыг Засгийн газар зорьж байна. Огцом нийлүүлэгч талд юм уу дэлхийн

зах зээл дээр огцом өөрчлөлт гарахгүй бол ер нь бол 2024 оны 1 сарын 1 хүртэл энэ үнийг барихыг зорьж байгаа гэдгийг танд хэлье ээ.

Яг Сингапурын биржийн үнэ 84, 83 доллар бол байгаа. Энэ ОХУ-ын Санктпетрбургийн бирж ч гэсэн нэг ойролцоо. Зарим тохиолдолд Сингагийн үнэнээс бас өндөр болчхоод байгаа. Эцсийн бүтээгдэхүүний хувьд ярьж байгаа. Гэхдээ Оюунчимэг гишүүний асууж байгаа зөв. Үнийн прогноз бол энэ Хятад ард улсын О ковид нээгдсэнээр түүхий эд бүтээгдэхүүний үнэ ер нь бол өсөж байгаа. Та анзаарч байгаа байх. Алт зэс бүх бүтээгдэхүүний үнэ бас ер нь бол жоохон сэргэлт ажиглагдаж байгаа. Тэгээд энэ тохиолдолд ОХУ-тай болохоор түүхий нефтийн үнэ жаахан буугаад байдаг. Дэлхий нийтдээ бол ер нь бол бид цаашдаа огцом биш ч гэсэн аажмаар өснө гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Содномын Чинзориг гишүүн асуултаа асууя.

С.Чинзориг: Ганбаатар сайд зөвөөр ойлгоно биз дээ. Засгийн газрын барьсан төсөл бас сайд нар юм ярилаа гэж магадгүй. Намайг Засагт орохоос өмнө Засгийн газар, Их Хуралд өргөн барьсан байсан төсөл байгаа учраас бас зарим зүйл асуумаар байгаа юм. Их Хурлаас энэ зарим гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг бас тогтворжуулах нөөц бүрдүүлэх хууль хаврын чуулганаар баталсан. Энэ хуулийн дагуу УУЯ-наас авч байх арга хэмжээ бас үр дүн өгч байгаа байх. Ялангуяа АИ-92 бензиний үнэ дээр бас тогтвортой түвшинд хадгалах ийм ажил зохион байгуулагдаад байна. Тэр хууль дотор чинь би бол ганцхан АИ-92 гэж бол ороогүй гэж бодоод байгаа юм. Түлш шатахуун гээд 92-оосоо гадна дизелийн түлшний үнийг тогтворжуулах нөөц бүрдүүлэх асуудал бол давхар явж байгаа л гэж ойлгоод байгаа юм. Тэгэхээр одоо танай яамнаас явуулж байгаа ажил үйл ажиллагааг харахлаар бол 92 дээрээ

анхаараад дизель түлшний үнэтэй холбоотой асуудал дээр жоохон ингээд дутуу анхаараад байгаа юм биш үү? Дизель түлштэй чинь хэрэглээ хаана өндөр байна хөдөөгийн иргэдэд л байгаа шүү дээ.

Энэ малчид, тариаланчидтай холбоотой асуудал. Энэ жил бас тэгээд ихэнх аймгуудад цаг хатуурч байна. Өвөлжилт хүндэрч байна. Хөдөөгийн иргэд отор, нүүдэл ихтэй байна. Энэ хөдөөгийн иргэдийг чинь ялангуяа энэ малчдын чинь гол хэрэглээ нь ерөөсөө л дизель түлш байгаа юм. Саяхан оны өмнө бас тойргоороо бид 3 бас 5, 6 сумаар ороод иргэд уулзсан. Уулзсан иргэд гурилын үнэ дизель түлшний үнийг л маш их яриад байна лээ шүү дээ. Би статистикийн газраас судалгаа авч үзсэн. Дизель түлшний үнэ 1 жилийн хугацаанд 40 хувиар өссөн гэсэн ийм судалгаа гаргаж өгсөн. Тэгэхээр цаашдаа ингээд нийт хөдөөгийн иргэдийн гол хэрэглээ болсон энэ дизель түлшний үнэ дээр тогтворжуулах ямар бодлого танай яам барих юм бэ? Оруулж ирж байгаа энэ тогтоол дээр чинь бол дизель түлшний татвар 5 хувь хэвээрээ л байна л даа. 92 нь болохлоор бол 5 хувийн татваргүй. Тэгэхээр хөдөөгийн иргэдийн гол хэрэглээ болсон Энэ дизель түлшний үнийг тогтворжуулах талаар тодорхой бас арга хэмжээ авмаар байна. Ганбаатар сайдаа. Энэ цаг хатуурахаар энэ хөдөөгийн хөдөөгийн иргэд чинь отор нүүдэл их хийдэг. Тэгээд энэ хөдөөгийн иргэд, ялангуяа энэ газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч чинь тэр дийлэнх нь л дизель түлш хэрэглэж байгаа шүү дээ. Энэ 92-ын зохицуулалт бол яах вэ нийт иргэдийн хэрэглээгээ зөв зохицуулж байгаа юм. Гэхдээ энэ чинь үндсэндээ төв суурин газрын Улаанбаатар хотын л иргэдийн л хэрэглээ шүү дээ.

Тэгэхээр бид нар ингээд хөдөө хотоор нь иргэдээ ялгаад байгаа юм шиг ийм асуудал байгаа юм. Энэ дээр бас анхаармаар байна. Тэр хаврын чуулганаар баталсан гол нэрийн бараа

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, нөөц бүрдүүлэх хууль чинь бол ганцхан 92 бензин гэж гараагүй шүү дээ. Түлш шатахуун л гэж гарсан шүү дээ. Бүх юмыг бол чадахгүй нь ээ. Гол нэрийн бараа бүтээгдэхүүн, түлш, шатахуун, мах, гурил гурав дээр л засаг, төр жаахан анхаарна. Үнийн тогтворжуулах бодлого баримтална. Нөөцөд бүрдүүлэх бодлого явуулна гээд ингээд иргэддээ хэлчихсэн. Хүлээлт үүсгэсэн.

Тэгсэн атлаа ингээд 2 нэр төрлийн бүтээгдэхүүн чинь нэгэн дээр нь анхаараад төв суурин газрын иргэдийн гол хэрэглээ болсон. 92 дээр нь анхаарал тавиад. Хөдөөгийн иргэдийн малчид, газар тариаланчдын гол хэрэглээ болсон энэ дизель түлшний үнэ дээр нь тохируулга хийхгүй ингээд орхигдуулаад байгаа юм биш биз дээ гэж би бодоод байх юм. Энэ дээр тэр хуулийг одоо хэрэгжүүлэх хоёрдугаарт нь хөдөөгийн иргэдийн гол хэрэглээ болсон дизель түлшний үнийг тогтворжуулах талаар танай яам ямар бодлого баримтлах юм. Ядаж одоо тэр 92-той нь адилхан дизель түлшийг чинь тэр 5 хувийн татвар юмыг нь тэглэж болдоггүй юм уу гэсэн ийм асуулт байгаа юм.

Чинзориг гишүүний асуултад Ганбаатар сайд хариулья.

Ж.Ганбаатар: Чинзориг сайдын асуултад хариулья.

Бас Чинзориг сайдын танхимд орж ирэхээсээ өмнө өргөн барьсан нь үнэн. Чинзориг сайд дизель түлш дээр бол Засгийн газар маш сайн анхаарч байгаа. Та өөрөө маш сайн мэдэж байгаа. Мэдэхгүй байгаа бол сайн сонсоод аваарай. Засгийн газраас Ерөнхий сайд ОХУ-д айлчилсан. Энэ айлчлалын үр дүнд дизель түлшийг зах зээлийн үнээс 10 хувийн хямдралтай гэрээг хийсэн. Энэ 1 сарын 1-нээс мөрдөж эхэлж байгаа. Энэ тодорхой үр дүнгээ өгнө өө гэдэгт би итгэж байна. Гэхдээ энэ дизель шатахууны чинь зардаг ААН-үүд хувийн

дандаа хувийн компани, ААН-үүдтэй. Сайдын хувьд бол бараг 14 хоног болгон энэ хувийн компаниудтай ялангуяа нийлүүлэлтийг тогтворжуулах, үнийг нэмэгдүүлэхгүй байх талаар уулзалт хийж байгаа юм. Улсын оролцоо төрийн одоо бид нар зөвхөн энэ агаарын түлш дээр л төрийн 50 хувийн оролцоотой ажиллаж байгаа. Саяхан энэ юу нээгдэж өгсөн. Дизель түлшний саяын таны ярьдаг асуудлууд юунаас болсон бэ гэвэл ОХУ-ын дотоод асуудлаас болоод дизель түлш нэг хэсэг бол хомсодсон. Энийг бол яаж зохицуулсан бэ гэвэл бид нар Хятад Ард улсын зохих түвшний хүмүүстэй яриад Энэ алдагдаж байгаа алдагдлыг нөхөж өгөх нийлүүлэлтийн шүү. Нийлүүлэлтийг ярьж байна. Энийг энэ дээр нь одоо Хятад ард улстай яриад нэг тодорхой хэмжээнд квот аваад Хятад бол дизель түлш бүр экспортолдоггүй зөвхөн импортолдог улс.

Тэгэхлээр бид нар бас нэг 40000 тонны нэг зөвшөөрөл аваад энийг импортолсны үр дүнд тогтворжсон. Одоо бол бид нар Роснефтьтэй бол 80000 тонны гэрээ байгуулж байна сар бүр. Өвлийн, хаврын бэлтгэл ажилд бол тодорхой анхаарал тавиад нөөцлөх талаас нь сайн анхаарч ажиллаж байна. Уул уурхай мэдээж таны хэлж байгаа ард иргэдийн амьжиргаа. Энэ бол ойлгогдож байгаа. Мэдээж дизель түвшин дээр хамгийн их анхаарлыг Засгийн газар ерөнхийдөө бүр бүх түвшинд тавьж байгаа. Өнөөдөр ч гэсэн ОХУ-ын зохих түвшний хүмүүс Монголд айлчлал хийж байгаа. Энэ орой 11 цагаас Ерөнхий сайдтай уулзалдаж байгаа. Яг энэ уулзалт дээр бид нар манай яам дизель түлшний асуудлыг бас тавина. ОХУ-ын дотоод нөхцөл байдалтай холбоотойгоор дизель түлшний хэрэглээ ОХУ-д өмнөх жилүүдэд байхгүйгээр ихэссэн. Маш ихэссэн. Энийг бол шалтгааныг нь та өөрөө сайн мэдэж байгаа. УУЯ-д дизель түлш 92 дээр ижил хэмжээний анхаарал тавьж байгаа. Дизель түлшний татварыг та асуулаа. Дизель түлшний татварын хувьд бол онцгой албан татвар 0 байгаа. НӨАТ 10 хувь байна.

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчих уу? Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууя. Байхгүй байна

МАН-ын бүлгийн дэд дарга Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал орж ирсэн. Тэгээд үүнийг харахаар зэрэг нэг ийм зүйл харагдаад болж өгөхгүй байгаа юм. АИ-92 бензин дээрээ болохоор зэрэг Бид тодорхой интервал авч үлдээд бусад газрын тос хийгээд газрын тосны бүтээгдэхүүн дээрээ хатуу коэффициенттой үлдэх гээд байгаа нэг ийм л санал байгаад байгаа л даа. Тэгэхээр миний ойлгож байгаагаар бол тэр холионд ороод бензиний чанар юм муутгаад тээврийн хэрэгслүүдийн эдэлгээний насжилтыг бууруулаад байдаг тэр зүйл дээрээ тав гэдгээ аваад бусдыгаа интервалтай авч үлдвэл яасан юм бэ. Засгийн газар нөхцөл байдлаа зөв үнэлж юун сараар битгий хэл өдөр цагаар өөрчлөгдөөд байгаа энэ нөхцөл байдалд дэлхийн зах зээл дээрх үнийн хөдлөлийг харгалзаж тэр 0-5 гэдэг коэффициент дотроо ажиллах уян хатан тэр механизмаа өөр дээрээ авч үлдвэл яасан юм. Ингэж зохицуулалтаа хийх бололцоо боломж байна уу гэдгийг би нэг зориуд тодруулж асуумаар байна.

2 дахь зүйл газрын тосны бүтээгдэхүүний үнэ цэн дэлхийн зах зээл дээр ямар ханштай байгаа юм. Монголоос экспортлогдож байгаа бүтээгдэхүүний чинь үнэ нь ямар өөрчлөлт орж, тэрүүгээр дамжиж бүтээгдэхүүн хуваах гэрээнийхээ зарчмаар Монгол Улсад төсөвт хэдий хэмжээний нэмэгдэл боломж орлого орж ирээд байгаа юм бэ? Үүнийг бид бас импорт талынхаа зах зээлийн үнийн мэдрэмж дээр энэ зөрүүгээ ашиглах бололцоо боломж бий юу? Нэг ийм 2 асуулт дээр их тодорхой хариулт авчихмаар байна.

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүний асуултад Ганбаатар сайд хариулъя.

2 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт болох тул гишүүд танхимдаа хүрэлцээ ирээрэй. Ганбаатар сайд асуултад хариулъя.

Ж.Ганбаатар: Батжаргал даргын асуултад хариулъя.

Сангийн яам 3 дахь саналыг боловсруулсан. Манай яам бол мэдээж энийг нэмээд өгөөч гэсэн санал бол өгөхгүй. Тэр ойлгомжтой. Гэхдээ Сангийн яамны саналыг бид бас хүндэтгэж байгаа. Яагаад гэвэл Дизель түлш маань 5 хувийн татвартай. Гаалийн татвартай. Онцгой 0 ингээд яваад ирсэн учраас хэрвээ энэ өөрчлөлт олох юм бол төсөвт нөгөө 2 талынхаа баланст асуудал үүснэ. Гэхдээ 0-5 хувь гэдгийг засагт эрх мэдлийг нь өгөөд явна гэдэг Батжаргал даргын санаа бол зөв. Манай яам ингэж яг боловсруулсан байгаа юм. Гэхдээ мэдээж энэ чинь татвартай холбоотой асуудал учраас Сангийн яам өөрөө яг бланкалдаг энэ бол яваад ирсэн зарчим. Бид бас Сангийн яамаа хүндэтгэлтэй хандаж байгаа. Энэ мэдээж төсөв төлөвлөгөөнд бас нэг жоохон юу үүсэх юм байна. Энэ ингээд аваад ирчихсэн татвар учраас тэрийг шууд ингээд авчихлаар төлөвлөсөн байгаа орлогодоо нөлөөлөх нь гэж. Энийг бол тодорхой хариулт өгсөн байх гэж бодож байна. Тэр дэлхийн зах зээл дээрх үнэ бол нэг ойролцоогоор наяс 83 тонн байна. Баррель нь. Баррелиар илэрхийлдэг учраас баррель нь тийм байна. Манай улс бол нэг энэ дизель түлшний хувьд бол 80000 сарын. 92 хувьд бол максимум 40000-ыг бол хэрэглэж байгаа тооноор. Бүтээгдэхүүн хуваах гэрээний хувьд бол өөрчлөлт оруулах гээд Петрочайнатай бол хэлцэл хийгээд Засгийн явж байгаа. Шадар сайд Амарсайхан сайд ахалж байгаа. Энэ дээр нэг зүйлийг хэлэхэд бол 1500 төгрөг гэж тооцоод тэрнийхээ 40 хувийг авч үлддэг байгаа. Ханшийг нь ярьж байна шүү дээ. Зүгээр дэлхийн зах

зээлийн ханш руу хөрвүүлэх юм бол тэр түүхий нефт 1800, 1900 төгрөг л болж байгаа байх. Яг экспортолж байгаа үнэ маань 1500 төгрөг. Гэхдээ энийг өөрчлөх тэр үлдэж байгаа 40 хувиа нөгөө хөрөнгө оруулалт талдаа нэг 40 хувийг өгөөд үлдсэн 60 хувиасаа нэг 40 хувийг нь манайх аваад 60 хувийг нь нөгөө тал авдаг. Энэ асуудлыг болохгүй байна гэж Засгийн газар үзсэн учраас тэгээд Шадар сайд ахлаад ажиллаж байгаа. Энэ ойрын 1 сардаа бол тодорхой хэлцэлд хүрчих байх гэж хүлээлттэй бол байгаа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гочоогийн Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Засгийн газар ер нь олон л асуудал оруулж ирэх юм.

Бид нар бол тууштай л дэмжээд байгаа. Тэгээд оруулж ирэхдээ нэг үнэ бууруулна. Үнэ барина гэдэг энэ яриагаа боль оо. Зүгээр түр зуурын эрсдэл байвал тэрийг хаах гэж байгаа л гэж оруулж ирэхгүй бол оруулж ирсэн юм болгон нь ингээд л үнэ бууруулна гэхээр нь бид нар дэмжчихдэг. Тэгээд бодит зах зээлээр болоод үнэ өсөөд ирэхээр өө бид нар нэмэргүй байна чадахгүй байна гээд л явж байгаа байхгүй юу. Түрүүн Чинзориг гишүүний хэлж байгаа нөгөө үнэ тогтворжуулах дээр чинь энэ гурилын үнэ, махны үнүүд чинь яг л тэгсэн шүү дээ. Үүнийгээ л хэдүүлээ тогтворжуулья гээд бид нар оруулж ирээд л өчнөөн мөнгө өгөөд л энэ гурилынханд чинь бараг 60, 70 тэрбум төгрөг 3 хувийн хүүтэй зээл төрөөс өгдөг.

Одоо гурилынх нь үнэ 2 дахин өсчихсөн. Эргээд л Засгийн газар тайлбарлахдаа тэр зээлээ өгчихсөн. Тэгсэн хэр нь ерөөсөө чадахгүй байна гээд л, ингээд л. Тэгэхээр үүнийг оруулж ирж байгаа асуудлуудаа оруулж ирэхдээ бас энэ нэр томъёоллоо бас арай өөрчилж баймаар байна. Нөгөө онгоцны түлш, нөгөө Роснефть давуу эрх, Эрчис ойлд давуу эрх олгоод л нэг тонн тутамд нь 2000 доллар бараг буугаад тэгээд л түлш

онгоцны тийзийн үнэ 30 хувь бууна гээд л оруулж ирээд л батлуулсан. Тэгээд өнөөдөр улам өсөөд байна шүү дээ онгоцны тийз чинь. Сая энэ шинэ жилийн үеэс бүр олдохоо байлаа. 2 дахин бараг өслөө шүү дээ. Тэгээд ер нь нөгөө ярьсан юм хаана байна. Хэзээ буух вэ. Хэдэн хувиар хэзээ гэхэд буух вэ? Тэр онгоцны түлшний нөгөө 2000 доллароор ч билүү хоёр сая төгрөгөөр ч билүү буусан уу яг нийлүүлж байгаа үнэ нь.

Тэгээд үүнд чинь ингээд өмнөх оруулж ирсэн юмнууд чинь хэрэгжихгүй болохоор бид нар ерөөсөө итгэхгүй байна шүү дээ. Одоо бол би энэ тогтоолын төслийг хараад АИ-92-ыг яах вэ 0 хувь болгоё гээд. Энэ нийт газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээний арван хэдхэн хувиа тэглээд бараг 80-аад хувь дээр нь хатуу 5 хувийн татвар тавих гэж байгаа л ийм тогтоолын төсөл байна гэж би ойлгож байна шүү дээ. Тэгэх юм бол би энийг дэмжихээр бол тэр 3 дахь заалтыг яг Батжаргал гишүүний хэлж байгаа шиг 0-5 гэдгийг нь эсвэл Засгийн газрынхаа интервалд өгөөд эсвэл яг дээд жишгээ шууд 0 болго л доо. Тэгээд яг тэр хувиараа та нар энэ үнийг нэг жоохон барь л даа. Тэгэхгүй бол ингээд нэг арван хэдэн хувийг нь тэглэж байгаа юм шиг хэр нь цаана нь наян хэдэн хувь дээр нь шууд Их Хурлаар шууд 5 хувь болгож байна шүү дээ.

Засгийн газарт угаасаа 0-5 хувийн эрх нь байна шүү дээ. Эрх нь байсаар байхад заавал Их Хурлаар заавал тав болгуулж яах гээд байгаа юм бэ. Дараа нь одоо бол Ингээд Их Хурлаас шууд 5 болгочихсон шүү дээ л гэх гэж байна шүү дээ. Засаг тэгвэл өөрөө эрхээ аваад өсгөх гээд байвал жоохон бууруулаад нэмэх гээд байвал буураад байвал өсгөдөг юм уу. Энийгээ эрхээ аваад л явж байх нь зөв юм биш үү. Тэгээд нөгөө талаасаа бол түрүүн би сая Ганбаатар сайдыг ОХУ-д нефтийн бүтээгдэхүүн бол буурч байна л гээд байгаа юм. Тэгэхдээ түүхий нефть буурч байгаа гэж байгаа байхгүй юу. Үгүй ээ нефтийн бүтээгдэхүүн, бүтээгдэхүүн

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

чинь шууд түүхий нефтээсээ л үнэ нь шууд хамаарна биз дээ. ОХУ-д нефтийн үнэ түүхий нефть нь бууж байвал бэлэн бүтээгдэхүүн нь бас л дагаад л адилхан буурдаг л ийм зарчимтай. Гол орц нь зуун хувь өөр ямар нэгэн хольц орцгүй л зүйл шүү дээ. Тэгээд ийм юмнуудыг бас хэдүүлээ нийгэмд нэг зөв ойлголт өгч энэ оруулж ирж байгаа тогтоолынхоо нэг үнэ барина, бууруулна гэдэг юмнуудаа боль оо.

Тэгээд энийг чинь нийгэм хүлээгээд л ингээд нефтийн бүтээгдэхүүний татварыг тэглэх гэж байгаа юм байна. Бас нэг буух нь гээд л хүлээгээд байж байна. Тэгээд л магадгүй хэд хоногийн дараа өсөөд л явдаг. Ийм л юм руу яваад байна шүү дээ. Тэгээд ер нь бол миний харж байгаагаар бол энэ ОХУ-тай нэг энэ арай гайгүй харилцаатай байгаа бүхий л улсуудын нефтийн бүтээгдэхүүн дээрээ хангалттай хэмжээний хөнгөлөлт дэмжлэг аваад яваад байх юм. Тэгээд манайх нэг 92 дээр нэг жоохон юм яриад л яваад байх юм. Энэ дээрээ бас нэг жаахан энэ яриа хэлэлцээр энэ дэмжлэг юмнууд дээрээ жаахан түлхүү анхаараач ээ. Олон улсад нэр нүүрээ бараад л энэ чинь хамгаалах.

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүний асуултад Ганбаатар сайд хариульъя.

Ж.Ганбаатар: Ганболд гишүүн ээ, АИ-92 бензиний үнэ харин маш тогтвортой байгаа. Бас дэлхийд байхгүйгээр тогтвортой байгаа. Хаана өсчихсөн юм? Та Харин өөрөө буруу мэдээлэлтэй байна шүү дээ. Харин 92-ын асуудал яригдаж байгаа юм энэ дээр чинь. 92-ыг чинь үнийг бууруулна гэдэг асуудал яриагүй байна, тогтоол. Тогтвортой энэ үнээ өсгөхгүй байх л асуудал би ярьж байгаа юм. Ер нь 92-ын үнийг бууруулна гэдэг юм тогтоол дээр байхгүй ээ. Ганболд гишүүн сайн хараарай. Уучлаарай.

Тэр онгоцны түлш 2400 байгаа 92. 2400-гаа долларт хувиргаад энэнээс

хямдхан бензин хэрэглэж байгаа улс байна уу гэвэл би харин харин асуудлыг ийм улс байна гээд ОХУ-ын дотоод үнээс ч бараг яг тэр үнэтэй дүйцэхүйц ийм үнэ барьж байгаа юм. Засгийн газар энийг бол харин ААН-үүд харин хөөрхий алдагдалтай. ААН-үүд олон жил алдагдал үүрч ирлээ. Зарим ААН-үүд АИ-92-ыг энэнээс болоод бүр дампуураад колонкууд хаалгаа барьж байгаа юм. Тэгээд энийг хэрэглэгч нар ойлгож байгаа байх. Зарим ААН-үүд дээр очихлоор АИ-92-оор үйлчлэхгүй байгаа. Тийм ч учраас бид бас энэ асуудлыг оруулж ирж байгаа юм. Тэгээд дизель түлш дээр би бас түрүүн Чинзориг гишүүний асуултад тодорхой хариулчихсан. Тэр онгоцны түлш дээр бол хямдрал бол 30 гэгээгүй 10 хувь. Би байнга л хэлсэн 10 хувь. Тэгэхдээ мэргэжлийн сайд нь бол хариулах байх. Өнөөдрийн надад байгаа мэдээллээр ихэнх авиа компаниудын үнэ бууж байгаа л гэдэг мэдээлэл өгч байгаа. Би та нарт тэр мэдээллүүдийг нь холбогдох яамнаас нь аваад хүргүүлье. Тэр 0-5 гэдэг интервалыг тэр болиоч ээ. Эрх мэдлээ гэж. Манай яам бол тийм л бодолтой байсан. Яг л тантай адилхан Ганболд гишүүн ээ. Тэгээд Сангийн яам яах вэ тэгээд л цаашаа энэ УУЯ явсаар байгаад аягүй бол бүгдийг нь тав юу болгочих байх гээд болгоомжилсон л байх л даа. Тэгээд хэрвээ Төсвийн байнгын хороон дээр хэлэлцэх явцдаа сайхан засаад энийг болохгүй ээ. Энэ чинь 05 байгаагаа больё юу 0-5 гэдэг эрх мэдлээ Засгийн газарт өгнө гээд явуулна маш сайн байна. Тантай 100 хувь санал нэг байна. Батжаргал гишүүн та хоёртой.

Хойшдоо зуун хувь санал нэгдэж байна дууслаа.

Хассуурийн Ганхуяг гишүүн асуултаа асууя. Дараачид нь дэмжсэн 3, дэмжээгүй 3 гишүүн үг хэлж болно. Ингээд санал хураалттай байгаа шүү.

Х.Ганхуяг: Сайн байцгаана уу. Энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Урт хугацаанд цаашдаа энэ шатахуунтай

холбоотой асуудлыг нэгэнт ингээд хөндөөд ярьж байгаа болохоор энэ л гал унтраах байдлаасаа илүү тэр чинь бас нэг мөрийн хөтөлбөртэй. Түлш боловсруулах үйлдвэр барина гээд оруулчихсан байдаг. 2024 онд ашиглалтад оруулна гээд ард түмэндээ амлачихсан байгаа. Тэгээд энэ түлш боловсруулах үйлдвэр ер нь хэзээ ашиглалтад орох юм. Тэрний түүхий эдийг нь хэрхэн яаж нийлүүлэх гэж байгаа юм. Тэгээд энэ сая яригдаад л байгаа. Тэр нафта энэ тэр гээд л тэр бодисуудыг бид нар чинь импортын татвараар тавьсан. Тийм ээ тэгэхдээ яах вэ тэр нь тэр түлш боловсруулах процесст ордог эсэх.

Тэгэхээр 3-т энэ Петро Чайнагаас наашаа түүхий эдээ татах нь гэж ойлголоо. Тэгээд хоолой барих юм байна гэдэг бас мэдээлэл авлаа. Тэгээд тэр нь ойролцоогоор 1 сая 500 мянган тонн түүхий эд наашаа багтах юм байна гэж ойлгосон байгаа юм. Тэгээд энэ чинь бас технологи нь их нарийн юм байна шүү дээ. Тэр чинь нэмэх 30 градусын дулааныг барьж байж тэр нэг түүхий эд чинь шингэн хэлбэрээрээ наашаагаа орж ирэх л юм байна л даа. Тэгээд тэр Петро чайнын олборлож байгаа хэмжээ нь 1 жилийн 650000 тонн олборлох юм байна. Барьж байгаа болон 1 сая 500 мянган тонны хоолой барьж байгаа юм байна. Тэгээд ер нь энэ хөрөнгө оруулалт нь оновчтой эсэхийг бас тодруулчихмаар байна. Тэгээд өнөөдөр чинь бид нар яг энэ түлшний асуудал ярьж байна. Одоо ингээд үдээс хойш төмөр замын асуудлыг ярих юм байна. Тэгээд энэ цаашдын логистикийн энэ ханган нийлүүлэлт асуудлыг хэрхэн яаж төлөвлөж байгаа юм. Түлшний үйлдвэр баригдаад дууссаных нь дараа хангамжийн асуудлуудыг нь шийдэх юм уу гээд нэг ийм 3 асуултыг л асуучихмаар байна. Яах вэ одоо бид нар бол яах вэ өнөөдөр бол АИ 92 дизель түлш гээд энэ нь яах вэ богино хугацааны л асуудал юм. Богино хугацааны үнийн шокийн л асуудал байгаа юм. Тэгэхээр 24 онд үйлдвэр маань баригдаж дуусах юм уу, үгүй юм уу. Тэгээд тэр чинь том том мега төслүүд яриад байдаг. Нэг бол зах зээлийн

үнээс чинь тав дахин илүү үнэтэй барьчихсан байдаг. Нэг болохоор мухар төмөр замууд бариад байдаг. Тэгээд сая энэ хоолойн асуудлыг бас сонссон чинь тэр нь бас л наашаагаа тэр түүхий эдээ татах нь нэлээн хүндрэлтэй л юм дуулдана лээ.

Тэгээд тэр нэг төмөр замаараа шийдэж болоогүй юм уу? Ер нь бол ингээд мега төсөл гэдэг маань өөрөө маш сайн судалгаатай, тэгээд зүтгээд л хийдэг л ажлууд шүү дээ. Тэгээд ингээд хараад л байхаар ингээд манай ихэнх мега төслүүд бүгдээрээ л дампуурал шүү дээ энэ бол. Баахан мухар төмөр зам холболтын цэггүй. Тэгээд төмөр замаа барьсны дараа холболтын цэгүүдээ хийдэг. Тэгээд энэ чинь энэ нефть үйлдвэр чинь энэ төмөр замтайгаа ч холбоотой, ханган нийлүүлэлттэйгээ ч холбоотой. Нэлээн том эко систем байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ тал дээр нэг мэдээллүүдийг нэг сонсчихмоор байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганхуяг гишүүний асуултад Ганбаатар сайд хариулаад нэмж ажлын хэсэг хариулах уу? Ганбаатар сайд эхэлж хариулах уу?

Ж.Ганбаатар: Ганхуяг гишүүний болгоомжлол бол 100 хувь зөв өө.

Ер нь өөрийн чинь авсан мэдээлэл бол зөв байна. Түлшний үйлдвэр 2025-2026 онд ашиглалтад орно гэсэн ийм төлөвлөгөөтэй байна. Алтанцэцэг гээд гүйцэтгэх захирал байгаа. Гүйцэтгэх захирал Их Хурал дээр тодорхой мэдээллүүдийг бас өгөөд л байсан харагдсан л даа. Би тэгэхэд бас сайд болоогүй байсан. Ер нь бол хоолойгоор явуулна гэдэг шийдвэр гараад хоолой дээр нь тендер зарлагдаад компани шалгараад явж байгаа. Таны хэлж байгаа үнэн. Халаагаад явуулах ёстой тодорхой зайнуудад тэр халаах тийм механизмуудыг хийх ёстой. Ер нь манай тос тийм жоохон өтгөн талдаа гэдэг тийм тайлбарыг гүйцэтгэх засаглал нь хэлдэг юм. Гэхдээ бид энэ олон зүйлүүдийг даван

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

туулаад өөрсдөө бас нефть боловсруулах үйлдвэр хийгээд хараат биш болоод ингээд урт хугацаагаа хараад явах нь зөв өө гэж Уул уурхай яам. Таны ч гэсэн үгэнд гарлаа. Тэр бол зөв. Гэхдээ мэдээж хүндрэлүүд бол байна. Хүндрэлүүд ч байна. Бас олон талаас нь харах зарим зүйлийг хүмүүс бас явуулахгүй байх. Бас хамаа замбараагүй янз янзын юм ярих тийм тохиолдлууд ч байна. Мэдээллийг бас жоохон гуйвуулсан маягтай асуудалд хандах. Тэр 1 сая 500 тонн байна. Петрочайна чинь хүрэхгүй юм байна гэдэг асуултад хариулахад бол НИК, Петровис компаниудын тодорхой талбайнууд дээр сайн үр дүнгүүд гарч байгаа.

Ер нь бол бүтээгдэхүүн угаах гэрээгээр Засгийн газар нэлээн олон компаниудтай гэрээтэй хамтран ажиллаж байна. Хайгуулын түвшинд. Энэ түвшиндээ бол бас Монголд бол тодорхой нөөцүүд бол байна. Тэндээ бид найдвар тавьж байгаа. 1 саяас 1 сая 500 тонн гэдэг мэдээлэл бол зөв. Гэхдээ хүндрэлүүд бол байгаа. Тодорхой хариулсан байх гэж бодож байна. Манай Газрын тосны газрын дарга бас нарийн мэдээллүүдийг өгчихье гэж бодож байна. Дарга зөвшөөрвөл. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Асуултад ажлын хэсэг нэмж хариулья. 83 дугаар микрофон. Өөрийн нэр албан тушаалаа хэлээд асуултад хариулья.

И.Анхбаяр: Ганхуяг гишүүний асуултад хариулья. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны газрын тосны бодлогын газрын дарга Анхбаяр.

Петро Чайна компанийн олборлолттой холбоотой асуудлууд бол ерөнхийдөө бас тодорхой хэмжээнд нөхцөл байдал байгаа. Газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад орох үед 1.5 сая тонн газрын тосоор хангах асуудал дээр бол УУХЯ бас нэлээн анхаарч ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор үүсээд байгаа асуудлуудыг нь бас танд нэг хэлээд өгье.

Нэгдүгээрт бол ер нь цахилгааны эрчим хүчний асуудал маш тулгамдаж байгаа асуудал байна.

Хоёрдугаарт бол ерөөсөө л орон нутгийн эсэргүүцэл ард иргэдийн эсэргүүцлийн асуудал бол нэлээн тулгамдаад байгаа асуудлууд байгаа. Үүнтэй холбоотой түрүүн бас Ганбаатар сайдын хэлсэн дээр Петро Матад гэж компани яг Петро Матад -20 талбай дээр бол үйл ажиллагаа эхэлсэн. Ашиглалт руу шилжих процесс нь бол явагдаж байгаа. Энэ компанийн үйл ажиллагаа эхлэхээр бас тодорхой хэмжээнд нөөцийг бол бид нар нэмэгдүүлнэ гэж харж байгаа. Мөн ялгаагүй орон нутгийн эсэргүүцэлтэй тулгараад байгаа. Үйлдвэрийг түүхий эдээр хангах асуудал дээр бол газрын тос боловсруулах үйлдвэр болон Уул уурхай хүнд үйлдвэрийн яамнаас хамтарсан байдлаар судалгааны ажлууд бол хийгдсэн байдаг.

Энэ дээр төмөр зам автомашин болон шугам хоолойн тээвэрлэлтийн арга механизмуудыг бид нар судалж үзсэний үндсэн дээр хамгийн зөв шийдэл нь бол газрын тос боловсруулах үйлдвэр рүү шугам хоолойгоор нийлүүлэх нь нэгж бүтээгдэхүүнийг тээвэрлэх хамгийн бага зардалтай.

Дээрээс нь байгаль орчиндоо ээлтэй ийм шийдэл юм байна гэдэг дээр бол шийдвэр гаргасан. Тосны өтгөн гэдэг асуудал дээр бол парафин өндөртэй учраас бас жоохон өтгөрөх тийм нөхцөл байдаг учраас. Энийг бол халаах системтэйгээр энэ хоолойг барихаар төлөвлөж байгаа.

Хоолойг барихаар бол Хятадын компани сонгон шалгаруулалтад оролцоод тэнцсэн. Энэ компани бол үйл ажиллагаагаа эхлүүлчихсэн. Зураг төслийнхөө ажлыг эхэлчихсэн ингээд явж байгаа гэдгийг танд хэлье ээ.

Хариулж дууслаа баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Дэмжсэн 3 хүртэл, дэмжээгүй хүртэл үг хэлж болно. Анандбазар гишүүнээр тасаллаа.

Анандбазар гишүүн үг хэлье.

Ц.Анандбазар: Өнөөдөр 92-ын татварыг тэглэж байгаа тогтоолын хугацааг сунгах ёстой л ийм заалт байгаа юм л даа. Тэгээд энэ яам яасан будилуун юм. Ер нь энэ бензин мэддэг хүн танай яаманд хэд үлдсэн бэ? Ганбаа уг нь сууж байна. Сангийн яамны хүн. Ганбаа сайд маань бас бензин нефтийн үйлдвэрийг ярихдаа бидэнтэй их сайн зөвлөж ярьж баймаар байна. Дэлхий нийт сонсож байгаа. Тэгээд та нарын ярьж байгааг харахад ерөөсөө л нэг тийм сургаар ажгаар гадаадын иргэн юм ярьж байгаа юм шиг л юм ярих юм. Энэ тогтоол чинь хэрвээ ийм байдлаар явах юм бол унана.

3 дугаар заалт ерөөсөө хэрэггүй. Хэн дизель түлш, бусад бүтээгдэхүүн нэмэгдэхгүй гэж хэлээд байгаа юм бэ? Нефтийн үнэ гэдэг чинь далайн давлагаатай адилхан байдаг эд шүү дээ. Өнөөдөр унаж байдаг, маргааш өсөж байдаг, нөгөөдөр бууж байдаг.

Тийм учраас зөвхөн тэр 92-ын татварыг тэглэсэн хугацааг сунгасугай гэсэн ганцхан заалтад оруулах горимын санал байна. Мөнхбаатар дарга аа. Тэгэхгүй бол энэ унах гээд байна. Ийм цөөхөн гишүүдтэй. Вагон дээр нуруун дээрээ зогсож байгаа 92 их олон байна. Хэрвээ тэрийг гаалийг хөнгөлж оруулахгүй бол маргааш приустэй хүмүүс жагсана шүү 92-ын үнэ өснө. Тэгээд ийм элементарный ойлгомжтой юмыг дунд нь хулгай оруулах гээд янз бүрийн заалт нэмээд бусад бүтээгдэхүүнийг 5 хувь болгоно гээд огт мэдэхгүй байж мэддэг юм шиг юм яриад, ингээд оруулж ирдгээ боливол яасан юм бэ? Энэ яамыг ерөөсөө сүүлийн үед ойлгохоо больчихоод байгаа юм. Найз нь дундаа юм хэлэхээр ойлгохгүй юм. Зөвлөгөө өгөхөөр хүлээж

авахгүй юм. Өөрөө бүү мэд. Мэдсэн хүний үгэнд бүү ор гээд хараал хүрсэн ийм хүмүүс байдаг гэж номд бичсэн байдаг. Арай тийм болчихоод байгаа юм биш биз танай яам.

Ер нь ус бензин 2 ялгагдаг хүн, хэдэн хүн байна? Яагаад ганцхан улс төр ороогүй. Хулгай нь нүүрлээгүй байгаа. Салбарыг дампууруулчих гээд байна. Маш олон мэргэжлийн бус сайдууд байсан. Бид мэддэг. Тэгэхдээ юм хэлээд зөвлөхөөр ойлгоод хүлээж аваад байдаг юм. Одоо илжигний чихэнд ус ч хийсэн сэгсэрнэ. Алт ч хийсэн сэгсэрнэ гэдэг шиг л юм ярьдаг болчихож. Яагаад та нар чинь ийм болчихоод байна. Суурь үнийн асуудал шүү энэ бол. Монгол Улсын хүн бүрийн карманд ордог суурь үнийн асуудал ярьж байна. Дэлхий дээр нефтийн үнэ унаад байдаг хөдөлгөөнгүй гэрээ хийчихсэн.

Тэгээд энэ асуудлыг чинь бол зөв гаргалгаагаар хамгаалж гарахгүй бол уначих гээд байна. Буруу ойлголт яваад байна шүү дээ. 3 дугаар заалт ерөөсөө хэрэг байхгүй. 5 хувь болгож өндөр өсгөчих юм бол дараа нь дахиад тэрийгээ засах гээд Их Хурал дээр тогтоол орж ирнэ. Энэ чинь Их Хурлын тогтоолоор зохицуулдаг эд биш шүү дээ. Засагт эрхийг нь өгөх ёстой юм. Тийм болохоор зарчмын зөрүүтэй саналаар санал хураалгаад энийг нь шийдээд өгье гэж бодож байна Мөнхбаатар дарга аа. Ерөөсөө 92-ын татварыг хугацаа нь дуусчихсан тэр хугацааг сунгасугай гэсэн ганцхан заалттай л оруулах ёстой юм. Тэгээд нэг мундаг. ухаантай хүмүүс баахан будилаантай юм оруулж ирчхээд ингээд гишүүдийн толгойг эргүүлээд. Тэгээд ярьж байгаа юманд чинь авах юм алга байна шүү дээ.

Энэ чинь дэлхий харж байдаг юм билээ Монголын парламентыг. Та бүхнийг ийм юм ярьж байгааг сонсох юм бол Монгол үйлдвэр барьж чадахгүй гэдгийг гадаадын ямар ч дээд сургууль төгссөн хүн шууд хэлнэ. Бензин ярихдаа

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

жоохон бодолтой яримаар байна. Улс төрждөг, хүн болгоны карманд ордог, амьдралыг нь тэмтэрдэг. Ийм ийм учраас мэдлэгтэй, мэддэг хүмүүсээр яриулж, зөв хандлагатай байхгүй бол энэ их аюултай. Цагаан сар болно оо. Бензиний үнээр тоглож болохгүй ээ. Нүүрсийг нь хулгайч болгоод дуусгасан. Нефть нефтийн бүтээгдэхүүнийг хулгайч болгоод дуусах нь л дээ. Эхнээсээ хулгайчууд ороод ирж байгаа. Энэ 3 дугаар заалт яагаад болохгүй гэхээр тэр Адышаа гишүүний өргөн барьсан хуурамч шатахууны юмтай шууд холбогдож байгаа юм. Ориг шатахууныг нь өндөр үнэтэй болгочоод, хуурамч шатахуунаа татваргүй болгох ийм хууль зөрүүлж өргөж барьж байгаа шүү дээ. Үгүй энэ яам чинь ер нь яачхаад байгаа газар вэ? Болохгүй бол өргөн барина шүү. Дэндэж байна шүү та нар.

Ядарсан ард түмнээр тоглож болохгүй шүү. Улаан цагаандаа гарна гэдэг болж байна шүү дээ энэ чинь. Ганбаа сайдтай бид уулзаад тохирсон шүү дээ.

3 дугаар заалтаа хасаад зөв оруулж ир ээ. Тэгэхгүй бол наадах чинь унана шүү гэж. Харин наадах хэлэлцэх эсэхээ зөв болгож оруул л даа. Эхнээсээ буруу явуулсан юм бол наадах чинь уначихна. Ойлгож байна уу? Хэрвээ энэ саналыг хүлээж авахгүй бол эсрэг дарчихъя. Горимын санал хэлж байна шүү дээ. Өөрөө юмаа мэдэхгүй юм ярьчаад тэгээд хачин юм яриад байх юм.

Л.Мөнхбаатар: Анандбазар гишүүн тодорхой асуудал яриад байх шиг байна. Гэхдээ энэ асуудал бол өнөөдөр хэлэлцэх эсэхийг нь шийдэж байгаа. Төсвийн байнгын хорооны хуралдаанаар энэ асуудлыг хэлэлцэнэ. Тэр үед тодорхой санал зарчмын зөрөөтэй санал байгаа бол тэр асуудлаа Төсвийн байнгын хороон дээрээ ярих нь зүйтэй. Гишүүд үг хэлж дууслаа. Ганбаатар гишүүн, Анандбазар гишүүн 2 хуралдаан явуулах нөхцөл бүрдүүлье. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хүсэлт явуулна. Ирц болж байна уу? Байнгын хорооны саналаар “Тогтоолд

нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая.

Бүртгэлийн санал хураалт явуулчихъя. Бүртгэлийн санал хураалт явуулсан. Гишүүд анхааралтай. Энд Баттөмөр гишүүн өөр энэ гишүүд байгаа боловч сая санал хураалтад оролцоогүй гишүүд байна шүү. Чинзориг гишүүн суудалдаа суу.

Энх-Амгалан гишүүн орж ирлээ. Мөнх-Оргил гишүүн. Санал хураалт явагдана. Гишүүд суудлаа эзэлье. Саналын томьёоллыг сая уншиж танилцуулсан.

Санал хураалт. 60.5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлээ. Ингээд Төсвийн байнгын хороо хуралдаж анхны хэлэлцүүлгээ хийнэ. Эргээд нэгдсэн хуралдаанд оруулна. Төсвийн байнгын хороо хуралдах бэлтгэлийг хангаарай.

11.20 цаг.

Дараагийнхаа асуудалд орёе.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна.

Нямбаатар сайдыг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулаарай.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын хуулийг мөн 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байгаа билээ. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт шүүгчийн туслах, эрх зүйч мэргэжилтэй хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна гэж. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд Монгол Улсын Шүүхийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө шүүхэд ажиллаж байгаа хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл аваагүй шүүгчийн туслах Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 89.1 дэх хэсэгт заасан шаардлагыг уг хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд хангана гэж хуульчилсан. Гэтэл практикт Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх Журмын тухай хуулийн дээрх 9 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхэд хүндрэл бэрхшээл үүсээд байна. Монгол Улсын хэмжээнд 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар анхан болон давж заалдах шатны 116 шүүхийн 41 нь тамгын газарт, нийт 454 шүүгчийн туслах ажиллаж байгаагаас хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 224, харин хуульчийн мэргэжлийн тусгай зөвшөөрөл аваагүй 230 хүн ажиллаж байна. Шүүгчийн туслахын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд нээлттэй зарлаж зохион байгуулж байгаа боловч цөөн тооны нэр дэвшигч хамрагдаж байгаа нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуульчид уг шалгалтад бүртгүүлэхгүй байгаатай холбоотой юм.

Тухайлбал Монгол Улсын Шүүхийн тухай хууль хүчин төгөлдөр

болсноос хойших 2 жилийн хугацаанд Монголын Хуульчдын холбооноос хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шалгалтыг 2 удаа ШЕЗ-ийн дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлөөс 2022 онд 7 удаа төрийн албаны тусгай шалгалтыг тус тус зохион байгуулсан байна.

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй шүүгчийн туслахуудыг ажлаас чөлөөлсөн тохиолдолд шүүхэд шүүгчийн туслахын хүний нөөцийн хомсдол үүсэж улмаар шүүн таслах хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүрээд байна. Иймд Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан хугацаанд өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн хэлэлцэх хэсгийг шийдвэрлэж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар танилцуулъя.

Цогтбаатар гишүүнийг индэрт урьж байна.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Шүүхийн тухай хууль шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хуулийн төсөл нэн яаралтай хэлэлцүүлэх тухай Улсын Их Хурлын даргын 14 дүгээр захирамжийн дагуу ХЗБХ 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 89.1-д заасан

шүүгчийн туслах, эрх зүйч мэргэжилтэй, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх шаардлагыг уг хуулийг дагаж мөрдсөнөөс хойш 2 жилийн хугацаанд хангана гэсэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зохицуулалтыг 3 жил болгон өөрчлөхөөр хуулийн төслийг боловсруулсан байна. Хуулийн төслийг d.parliament.mn цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно оо.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 54.5 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

ШЕЗ-ийн дарга Рэнцэндоржийн Онончимэг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон нар оролцож байна.

Өнөөдөр нийтдээ 18 асуудал хэлэлцэж шийдвэрлэнэ.

Чуулганы нэгдсэн хуралдааны дундуур Аюулгүй байдлын байнгын хороо, ХЗБХ, Төсвийн байнгын хороод бас хуралдана. Нэлээн ачаалалтай хуралдаантай Өдөр байгаа. Тийм учраас асуудлуудаа жаахан шуурхай хэлэлцээд явъя. Нямбаатар сайд эхэнд нь нэг тодорхой мэдээлэл өгчихмөөр байгаа юм. Тэгж байгаад санал хураалт, үг хэлэх дээрээ оръё гэсэн бодолтой байна.

Ингээд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? нэрсээ өгөөрэй. Нямбаатар юу өгөх юм уу байхгүй юу. Тайлбар хэлэх юм уу? Алга байна.

Гишүүдийг танхимдаа урьж байна. Санал хараалт.

Үг хэлэх гишүүд байна уу? Нямбаатар гишүүнээр тасаллаа. Нямбаатар гишүүнээр тасаллаа. Үг хэлсний дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа байраа эзэлъе.

Нямбаатар гишүүн үг хэлнэ.

Х.Нямбаатар: Энэ бид нар 2021 онд Шүүхийн тухай хуулиа баталж авсан. Тэгээд Шүүхийн тухай хууль дээр ажлын хэсэг дээр энэ 89-ийн нэг дэх заалт дээр шүүгчийн туслахад бид нар хуульчийн тусгай зөвшөөрлийн шаардлага болзол тавилгүйгээр хуулийн төсөл анх өргөн баригдсан. Ажлын хэсэг хэлэлцүүлгийн шатанд энэ шүүгчийн туслах нь заавал хуульчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байна гэдэг зарчмын зөрүүтэй санал хураалгаж, тэр нь дэмжигдээд явж байгаа юм. Тэгээд энэ хугацаанд бид нар энэ 2 жил гаруйн хугацаанд шүүгчийн туслахын орон тоог нөхөх зорилгоор хуульчийн тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулсан.

Дээр нь ШЕЗ-ийн дэргэд байдаг төрийн албаны салбар зөвлөлөөс мөн 7

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

удаа энэ шүүгчийн туслахын орон тоон дээр хуульчийн тусгай зөвшөөрөлтэй хүмүүсийг сонгон шалгаруулалт зарласан болов чиг өнөөдрийн байдлаар тавь гаруй хувь нь энэ хуульчийн тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг босгыг давж энэ болзлыг хангаж чадаагүй ээ.

Тийм учраас энэ 3 сарын 1-нээс нийт шүүгчдийн туслахын бараг 50 гаруй хувийг чөлөөлөхүй ийм нөхцөл байдал үүсээд байгаа. Чөлөөлсөн тохиолдолд цаашид шүүн таслах үйл ажиллагаа хэвийн явагдах ийм нөхцөл байдал алдагдана. Ийм учраас бид нар 1 жилээр энэ хугацааг сунгаж авъя. Энэ хооронд иргэд Шүүхийн тухай хуулийн амьдралд бас хэрэгжихгүй байгаа зарим заалтуудыг эргэж харах, ийм хуулийн төсөл боловсруулах ийм ажил хийе гэдэг ийм зүйлийг л би хэлэх гэсэн юм. Тэгээд ШЕЗ-ийн дарга бас энд ирчихсэн байгаа. Бид нар энэ Шүүхийн тухай хуулийн хэрэгжилт дээр нэлээд бас тодорхой судалгаануудыг хийсэн.

Хоёр гэвэл би бас Их Хурлын гишүүддээ нэмэлт мэдээлэл өгөхөд энэ хаврын чуулганаар Шүүх байгуулах тухай Монгол Улсын хуулийн төслийг Засгийн газраас өргөн барихаар төсөвлөж байгаа.

Өнөөдөр Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа нийтдээ 116 шүүх байгаа. 116 шүүх байгаа. Тэгэхээр бид нар энийг одоо нөгөө Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хүрээнд нь газар нутгийн ойр хэрэг маргааны ачаалалтай нөхцөл байдал зэргийг харгалзаж үзэж шинээр шүүх байгуулах хуулийг оруулж ирэх гэж байгаа. Энэнээсээ өмнө бас мэргэжлийн Байнгын хороотойгоо нэлээн сайн зөв

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд танхимдаа орёё.

Санал хураалтад бэлтгээрэй. МАН-ын дэд дарга Батжаргал дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг нар ирцээ бүрдүүлээ. АН-ын бүлгийн дарга Цогтгэрэл бас ирцээ бүрдүүлэе. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая.

Санал хураалт.

Гишүүдийн 54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцсон.

Анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүллээ.

ХЗБХ хуралдаж төслийн анхны хэлэлцүүлэг явуулж, төслийг нэгдсэн хуралдаанд оруулж ирнэ. ХЗБХ хуралдуулах ажлын хэсгийг Байнгын хороо хуралдах бэлтгэлийг хангаарай.

11.34 цаг

Дараагийнхаа асуудал орёё.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулъя. Ажлын хэсгийн оруулаарай.

Сандаг-Очир гишүүнийг индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн билээ. ХЗБХ 2023 оны 1 дүгээр тогтоолоор хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Ц.Мөнх-Оргил, Ц.Сандаг-Очир нар болон холбогдох бусад албан тушаалтнууд ажиллаа.

ХЗБХ 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан хуулийн төслийн нэгдүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно оо.

ХЗБХ-ны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж дараах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Үүнд: Штабын дарга нь дотоодын цэргийн командлагчийг түр эзгүйд түүний хуулиар олгосон эрхийн хүрээнд орлох бөгөөд гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үр дагаврыг өөрөө хариуцахаар,

2.Дотоодын цэргийн албан хаагчдыг албан үүргээ гүйцэтгэж байх үед албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг нэгжлэг хийх тохиолдолд тухайн албан хаагчийг шууд захирах даргад мэдэгдэх,

3.Дотоодын цэргийн командлагч өөрийн зарим чиг үүргийг зөвхөн тушаалаар буюу холбогдох эрх зүйн баримт бичгийг батлан штабын даргад шилжүүлэх,

4.Улсын онцгой онц чухал объектын хамгаалалтын найдвартай, аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалуулагч байгууллагын нэмэлт санхүүжилт авч болох бөгөөд холбогдох журмыг Засгийн батлах зэрэг болно оо.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Бямбабаярын Анхбаяр, Дотоодын цэргийн штабын дарга бригадын генерал Рэнцэндоржийн Чингис, ЦЕГ-ын захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Лхамдоржийн Нямдаваа, ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Идэрийн Батчулуун, Дотоодын Цэргийн штабын орлогч харуул хамгаалалтын хэлтсийн дарга дэд хурандаа Нэргүйн Мөнх-Итгэл нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Нэрсээ өгье. Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 12 санал байгаа. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

ХЗБХ-ны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.3 дахь хэсгийн “, энхийг дэмжих, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох” гэснийг хасаж, мөн хэсгийн “байна” гэснийг “байж болно.” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Ц.Мөнх-Оргил, Ц.Сандаг-Очир /цаашид “Ажлын хэсэг” гэх/.

Санал хураалт.

55.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалтыг явуулъя.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.3 дахь хэсгийн “18-аас” гэснийг “15-аас” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.8 хувиар санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалтыг явуулъя.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.4 дэх хэсгийн “түүнийг” гэсний дараа “энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд” гэж нэмж, мөн хэсгийн “энэ хугацаанд” гэснийг хасаж, мөн заалтын 9.5 дахь хэсгийн “даргад” гэсний дараа “тушаалаар” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.4 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 36.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.7.Дотоодын цэргийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байх үед албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг нэгжлэг хийх тохиолдолд тухайн алба хаагчийг шууд захирах даргад мэдэгдэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 38.4 дэх хэсгийн “үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглах, мэдээлэл дамжуулах,” гэснийг хасаж, мөн зүйлийн

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

“болно” гэснийг “болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар зүйлийн “4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “тогтоосон” гэсний дараа “улс орны нийгэм, эдийн засаг, стратегийн” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “улсын онц чухал” гэсний дараа “болон шаардлагатай бусад” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

59.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 4.1.1 дэх заалтын “аль нэг” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “8.1.13” гэсний дараа “, 8.1.14” гэж нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн “33.1.1.12” гэснийг “33.1.12” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийн “тус тус” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

56.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн

бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 15 дугаар зүйлийн 15.35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “нэвтрэгчид” гэснийг “нэвтрэх эрх бүхий хүнд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг танилцуулъя.

Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн 1 санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “6.33” гэснийг “6.62” гэж, Төслийн 2 дугаар зүйлийн “6.33” гэснийг “6.62” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

61.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Хууль зүйн байнгын хороо хуралдаж эцсийн хэлэлцүүлэг явуулж, төслийг нэгдсэн хуралдаанд оруулж ирнэ. Энэ бэлтгэлийг холбогдох Байнгын хороо хангаарай.

11.48 цаг.

Дараагийнхаа асуудалд оръё.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийг анхны хэлэлцүүлэгт явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлут танилцуулна.

Батлут гишүүнийг индэрт урьж байна.

Д.Батлут: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн

хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг хуулийн төсөл батлагдсанаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн эрх үүрэг хэвээр байх талаар тодруулж өөрчлөгдсөн тохиолдолд энэ чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг төрийн бус байгууллагуудаар зарим эрх үүргийг гүйцэтгүүлэх эсэх талаар Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болох эрхээ ТББ-аар хэрэгжүүлж байгаа эсэх, хуулийн төсөл батлагдсанаар нэмж хэдэн төрлийн үйлчилгээг гүйцэтгүүлэх эрхийг ТББ-д шилжүүлэх талаар асуулт асууж хариулт авлаа.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Байнгын хорооны гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасныг баримтлан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 70 хувийн саналаар дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Төмөрбаатарын Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Гомбосүрэнгийн Өнөрбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Содномдоржийн Дамбий, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль эрх зүйн хэлтсийн дарга Дугаржавын Рэнчиндорж, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний газрын дарга Загарын Буянбадрах нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа. Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуулт асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ тусгай зөвшөөрлийг хуульд заасны дагуу бусад этгээдүүдэд шилжүүлж болно гэсэн заалттай хуулийн төсөл өргөн баригдсан шүү дээ. Тэгээд энийг ер нь яг хэнд шилжүүлэх гээд байна. Хэнд ч шилжүүлж болно гэж бид нар үзээд байгаа юм бэ. Тэгээд энэ гадаадад ажиллах хүч гаргах асуудлыг чинь ингээд янз бүрийн ТББ ч байдаг юм уу компани ААН-үүдэд сайд нь мэдээд шилжүүлээд байвал энэ процесс чинь ер нь замбараагаа алдах тийшээ явах юм биш үү? Ямар нэгэн энэ хуульдаа хэмжээ хязгаар лимит тогтоож өгөхгүй юм уу? Жишээ нь юу гэдэг юм? Яах вэ тэр Солонгосдоо Засгийн газар хоорондын хэлэлцээртэй байлаа гэж бодоход Япон ч юм уу, Герман ч юм уу хаашаа ажиллах хүч гаргая гэж бодъё л доо. Тэгэх юм бол тэнд Худалдаа аж үйлдвэрийн танхим ч нэг нь гаргаад л, тэнд нэг компани ч гаргаад л, Засгийн газар нь гаргаад л хэмжээ дамжаагаа алдах юм биш үү.

Энэ дээр хязгаар тогтоох юм яриагүй юм уу?

Хоёрт энэ аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраас бусад төрийн өмчит хуулийн этгээдийн гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг Засгийн газрын шийдвэрээр хөнгөлж чөлөөлж болно гэж байгаа байхгүй юу. Тэгсэн мөртөө доод талд нь бусад аж ахуй нэгжүүдийнхийг бас чөлөөлж болно гэж байгаа юм. Тэгээд энийг нийлүүлээд нэг заалт болгомоор байгаа юм. Яагаад гэвэл байна шүү дээ энэ төрийн өмчит ААН-үүд нь чөлөөлөгдчихдөг. Хувийн ААН байгууллагууд нь гадаад ажиллах хүч оруулж ирэхээрээ өндөр төлбөрөө төлөөд яваад байдаг. Тэгээд эцсийн дүндээ ямар нөхцөл үүсэх вэ гэхээр зах зээлд энэ чинь туйлын шударга бус байдал бий болно шүү дээ. Хувийн аж ахуй, хувийн өмчит ААН-үүд нь төлбөрөө төлөөд байдаг. Яг тэд нартай адилхан өрсөлдөж байгаа юм уу, адилхан үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит ААН-үүд нь төлбөр төлдөггүй. Ингээд өрсөлдөөний зарчим алдагдана. ААН-үүд хохирно.

Гуравт энэ ААН-үүдийг гэж байгаа юм. Ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ, гадаад ажилтны ажлын төлбөрийг хөнгөлж болно гэж байгаа юм. Яах вэ тэгээд сайд нь юм уу нэг нь хөнгөлөх нь л дөө. Тэгэхдээ энэ дээр ахиад энэ чинь бас нэг ерөнхий чиг хандлага, зарчим лимит хязгаар энэ тэр гэж юм байхгүй юм уу. Тэгээд л сайд нь юм уу, Засгийн газар нь дуртай үедээ шийдвэрээ гаргаад л дуртай үедээ шийдвэрээ цуцлаад л, нэг эсвэл хөнгөлөлт олгоод л эсвэл зарим ААН-үүдэд нь хөнгөлөлттэй зарим ААН нь хөнгөлөлтгүй яваад байх юм уу? Энэ чинь ААН-үүд дээрээ яриад байгаа байхгүй юу. Салбараараа яривал болж байгаа байхгүй юу. Тэр ААН нь улсынх байна уу, хувьсгалынх байна уу, хувь өмчид байна уу үл хамаараад тэр салбарт орж ирж байгаа ААН нь бүгдэд нь ажиллах хүчний

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

төлбөрийг хөнгөлнө өө чөлөөлнө өө гэх юм бол ойлгомжтой байгаа байхгүй юу.

Гэтэл барилгын салбарт ажиллаж байгаа зарим байгууллагуудад нь хөнгөлчхөөд заримд нь хөнгөлдөггүй. заримыг нь бүүр чөлөөлөөд хаячихдаг. Ингээд энэ зах зээлд учир начраа олодохоо байсан шударга бус өрсөлдөөний нөхцөл үүсэх гээд байгаа юм биш үү. Энэ дээр Засгийн газар Байнгын хороон дээр засвар өөрчлөлтүүд оруулж ирж байгаа юу? Ийм 3 асуулт байна.

Л.Мөнхбаатар: Мөнх-Оргил гишүүний асуултад хэн хариулах уу? 3 асуулт асуулаа. Ажлын хэсгийн микрофоныг өгье. Өнөрбаяр дарга хариулъя.

Г.Өнөрбаяр: Засгийн газраас бол энэ төрийн зарим чиг үүргийг бол төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд бас шилжүүлэх энэ бодлого баримталж байгаа. Энэний хүрээнд бол энэ хуулийн төсөл дээр бол гадаадад ажиллах хүч гаргах энэ асуудлыг бол ялангуяа энэ иргэний нийгмийн байгууллагууд буюу мэргэжлийн холбоод, Ажил олгогч эздийн холбоо, Худалдаа аж үйлдвэрийн тэнхим гэх мэт ялангуяа энэ бизнес эрхлэлтийн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэний нийгмийн байгууллагуудаар бас эрхлүүлж болох юм гэсэн ийм байр суурьтай байгаа. Гэхдээ гадаадад энэ ажиллах хүч гаргах асуудлыг бүх байгууллагууд бол гаргана гэсэн үг бол бас биш юм. Тухайн байгууллага өөрөөр хэлбэл Засгийн газар журам гаргаад энэ зөвшөөрлийг шилжүүлж болно. Шилжүүлэхгүй ч байж болно. Энийг бол хуулиар бас нээж өгье өө гэсэн ийм агуулга томъёоллоор бас оруулж ирсэн гэдгийг бол бас танд хэлье. сая энэ хуулийн төсөл дээр орж байгаа 32.5, 32.6 хоёрыг бас нийлүүлэх тухай асуудал яригдлаа. 32.6 дээр бол энэ Монгол Улсын урт дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн өөрөөр хэлбэл баримт бичигт туссан хугацаанд гэж хэлж байгаа.

Энэ бол өөрөөр хэлбэл тодорхой бас хугацаатай байгаа энэ хугацаатай уялдуулж оруулж ирсэн бас томъёолол юм. Дээр нь нэмээд энэ Засгийн газар аль салбар дээр энэ ажлын байрны хөнгөлөлт чөлөөлөлт олгох вэ гэдэг дээр бол журмаар зохицуулаад журам дээрээ бол нарийн томъёоллуудыг бол бас оруулж өгч байгаа гэдгийг бол бас хэлье. Анхаарал тавсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Мөнх-Оргил гишүүн тодруулах уу? Мөнх-Оргил гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнх-Оргил: Ажиллах хүчний шилжилт Хөдөлгөөний тухай хуульд ерөнхийдөө ийм чиглэлээр өөрчлөлт оруулж байгааг би дэмжээд байгаа юм. Хамгийн гол нь энэ чинь эрх зүйн ойлгомжтой, тогтвортой байдал бий болох ёстой л доо. Гадаадад ажиллах хүч гаргана гэдэг чинь тийм амар асуудал биш шүү дээ. Тэр хүмүүс очоод ажиллаад цалин хөлсөө авч чадахгүй бол яах юм. Эрх нь хангагдахгүй бол яах юм. хөдөлмөрийн аюулгүй байдал нь хангагдахгүй бол яах юм Хохирчихвол яах юм. Бэртчихвэл, гэмтчихвэл яах юм гээд ямар сайндаа л энийг чинь жишээ нь Солонгостой, Засгийн газар хоорондоо хэлэлцээрийн хэмжээнд хийж байна шүү дээ. Тэгээд ийм хариуцлагатай, олон хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөртэй нь холбоотой асуудлыг ямар нэгэн хэмжээ хязгааргүйгээр хуулийн шаардлага тавихгүйгээр аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагуудад өгөөд байх нь эрсдэлтэй. Энд хязгаар байх ёстой. Жишээ нь Өнөрбаяр дарга бол энийг Засгийн газрын тогтоолоор энийг ингээд хязгаарлалчих юм гээд байгаа юм. Гэтэл энэ хуульд чинь Засгийн газрын тогтоолоор хэмжээ хязгаарыг нь зааж өгнө гэсэн юм байхгүй.

Л.Мөнхбаатар: Мөнх-Оргил гишүүний тодруулгад нэмж хариулъя. Өнөрбаяр дарга ажлын хэсэг нэмж хариулъя.

Г.Өнөрбаяр: Одоо ч гэсэн энэ Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль дээр бол энэ гадаадад ажиллах хүч гаргаж байгаа байгууллагууд дээр бол бас тодорхой хэмжээний шалгууруудтай байгаа. Өмнө нь Улсын Их Хурал бол ялангуяа энэ гаргаж өгсөн нөхцөл шаардлагуудыг бол маш тодорхой зааж өгсөн байгаа. Тухайн байгууллагуудын орлого болон бусад бүх зүйлүүдийг бол нарийвчилж зааж өгсөн. Тийм учраас энэ гадаадад ажиллах хүч гаргаж байгаа хүссэн байгууллага бол гаргах тийм боломжгүй ээ. Энэ дээр нь бол бас манай яам хяналтуудаа тавиад яваад өгнө өө гэдгийг бол бас хэлье.

Мөн энэ журам дээр бол энэ асуудлуудыг бид нар бас нэлээд нарийвчлаад хязгаарлаад өгчихсөн тийм зүйлүүд бол бас байгаа гэдгийг бол бас хэлье ээ.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Байнгын хороо Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах, үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Ингээд одоо санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хэн горимын санал гаргах юм. Жамъяангийн Мөнхбат гишүүн горимын санал гаргая.

Ж.Мөнхбат: Би нөгөө сая санал өгсөн боловч энэ будилаад нөгөө төхөөрөмж дээр жаахан алдаа гарчихлаа. Дахиж санал хурааж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Мөнхбат гишүүний гаргасан горимын саналаар саяын явуулсан санал хаалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Гишүүн анхааралтай саналаа өгөөрэй. Гишүүд санал хураалтдаа анхааралтай оролцъё. Хэн ороогүй юм. Горимын санал гаргах гишүүн байгаа юм уу? Горимын санал гаргах гишүүн байгаа юм уу? Сарангэрэл гишүүн байна. Сарангэрэл гишүүн санал гаргах уу? Горимын санал гарчихъя.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дэд даргаа сая техникийн саатлын улмаас миний санал эсрэг гарчихлаа. Уг нь би дэмжсэн юм байгаа юм. Үүнийг хүчингүй болгох санал хураалтыг дахин явуулж өгөөч гэсэн хүсэлт тавьж байна.

Л.Мөнхбаатар: Сарангэрэл гишүүний гаргасан горимын саналаар саяны санал хураалтыг хүчингүйд тооцох садруулан явуулъя.

Санал хураалт.

Гишүүд энэ санал хураалтдаа анхааралтай оролцъё оо. Засгийн газрын гишүүд Учрал гишүүн горимын санал гаргах уу? Учрал гишүүн горимын санал гаргая.

Н.Учрал: Энэ техникийн асуудал гарсан учраас дахин санал хурааж өгөх горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Учрал гишүүний гаргасан горимын саналаар саяын явуулсан санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд анхааралтай шалгаруулалтад оролцъё оо.

Санал хураалтад бэлэн байна уу? Хүчингүйд тооцох санал хураалт явууллаа. Санал хураалт.

52.5 хувиар санал хураалтыг хүчингүйд тооцох санал дэмжигдлээ. Одоо саналын томьёоллыг уншиж танилцуулсан. Үндсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт, гишүүд ээ.

Улсын Их Хурлын гишүүн Батболд горимын санал гаргая. Энэ техникийн боломжийг Их Хурлын Тамгын газрынхан бас хангаарай гишүүдийн санал хураалт эсрэг гараад байна шүү.

С.Батболд: Харин сая техникийн юу гараад миний дэмжсэн санал эсрэг гарчихлаа. Дахин санал хураалгах горимын санал гаргаж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Батболд гишүүний саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалт.

Батболд гишүүний төхөөрөмж бас сайн ажиллахгүй байгаад байна. Манай Их Хурлын Тамгын газрын Техникийн хэлтсийнхэн ирээд бас үзээд өгөөрэй. Нөгөөтээгүүр Батболд гишүүн горимын санал гаргая.

Сая дэмжсэн санал өгсөн боловч санал хураалтад оролцохгүй байгаад байна. Батболд гишүүн саналаа гаргая.

С.Батболд: Би төхөөрөмжөө нэг шалгуулчихмаар байна. 2 удаа дараалан эсрэг гараад байна. Тийм учраас энийг дахин санал хураалтын горимын санал гаргаж байна. Дээр нь энэ төхөөрөмжөө бас нэг үзүүлээд. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Манай техникийнхэн ирээд төхөөрөмжийг шалгаад орхиё. Үүний дараа санал хураалтыг явуулъя.

Батболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалтыг хүчингүйд тооцох тухай санал хураалтыг 55 хувь нь дэмжсэн байна. Уг саналыг хүчингүйд тооцлоо. Одоо түрүүн уншиж танилцуулсан саналын томьёоллоор санал

хураалт явуулъя. Үндсэн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

52.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

12.08 цаг

Дараагийнхаа асуудалд орёё.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал танилцуулна. Учрал сайдыг индэрт урж байна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2000-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр бүлэг буюу засаглалын бодлогын 4.1.2-т хүний эрхийг дээдэлсэн, цахим засаглалыг дэмжсэн технологийн аюулгүй зохистой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 82 дугаарт, ҮАБЗ-ийн 2022 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 08 дугаарт

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

зөвлөмжийн хэрэгжилтийг хангах үүднээс Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын зүгээс боловсруулан танилцуулж байна.

Технологийн хөгжилтэй зэрэгцэн бидний өдөр тутмын амьдрал цахим орчин олон нийтийн сүлжээнд өрнөх болж, худалдаа наймаагаа хийх, эрхлэх, мэдээлэл солилцох, үзэл бодлоо илэрхийлэх, хуваалцах зэрэг явдал нь ердийн үзэгдэл болж хэвшсэн байна. Технологийн дэвшил нь мэдээлэл бараа үйлчилгээ солилцоонд өндөр хурд авчирч холыг ойртуулж 2-ыг уулзуулж байгаа хэдий ч үүнийг дагасан сөрөг үр дагавар аюул эрсдэл үүсгэж байна. Цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоо хохирол асар хурдацтай өсөн нэмэгдэж байна.

Цагдаагийн байгууллагын мэдээллээр зөвхөн 2022 онд цахим орчинд үйлдэгдсэн 8563 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Ганцхан жилийн дотор цахимаар залилах гэмт хэрэг 99.8 хувиар буюу 2 дахин, алдаатай гүйлгээ андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө алдуул мал завших гэмт хэрэг 95.2 хувиар, кибер орчинд хууль бусаар халдах гэмт хэрэг 70.7 хувиар, хулгайлах гэмт хэрэг 37 хувиар, хүүхдийг садар самуунд уруу татах, бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг 18.5 дахин, бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх гэмт хэрэг 8.9 дахин өсжээ.

Энэ бүх тоо статистикийг дурдаад өнгөрөх нэг хэрэг. Нугарч өссөн тоо хэмжээ хувь бүрийн цаана Монгол хүний амьдрал, хувь заяа, амь нас, эрүүл мэнд, хүүхдийн ирээдүй насан туршид нь үл арилах сэтгэлийн шарх, гэмтэл үлдэж хоцордог оо. Зөвхөн өнгөрсөн 2022 онд цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас 19 тэрбум төгрөгийн хохирол учраад байна. Цахим гэмт хэргийн сэтгэл сэрдхийлгэм жишээнүүд бидний хажууд илхэн байна. Заримаас нь танилцуулья.

1.Иргэн С 2019 оноос цахим сүлжээ ашиглан иргэдийн интернэт банкны дансанд нэвтэрч мөнгийг шилжүүлэн авдаг гэмт хэргийг байнга амьдралын эх үүсвэрээ болгосон бөгөөд 100 гаруй удаагийн үйлдлээр 1 тэрбум төгрөгийг иргэдээс залилж авсан байна. Сэжигтнийг ЭЦГ-ынхан 2021 оны 12 дугаар сард АНУ-аас баривчилж авчирсан байна.

2.Иргэн А фэйсбүүк хаягаараа насанд хүрээгүй охидтой харилцан нүцгэн заргаа харилцан солилцож олон нийтийн сүлжээнд цацна гэж заналхийлэх замаар дахин нүцгэн зургийг нь авхуулах ёс бус бичлэг хийлгүүлэх, удаан хугацаанд харилцсан охидтой уулзаж бэлгийн харьцаанд орсон хэргийг СХД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Нийслэлийн давж заалдах шатны шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1, 13.5, 12-ын нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт тус тус зааснаар 20 жилийн хорих ял иргэн А-д оногдуулсан байна.

3.2022 оны 2 дугаар сард иргэн Э хүүхдүүд нэртэй нууц групп чат шинээр нээж насанд хүрээгүй хүүхдүүдийн садар самуун агуулсан дүрс бичлэгийг байршуулж, иргэдэд төлбөртэйгөөр үзүүлсэн хэргийг БЗД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх хэсгээр 2 жил хорих ял оногдуулсан байна.

4.Иргэн Г нь бага насны хүүхдүүдэд ихэвчлэн ашигладаг. Лайки аппликэйшнд эмэгтэй хүүхдийн профайл зурагтай хаяг үүсгэж насанд хүрээгүй охидтой үеийн охины дүрээр нь харилцаа үүсгэн дотносож, эцэг эхээс далдуур нууц яриа өрнүүлэх, садар самуун агууламж бүхий харилцаа үүсгэж нүцгэн зургийг нь авдаг байсан бөгөөд үргэлжлүүлэн манай ахтай харилц. Видео дуудлага хий. Тэр хүний хий гэснийг хий үгүй бол чиний зураг, бичлэгийг олон нийтийн сүлжээнд

цацна. Эцэг эх сургуулийн хүрээллийн хүмүүс чинь үзүүлнэ гэх зэргээр дарамталж өөрийн ашигладаг фэйсбүүк хаягаар өөр хүний дүрд тоглож хохирогч хүүхдүүддээ видео дуудлага хийж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангадаг байсан хэрэгт шүүхээс 6 жил 8 сарын хорих ял оногдуулсан.

Нийт 20 орчим хэргийн үйлдэлтэй байна.

5.Жон Ли гэх нэртэй фэйсбүүк хаягтай гадаад улсын иргэн Монгол Улсын иргэн Д-тэй 2022 оны 8 дугаар сараас эхлэн фэйсбүүк чатаар харилцаж эхэлсэн бөгөөд өөрийгөө Англи улсын иргэн эхнэрээсээ салсан, 11 настай охины хамт амьдардаг. Нэгдсэн үндэсний байгууллагын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцдог хөлсний цэрэг гэх зэргээр өөрийгөө Гүүгл транслэйт ашиглан Монгол хэлээр танилцуулан удаан хугацаанд харилцсан байна.

Аав нь Монгол Улсад амьдарч байсан Монгол эмэгтэй хүнтэй гэрлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлж иргэн Д бэлэг илгээсэн шуудангийн зардал, хил гаалийн хураамжийг түр шилжүүлж өгөхийг хүсэж, Монголд ирснийхээ дараа буцааж өгье хэмээн хууран мэхэлж, 4 удаагийн шилжүүлгээр нийт 22529 америк доллар, Кумар Охаши гэх хүний данс руу шилжүүлэн авч залилсан хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн.

Айж сүрдсэн, дарамт шахалтад өртсөн, хаана хэнд хандахаа мэдэхгүйн улмаас бүртгэлд ороогүй, гомдол гаргаагүй, хохирол нь тогтоогдоогүй гэмт хэрэг, зөрчил хэдэн арваараа биш, хэдэн мянгаараа нуугдан хоцорч үлдэж байна. Тэр хэрээр гэмт хэрэгтнүүд өөгшин амтшиж, илүү олон хүнийг хохироож байна гэсэн үг ээ. Цахим орчин дахь гэмт хэрэг огцом хурдан өсөж байхад түүнээс урьдчилан сэргийлэх шийдвэртэй тэмцэх ажил удаан байна. Хуучинсаг байна.

Шинэ орчны гэмт хэрэгтэй шинэ орчинд нь тэмцэхгүй бол хурдан

машинтай малын хулгайч нарыг мориор хөөхтэй зарчмын хувьд ялгаа байхгүй ээ. Олон талын хүчин зүйл бий ч бүгдийг нь биш үндсэн 3 гол шалтгааныг нь онцлон хөндье. Үүнд:

Нэгт, цахим орчинд хүний эрхийг хамгаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль эрх зүйн орчин байхгүй. Олон нийтийн сүлжээний талаар төрөөс баримтлах бодлого тодорхойгүй, гэмт хэрэгтэй тэмцэх хүний нөөц, техник технологийн боломж муу, уламжлалт бус орчинд гарч байгаа гэмт хэрэгтэй уламжлалт аргаар тэмцээд үр дүнгүй. Дэлгэцийн цаанаас өндөр хурдаар тархааж, өргөн олон хүнийг хамарч үндэстэн улсаар нь хохироодог нарийн заль мэх, арга технологи ашигласан гэмт хэрэгтэй өндөр хурдтай үр дүнтэй тэмцэхийг нөхцөл байдал та биднээс шаардаж байна. Технологи ашигласан гэмт хэрэгтэй технологи ашиглаж тэмцэхийг цаг үе та биднээс шаардаж байна.

Хоёрт, Хэрэглээнд өргөн хүрээнд нэвтэрсэн Фэйсбүүк гэх мэт олон нийтийн сүлжээ эрхлэгчтэй харилцан ойлголцох хамтран ажиллах нөхцөлөө тохирч чадаагүй зөрчилтэй контент гэж яг юуг хэлэх вэ? Хэрхэн тэмцэх гэдэг талаар ойлголтын эрс зөрүүтэй явж ирлээ. Монгол Улсаас янз бүрийн байгууллагууд иргэд хүний эрхэнд халдсан гэмт хэрэг өдүүлсэн мэдээллийг устгуулахаар хандахад 18 хувь буюу 5 тохиолдлыг зөвхөн нэгийг нь шийдвэрлэсэн байна. Харин ийм хуультай Европын улсуудад цахим орчинд хүний эрхийг хамгаалж чаддаг ХБНГУ-д гэхэд энэ үзүүлэлт 95 хувьтай байна. Хэн ямар байгууллага, үйлчилгээ эрхлэгчтэй харилцах, зөрчилтэй контентыг илрүүлж, нотлон мэдээлэх нь тодорхойгүй байна. Анагаах ухаанаар бол олон хүнийг хохироох, халдварт өвчинтэй тэмцэх, түргэн тусламж оношлох тусгаарлах арга хэмжээ эрс үгүйлэгдэж байна.

Гурав.Иргэдийнхээ цахим мэдлэг боловсролд анхаараагүй, зохистой

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хэрэглээг төлөвшүүлээгүй, хуурамч мэдээлэл зохион байгуулалттай, тодорхой зорилготой нөлөөллөөс өөрийгөө хамгаалах дархлаа муу зэргээс болсон байна. Эцэг эхчүүдийн 95 хувь нь хүүхдээ цахим гэнэт халдлагаас хэрхэн хамгаалахаа мэдэхгүй байна. Хүүхэд биеэрээ эцэг эх багшийнхаа хараа хяналтад хажуу дэргэд гэр орондоо байлаа ч гэсэн оюун санаа эрх чөлөөнд нь хэн ч хаанаас халдаж болдог, хил хязгаар хаалга үүдгүй шинэ орчинд бид амьдарч байна. Иймд олон нийтийн сүлжээнд хүний эрх, хууль ёсны, ашиг сонирхлыг хамгаалах, ялгаварлан гадуурхалд өртдөггүй үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхээ баталгаатай эдэлдэг байх, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

Мөн түүнчлэн олон нийтийн сүлжээнд үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчилтэй контентыг нэн яаралтай тодорхойлох, олж илрүүлэх, таслан зогсоох, цахим гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн үндсийг тодорхойлж, гэмт хэрэгтэй тэмцэх чадавхыг нэмэгдүүлэх нь энэ хуулийн үндсэн зорилго.

Эрхэм гишүүд ээ, Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулиар хүний захидал харилцааны нууцад огт халдахгүй ээ. Олон нийтийн буюу 3 ба түүнээс дээш хэрэглэгчтэй цахим сүлжээнд нийтэд хүний эрхэнд халдсан гэмт хэргийн шинж бүхий сөрөг агуулгатай контент нийтлэх, түгээх харилцаанд хамааруулж зохицуулсан. Хэрэглэгчийн эрх үүрэг, хүний эрхийг зөрчсөн гэмт хэргийн агуулга бүхий контенттой тэмцэх тогтолцоог тогтоож өглөө.

Олон нийтийн сүлжээний үйлчилгээ үзүүлж байгаа этгээд гэж хэнийг хэлэх вэ? Ямар эрх үүрэгтэй байх вэ? Зөрчилтэй контенттой холбогдуулан хэрэглэгчээс ирсэн гомдол мэдээллийг шийдвэрлэх, хэрэв Монгол Улсаас бүртгэлтэй 300000 ба түүнээс дээш тооны

хэрэглэгчтэй бол төлөөлөгчийн газар нээж ажиллуулах, хэрэглэгчийг баталгаатай утасны дугаар, цахим шуудангийн хаягаар баталгаажуулан бүртгэх, зөрчилтэй контентын талаарх олон нийттэй харилцах нэгжийн хүсэлт, шийдвэрийг хүлээн авч 7 хоногийн дотор хянан шийдвэрлэх үүрэгтэй болохыг тусгалаа. Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах нь төр дангаар хийж хүчрэх ажил биш ээ.

Тиймээс технологийн салбарын мэргэжлийн шинжээч, хүний эрхийн хамгаалагчид, судлаачид, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд, ХЭҮК-ын идэвхтэй оролцох өргөн бололцоог хуульчлан баталгаажууллаа.

Зөрчилтэй контентуудыг хянан шийдвэрлэх олон нийтийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчидтэй хамтран ажиллах нэгж байна. Хүний эрхийг зөрчсөн гэмт хэргийн шинжтэй контентыг 24 цагаар тасралтгүй илрүүлж оношлон тодорхойлж, нэн яаралтай горимоор сүлжээ эрхлэгчид нотлон мэдээлэл өгөх үүрэгтэй ажиллана. Уг нэгжийг улсын төсөвт нэг ч төгрөгийн нэмэлт зардал гаргахгүйгээр Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн бүтцэд багтаан байгуулж ажиллуулахаар хуулийн төслийг боловсрууллаа. Засгийн газрын яамд, холбогдох байгууллагуудаас саналыг авч хуулийн төсөл боловсруулах ажилд оролцоог нь хангаж ажилласан болно оо.

Түүнчлэн хувь хүний хуулиар тогтоосон алдар нэрийг хүндэтгэх зарчмыг бэхжүүлэх үүднээс Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд хүний хувийн мэдээллийг хуулийн дагуу олон нийтэд хүргэхдээ зөвхөн мэдээллийн эзэнд нь мэдэгдэл хүргэх зарчмыг баримталж нийтийн албан тушаалтан, төрийн байгууллага, хувь хүний мэдээлэлд хүндэтгэлтэй хандах, ямарваа байдлаар олон нийтийн сүлжээнд

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

дэлгэдэг зохисгүй байдлыг энэ хуулиар бүрмөсөн хориглоно оо.

Үүний эхлэл болгож Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барьж байгаа бөгөөд удаа дараа татварын зөрчил гаргасан хүний хувьд тухайн хүнд нь мэдэгдэл хүргэхгүйгээр олон нийтэд мэдээлдэг зохицуулалт байсныг энэхүү хуулийн төсөлд өөрчилж зохих зохицуулалтыг тусгалаа. Цахим шилжилтийг эрчимжүүлэхэд төрийн байгууллагуудын мэдээллийн сангийн зөрүүтэй байдал, давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, иргэдийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах нь туйлын чухал ач холбогдолтойг онцолж, төрийн цахим үйлчилгээг зохицуулахтай холбоотой хуулийн давхардал, хийдлийг арилгах 139 хуулийн нэмэлт өөрчлөлт, дүрэм журам, дата мэдээллийн түгжрэлийг тайлахаар Монгол Улсын Засгийн газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яам ажиллаж байна.

Энэхүү хуулийн төслийг дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулъя. Наранбаатар гишүүнийг индэрт урьж байна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын Дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хурлаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл төслүүдийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2013 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлээгүй бөгөөд гишүүдийн олонх дээрх хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Наранбаатар гишүүнд баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Сүхээгийн Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга Хаш-Эрдэнийн Сүрэнхорол, ХЭҮК-ын дарга Жаргалсайханы Хунан, ХЭҮК-ын гишүүн Ганбатын Нарантуяа нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна

уу? Алга байна. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Баатарбилиг гишүүн асуултаа асууя.

Ё.Баатарбилэг: Хууль их зөв хууль орж ирж байна гэж харж байна л даа. Дэмжмээр байна. Цахим орчинд хүний эрхийн асуудал бол маш олон жил яригдсан нэлээн урхагтай. Ийм асуудал болчихоод байгаа шүү дээ. Цахим орчинд Монголчууд бие биеийгээ гүтгэдэг, бие биеийгээ хэл амаар доромжилдог. Хувь, хувьсгалын янз бүрийн асуудлуудаар хувийн болон янз бүрийн нууцын хууль зөрчсөн ийм мэдээлэл постууд түгээдэг. Тэрэндээ ямар ч хариуцлага хүлээдэггүй. Тэр дотроо энэ цахим орчин дахь хүүхдийн эрхийн асуудлууд бол маш их зөрчигдөж байгаа. Томчуудын буруугаас болоод ажилтан албан тушаалтнуудын буруугаас болж хүүхдүүд хохирдог. Гэр бүлийн асуудлаас болоод хүүхдүүд хохирдог. Энэ болгон дээр хүүхдийн эрхүүд байнга зөрчигдөж байдаг. Энийг нь зохицуулсан зохицуулалт өнөөдөр байхгүй байна л даа. Зүгээр энэ хуулийг хуулийн төслийг Засгийн газраас өчигдөр өргөн бариад өнөөдөр яаралтай горимоор шууд оруулж ирж байгаад нь би жаахан эмзэглэж байна. Яагаад гэхээр Учрал сайдаа энэ хуулийн төсөлтэй чинь бид нар танилцаагүй байна.

Дөнгөж өчигдөр өргөн барьсан тэгээд ингээд ийм яаралтай гээд ийм чухал хуулийн төслийг ийм яаралтай гээд цаг хугацааны хайчинд оруулж ирээд л ингээд л Улсын Их Хурал руу Засгийн газраас ийм чухал чухал хуулиудыг цаг хугацааны хайчинд оруулж ингэж орж ирдгийг болиоч л гээд байгаа юм шүү дээ. Бид нар энэ хууль дээр чинь тодорхой танилцуулгуудыг нь аваад тодорхой судлаад энэ өнөөдөр чинь хэлэлцэх эсэхийг нь шийдэх гэж байна шүү дээ. Тэгээд яг хэлэлцэхэд ажлын хэсэг байгуулах дээрээ ийм юман дээр анхаараарай.

Энэ дотор нэг ийм юм байна. Энэ нь зөв байна, буруу байна. Миний бодлоор

бол ийм байна гээд Их Хурал, Их Хурлын гишүүд чинь байр сууриа илэрхийлээд Их Хурлаас тодорхой санаа оноонууд гаргаад ингээд явдаг. Энэ энэ юм байхгүй л энэ хууль дээр бол байхгүй л болж байна. Засгийн газар өргөн барьж байгаа сайд бол бүх бүгдийг нь бол өөрсдийнхөөрөө хамгийн сайнаар хийгээд л орж ирж байгаа. Тэр бол ойлгомжтой. Нэгэнт ингээд орж ирээд хэлэлцэх эсэхийг шийдэх гээд, ингэж байгаа учраас энийг бол дэмжээд явах байх. Тэгэхээр энэ өмнө нь Хүний эрхийг хамгаалах хууль өнгөрсөн жилийн өмнө байхаа батлагдсан байгаа байх.

Нэгдүгээрт, энэ хуультай Концепцын хувьд ямархуу байгаа юм. Энэ ХЭҮК-ын ажлын хэсгээс энэ дээр хариулт өгнө биз. Тэрийгээ бол нэлээн дотор нь детальчилж, задалж хүүхдийн эрх цахим орчин дахь энэ тэр гээд яаж байгаа болов уу.

Хоёрдугаарт, энэ сошиал орчин дахь энэ Цахим хөгжлийн яамныхан байгаа юм чинь сошиал орчин дахь энэ акаунтынхаа асуудлыг нэг мөсөн цэгцэлчхэж болохгүй байгаа юм уу. Одоо ерөөсөө энэ нэг нэрээ нуусан хуурамч ийм акаунтнуудаас л бие биеийгээ гүтгэдэг, доромжилдог, бие биеийнхээ эрхэнд халддаг ийм л юм яваад байгаа шүү дээ. Нэг хүн нэг акаунт гэдэг юм уу өөрийнхөө нэртэй тэр акаунтаас юугаа постлох нь тэр хүний эрх гээд. Тэгэхдээ ийм ийм зүйлс ингэх юм бол ингээд бусдын эрхэнд халдах юм бол ийм хууль бус юм сурталчлах юм бол ингэж буруу мэдээлэл түгээх юм бол хүн гүтгэх юм бол ийм ийм хариуцлагатай гэдэг юмаа хуульчилж өгөөд нэг хүн нэг акаунт Монгол Улсад бараг хүн амынхаа тооноос илүү олон энэ фэйсбүүкийн хэрэглэгчийн тоо болчихсон гээ биздээ. Нялх бүр өлгийтэйгүүд нь ороод хэдэн хэрэглэгч байдаг вэ фэйсбүүк дээр жишээлэхэд. Тэгээд энийгээ энэ хуулийн хүрээнд цэгцлэх юм уу, ер нь танайх цэгцлэх юм уу? Тэгээд л наад акаунт болгон чинь эзэнтэй болчих юм бол бүх юм тодорхой шүү дээ. Хүн

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

өөрийнхөө тэр нэр устай юмнаасаа юугаа постлох нь тэр. Хүний эрх байлаа гэхэд тэрүүгээр нь эргээд тэр хүний хүндээ хариуцлага тооцох юм нь хууль эрх зүйн орчин нь байж байдаг. Үндсэндээ дандаа ийм хуурамч акаунтын араас твиттер дээр, фэйсбүүк дээр балиар юмнууд явсаар байгаад өнөөдрийг хүргэчихлээ л дээ. Тэгэхээр үүн дээр сайд ямархуу байр суурьтай байгаа юм.

Л.Мөнхбаатар: Баатарбилэг гишүүний асуултад хэн хариулах вэ.

Учрал сайд хариулья.

Н.Учрал: Баатарбилэг гишүүний асуултад хариулья. Энэ 2017 онд Бямбацогт сайд Хууль зүйн сайдаар томилогдоод л энэ хуулийг боловсруулаад Засгийн газраас санал авах гээд эхэлсэн. Тухайн үед хэд хэдэн Их Хурлын гишүүн энэ хуулийн төслийг санаачилж байсан.

Ер нь бол бараг 10 гаруй хуулийн төсөл байгаа. Манай яам бол энэ бүх хуулийн төслүүдийг авч танилцаад өнгөрсөн хугацаанд ажилласан. Их Хурлын гишүүд ч гэсэн Их Хурлын дэд дарга Одонтуяа гишүүний ч хууль байна. Өнгөрсөн хугацаанд өнгөрсөн парламентын үед хүүхдийг тэдгээрийн хүмүүжилд төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээллээс хамгаалах хууль гээд л байна. Цахим орчин дахь хүүхэд хамгааллын хууль гээд л маш олон хуулийн төслүүдийг боловсруулсан.

Ингээд 17 оноос хойш энэ чинь бараг 5, 6 жил өнгөрчихлөө. Гэтэл зөвхөн өнгөрсөн онд гэхэд садар самуунд хүүхдийг уруу татах гэмт хэрэг 18.5-аар өсчихсөн. Цахим залилан бол ерөөсөө бүтэн нэг улиралд 2 дахин өсөж байгаа. Цахимаар залилах гэмт хэрэг. Энэ бол ноцтой тоо. Тэгэхдээ энэ чинь шүүхээр шийдвэрлэгдэж байгаа байдлууд болохоос биш шийдвэрлээгүй процесс бол маш их. Тэгээд хууль хяналтын байгууллагууд өөрсдөө шалгая гэхээр зөрчилтэй контентыг ялгахад төвөгтэй

байдалтай байна. Өмнөх ажлаа барахгүй байна гээд байдаг. Тэгээд цаг хугацааны явцад нөгөө гэмт хэргийн учиг нь бүр ингээд үргэлжлээд л яваад байдаг. Тийм учраас энэ хууль бол үнэхээр цаг хугацааны хайчинд байгаа юм.

Тэгэхээр энэ Их Хурлын түүхэн үүрэг байх гэж бодож байна. Ирээдүйгээ хамгаалахад олон нийтийн сүлжээнд хүүхдийн эрх, хүний эрхийг хамгаалахад. Тэгэхдээ энэ хууль бол энэ зөрчилтэй контентууд гээд ангилсан 6.1.1-6.1.11 энэ бол зөрчилтэй контент гэж үзнэ. Тэгэхдээ зөрчилтэй контентыг гаргаснаараа ямар нэгэн шүүхийн шийдвэр шиг шийдвэр гаргах тийм эрх бүхий байгууллага ч байхгүй. Гол нь контентууд дээр нь ажиллаад энэ зөрчилтэй контент гэж үзсэн бол фэйсбүүкч буюу олон нийтийн сүлжээ эрхлэгч рүү явуулна. Хууль хяналтын байгууллага руу явуулна хууль бол тэр эрүү Зөрчлийнхөө хуулиар шийдвэрлэнэ. Нөгөө фэйсбүүкийн үйлчилгээ эрхлэгч байгууллага, бусад тэр үйлчилгээ эрхлэгч байгууллага бол шаардлагатай бол түр түдгэлзүүлээд л арга хэмжээгээ авна. Фэйсбүүк компаниас бид нар статистик авахад нэг жилд 1.8 тэрбум хуурамч акаунт устгасан байгаа. Хийм л оюун ухаан ажиллуулаад. Арга нь нарийссан гэдэг шиг дүр зүсээ хувилгаад амьд хүн шиг янз бүрийн истори хийж амилуулдаг. Фэйсбүүк хөгжүүлэгч нар хүртэл бий болчихсон.

Тэгэхээр энэ хууль бол улс төрчдийг хамгаалах хууль биш. Энэ бол монголын ирээдүйг хамгаалах, хүний эрхийг хамгаалах хууль гэж бодож байгаа. Тийм учраас энэ хуулийг дагалдуулаад ямар нэгэн Эрүү, Зөрчлийн хууль, хэвлэлийн эрх чөлөөний хууль ямар нэгэн хууль ороогүй. Энэ бол зөрчилтэй контентын арга хэмжээ авах, Монгол Улс үйлчилгээ үзүүлэгчтэй харилцах нэг сувагтай болох ийм зохицуулалтыг хийж байгаа хуулиа. Тэгэхээр илүү гадаад харилцааны чиглэл буюу хууль батлуулсны дараа манай дотоодын хууль тогтоомжийг мөрдөөч гэж олон нийтийн

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

үйлчилгээ эрхлэгч нар хамтран ажиллах гэж байгаа юм. Ажлын хэсгээс тэр саяын тайлбар.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгээс Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүний асуултад нэмж хариулья. Энэ ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье. Нэр албан тушаалаа танилцуулаад, асуултад хариулаарай.

С.Тэнгис: Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Тэнгис байна. Баатарбилэг гишүүний асуусан 2 дахь асуултад тодруулга өгье. Хуурамч хаягийн асуудал бол дэлхий даяар л асуудал болчихсон. Олон нийтийн бүх сүлжээнд хуурамч хаягийн асуудлыг бол үнэндээ дэлхий даяараа л тасралтгүй байнгын тэмцэж хаасаар байгаа. Фэйсбүүкийн өөрийнх нь рефорт олон нийтэд ил байдаг. transparency.face, Датаком гээд. Энэ дээр бол зөвхөн 2022 оны 3 дугаар улирлын байдлаар 1.5 тэрбум хуурамч хаягийг зөвхөн фэйсбүүк өөрөө хаасан. Тэгэхээр энэ бол тасралтгүй явагддаг ажиллагаа. Нөгөө талаасаа фэйсбүүкийн өөрийнх нь бас баримталдаг зарчим бол бас нэг тодорхой хэмжээгээр хүнийг нөгөө тодорхойлох боломжгүй байдлаар бас тэгж яахыг бас ингээд өөрөө бодлогоор бас зөвшөөрөөд байгаа юм.

Тэгэхдээ мэдээж хуурамч хаягаар янз бүрийн зохисгүй агуулга, контент гарах юм бол фэйсбүүк бусад бодлогоороо бол энэ контентыг бол хаах, хязгаарлах, хэрэглэгчээс нь рефорт авах. Холбогдох Ногоон сувгийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд бас хүсэлтийг нь авч шийдвэрлэдэг. Тэр процессыг бол энэ хуульд бол албан ёсоор хуульчилж өгч байгаа. Нөгөө талаасаа Монгол Улсын хувьд бол бид нар хэрэглэгчийн үйлчилгээ дээр хэрэглэгчийг утасны дугаар болон эсвэл цахим шуудангийн хаягаар нь баталгаажуулан бүртгэх гэдэг бас тийм үүргийг бас хүлээлгэж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Баатарбилэг гишүүний асуултад ХЭҮК-ын дарга

Хунан хариулья. Ажлын хэсгийн 82 дугаар микрофоны өгье.

Ж.Хунан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Тэгээд Баатарбилэг гишүүний асуултад хариулья.

Энэ цахим сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хууль маань бол Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуультай бол давхардсан зүйл бол байхгүй байгаа. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль бол хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа иргэнийг хамгаалах ийм асуудлыг зохицуулж байгаа ийм хууль байгаа.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах хэрэгцээ шаардлага байгаа юу гэвэл байгаа. Хүний эрхийн маш олон зөрчил олон нийтийн сүлжээнд гарч байна. Олон нийтийн сүлжээг ашиглаж бол хийгдэж байгаа. Энэ дээр бол яах аргагүй зохих арга хэмжээг авах. Ийм хэрэгцээ шаардлага бол байгаа. Энэ хуулийн хувьд бол энэ олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн хувьд бол ХЭҮК бол нэг дэх өдөр энэ хуулийн төслийг бол хүлээж авсан байгаа. Энэ маань бол бас хангалттай хугацаа бол биш.

Тийм учраас бол энийг бол бас илүү нарийн шинжилж судлах ийм шаардлага байгаа. Ингэсний ард бол албан ёсоор байр суурь саналыг өгөх нь зүйтэй юм. Тэгэхдээ одоо энэ хуулийн төсөлтэй танилцаад анхаарал татсан бол хэд хэдэн асуудал байгааг бол хэлэх нь зүйтэй байх. Нэгт гэвэл энэ Хүний эрхийг мэдээж хэрэг хангах хамгаалах энэ чиг үүргийг бол энэ холбогдох байгууллагууд бодит амьдрал дээр хэрэгжүүлэхээс гадна цахим орчинд нь бол бас хамаарч байгаа гэж ойлгоно оо. Тэгэхээр бол тусдаа бас яг хууль гаргаснаараа энэ цахим орчин дахь энэ хүний эрхийг хамгаалах чиг үүрэг нь бол баталгаажна бэхэжнэ гэдэг нь бол бас эргэлзээтэй асуудал.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тийм учраас энэ хуулийн хэрэгцээ шаардлагыг бол бас дахиж харах хэрэгтэй. Нарийн судалгаа, шинжилгээнд бол үндэслэх хэрэгтэй.

Дээрээс нь энийг дагаж гарч байгаа хуулиудыг бол бас нарийн үзэх ийм шаардлага байгаа. Тэгэхгүй бол хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бол хумигдах боогдох, дээрээс нь хүний хувийн мэдээлэл бас алдагдах ийм эрсдэлийг дагуулсан энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт явж байгаа гэдгийг бас хэлье ээ.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн тодруулж асууя.

Ё.Баатарбилэг: Тэгэхээр одоо өнөөдөр ингээд хэлэлцэх эсэх асуудал шийдэгдээд ажлын хэсэг гараад Их Хурал дээр нэлээн сайн ажиллах байх гэж би ойлгож байгаа шүү дээ. Саяын хүн шиг нөгөө анхны хэлэлцүүлгээр ингээд яаралтай горим энэ тэрээр батлаад ингээд явна гэвэл буруудна. Хүний эрхийн комиссынхон хүртэл ярьж байна. Дотор нь анхаарах асуудлууд байна гэж. Тэгээд сайд өөрөө хэллээ. Цахим орчин дахь энэ зөрчилтэй асуудал контент зөрчилтэй энэ юмнууд дээр бол нэлээн анхаарч байх тийм хууль юм байгаа юм.

Тэгэхээр ерөөсөө энэ зөрчлийн чинь уг урхаг нь нөгөө л хуурамч акаунтын асуудал байхгүй юу. Тэгэхээр одоо ерөөсөө энэ Засгийн газраас нэгэнт энэ хариуцсан яам байгаа юм чинь энэ хуурамч акаунт хуурамч гишүүн болгонтой энэ бодитоор нь яаж тэмцэж үр дүнд хүрэх вэ гэдэг рүү л гол анхаарлаа хандуулаад явах шаардлагатай байгаад байгаа юм л даа. Миний ойлгож байгаагаар Герман болон Европын зарим орнууд нэлээн сайн хуультай болчихсон юм гэнэ лээ. Ер нь хуурамч акаунтны асуудлыг нэлээн чангатгасан гэх зэргээр энэ хуурамч акаунтыг л нэг цэгцлэх ёстой.

Л.Мөнхбаатар: Баатарбилэг гишүүний тодруулгад нэмж хариулъя. Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Баатарбилэг гишүүний асуулгад хариулъя.

Анхааралтай ажигласаар ажлын хэсэг ажилласаар яг 6 жилийн нүүр үзлээ. Тэгэхээр анхааралтай ажиглах ажлын хэсэг ажиллах хугацаа бол шаардлагагүй байх. Одоо бол хуулиа л баталбал батлах ёстой. Үгүй бол 7975 хэргээс яах вэ тэр бол Их Хурал яриад шийднэ. Зүгээр би саналаа л хэлж байна. 7975 хэргийн бүртгэлт хийгдсэнээс 4552 нь л шийдэгдсэн байгаа байхгүй юу одоо. Тэгээд одоо яг нөхцөл байдлыг би хэлье л дээ. Жишээ нь яг хуурамч акаунт гэмт хэрэгтэй холбогдуулаад мэдээлэл явууллаа гэхэд жишээ нь Харилцаа холбооны зохицуулах хороо нэг хэлтсийн дарга мэйл бичдэг. Харилцаа холбооны зохицуулах хороо нэг мэйл бичдэг юм байна. Цагдаа нэг мэйл бичдэг юм байна. Ингээд Хууль зүйн яам нэг мэйл бичдэг юм байна. ХЭҮК нэг мэйл бичдэг юм байна. Дахиад нөгөө олон улсын факт чек, мек гээд байгууллагууд бичдэг юм байна. Тэгэнгүүт Фэйсбүүкийн тэр албан ёсны төлөөлөгч нартай уулзахаар яг хэнтэй харилцах юм бэ? Бид мэдэхгүй байна гээд гэдгээ хэлдэг. Тэгэхээр суугаа эхэлж ямар ч гэсэн ойлгомжтой болгоод манай дотоодын хуулиараа та нар баталгаажсан мэйл утасны дугаараараа хийж өгөөч гэдгийг хүсэлт тавих нэг асуудал байгаа юм.

Дээрээс нь Төлөөлөгчийн газраа байгууллаа гээд дотоодын хуультай болчихсон гэдгээ үүний дараа хүсэлт тавих нэг ажил бол байгаа. Ингээд Төлөөлөгчийн газраараа дамжуулаад албан ёсны сувгаараа дамжуулаад энэ хуурамч акаунт, зөрчилтэй контентууд дээр ажиллаж ингээд илүү нэг жоохон хурдан хугацаанд ажиллахгүй бол болохгүй байна гэдэг утгаараа л нөгөө өнгөрсөн хугацаанд 6 жил ажилласан хуулиудыг нийлүүлээд сайн ажиллаад л

ингээд л нэг боломжоороо л өргөн барьсан. Тэгээд Их Хурлаараа л мэдээж шийднэ л дээ.

Ер нь бол их л цаг хугацааны хувьд бас давчуу байсан шүү. Бас яаралтай ажиллах ёстой байх л гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Баатарбилэг гишүүн тодруулах юм уу? Баатарбилэг гишүүн тодруулж асууя 1 минут.

Ё.Баатарбилэг: Үгүй ээ. Би энэ хуулийн төслийг батлах нь зүйтэй л гэж байгаа юм. Хэлэлцэхийг дэмжиж байгаа. Их Хурал дээр дөнгөж орж ирж байгаа учраас Их Хурал дээр энэ орж ирж байгаа хуулийн төслийг тал талаас нь маш сайн ярих ёстой юм байна шүү. Сая ХЭҮК-ынхон хүртэл нэг дэх өдөр авсан дотор нь хэд хэдэн анхаарах асуудлууд байна гээд ярьж байгаа учраас энэ хуулийн төслийг Их Хурлаар батлан гаргал Их Хурал дээр бол ажлын хэсэг байгуулагдах байх. Нэлээн тал талаас нь сайн ярих байх гэдэг агуулгаар энийг бол нэлээн сайн ярих ёстой шүү гэж ийм агуулгаар хэлсэн. Сайд болохоор 6, 7 жил ажилласан. Ер нь бол хангалттай ажиллачихсан бид нар бол ер нь. Тэгээд Их Хурал хурдан баталж өг гэдэг маягаар. Ингэж ярих юм бол наадах чинь бол асуудал. Ямар хууль орж ирчхээд бид нарыг хүчиндэж шахаад байгаа юм. Юу гэсэн үг юм. Их Хурал бүрэн эрхийнхээ хүрээнд тэгээд л баталбал батлаад л явна шүү дээ. Тэрнээс бид нар 6 жил ажиллачихсан хангалттай зүгээр Их Хурал дуугүй батал гэж ингэж ярьж байгаа ямар ёс зүй, зарчим байна аа? Сайдад өөрт нь.

Л.Мөнхбаатар: Энэ олон нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулах хэлэлцүүлэх мөн энэ хууль батлагдан гарсны дараа хэрэгжилтэд хяналт тавих нэг чухал байгууллага бол энэ Харилцаа холбооны зохицуулах хороо байгаа. Энэ Харилцаа холбооны зохицуулах хорооноос хүн байгаа юу? Ажлын хэсэгт нэмж дуудаж оролцуулаарай. Учрал сайд

Дараагийн хэлэлцүүлэг болон энэ Байнгын хороодоор хэлэлцэх үед Харилцаа холбооны зохицуулах хорооны холбогдох албан тушаалтнуудыг байлцуулна шүү.

Цэндийн Мөнх-Оргил гишүүн асуулт асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Ийм хууль батлагдах ёстой.

Тэгэхдээ ингэж шуурахгүй ээ, Учрал гишүүн ээ. 18-ны үдээс хойш өргөн бариад 19-ний өглөө Байнгын хороогоор хэлэлцүүлээд 19-ний үдээс хойш нэгдсэн хуралдаанаар оруулаад тэгээд 20-ны өдөр энэ хууль батлуулна гэж зарчимгүй юм ярихгүй шүү. 6 жил Засгийн газар ажилласан байж болно оо. Тэгэхдээ хууль баталдаг байгууллага чинь энэ Их Хурал сууж байна. Их хурал сууж байна. Их Хурлын гишүүдэд өргөн барьсныг хурдан батал, цаана чинь гэмт хэрэг болохоо байлаа. Та нар ер нь Засгийн газрын өргөн барьсныг л батлах ажилгүй гэсэн маягтай юм яриад даналзаад суугаад байж таарахгүй шүү. Хөл нь хаана байгаа юм. Толгой нь хаана байгаа юм. Учир начраа олмоор байна шүү. Их Хурал гэж энэ тусдаа байгууллага байна. Засгийн газар тусдаа байгууллага байна. Институт хоорондынхоо харилцааны онцлогийг хуулиар олгогдсон эрхийнхээ ялгааг сайн гаргаарай, нэгдүгээрт.

Хоёрдугаарт хэлэлцэх эсэхийг нь дэмжлээ өнөөдөр гэж бодоход. Ажлын хэсэг гараад хүний эрхийн комиссынхныг оруулаад зохицуулах хорооныхныг дуудаад хуулийн төсөл өргөн барьсан гишүүдийг бүгдийг нь оролцуулаад хаврын чуулганаар энэ хуулийг батлах хэрэгтэй.

Тэрнээс биш 24 цагийн дотор ийм нийгмийн харилцааны өргөн утгатай олон үр дагавартай. Учир начиртай хуулийг Засгийн газар 6 жил бид нар хэлэлцчихсэн юм та нар батал гэдэг шахалтаар баталж болохгүй ээ.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Гуравдугаарт, миний бодлоор бол Засгийн газар энэ хуулийг өргөн барихдаа Учрал сайд биш Нямбаатар сайд өргөн барих ёстой юмаа. Яагаад гэвэл явсаар байгаад энэ хүний эрхийн асуудал ярьж байгаа байхгүй юу. Эрх зүйн асуудал ярьж байгаа юм. Тэрнээс техник технологийн асуудал энд ерөөсөө яригдаагүй. Хэнд ямар эрх өгөх юм. Хэний эрхийг яаж хасах юм. Хэн ямар эрх үүрэгтэй байх юм. Хууль хяналтын байгууллага тэр кибер аюулгүй байдлын байгууллага чинь юу хийх юм гэдэг чинь дандаа хүний эрхийн асуудлууд явж байгаа байхгүй юу.

Дөрөвдүгээрт гишүүдээ энэ ийм асуудал байгаа юм. Цахим сүлжээнд хүний эрхийг хамгаалах асуудал маш чухал. Тэрийг бид нар бүгд ойлгож байна, гэмт хэрэг үйлдэгдээд байна тэрийг таслан зогсоох ёстой. Тэгэхдээ нөгөө талдаа энэ чинь хүн үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үгээ хэлэх, хэвлэн нийтлэх хүний үндсэн эрх гээд Үндсэн хуулийн 16.16-д чинь заачихсан байгаа байхгүй юу. Энэ хоёрын тэнцвэрийг олох асуудал байхгүй юу даа. Тэнцвэрийг нь балансжуулах асуудал. Энийг олно гэдэг чинь өөрөө маш их нарийн одоо зөвхөн кибер аюулгүй байдлын асуудал яриад технологийн аргаар шийдээд, эсвэл 300000 хэрэглэгчтэй болчихвол төлөөлөгчийн газар нь Монгол Улсад байгуулаад явчихдаг асуудал биш ээ. Таны сая яриад байгаа юм Учрал гишүүнээ Засгийн газар зохион байгуулаад хийхэд бүр шаардлагатай бол Засгийн газрынхаа шийдвэрээр шийдчихээр асуудлууд байгаа байхгүй юу. Тэрийг заавал ч үгүй хууль байж байж л ийм ажил бид нар хийнэ гэж ярих чинь бас учир дутагдалтай байна.

Тийм учраас хэлэлцье, хэлэлцэх эсэхийг нь дэмжье. Ажлын хэсгээ байгуулъя. Хаврын чуулганаар яаравчлан баталъя, шуурахгүйгээр. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Мөнх-Оргил гишүүний асуултад Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя.

Тэгээд би яах вэ өнгөрсөн хугацаанд олон хууль байсан. Тэгээд хооронд нь харьцуулаад бас нэлээн судалгаа хийж байгаад оруулж ирлээ. Тэгээд та бүхэн мэдээж Их Хурал дээр ажлын хэсэг байгуулаад тэгээд хэлэлцээд зохих журмынхаа дагуу бол шийднэ. Мэдээж Их Хурлын эрх. Зүгээр өнгөрсөн хугацаанд бол бид нар бас нөгөө боловсруулж яг өргөн барихад бол маш их цаг хугацаа бас алдсан байна гэдгийг л өнөөдрийн энэ цахим орчинд үйлдэгдэж байгаа гэмт хэргүүдийн статистикаас хараад байгаа юм л даа. Тэгэхээр цаг хугацааны хувьд бол бас аль аль талдаа хурдан ажиллаж батлах нь бол нийгмийн хэрэгцээ шаардлага мөн байна гэвэл мөн байна гэдгийг бас та бүхэн бас анхаарч үзсэн биз дээ гэж хэлмээр байна.

Тэр зөрчилтэй контентууд дээр бол ямар нэгэн хүний үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхэнд бол халдах ямар нэгэн зохицуулалтыг огт хийгээгүй. Та бүхэн бас энэ хуулийн төсөлтэй танилцвал яг 6.1.1-6.1.12 хүртэлх яг тодорхой заалтуудыг бол оруулсан. Жишээ нь шууд цахим сүлжээ ашиглан залилсан бол хүүхдийн бие махбодь, оюун санаа ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж дарамт үзүүлсэн, хүчирхийлэл, садар самууныг уриалсан, сурталчилсан мансуурах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг уриалсан экстермист үйл ажиллагаа явуулах үндэсний эв нэгдлийг бусниулахад саад учруулж турхирсан, уриалсан цахим гадуурхал бий болгосон, оюуны өмчийн эрхийн зөрчилтэй бол гэмт хэрэг зөрчлийг үйлдлийг нарийвчлан зааварчилж эсвэл гэмт хэрэг зөрчил үйлдэхийг өдөөн турхирсан ч гэдэг юм уу. Ингээд шууд заачихсан.

Тэгэхээр яг эд нар л бол зөрчилтэй контент. Тэрнээс биш эрүүгийнхээ нөгөө Зөрчлийнхөө хуулиараа гэмт хэргийн шинжтэй байх юм бол хууль хяналтын байгууллага өөрөө л шийдвэрлээд явна.

Энэ хууль гарснаараа бол зүгээр зөрчилтэй контент дээр нь мэргэжлийн шинжээч нар ажиллаад л энэ зөрчилтэй байна гээд эрх бүхий байгууллагад шилжүүлнэ. Тэгээд тэр байгууллага шийдвэрлэнэ, олон нийтийн үйлчилгээ үзүүлэгч нарт хүргэнэ.

Дээрээс нь энэ фэйсбүүк орчин дээр нөгөө редакцтай мөртөө үйл ажиллагаа явуулдаг хэвлэл мэдээллийн сайтууд жишээ нь албан ёсны пэйжтэй байдаг. Зарим нь болохоор нэг хоёрхон хүнтэй эсвэл хуурамч пэйжтэй олон дагагчтай. Тэгээд янз бүрийн мэдээлэл тавиад садар зам руу сурталчилсан ч юм уу ямар нэгэн нийгмийн эмх замбараагүй байдал, өдөөн турхирсан ч юм уу янз бүрийн юмыг аваачаад спонсорлоод ингээд түгээчихдэг. Энийг ялгая гэдгийг хэвлэл мэдээллийн байгууллагыг хүртэл хэлээд байгаа юм. Тийм учраас тэр рефайд гэдгийг энэ бол редакцтай ингээд рефайд албан ёсны пэйж юм. Энэний чинь ард хариуцах редакц нь байна гэдгийг ялгаж өг өө гэдгийг хэвлэл мэдээллийн байгууллагууд хүртэл хэлж байгаа юм.

Тэгэхээр энэ хууль бол хэвлэлийн эрх чөлөөнд ерөөсөө халдахгүй. Энэ бол ерөөсөө хэвлэл мэдээлэлтэй холбоо байхгүй. Дээрээс нь эрүү, зөрчлийн ч хууль биш. Монгол Улс нэг сувагтай болъё. Олон нийтийн үйлчилгээ үзүүлэгч нар үүгээрээ дамжаад редакцтай редакцгүйгээр хэвлэл мэдээлэлдээ хүртэл бид нар хүндэтгэлтэй хандъя.

Дээрээс нь төр иргэний мэдээллийг мэдэгдэл хүргэж зөвшөөрснөөр л олон нийтэд мэдээлэхгүй бол сүүлийн үед бол өнөөдөр жишээ нь нөгөө татварын хууль дээр татварын удаа дараа зөрчил.

Л.Мөнхбаатар: Нямбаатар сайд нэмж хариулъя.

Л.Мөнхбаатар: Баярлалаа. Сая бас гишүүдийн хэлж байгаа шүүмжлэлийг зөв гэж ойлгож байна аа? Тийм. Бид нар энэ өнгөрсөн жил цахимын багц хуулиа

батлаад ингээд цахим ямаа байгуулаад цахим эрх зүйн орчин дахь бид нар алдаатай цоорхой дутагдалтай талуудаа яг өнөөдөр ингээд тод харагдаж байгаа юм. Сая тэр юутай хүүхдийн мөнгөний олголттой холбоотой асуудлууд дээр дундын мэдээллийн санг хэрхэн хуваалцах вэ гэдэг асуудал хүртэл өнөөдөр бид нар техникийн хувьд том шийдлүүдээ хийж чадаагүй байна.

Бид нар өөрсдөө цахимтай харьцах харилцаан дээрээ бид нар бас өөрсдөө тодорхой зохицуулалтуудыг хийх зайлшгүй шаардлага байгаа юм. Тэгээд сая Учрал гишүүн чи сайд ч хэллээ. Мөнх-Оргил гишүүний хэлдэг түмэн зөв. Энэ дээр ямар нэгэн хүний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх асуудлыг филтердэх тухай ойлголт огт байхгүй. Одоо Монгол Улсад нийт үйлдэгдэж байгаа гэмт хэргийн 33-аас дээш хувийг цахим орчинд үйлдэгдэж байна. Бэлгийн хүчирхийлэл, насанд хүрээгүй хүүхдүүдийг нөгөө сошиал бүлийтэх, цахим залилан, хуучин өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг нийт гэмт хэргийн 30-аас дээш хувийг эзэлдэг байсан бол өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг буюу хулгайн гэмт хэргийн урд талд нь цахим гэмт хэрэг орж ирж байгаа юм.

Цахим орчин дахь биеэ үнэлэлт, садар самууныг сурталчлах энэ асуудлуудыг бид нар цэгцэлж авахгүй бол болохгүй байгаа учраас цахим яам энэ харьяаллын дагуу энэ цахим орчинд Хүний эрхийг хамгаалах хуулийг Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр боловсрогдож байсан хуулийг шилжүүлж аваад тэгээд холбогдох байгууллагуудтай хамтраад дундаасаа ажлын хэсэг гараад ажилласан юм. Тийм учраас Мөнх-Оргил гишүүний Баатарбилэг гишүүний хэлж байгаа зөвөө. Бид нар Их Хурлын хууль тогтоох эрхэнд тулгалт хийх ямар ч Засгийн газарт эрх байхгүй.

Тийм учраас бид нар хүлээж аваад хэлэлцэх эсэхээ шийдээд хэдүүлээ богино хугацаанд ч гэсэн ажлын хэсэг гаргаад, ажиллаад, ХЭҮК-ынхоо гаргаж байгаа

саналуудыг оруулаад тэгээд энэ хуулиа баталъя гэдэг ийм л саналыг би гишүүддээ гаргах гэсэн юм. Мөнх-Оргил гишүүн ээ. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань бас эргэж хараач ээ. Бид нар бас 2 дугаар сард энэ социал платформуудын хамгийн том нь болох Фэйсбүүк группийн Ази Номхон далайн бүсийн удирдлагууд хуулийн баг, техникийн багтайгаа ирж. Ийм эрх зүйн орчин үүссэн тохиолдолд бид нар хамтарч ажиллахад бэлэн байна гэдгээ илэрхийлсэн. Бид нартай уулзаад явсан. Эргээд нөгөө дараагийнхаа багийг авчирч энэ цахим орчинд тодорхой хэмжээний ийм эрх зүйн эсрэг чиглэсэн үйлдлүүдийг хяная гэж байгаа юм.

Тэрнээс биш гишүүдийн эмзэглэж байгаа шиг үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг ерөөсөө хонох тухай ойлголт нэг ч байхгүй ээ. Ер нь бол энэ нь өөрөө фэйсбүүк энэ твиттер бусад энэ платформууд бол өөрөө энэ ардчилал хүний эрхийн хамгийн том бас баталгаа гэдэг дээр санал нэг байгаа.

Л.Мөнхбаатар: Энхбаярын Батшугар гишүүн асуултаа асууя.

Э.Батшугар: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Энэ хуулийг дэмжиж байгаа юм. Үнэхээр цаг үеэ олсон хууль гэж бодож байна. Өнөөдөр бол техник технологи хөгжөөд маш хурдтай хөгжиж байна. Тэгээд үүнийг дагаад цахим гэмт хэрэг ч гэсэн яг адилхан бүр ч илүү хурдан хөгжиж байна. 2021 оны тоогоор бол нийт дэлхий даяар бол 7 триллион долларын цагийн гэмт хэрэг үйлдсэн байна. 7 триллион доллар гэдэг чинь бол нэг ёсны Герман болон Япон улсын нийт ДНБ-ийг нийлүүлсэнтэй адилхан тоо. Монголд бол яах вэ өнөөдрийн байдлаар бол 19 тэрбум төгрөг гэж ярьж байна. Энэ бол зүгээр л эхлэл шүү. Харин дан санхүүгийн гэмт хэргээс гадна садар самууг сурталчлах дээрээс нь нэмээд социал бүли хийх гэх мэтчилэн Гэмт хэрэг маш их гарч байгаа

юм. Энийг бол ямар нэгэн байдлаар мөнгөөр хэмжих тийм зүйл байхгүй хэцүү.

Дээрээс нь нэмээд Монгол Улсын нийт идэвхтэй интернэтийн хэрэглэгч нь бол 70 хувьтай байна. Бүгдээрээ л дийлэнхээр мобайл банкиг ашиглаж байна. Энэ бол зүгээр л Монгол Улсад санхүүгийн гэмт хэрэгт өртөх эмзэг байдал нь харагдаад байгаа юм. Цахим санхүүгийн гэмт хэрэгт өртөх.

Дээрээс дан санхүү садар самуун өгөхгүй. Гадаадын тусгай албанууд бол энэ социал медиаг ашиглаж өөрсдийнхөө улс орныхоо үзэл бодлыг илэрхийлж янз янзын байдлаар бол нөлөөлдөг нь бол бас нууц биш ээ. Энэ бол гэмт хэрэг маш их явж байгаа. Дэлхий даяар өнөөдрийн хувьд? Мөн та бүхэн мэдэж байгаа бол Кембриж аналитик гээд компани байгаа байсан. 2018 онд татан буугдаад удирдлагууд нь бүгдээрээ шоронд орсон. Энэ компани Англид бүртгэлтэй компани бол ер шууд гадаад улсын сонгуульд мөнгөөр нөлөөлдөг компани байсан. Энэ бол олон улсын ардчилал, хүний эрх болон шууд сонгуульд нөлөөлдөг байдал нь бол гэмт хэрэг гэж дүгнэгдээд. Тэгээд удирдлага нь шоронд ороод удирдлагууд нь шоронд ороод компани татан буугдсан. Тэгэхээр бол энэ хууль яалт ч үгүй цаг үеэ олсон хууль гэж ярьж байгаа юм. Тэгэхээр 2 асуулт байна. Эхний асуулт нь бол 7.1.7-д зөрчилтэй контент илэрсэн үед 7 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ гэж байна. Энэ 7 хоногт чинь бас харьцангуй бага тоо. Их тоо биш шүү? Яагаад гэвэл олон фолловертой пэйж дээр бол тодорхой хэмжээний социал, булими гэх мэтчилэн контент гарангуут маш олон шэйр болон хүмүүс үзэж боломжтой. Тэгээд 7 хоногтоо энийг нь засна гэдэг чинь бол хэдэн мянган хүн үзчихсэн юмыг чинь эргэж засахад бол бас ялангуяа хүний эрхэнд халдсан асуудал дээр бол маш эмзэг асуудал яригдаж байгаа юм. Наад захын гэхэд л бол яг бодит амьдралын кэйс ярья. манай нэг таньдаг хүний 10 жилийн охиныг ангийнх нь бүли

хийх гээд фэйсбүүк дээр зургийг нь тавиад энэ охин биеэ үнэлдэг охин гээд тавьчихаж байгаа юм. Тэгээд нөгөөдөх нь устгуулсаар байгаад маш олон хоног алдаад, тэгээд сургууль даяар эд буруу ойлголт үүсчээд тэр охинд. Тэгээд тэр охин яах юм сургуулиа солихоос өөр аргагүй болсон. Яагаад гэвэл сургууль даяар хэчнээн засаж залруулсан мэдээлэл гаргасан ч гэсэн тэгээд л бүгдээрээ муу муухайгаар дуудагдаад шоглогдоод явчхаж байгаа юм. Үүн дээр нь асуулт асууя.

2 дахь асуулт бол ямар нэгэн асуудал гарвал урьдчилан сэргийлэх нь хамгийн чухал байдаг. Сошиал дээр байна уу, гэмт хэрэг байна уу, эрүүл мэнд байна уу гэх мэтчилэн. Тэгэхээр үүнтэй холбогдуулан яг буруу аль эсвэл садар самууг хүн гүтгэсэн хүний эрхэнд халдсан контент гаргахаа бас урьдчилан сэргийлэх нь хамгийн зүйтэй л дээ.

Тэгэхээр яалт ч үгүй үүнтэй холбогдон нөгөө нэг тролл ярих нь зөв. Тэгэхээр бид нар бол яг троллыг урьдчилан сэргийлээд болиулах, аль эсвэл нэг хүн дээр үүсгэсэн маш олон тийм нэр дээр үүссэн акаунтыг устгах тийм бололцоо боломж нь энэ хууль батлагдсанаар хир зэрэг амжилттай үйл ажиллагаанд гаргах вэ? Жишээлбэл би өөр дээрээ ярихад бол миний нэр дээр маш олон хуурамч акаунт твиттер дээр болоод фэйсбүүк дээр үүсгээд тэгээд хүн гүтгэсэн.

Л.Мөнхбаатар: Батсуурь гишүүний асуултад Учрал сайд хариулья.

Дараа нь Батшугар гишүүн тодруулаад асуучих. Учрал сайд хариулья.

Л.Мөнхбаатар: Батшугар гишүүний асуултад хариулья. Энэ 7.1.7 бол нөгөө зөрчилтэй контентын талаарх хүсэлтийг 7 хоногийн дотор хянан шийдвэрлэх нь бол үйлчилгээ эрхлэгчийн үүрэг. Тэгэхээр үйлчилгээ эрхлэгч гэдэг

бол бидний нэрлэж байгаагаар бол нөгөө фэйсбүүк, твиттер, инстаграмм гэдэг шиг олон нийтийн үйлчилгээ үзүүлэгч нар нэг ёсондоо бол 10.2 дээр болохоор тэр олон нийтийн харилцах нэгжийн 72 цагт хянан шийдвэрлэнэ. Монголд байгаа нэгж рүү нь явуулахад 72 цагт хянан шийдвэрлээд тэднийхээс тэр олон нийтийн сүлжээ үйлчилгээ эрхлэгч нар руугаа хүсэлтийг явуулаад хууль хяналтын байгууллага руу явуулаад тэр олон улсад итгэмжлэгдсэн пак чек шиг байгууллага руу ногоон суваг руу нь явуулаад. Нөгөө үйлчилгээ эрхлэгч буюу тэр олон улсад байгаа үйлчилгээ эрхлэгч байгууллагыг бид нар бас нөгөө үүрэгжүүлээд хуулиараа өгч байгаа учраас харилцаа хамтын ажиллагаагаа гэрээ хэлцэл хийж баталгаажуулахдаа тэр байгууллагаас явуулсан хүсэлтийг хурдан хугацаанд шийдвэрлэ гэдгийг тавьж өгснөөс энэ нөгөө Монгол дахь асуудал биш. Монголдоо бол тэр олон нийттэй харилцах нэгж бол хугацаа маш богино, 72 цаг дотор хянан шийдвэрлэнэ. 24 цаг ажиллах ёстой гэж байгаа.

Тэгээд кибер халдлага бол бас нэмэгдэж байгаа манай улсад. Тэгэхээр кибер халдлага яг яагаад энд ингээд холбоод байгаа вэ гэхээр кибер халдлага бол 80 хувь нь сошиалаар дамжиж сошиал инженеринг хийдэг юм байна. Тэгэхээр Кибер халдлагатай тэмцэх нийтийн төвийг та бүхний баталсан Кибер аюулгүй байдлын хуулиар баталсан. Энэ паблик төвийнхөө дэргэд дотор нь ийм олон нийттэй харилцах нэгж байгаа юм.

2 дахь асуулт болохоор ер нь энэ манай нэг хуурамч акаунтуудыг хүний нэр дээр би жишээ нь твиттер орчинд байхгүй гэхэд миний акаунт маш их байна шүү дээ. Тэгэхээр тэр акаунтуудыг яаж цэгцлэх вэ гэхээр жишээ нь албажуулах ёстой. Батшугар гишүүний верифайд энэ хуудас ганцхан байх ёстой. Бусдыг нь түдгэлзүүлэх саналыг нь олон нийттэй харилцах нэгж явуулж байж цэгцэлж өгнө. Одоо болохоор тэр верифайд хүсэлтийг Монгол Улс нэг сувгаар ярьдаггүй гэдэг. Фэйсбүүк компани бол

жишээ нь одоо нэг зохицуулах хорооны хэлтсийн дарга мэйл бичдэг, нэг яамнаас бичдэг, 1 цагдаа бичдэг. Бид нар энэ чинь алийг нь албан гэж үзэх юм. Иргэд өөрөө хүсэлт гаргах юм уу? Ихэнх улсууд өөрөө дотоодын хууль тогтоомжоороо энийг ингээд зохицуулж өгдөг.

Тийм учраас та бүхэн өөрсдийнхөө дотоодын хуулиараа зохицуулчих юм бол бид нар албан ёсны харилцаагаа баталгаажуулъя гэдэг. Ийм байдлаар бол ажиллаж байгаа. Тэд Япон шиг манай улсын цахим мөрдлөгийн хууль гаргах гээд байгаа ч биш гэдгийг бол бид нар сайн бодох ёстой. Энэ бол тийм учраас энэ Хууль зүйн сайдын гэхээсээ илүү яг нөгөө хэрэгжилт, гадаад харилцаа, контентын зөрчил дээр суух, хүний эрхийн шинжээч нарыг томилох гээд энэ бол яг хууль хэрэгжүүлэх байгууллага нь өөрөө илүү бас цахим яам байх юм байна. Энэ өөрөө тийм мөрдлөгийн шинжтэй, зөрчлийн шинжтэй тийм шүүхийн процесс дээр очих тийм хууль бол биш ээ.

Илүү соён гэгээрүүлэх тал руугаа хандана.

Л.Мөнхбаатар: Батшугар гишүүн тодруулж асууя.

Э.Батшугар: Тийм Яах вэ верифай гэдэг нь зөв л дөө. Гэхдээ Монгол Улсын нийт 2 сая 800 мянган хүнээс фэйсбүүк хэрэглэгчдийг жишээлбэл верифай байлгахад маш хэцүү. Тэгэхээр нөгөө нэг урьдчилан сэргийлэх байдлаар гэдгээр бас нөгөө нэг одоо ба троллийн хаягуудыг олж мэдэж, тэгээд устгах бололцоо байгаа юу? Энэ хууль батлагдсанаар.

Дээрээс нь нэмээд бас нэг бодитой л кэйс ярих гээд байна л даа. Жишээлбэл өнөөдөр гэхэд нэг Монгол Улсын иргэн хар тамхи хэрэглээг сурталчлах тийм пост тавьчихсан байгаа юм. Тэгэнгүүт тэр постыг нь бусад хүмүүсүүд бас шэйрлээд явчхаж байгаа юм. Скриншот хийгээд. Тэрэнд чинь бол 2 төрлийн гэмт хэрэг явчхаж байгаа байхгүй юу. Нэг нь бол

гэмт хэрэг, нэг нь бол хар тамхины хэрэглээг сурталчлах. Нөгөөдөх нь тухайн иргэнийг бас шэйр хийж байгаа иргэд нь бас хүний эрхэнд халдаж байгааг бас мэдэхгүй. Хүний эрхэнд алдаад байгаа нь тэр. Иргэний хэргээр тэгэхээр энэ гэх мэтчилэн гэмт хэргийн урьдчилан сэргийлэх ямар арга хэмжээ авах вэ? Ялангуяа хүний эрхийг мэдэхгүйгээр халдаж байгаа хүний эрхэнд.

Л.Мөнхбаатар: Батшугар гишүүний асуултад Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ хуурамч акаунтыг илрүүлэх чиглэлээр бол олон улсын энэ олон сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд бол тогтмол ажиллаж байгаа. Хиймэл оюун ухаан ажиллуулаад ч гэсэн тэр 1.5-1.8 тэрбум орчим хуурамч акаунтыг устгаад явж байгаа бол хиймэл оюун ухаанаар шийдвэрлээд л явж байгаа. Дээрээс нь фэйсбүүкийн коммунити стандарт гээд ямар шаардлага барих вэ? Угаасаа энэ фэйсбүүк өөрөө тэр садар самууныг сурталчлах, бэлгийн хүчирхийллийг сурталчлах, хар тамхи, мансууруулах бодисыг сурталчлах, хүүхдэд хүмүүжиж төлөвшсөн сөрөг нөлөө үзүүлэхэд мэдээллээс хамгаалах, цахим залилан хийх дээр бол өөрсдөө тэмцэл өрнүүлдэг.

Тийм учраас энэ хуулийг боловсруулахад фэйсбүүкийн болоод олон нийтийн үйлчилгээ үзүүлэгч нарын барьж байгаа стандартыг илүү нийцүүлэхийг хүсэж хийсэн. Түүнээс биш ардчилсан орны хувьд үгээ хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө рүү бол огт орохгүй учраас хуулийн зарчим дээрээ хүртэл тусгаад зөрчилтэй контентууд дээрээ үг хэлэх үзэл бодлоо илэрхийлэхийг зохицуулж өгсөн. Цаашдаа бид нар нэг сувагтай болох юм бол дотоодод байгаа энэ хуурамч акаунтуудын мэдээллүүдийг иргэдийн хүсэлт, хүний эрхийн комисс тэр олон улсад итгэмжлэгдсэн факжек ч гэдэг юм уу тэр байгууллагуудын хүсэлтийг нь уламжлаад цаашаа нэг сувгаар уламжилж

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

эхэлнэ. Тэгэхээр бол урьдчилан сэргийлэх ажил бол бас тодорхой болно гэсэн үг.

Дээрээс нь нэг бүлгээрээ соён гэгээрүүлэх ажиллагааг хуульчилж өгсөн. Ер нь Сингапур ч бай дэлхийн энэ өндөр хөгжилтэй улсууд соён гэгээрүүлэх ажиллагааг тогтмол хийдэг юм байна. Ер нь дандаа мэдээллүүдийг өгч байдаг. Энэ ажлуудыг тогтмол хийнэ.

2-т, Монгол Улсын хууль тогтоомжид тэр нөгөө контент нь өргөн нэвтрүүлгийн хуулиар зохицуулагдаад нэг томьёотой. Гэхдээ яг нөгөө контент нийтлэх, контентыг түгээх гэдэг ойлголтыг юу гэж ялгах вэ гэдгийг томьёолоогүй. Энэ хуулиар контент нийтлэх буюу контентыг олон нийтийн сүлжээнд нийтэд нээлттэй хүргэх буюу яг постлохыг контентыг түгээх гэдэг нийтэлсэн контентыг олон нийтийн сүлжээнд дамжуулаад бусад этгээд дамжуулахыг гэж тодорхой бас томьёолж өгснөөрөө хууль хяналтын байгууллага ажлаа хийхэд ч гэсэн их дөхөм болох байх.

Л.Мөнхбаатар: Учрал сайд, энэ яах вэ, хэрэглэгчийн энэ баталгаажсан хаяг верипайед энэ хаягийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын түвшинд та бүхэн нэлээн ажиллаж байгаа юм байна лээ. Энэ үйлчилгээ эрхэлж байгаа байгууллагуудтай хамтын ажиллагаа эхэлчихсэн яваад байгаа. Үүнээс гадна нэг чухал зүйл бол нэг ийм зүйл харагдаад байгаа шүү дээ. Одоо мета, твиттер, энэ youtube-ийн хувьд энэ платформууд чинь нөгөө хиймэл оюун ухаанд суурилсан ийм үйлчилгээ үзүүлээд байгаа. Энэ дотроо нөгөө хуурамч болон хууль бус мэдээллүүдийг чинь ингээд филтердэж байгаа шүү дээ. Энэ шүүлтүүр хийж байгаа. Одоо филтер систем ажиллуулдаг. Гэхдээ энэ нь өөрөө нөгөө тухайн хэлээр нь үйлчилгээ үзүүлж байгаа шүү дээ. Тийм ээ, хайж байгаа. Тийм учраас харин энэ гүүгл транслэйт буюу үүнийгээ хөгжүүлээд хөгжүүлэлтийг нь нэг сайн хийх юм бол уул нь энэ зүйл чинь бас

нэлээд шийдэгдэх юм байна гэж харагдаад байгаа юм. Одоо тухайн улсын хэлээр ийм шүүлтүүр хийдэг учраас. Энэ дээр бас нэлээн харах ёстой юм шиг байна лээ шүү гэдгийг хэлье.

МАН-ын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг асуултаа асууя.

М.Оюунчимэг: Энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Манайхаас бусад бүх л улс орон яг энэ олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалахдаа худал гүтгэлэг мэдээллүүдэд бас нэг тодорхой хэмжээний хяналт тавих. Энэ нь өөрөө үндэсний аюулгүй байдалтай холбоотой. Хүний эрхтэй холбоотой. Хүний нэр төртэй холбоотой гэдэг юм уу. Ийм зүйлүүдээ яг гаргаад ингээд явж байгаа. Хамгийн тод жишээ ХБНГУ байгаа. Бид нар хуулийг нь ч бас маш сайн судалж үзсэн. Хамгийн гол нь иргэдийн дунд яах вэ, эргэлзэж байгаа зүйл нь юу вэ гэхээр хэвлэл мэдээллийн хэвлэн нийтлэх, үг хэлэх, ард түмний Үндсэн хуулиар олгогдсон үг хэлэх эрх чөлөөнд энэ маань өөрөө халдахгүй байх нь чухал гэдэг үзүүлэлт байгаа. Бид бас олон удаа ярьж энэ бас судалж үзсэн. Ямар ч байсан хэвлэл мэдээллийн байгууллагуудын хэвлэн нийтлэх хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай огт энэ зөрчилдөж байгаа зүйл байхгүй байна.

Дээрээс нь хүний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх энэ эрх мэдэл эрхтэй бас зөрчиж байгаа зүйл байхгүй гэсэн байр суурийг бас ЗГ, хууль санаачлагчдын зүгээс хэлж байгаа. Би энэ дээр Хүний эрхийн комиссын дарга энд сууж байна. Энэ хуультай та бүхэн маань та бүхний оролцоо яаж хандаж байгаа вэ? Энд яг хүний эрхийг хамгаалах талаасаа үнэхээр энэ хууль зайлшгүй цаг алдалгүй гарах ёстой гэдэг дээр та бүхэн санал нэг байгаа юу. Эсвэл энэ дээр бас хүний эрх эсрэгээрээ үг хэлэх ч юм уу, хэвлэн нийтлэх эрх зөрчигдсөн заалт энд бас байгаа гэдэг бодолтой байгаа юу. Энэ дээр

энэ хүний эрхийн комиссын байр суурийг би сонсьё гэж бодож байна.

Ер нь сүүлийн үеийн тоо энэ статистик судалгаануудыг харахад олон нийтийн сүлжээнд сошиалаар дамжсан ялангуяа фэйсбүүк, инстаграм дээр өсвөр насны хүүхдүүд бие биеийгээ элдэв үг хэлээр яах буруу сөрөг нөлөөлөл үзүүлэх, энэ ялангуяа санхүүгийн гэмт хэргүүд, амиа хорлолт руу оруулах, үндэсний аюулгүй байдал талаасаа бас нэлээд ийм буруу жишиг тогтоох ч гэдэг юм уу иймэрхүү зүйлүүд бас байгаад байгаа. Бусад улс орон ч гэсэн ийм зүйл гарсан байгаа шүү дээ. Тэгэхээр энэ хуулийн гол зорилго нь л жишээ нь тэр Фэйсбүүк, инстаграм, твиттер ч гэдэг юм уу энэ бизнесийн байгууллагуудтай Монгол Улс ямар харьцах зарчмаа л тодорхой болгоё. Энэ нь өөрөө хүний эрхийг хамгаалах үндсэн дээр суурилсан байх ёстой гэдэг утгаараа л энэ хууль орж ирж байгаа гэж харж байгаа. Бид нэлээд судалж үзлээ. Ер нь өнөөдөр төрийн бодлого нь, хууль хүчний байгууллагын шийдвэр нь, ер нь бүх юм олон нийтийн сүлжээн дээр л үнэн худал мэдэгдэхгүй байх юм бол хэн энэ улс орныг удирдаад байгаа нь ч бараг тодорхойгүй энэ тэр болж байна шүү дээ. Харин үүний цаана хардах эрхээ хэвлэл мэдээллийн байгууллага эдлэх тэр эрх зөрчигдөх ёсгүй, хүний бас өөрийнхөө нэрээрээ Дорж гэдэг хүн яг Доржоороо ороод энэ би энд ийм юм гэж харж байна юм уу. Эсвэл ингэж хүний эрх зөрчигдөж байна. Эсвэл тэр ийм хууль бус юмыг энэ төрийн эрх мэдэлтэн хийж байна ч гэдэг юм уу. Тэр нь нээлттэй үлдэж байгаа гэж би харж байгаа.

Тэгэхээр хүний эрхийн комиссын байр суурийг би сонсьё оо гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгээ хэд вэ, хэн хариулах вэ? Хунан дарга хариулъя. ХЭҮК-ын дарга.

Ж.Хунан: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ХЭҮК-ын зүгээс бол энэ ажлын хэсэгт орсноо өнөөдөр өглөө мэдсэн. Харилцаа холбооны дэд сайдтай 2 хоногийн өмнө уулзаж энэ төслийн анхны хувилбартай танилцсан байгаа. Тэгэхээр энэ хуулийн төсөлтэй танилцахад хэд хэдэн хүний эрхийн зөрчил байж болзошгүй асуудлыг анхааралтай ажигласан. Ажигласан ч юу байх вэ, ажиглалт хийсэн. Юу вэ гэхээр энэ Үндсэн хуулийн төслийн хувьд ноцтой, хүний эрхийн зөрчил гэж үзэх ийм зүйл бас бага байгаа. Тэгэхдээ энэ зөрчилтэй контент гэдэг дээр дахин харах ийм зайлшгүй шаардлага байгаа гэдгийг хэлье.

Мөн энэ хуулийг дагаж гаргах, энэ зарим хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд яг энэ хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг бодитой хязгаарлах ийм эрсдэлийг агуулж байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй байх. Энэ хуулийг дагаад Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт оруулах ийм хуулийн төсөл явж байна. Энэ дээр юу гэж заасан бэ гэхээр Кибер аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрээр зөрчилтэй контентын тархцыг бууруулах, харилцаа холбооны сүлжээг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь хязгаарлах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ ээ гэж ийм текст явж байгаа. Тэгэхээр энэ болбол хэзээ, яаж хэрэглэх энэ асуудал бол төрийн захиргааны байгууллагын хамааралтай болж болзошгүй байна гэдэг ийм болгоомжлолыг илэрхийлж байгаа. Тийм учраас үүнийг эргэж бас харах илүү нарийвчлах, магадгүй өөрчлөх ийм шаардлага байгаа гэж харж байна.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүн тодруулах юм уу. Тодруулж асууя. Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Тэгэхээр тэр саяын хэлээд байгаа энэ фэйсбүүк, твиттер юм уу? энэ бизнесийн олон улсын байгууллагуудтай харилцах гүүр болох тэр бүтэц схем тоглоомын дүрмээ тодорхой болгох нь өнөөдрийн энэ

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хуулийн гол зорилго гэж харж байгаа. Тийм учраас энэ хуулиа өнөөдөр ингээд дэмжээд явчих нь зөв болов уу.

Харин дагалдаж гарах хуулиуд, саяын энэ Хүний эрхийн комиссын даргын хэлж байгаа дагалдах хуулиудыг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд ирэх хаврын чуулганаар маш нухацтай хэлэлцэх нь зөв болов уу гэсэн бас байр суурьтай байна. Тэгээд саяын тэр зөрчилтэй контент гэдэг дээр Учрал сайд та нэг хариулаадхаач. Энэ үг нь өөрөө хэвлэл мэдээллийн байгууллагуудын юм уу хүний эрхийн зөрчил энэ тэр агуулж байгаа юу. Эсвэл энэ өөр агуулгаар энд хандаж байгаа юу? Та энэ дээр бас тайлбар өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад Учрал сайд хариулья.

Н.Учрал: Кибер аюулгүй байдлын хууль батлагдсан. Гэмт халдлага кибер орчинд л өрнөж байна. Тэгээд кибер орчны буюу нэг сошиалаар дамжиж илүү их өрнөж байна гэдэг ийм дүгнэлт гараад байгаа учраас Кибер аюулгүй байдлын хуулийг дагалдуулсан нийтийн төвийнхөө дэргэд энэ олон нийттэй харилцах нэгж нь байх зөв юм гэж үзсэн. Тэгээд өнгөрсөн, ямар ч хуулиар нөгөө зөрчилтэй контент гэж яг юуг ойлгох юм бэ гэдгийг томьёолж өгөөгүй байгаад байгаа учраас бид нар яах вэ, зөрчилтэй контентыг жагсаагаад л, энэ зөрчилтэй контентуудын хүрээнд л тэр гомдол, санал, хүсэлтээ олон нийттэй харилцах нэгждээ илгээгээд түүнийг нь 72 цагийн дотор хянан шийдвэрлээд эрх бүхий байгууллагууд руу өгнө өө л гэсэн үг. Тэгээд энэ хуульд ямар ч Эрүүгийн хуулийн, зөрчлийн хуулийн, хэвлэлийн эрх чөлөөг хөндсөн зохицуулалт, заалт ерөөсөө байхгүй.

Европын холбоо 28 улсдаа акт гаргаад хэрэгжүүлээд л явж байгаа. Энд яг иймэрхүү л хууль. Ерөнхий ийм хуулиа гаргаад л харилцах сувгаа тодорхой болгоод л олон улсын байгууллагуудын

түвшинд харилцаагаа ойлгомжтой л болгодог. Тэгэхээр энэ хууль гарснаараа шууд маргааш нь асуудал шийдэгдэхээс илүүтэйгээр тогтолцооны хувьд маш ойлгомжтой болно. Олон улсын харилцааны суваг нь ойлгомжтой болно л гэдэг ийм л зүйл.

Хунан даргын сая хэлж байгаа дагалдах хууль дээр угаасаа тэр байсан зохицуулалт. Байсан зохицуулалтуудыг харин хэн тэр сүлжээнд хяналт тавина гэдэг үгийг ингээд тавьчихсан байсан. Харин үүнийг нэг хүн хамаарахгүй байх үүднээс наад чинь кибер зөвлөлөөрөө оруулж байж дүгнэлт гаргаж байж шийдвэрлэе ээ гэдэг байдлаар хүний эрхийг илүү хангасан заалтыг оруулж өгсөн л гэж бас тайлбарлах нь зөв байх.

Л.Мөнхбаатар: Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууя.

Г.Ганболд: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгээд энэ хуулиар нэг яг тов тодорхой нэг 3 асуудлыг би зохицуулж байна гэж ингэж хараад байгаа юм. Эхлээд ямар ч гэсэн ийм зөрчилтэй контент гэж нэрлэнэ үү, юу гэж нэрлэнэ үү, үүнийг энэ кибер орчинд гараад байгаа энэ гэмт хэргүүдийнхээ нэг зүйлүүдийг нэг тодорхой болгочихъё. Үүнийхээ дагуу энэ Монгол Улсад энэ үйлчилгээ эрхэлж байгаа энэ твиттер, фэйсбүүкийн энэ байгууллагуудыг нэг Монголд салбараа нээх үүрэгжүүлчихъё. Тэгээд чадвал салбар нь нээгдчих юм бол маш богино хугацаанд энэ асуудлуудыг шийддэг болчихъё.

3-т нь, энэ Монгол Улсын олон салбараар биш цагдаагийн байгууллага нь Харилцаа холбооны зохицуулах хороо нь ч гэдэг юм уу ийм олон салбар биш. Нэг л нэгжээр энэ байгууллагуудтайгаа харьцдаг больё гэдэг энэ 3 асуудлыг л би их тодорхой болгох гэж байгаа хууль байна гэж ингэж бодож байгаа юм.

Тийм учраас би маш яаралтай дэмжих ёстой гэж хараад байгаа юм. Өнөөдөр Монгол Улсад гэмт хэргийн 33

хувь нь цахим орчинд үйлдэгдэж байна гэдэг бол асар хурдацтай өсөж байна л даа. Тэгэхээр үүний гол шалтгаан бол хуурамч хаяг, энэ хуурамч аккаунт гэж яриад байгаа зүйл шүү дээ. Хуурамч хаягаас л хүнийг дарамтална. Хуурамч хаягаас л залилан хийнэ. Түүнээс өөрийнхөө хаягаар, нүүрээр залилан хийдэг, гэмт хэрэг хийдэг зүйл гэж байхгүй шүү дээ. Тэгээд үүнийг зохицуулах гол зүйл нь би энэ салбаруудыг нээх асуудал хамгийн чухал гэж бодож байгаа юм. Өнөөдөр бид нарын яриад Учрал сайдын хэлээд байгаа тэр нэг 30 хоногт багтааж устгуулж байгаа зүйлийг нэг 3 хоногт юм уу, 7 хоногт устгуулах гээд байгаа нь тийм ч ач холбогдолтой биш л дээ. Өнөөдөр бараг ингээд 2 өдрийн дотор л хүнийг байхгүй болгоё гэх юм 2 өдөрт л байхгүй болгож байна шүү дээ. Худал, үнэн зүйлээр ингээд л гүтгээд л нийгмээрээ дор нь давлагаалахад 3 хоногийн дотор л тэр хүнийг амьдрал ахуй, нэр хүндийг нь байхгүй болгочхож байгаа юм. Тэгээд сүүлд нь тэр хүн яах вэ гэхээр зэрэг гүтгүүлсэн хүн ерөөсөө уйлах, инээх 2-оос өөр ямар ч арга байхгүй. Нэг нь уйлаад л нэг нь инээгээд л ингээд л өнгөрдөг.

Хамгийн гол зүйл би ерөөсөө тэгж гүтгэлэг хийсэн юм уу, гэмт хэрэг хийсэн энэ хүмүүс дээр ирэх хариуцлага тодорхойгүй байгаа учраас энэ хуулийг дагаж энэ Эрүүгийн болон Зөрчлийн хуулиудынхаа тов тодорхой заалтуудыг оруулж ирэх ёстой. Тэгж байж энэ сошиал орчинд энэ гэмт хэрэг үйлдсэн бол, хүний нэр төрд халдсан бол эргээд уучлалт гуйдаг. Түүнийхээ төлөө маш их хэмжээний төлбөр торгууль төлдөг. Ийм байж байж л үүнийг давахгүй бол хаалаа гээд бид нар яах юм. Хурдан хугацаанд хаалаа гээд тэртээ тэргүй нийгэмд гарсан зүйл 3 хоногийн дотор л бүхэлдээ явчхаж байгаа шүү дээ. Тэгээд л дараа нь юу ч болоогүй өнгөрдөг. Хэчнээн тайлбар хийгээд нөгөө хүмүүс нь үгүйсгээд ямар ч арга байдаггүй. Нэгэнт алдагдсан нэр хүнд тэгээд дуусдаг. Түүний төлөө харин гүтгэснийх нь төлөө тэр гүтгэсэн хүнээр

нь, эсвэл Монголын төр тэр нэр төр нь алдагдсан хүмүүсээс уучлалт гуйдаг. Ийм хуулийн тогтолцоо руу бид нар л яаралтай орж байж үүнийг давах ёстой байгаа юм. Тэгээд энэ хуулиа оруулж ирэх болоогүй юу Нямбаатар сайд аа. Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль бол нэлээн хатуу байх ёстой шүү гэж бодож байна. Тэгэхгүй бол өнөөдөр Монгол Улсад яаж байна гэхээр маш олон хуурамч олон дагагчтай аккаунтуудад мөнгөтэй хүмүүс өөр дээрээ нь цуглуулж аваад л нэг хүн дээр асар их байна шүү дээ. Тийм хүмүүс л өнөөдөр Монголын нийгэмд хамгийн нэр хүндтэй хэнийг ч байхгүй болгодог. Ийм түвшинд байгаа учраас энэ чиглэл рүү тодорхой ажил хийх ёстой байх гэж би бодож байна.

Нөгөө талаас Учрал сайд аа. Хэрэв бид нар ингээд хуульчилчихлаа. Эсвэл нөгөө манайд үйлчилгээ үзүүлж байгаа мета групп ч юм уу, твиттерийнхэн салбараа нээхгүй бол бид нар бас яах вэ. Бид нар хуульчилчихдаг. Гэтэл орж ирээд ингээд салбараа нээхгүй гэвэл үүнийг бид нар хаахад хүрэх үү. Эсвэл ингээд л ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүний асуултад хариулья, Учрал сайд хариулья. Хэн хариулах юм. Учрал сайд хариулаад, нэмж Нямбаатар сайд хариулья.

Н.Учрал: Яах вэ, дэлхийн улсууд энэ Европын холбооны улсууд акт гаргаад, Европын Холбоо бүх улсдаа хэрэгжүүлж байна. Жишээ нь, холбоодын бүгд найрамдах Герман улс, Япон улс ч гэдэг юм уу эхлээд хууль гаргаад хуулийнхаа дагуу тэр олон улсынхаа байгууллагуудтай манайхтай ийм байдлаар ажиллаач ээ. Манайх дотооддоо ийм хууль журамтай гэдэг байдлаар харилцаагаа үгүйсгээд явдаг ийм л жишиг байдаг юм байна. Тэгээд би түр хорооны даргаар байхдаа ч Байнгын хорооны дарга болчхоод ч сая сайдаар томилогдоод ч гэсэн энэ фэйсбүүкийн төлөөлөгч нартай бас уулзалт хийсэн. Нямбаатар сайд ч гэсэн уулзсан. Тэгээд бид бол та бүхэн

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

баталгаажсан дугаараар бүртгэхийг дэмжээч. Төлөөлөгчийн газраа бид нар байгуулахыг, та бүхнийг байгуулаач гэж хүсэлт тавьж байна. Дээрээс нь бид нар нэг харилцах сувгаар та бүхэндээ дамжъя гэхээр танайх хууль, эрх зүйн хүрээнд үнэхээр манай фэйсбүүкийн тэр үндсэн коммунити стандартыг бариад хуулиа хийгээд ингээд эрх үүрэг нь ойлгомжтой болоод эхэлбэл бид дотоодын чинь хууль тогтоомжийг бас хүлээн зөвшөөрөөд цаашдын харилцаагаа ярилцана л гэдэг ийм л байр суурийг хэлсэн. Тэгэхээр яах вэ, хууль гаргахгүйгээр бид ингээд харилцаагаа сайжруулья гээд ингээд яваад байх нэг арга зам байгаа ч гэсэн тэр бүр үйлчилгээ үзүүлэгч нар бид нарын үгэнд ороод эсвэл нэг салбарын сайдын саналыг сонсоод энэ бас шийдээд явна гэдэг маш их эргэлзээтэй юм байна лээ. Тэгэхээр та нар ядаж хууль тогтоомжтой. Жишээ нь олон нийтийн сүлжээгээр нэг пост хийлээ. Тэрийг нь юу гэж хуулиараа үздэг юм. Нийтлэг гэх юм уу, түгээх гэх юм уу, түдгэлзүүлэх гэх юм уу. Бид өөрсдийнхөө фэйсбүүк стандартаар тэр тэр хүн садар самуун сурталчлаад байгаа тэр постыг чинь Хайди хийгээд ингээд түдгэлзүүлдэг. Тэрийг бид хуулиар чинь юу гэж үзэх юм. Тэгээд яг ингээд ямар харилцааны сувагтай байх юм бэ гэдэг чинь их ойлгомжгүй байна л гэж хэлдэг.

Тийм учраас бид эхнийхээ түвшинд хуулиа гаргаад мэдээж яах вэ, Эрүүгийнхээ тэр Зөрчлийн хуулиар тэр гэмт хэргүүд нь хуульчлагдчихсан байгаа шүү дээ. Тодорхой төрлүүдээ хуульчилчихсан. Энэ бол тухайн асуудлаараа зохицуулагдаад хууль хяналтын байгууллага шийдвэрлээд л өнөөдрийг хүрсэн. Тэгэхээр энэ урьдчилан сэргийлэх тохиолдол буюу тэр гэмт хэрэг гарч болзошгүй байдлыг нь энэ хуулиараа зохицуулдаг, урьдчилан сэргийлж соён гэгээрүүлдэг, харилцах суваг ойлгомжтой болдог учраас энэ бас нэг талаасаа гадаад бодлогын ажил юм байна гэдэг утгаар нь бас бид нар анхаарсан.

Тэгэхээр хууль батлагдсаны дараа бол сая Нямбаатар сайдын хэлдгээр бид нар Ази Номхон далайн тэр төлөөлөгч нартай нь уулзалт хийнэ. Хуулийг амилуулах ажлыг шат дараатай зохион байгуулаад ингээд ажиллана гэдгийг бас хэлэх ёстой байх.

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүний асуултад Нямбаатар сайд нэмж хариулья.

Х.Нямбаатар: Ганболд гишүүний асуултад хариулья. Юу, тэр мета компани ч гэдэг юм уу, твиттер компани ч гэдэг юм уу, төлөөлөгчийн газраа нээхгүй бол яах юм бэ. Ямар хөшүүрэг байгаа юм бэ гэдэг асуудал яригдаж байгаа. Энэ шинэ тутам харилцаа. 2017 онд шиг санагдаж байна, Европын холбоонд, тэр дундаа ХБНГУ энэ цахим орчинд Хүний эрхийг хамгаалах хуулиа баталсан. Боловсруулсан субъектүүдтэй бид нар бас уулзаж байсан. Тэгээд ерөөсөө энэ мета групп энэ тэрийн тавьдаг шаардлага нь та нар хуулиа гаргачих. Бид нар тэр хуулийг хүндэтгэлтэй биелүүлэх төлөөлөгчийн газраа байгуулья л гэдэг л ийм зүйлүүдийг ярьдаг.

Манай улсын ЗГ-ын эрх бүхий албан тушаалтнуудтай маш олон удаагийн уулзалтууд хийгдсэн байгаа. Уулзалт болгон дээр ийм асуудал ярьдаг. Тэгэхээр энэ бид нар айлын талаас тавьж байгаа тэр шаардлагынх нь дагуу 1 дүгээрт, төлөөлөгчийн газартай байх эрх зүйн орчныг нь бүрдүүлье ээ гэж байгаа юм. 2 дугаарт, энэ давхар татварын хэлэлцээрээр энэ Монгол Улсын нутаг дэвсгэрт ашиг орлого олж байгаа тохиолдолд татвар төлөх бас үүрэгтэй юм байна лээ. Тэгэхээр нөхдүүд энэ асуудлаа бас давхар ярьдаг. Бид нар хууль гарсан тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийг бүхэлд нь хэрэгжүүлэхэд бэлэн байна гэдгээ илэрхийлдэг ээ.

Манай ХЗБХ дээр Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл өргөн баригдаад,

хэлэлцэх эсэх нь шийдэгдчихээд байгаа. Их Хурлын дэд дарга Мөнхбаатар дарга уг нь хуулийн төслийг ахалж байсан. Тэгээд ингээд дарга маань бид нарыгаа орхиод дарга болоод явчихлаа. Одоо бид нар бас ойрын үед ажлын хэсгээ шинэчлэн байгуулаад энэ чуулганы завсарлагаагаар энэ Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн ажлын хэсгээ шинээр ажиллуулах ийм шаардлага байгаа. Энэ дээр бид нар бас тодорхой шинэ санхүүгийн гэмт хэргүүд, цахим орчинд үйлдэгдэж байгаа санхүүгийн гэмт хэргүүдийг шинээр хуульчилж оруулж ирж байгаа. Мөн гүтгэлэг доромжлолтой холбоотой асуудлыг бид нар бас зааглаж үзэх ёстой гээд Эрүүгийн хууль дээрээ тусгаад төсөл дээр орж ирж байгаа. Одоо энэ дээр хаврын чуулганаар гишүүд ажлын хэсэг ажиллачхаад хаврын чуулганаар уг нь үүнийг хэлэлцэн батлах энэ ажил явагдах ийм учиртай байгаа гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Дамдины Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Д.Цогтбаатар: Энэ хуулийг үзэл баримтлалынх нь хувьд үзэл санаа, цаад зорилгынх нь хувьд дэмжиж байгаа. Учрал сайд залуу сайдын хувьд нийгэмд яг тулгамдаад байгаа асуудлаа л барьж аваад л орж ирж байна. Тэгэхээр энэ үүднээс нь би ойлгож байна. Бас яагаад энэ асуудалд бас яарч хандаж байгаа юм.

Тэгэхдээ ЗГ маань энэ асуудалдаа яарч хандаж байгаа нь ЗГ-ын байр суурь. Би бас тэрийг нь ойлгож байна. ЗГ маань Их Хурлаа бас ойлгох ёстой. Их Хурал өөрийнхөө журмаар авч үздэг. Тэр журмаараа л хэлэлцээд л шийдээд явах ёстой. Тэгэхээр энэ дээрээ бас тал талдаа ойлголцох ёстой байх. Тэгээд надад нэг ийм асуудал байгаа юм.

Ер нь сая энд ингээд танилцуулгаас үзэж байхад энэ сайбер орчинд иргэд иргэдийнхээ эрхийг зөрчих тохиолдолд

маш их байгаа. Тэгэхээр энэ дээр үнэхээр энд бас ноцтой хэмжээнд хүрчихсэн эс үгүй бол хүрэхүйц ийм эрсдэл зөвхөн Монголд биш дэлхий даяар байгаа болохоор энэ дээр анхаарахаас өөр арга байхгүй. Тэгэхдээ Учрал гишүүн ээ, танилцуулахаас би нэг юм сонссонгүй. Төр, улс төрийн намууд, улс төрийн хүрээнийхээ иргэний эрхийг зөрчих эрсдэл энэ дээр танилцуулгад бас анхаарч байгаа энэ өнцөг харагдсангүй. Төрөл, иргэдийг яг энэ дээрээ бие биетэйгээ харьцахдаа нэг нэгнийхээ эрхийг олон зөрчөөд байна. Тэр нь үнэн юм чинь түүн дээр анхаараад байна.

Гэтэл бас иргэний эрхийг төр зөрчих тохиолдлууд байгаа шүү дээ. Энэ дээр судалгаа хийсэн үү? Энэ хуулийг гаргахад үүнийг заавал авч үзэх ёстой. Яагаад гэвэл жишээлбэл ингээд л сүүлийн үед социал харж байхад яах аргагүй мөрдөн байцаах үйл ажиллагааны дүнд олоод авчихсан материалууд яаж явж байгаад ийм улс төрийн нам, улс төрийн хүрээнийхний гарт ороод, ингээд тэр асуудал шийдэгдээгүй байхад социалаар цацагдаад, тэгээд ёстой урьдчилсан нөгөө гэм буруугүйн зарчим бүгд мартагдаад, нөгөө яллах процесс яваад эхэлдэг. Ийм тохиолдол зөндөө байгаа шүү дээ. Тэр ямар нэгэн иргэд олж авах ямар ч боломжгүй материал. Гэтэл энэ социал дээр аль эрт гараад ирдэг. Тэгэхээр энэ тал дээр би хууль санаачлагчаас ч, энэ ажлын хэсгээс ч асуумаар байна. Төрийн зүгээс ийм тусгай арга үйл ажиллагааны явцад олж авсан энэ мэт материалууд гарсан энэ тохиолдлуудыг статистикийн хувьд судалж үзсэн үү, хэр их байгаа вэ? Үүнийг жишээлбэл хүний эрхийн комиссынхон маань яг энэ дээр судалгаа хийж үзсэн үү? Энэ чинь аягүй ноцтой бас хүний эрхийн зөрчлүүд явж байгаа байхгүй юу.

Тэгээд төрийн зүгээс тэр мэдээллийн нууц алдагдсаны зүгээс юу алдагдсаны улмаас зөрчигдөөд байгаа. Тэгэхээр энэ судалгааг хийж үзсэн үү? Энэ мэтийн нарийн судалгаануудыг хийж тэгээд гол барих зарчим бол үнэхээр

хүний эрх бол халдашгүй шүү. Юун УИХ-ын гишүүний дархан эрх. Энэ чинь Үндсэн хуулиараа иргэн дархан эрхтэй байхгүй юу. Төрөөс хамгаалагдах. Тэр иргэний эрх чөлөөг хамгаалах эрх чөлөөний тэр ариун байдалд ямар нэгэн халдах эрсдэлийг харин энэ хууль үүсгэж болохгүй шүү дээ. Түүнийгээ харин эсрэгээрээ төр халдах биш төр өөрөө хамгаалах ёстой байхгүй юу. Төр өөрөө өөрөөсөө хамгаалах ёстой, гаднын халдлагаас Монгол иргэдийг хамгаалах ёстой. Ийм 2 функц байгаа. Тэгээд энэ үүднээс судалгаа хийсэн ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Цогтбаатар гишүүний асуултад Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Цогтбаатар гишүүн их чухал асуудлыг хөндөж байна. Бид 2021 онд Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийг баталсан. Хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийг баталснаараа төр ямар нэгэн байдлаар иргэнийхээ мэдээллийг ашигласан тохиолдолд зөвхөн тэр мэдээллийн эзний зөвшөөрлөөр мэдэгдэх хуудсаар дамжуулж иргэндээ мэдэгдэл хүргэдэг болсон. Тэгээд иргэд өнөөдөр нөгөө утсанд нь и-монголоор нь дамжуулаад дон дон гээд дуугарахад сонсоод. Энэ миний мэдээллийг ийм үйлчилгээ авсан, харж байна гээд. Энэ бас дэвшил.

Тэгээд энэ хууль дээр яг төр өөрөө хүний хувийн мэдээллийг хамгаалах зохицуулалтыг бас тусгаж өгсөн. 6.3 дээр нийтийн албан тушаалтан хүний хувийн мэдээллийг олон нийтийн сүлжээнд зөвшөөрөлгүйгээр нийтлэх, түгээхийг хориглоно оо гэдэг заалтыг тусгаад хувь хүний мэдээлэл хамгаалах хуульд өөрчлөлт оруулсан. Яг нэг жишээ кэйс. Одоо 1 иргэн ҮХЦ-д жишээ нь мэдээлэл гаргасан байна. Тэр мэдээлэл гаргасан нь юу вэ гэхээр Татварын ерөнхий хууль дээр татвар төлөгч нь татварын хууль тогтоомжийг зөрчсөн бөгөөд хууль тогтоомжид заасан хугацаа нь зөрчлөө арилгаагүй. 1 зөрчлийг 3 болон түүнээс

дээш удаа давтан гаргасан, эсвэл эрэн сурвалжилж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба татвар төлөгчийн зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно оо гэдэг заалт. Гэтэл тэр хүн татвараа төлөөгүй нэг зөрчил удаа гаргасан ч гэсэн ерөнхий байдлаараа татвар төлөгчдийн талаар гэхээр банк санхүүгийн тайлан мэдээллийг хэн нэгэн ямар ч төрийн албан тушаалтан, нийтийн албан тушаалтан гаргах боломжгүй шүү дээ. Тэгэхээр ийм зохицуулалтыг өөрчлөх үүднээс нь хувь хүний мэдээлэл хамгаалах хуулийг дагалдуулж өөрчлөлт оруулаад Татварын ерөнхий хуулийн энэ заалт дээр хэрвээ удаа дараа зөрчил гаргасан зөвхөн мэдэгдэл мэдээллийн эзний зөвшөөрснөөр тэр татвар төлөгчийн нэр, хуулийн этгээдийн нэрийг л өөрийнх нь зөвшөөрснөөр нийт мэдээлж болно. Татварыг нь төлүүлэх үүднээсээ гэдэг зохицуулалтыг нь хааж өгсөн.

Тэгэхээр энэ хуулиар маш том дэвшил гарна. Энэ бол нийтийн албан тушаалд ямар ч тохиолдолд хүний хувийн мэдээллийг олон нийтийн сүлжээнд зөвшөөрөлгүйгээр нийтлэг түгээхийг хориглоно. Энэ бол зөрчилтэй контент гэж энэ хуулиар үзэж байгаа юм. Тэгэхгүй бол иргэдийнхээ тэр мэдээллийг зөвшөөрөөгүй байхад нь олон нийтэд пост хийгээд түгээчихдэг. Түүнийг нь эргэж санаатай, санамсаргүй байдлаар нөгөө бидний нэрлэдгээр шэйрлэчихдэг. Ингээд үүний чинь цаана иргэдийн аюулгүй байдалд энэ чинь хувь хүний мэдээлэл алдагдаж байдаг учраас энэ хууль гарснаараа ийм бас том дэвшил бас ирж байгаа гэдгийг бас хэлэх ёстой байх. Ажлын хэсгээс нэмж тайлбар ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. Хэн хариулах вэ.

Ажлын хэсгийн 82 дугаар микрофон Хунан дарга хариулъя.

Ж.Хунан: Цахим орчинд төрийн байгууллагын зүгээс хүний эрхийг

зөрчсөн талаарх судалгааг комиссоос хийгээгүй. Тэгэхдээ Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн хүрээнд энэ судалгаа хийгдсэн гэж харж байгаа. ХЭҮК-т үүнээс үл хамаараад гомдол мэдээллүүд ирдэг. Ялангуяа төрийн байгууллагын зүгээс хувь хүний нууцад хамаарах хувийн мэдээллийг ил болгосонтой холбоотой гомдлууд нэлээдгүй ирж байсан. Ялангуяа ковидын үед бол хүний нууц мэдээллийг ил болгосноор ялгаварлан гадуурхалтад өртсөн, төрийн үйлчилгээ авах эрх нь хязгаарлагдсан ийм гомдлууд ирж байсан. 5 сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулийн хүрээнд өнгөрсөн онд ХЭҮК-т 12 гомдол мэдээлэл ирсэн. Үүнээс 10-ыг нь шийдвэрлэсэн, 8-д нь комиссын гишүүний зөвлөмж, шаардлага хүргүүлэгдсэн байгаа. Энэ нь мэдээж хэрэг бүгдээрээ хувь хүний нууц мэдээлэл ил болгосон, ил болгосонтой холбоотой. Энэ дунд хувийн хэвшил болон төрийн байгууллагууд орж байгаа.

Л.Мөнхбаатар: Нэмэлт хэн хариулах уу. Цогтбаатар гишүүн тодруулж асууя.

Д.Цогтбаатар: Тэгэхээр миний асуултад тэр судалгаа байхгүй ээ гэдэг хариу орж ирж байна. Тэр судалгааг хийгээрэй. Яагаад гэвэл ийм хууль гаргах гэж байхад судалгаа мэдээлэл дээр суурилж л шийдвэр байгаа юм. Энэ чинь хууль гаргах гэж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр ийм хууль гарах гэж байхад энэ судалгаа мэдээлэл дээр суурилж бас тодорхой заалтууд, үг, үсэг энэ хуульд орох шаардлага гарахыг үгүйсгэхгүй учраас заавал хийгээрэй л гэж хэлмээр байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр цахим орчинд хүний эрх хамгаалах тухай хуулийг концепцын хувьд дэмжиж байна. Тэгэхдээ энэ хууль маань хүний үзэл

бодлоо илэрхийлэх эрх чөлөө мөн ялгаварлан гадуурхагдахгүй байх эрх чөлөө хоёрын зааг дээр буюу энэ 2 эрх чөлөөг хоёуланг нь тэгш харгалзан үзэх ёстой, хүний эрхийн нэлээд мэдрэмж саарчихсан ийм асуудал. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19.1-ээр хүний үзэл бодлын эрх, эрх чөлөөг тунхаглан баталгаажуулсан. Мөн тус фактын хорьдугаар зүйлээр ямар тохиолдолд хүний үзэл бодол илэрхийлэх эрх чөлөөг хуулиар зохицуулах боломжтой гэдгийг зааж өгсөн байгаа юм. Алагчлан дайсагналцах болон хүчирхийллийг өдөөн турхирдаг, үндсэрхэг үзлээр арьс үндсээр болон шашин шүтлэгээр үзэн ядах байдлыг дэмжсэн аливаа ухуулга сурталчилгааг хориглоно оо гэж. Тэгвэл энэ цахим орчинд Хүний эрх хамгаалах тухай хууль маань яг энэ иргэний болон улс төрийн эрхийн тухай фактын хорьдугаар зүйлийн энэ агуулгатай ер нь концепцын хувьд нийцэж байгаа гэдэгт найдаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар хүнийг үзэл бодол, үндэс угсаа, эрхэлсэн ажил, тэгээд нийгмийн бэлгийн чиг баримжаа, албан тушаал гээд энэ зүйлээр ялгаварлахыг хориглосон байгаа. Харамсалтай нь энэ нийгмийн сүлжээний олон сувгуудаар маш олон бүлэг тодорхой хохирогч тухайлбал хүчирхийллийн гэмт хэрэгт хохирсон этгээдийн нэр зурагтай ил явах, эсвэл нийгмийн үндэсний цөөнх болон мэргэжлийн болон бусад бэлгийн чиг баримжаа бүхий иргэдийн эрхэнд халдсан мэдээлэл асар их явдаг. Үүний эсрэг чиглэсэн гээд анхны зохицуулалтыг оруулж ирж байгаа нь зарчмын хувьд дэмжиж байна. Тэгэхдээ энэ нийгмийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах хууль маань үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хаачих вий. Хэн нэгэн бүлгийнхний эрх ашгийг хамгаалахын үүднээс бусад ардчиллын суурь үндэс эрх чөлөөгөө хаачихгүй байхад маш нарийн зохицуулалт хэрэгтэй байгаа.

Ер нь олон улсад энэ чиглэлээр хамгийн анхны зохицуулалтыг 2017 онд

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХБНГУ баталсан. Тэгээд 2018 онд тэдний хууль хэрэгжиж эхэлсэн. Энэ амжилттай сайн явж байгаа. Тэгэхдээ энэ хуулийн дагуу ЗГ-ын хүлээх үүрэг хариуцлагууд хэр нэмэгдэх вэ? Мөн энэ хуулийг хэрэгжүүлэх явцад олон улсад нэлээд түгээмэл хэрэглэгдэж буй хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт гэдгийг хэр дэмжиж урамшуулж өгөх вэ? Тухайлбал зарим нэг судалгаанаас ингээд харахад нэр төр нь зөрчигдсөн эсвэл хэвлэл мэдээлэл юм уу тухайн сошиал контентоор үзэн ядуулсан гэдэг юм уу хэн нэгний дайралтад өртсөн хүн бол ихэнхдээ тухайн сайт руу хүсэлт гаргадаг. Сайтыг сайт гэдэг юм уу тухайн сошиал сүлжээний админ хариуцагч нь тухайн контент гэдэг юм уу тухайн коментыг устгаж өгөх үүргээ зарим үедээ хэрэгжүүлдэггүй байгаа. Уг нь бол хэрвээ хэвлэл мэдээлэл маань өөрийн зохицуулалтынхаа дагуу ёс зүйгээ ингээд сахиад явж байгаа тохиолдолд заавал ийм хуулиуд шаардлагагүй байгаа. Тэгээд зүгээр энэ хууль маань хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон нийтийн оролцоо, иргэний нийгмийн оролцоог сайн хангаж болох шаардлагатай байна. Болж өгвөл хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтаар тэр хүний нэр төрд халдсан, хэн нэгнийг ялгаварласан, хэн нэгнийг хүчирхийлэлд өдөөн турхирсан гэдэг юм уу, бага насны хүүхдийг садар самуунд уриалан дуудсан энэ контентуудаа өөрсдөө устгаж байх ёстой юм. Тэгж чадахгүй байгаа учраас яах аргагүй хууль орж ирж байна гэж харж байна.

Тэгэхээр ийм 2 асуулт байна. Ер нь энэ цахим орчинд хүнийг үзэн ядсан, гүтгэн доромжилсон, тэр байтугай хүнийг амиа хорлоход хүргэсэн ийм гэмт хэргүүд нэлээд гарч байгаа. Тэгэхээр энэ чиглэлийн судалгаанууд хэр хийгдсэн бэ? Энэ төслийг боловсруулах явцдаа хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагууд болон эрдэмтэн судлаачдын саналыг хэр авсан бэ?

2 дугаар асуулт нь, ер нь энэ олон улсын энэ гол медиа, сошиал медиа томоохон компаниудтай энэ хуулийг хэрэг гаргасны үр дүнд хэрхэн дэвшилтэй ажиллаж чадах вэ? Бид нар ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Өчигдөр ХЗБХ-ны хуралдаж, Байнгын хороо хуралдаад Мөнхцэцэг гишүүнийг Хүний эрхийн дэд хорооны даргаар сонгосон. Мөнхцэцэг гишүүндээ хүний эрхийн дэд хорооны даргаар сонгогдон томилогдсон явдалд УИХ-ын гишүүдийнхээ нэрийн өмнөөс бас баяр хүргэж амжилт хүсье. Мөнхцэцэг гишүүний асуултад Учрал сайд хариулъя.

Н.Учрал: Энэ хууль гарснаараа хүний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд ямар ч хязгаарлалт бий болгохгүй. Яагаад гэхээр тавдугаар зүйл дээр үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх, хүнийг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байхыг хуульчилж өгсөн. Зарчим дээрээ. Дээрээс нь зөрчилтэй контентуудыг ялгаж өгсөн. Зөрчилтэй контентууд дотор хүний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх тэр асуудлыг ерөөсөө огт оруулаагүй. Ерөөсөө л зөрчилтэй контент гээд л хатуу энэ нэг 11 заалтыг тавьчихсан юм. Энэ 11 заалтын хүрээнд л ажиллана. Түүнээс биш энэ өөрөө гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх тэр шүүх хяналтын байгууллагын ажлыг хийх хууль биш учраас энэ урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хууль учраас бид ерөөсөө л тэр контент нь өөрөө яг хүүхдийн бие махбод, оюун санаа, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлж байна уу. Хүчирхийлэл, садар самууныг сурталчилж байна уу, хүнийг заналхийлж байна уу, амиа хорлоход уриалж байна уу, экстермист үйл ажиллагаа явуулахад нөлөөлж байна уу, террорист үйлдэл хийхийг сурталчилж байна уу, өдөөн турхирч байна уу. Цахим гадуурхлыг бий болгож байна уу, оюуны өмчийн эрхийг зөрчиж байна уу. Гэмт хэрэг, зөрчлийн үйлдлийг нарийвчлан зааварчилсан өдөөн турхирсан хандлага байна уу. Тэгээд мэдээллийг нийтлэгдсэн олон нийтийн

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

сүлжээнд нөхцөл шаардлага буюу тухайн олон улсын тэр үйлчилгээ үзүүлэгч байгууллагын үндсэн стандартыг зөрчиж байна уу гээд ерөөсөө л энэ хүрээндээ л явна. Энэ хүрээнээс халих юм бол энэ хуулийн асуудал гэхээсээ илүүтэйгээр тэр гэмт хэргийн ямар нэгэн бүрэлдэхүүнтэй бол хууль хяналтын байгууллага өөрсдөө шийдвэрлэж явах.

Дээрээс нь энэ хуулийн онцлог бол энэ хууль бүхэлдээ хэрэглэгчийг үүрэгжүүлэх гэхээсээ илүүтэйгээр энэ ЗГ-ыг үүрэгжүүлсэн хууль. Төрийг үүрэгжүүлсэн хууль шүү. Яагаад гэхээр энэ хууль батлагдсанаараа маргааш нь хэрэгжихээсээ илүүтэйгээр ЗГ-ын л ажил болж эхэлнэ. Олон улсын үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай харилцан тохирч төлөөлөгчийн газраа байгуулах, баталгаажсаны дагуу утасны дугаараар бүртгэх, тэр кибер төв нь дэргэдээ олон нийттэй харилцах нэгжээрээ иргэдийнхээ санал хүсэлтүүдийг нь аваад хүний эрхийн зөрчилтэй, зөрчилтэй контент хийвэл холбогдох байгууллагуудад нь шилжүүлээд зохих арга хэмжээнүүдийг авдаг. Энэ дээр нь мониторинг хийгээд ингээд хурдан хугацаанд иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах чиглэлээр ажиллаж байдаг. Аль болох тэр садар самууныг сурталчилсан янз бүрийн контентуудыг илүү түгээхгүй байх үүднээсээ тэр зөрчилтэй контентуудыг хууль хяналтын байгууллагад нь шилжүүлээд түр хугацаанд ч гэсэн тэр садар самуун, бэлгийн хүчирхийллийг сурталчлаад байгаа контентуудыг нь хэсэг хугацаанд ч гэсэн хязгаарлалт хийчихдэг тэр боломж нь зөвхөн цаад дээр олон нийтийн үйлчилгээ үзүүлэгч нар авч хэрэгжих учраас. Тэгээд бид өнгөрсөн хугацаанд зүгээр судалгаа гэвэл нээрээ юу гэдэг юм уншаад ч дуусахгүй их судалгаа байгаа. Тэгээд бид нар уншсан, судалсан, ажилласан, 10 гаруй хуулийн төслүүдтэй холбогдуулаад маш их судалгаа хийгдсэн юм байна лээ. Тэр судалгаануудыг та Хүний эрхийн дэд хорооны даргын хувиар танилцахад бол та хэдэн өдөр уншаад

дуусахгүй их магадгүй сар жилээр унших тийм их ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Мөнхцэцэг гишүүн тодруулах юм уу. Мөнхцэцэг гишүүн тодруулж асууя.

Ц.Мөнхцэцэг: Энэ хуулийг баталснаар энэ манай ЗГ-ын зүгээс энэ олон улсын гол үйлчилгээ үзүүлэгч youtube, твиттер, фэйсбүүк гээд тэгээд тэр компаниудтай хэр амжилттай ажиллаж чадах вэ? Германы жишээгээр энэ 2018 оны 1 сарын 1-нээс хэрэгжээд зөвхөн эхний хагас жилдээ гэхэд энэ нэр дурдсан гол компаниуддаа маш амжилттай ажиллаад, тухайлбал тийм ээ, фэйсбүүк дээр 362, твиттер дээр 28000, youtube дээр 58000, гүүгл дээр 1277 контентуудыг устгаж чадсан байна лээ. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар бид нар энэ гол энэ провайдер компаниуддаа үнэхээр амжилттай сайн ажиллаад цахим орчин дахь энэ үзэн ядсан үг хэллэг, хүчирхийлэл, садар самуун, үндэсний аюулгүй байдлын эсрэг энэ мэдээ контентуудыг амжилттайгаар цахим орчныг эрүүл болгох тийм эрх зүйн боломж дэвшил гарах уу?

Л.Мөнхбаатар: Учрал сайд тодруулгад хариулья.

Н.Учрал: Гомдол шийдвэрлэх механизм л энэ хуулиар бий болно, тогтолцоотой болно. Тэр нь гэмт халдлагын шинжтэй бол Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дэргэд байгаа тэр нийтийн төв, үндэсний төв өөрөө хариуцаад тэр гэмт халдлагыг бууруулах чиглэлээр ажиллана гэдгээрээ онцлогтой. Дээрээс нь бид өнгөрсөн хугацаанд тэр сүлжээ үйлчилгээний үзүүлэгч нартай хэд хэдэн уулзалт хийсэн учраас дотоодын хууль тогтоомжоо баталчхаад тэгээд дараагийн харилцаануудыг яриад явна гэж байгаа. Цаанаасаа барьж байгаа стандартуудыг нь л ерөнхийдөө бас хуульд нэлээн тусгай зөвлөмжүүдийг бол авсан учраас дэвшил гарна л гэж ингэж үзэж байгаа.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тэгэхээр энэ хуулийн онцлог бол иргэдийг нэг их тийм үүрэгжүүлэх тийм хууль ерөөсөө биш. Ерөөсөө бараг тийм зохицуулалт байхгүй. Энэ бол яг төрийн үүрэг талдаа илүү тодорхой болж байгаа. Сүүлд энэ манайд 2.8 сая хэрэглээд байгаа жишээ нь тэр олон нийтийн үйлчилгээ үзүүлэгч нарын нэг байгууллага фэйсбүүк компани гэхэд ингэж хэлсэн. Монгол хэлтэй хүмүүс бид нар ажилд аваад ажиллуулж байгаа юм. Түрүүн бас Мөнхбаатар дарга хэлж байна. Нөгөө Монгол хэлтэй хүмүүс тухайн компани ажилд аваад ажиллуулж байгаа. Та нар үнэхээр албан ёсны харилцах сувгаараа хийх юм бол манай тэр Монгол хэлтэй Монгол залуучууд манайд ажиллаж байгаа тэр хүмүүс чинь тэр гомдол маргааныг чинь шийдвэрлээд ингээд та нартай харилцаад явахад бүрэн бололцоотой. Бид өөрсдөө шийдэх гээд манлайлал үзүүлээд тэгээд бид ингээд Монгол хүн хүртэл ажилд аваад та нартай харилцах гэхээр та нар чинь хаана хамаагүй захидал бичдэг. Яах гээд байгаа нь мэдэгдэхгүй, хэн харилцаад байгаа нь ч ойлгомжгүй. Ямар сувгаар дамжих гээд байгаа нь ч ойлгомжгүй. Ийм байдалтай байна.

Дээрээс нь Монгол Улсад бид нар бүр албан ёсны тэр итгэмжлэгдсэн фак чек гээд байгууллагыг хүртэл байгуулчихсан. Наад хүмүүстэйгээ та нар харилцаач ээ. Бид нартай ингээд нягт ажиллах юм бол манай энэ фэйсбүүк орчинд дэвшлүүд гарна гэдгээ хэлсэн.

Л.Мөнхбаатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би энэ хуулийг зарчмын хувьд үзэл баримтлалын хувьд хэлэлцэх нь зүйтэй. Дэмжих нь зүйтэй гэж ингэж бодож байгаа. Ер нь сэтгэл санааны хохирлыг үнэлдэг, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр хохирлыг барагдуулдаг болсон. Тэгвэл сүүлийн үед цахим орчинд ерөөсөө сэтгэл санааны хохирлыг тооцож байгаа юм ерөөсөө

байхгүй байгаа л даа. Сүүлийн үед шүүхээр гэхээсээ илүүтэйгээр социал орчинд хүнийг ялладаг, цоллодог, нэр хүндийг нь гутаан доромжилдог, алдар хүндэд нь халддаг олсон. Тэгээд түүний хохирлыг хэн ч тооцож ярихгүй байгаа өнөөдөр. Хамгийн сүүлийн жишээ гэхэд л нүүрсний хэрэгт хэчнээн олон хүмүүсийг холбоотой гээд л нэр усыг нь зарлачихсан. Үнэн худал нь мэдэгдэхгүй. Тэгээд үндсэндээ бараг шүүхээс өмнө ялчлаж байгаа юм. Тэр улсуудын зүгээс үзэхэд тэр хүмүүсийн ар гэр, ах дүү, найз нөхөд, үр хүүхдүүдэд сэтгэл санааны болоод ямар их хохирол учирч байгаа билээ гээд. Тэгээд энэ хууль батлагдсанаар сэтгэл санааны хохирлыг тооцох тэр хариуцлагын асуудал бас байх ёстой л гэж би хувьдаа үзэж байгаа шүү. Энэ дээр бас хэлэлцүүлгийн үед бас энэ байр сууриа илэрхийлнэ ээ. Энэ дээр бас хууль санаачлагч бас юу гэж үзэж байгаа вэ?

Хууль батлагдсанаар энэ хуурамч аккаунтууд, тролууд сүүлийн үед Монголын төр чинь бараг социалд хөтлөгдөж, социалд нийцэж шийдвэр гаргадаг болох гээд байна шүү дээ. Зориуд бараг ингэж Монголын төрийн шийдвэрт нөлөөлөх байдал үзүүлдэг болсон байна. Тэгээд үндсэндээ сүүлдээ бараг 20000-аас дээш дагагчтай фэйж аккаунтуудыг худалдаж авдаг, 500000 дагагчтай фэйжийг 500 сая төгрөгөөр үнэлж байх жишээтэй. Ийм болчихсон байна. Ингээд ерөөсөө хэдхэн хүмүүс хэдхэн мөнгөтэй улсууд, улс төрч нар улс төрч нарыгаа намнах, улс төрийн намууд бусад улс төрийн намуудаа намнах ийм хэрэгсэл болгочоод явж байна шүү дээ, өнөөдөр. Энэ хууль батлагдсанаар энэ аккаунтыг чинь өнөөдөр ч гэсэн өнөөдрийн байгаа нөхцөл бололцоогоор бол цахим шуудан болоод утасны хаягаар л үүсгэж байгаа шүү дээ. Энэ хуулиар ч гэсэн энэ байдал яг хэвээрээ л байх юм байна. Тэгээд цаашдаа энэ хуурамч акаунтуудыг хязгаарлах энэ хууль батлагдсанаар хэдэн зуун мянга, саяараа байгаа энэ хуурамч акаунтуудыг хязгаарлах гэдэг юм уу, хүчингүй болгох ийм бололцоо боломж

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

үүсэх үү. Энэ чинь эргээд Монголын үндэсний аюулгүй байдал, Монгол төрийн бодлогод нөлөөлөх гэж байна шүү дээ. Магадгүй зарим нь санаатай байлгахыг хүсдэг хүмүүс байхыг үгүйсгэхгүй байхгүй юу. Албаар ийм троллуудыг бий болгож байгаж тэгээд нийгэм нийтээрээ ингэж үзэж байгаа юм шиг ийм байдлыг төөрөгдүүлж бий болгодог. Энэ дээр нэг хууль санаачлагч маань бас тайлбар өгөөч ээ.

Би энэ зөрчилтэй контентын 11 заалтыг уншлаа. Зөвхөн гутаан доромжлох гэдэг асуудал орж ирсэн байна. Би үүн дээр нэмээд хэлэлцүүлгийн үед бас байр сууриа илэрхийлье. Хүний алдар, нэр хүндийг гутаан доромжлох гэдэг асуудлыг заналхийлэх гэдэг л асуудал орсон байгаа байхгүй юу. Гутаан доромжлох ороогүй байна. Гутаан доромжлох, алдар хүндийг гутаан доромжлох гэдэг асуудлыг оруулж өгмөөр байна. Хууль санаачлагч аа. Бусад зүйлүүд нь болж байна. Өнөөдөр заналхийллээ. Дийлэнх олонх сошиалаар нь үндсэндээ л гутаан доромжилж байгаа. Нотлогдоогүй баримтаар хүнийг гүтгэж гүжирдэж байгаа. Энэ нь сонгуулийн үеэр бүр их гарч ирдэг. Тийм учраас тэр зөрчилтэй контент дээр заналхийлэхээс гадна нэр хүнд, алдар хүндийг гутаан доромжлох гэдэг заалтыг бүр бас оруулж өгмөөр байна. Энэ дээр та бүхэн бас ямар байр суурьтай байна вэ гэдэг ийм 2, 3 асуулт асууя. Баярлалаа.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал сайд.

Н.Учрал: Сандаг-Очир гишүүн их чухал асуудлыг хөндөж байна. Тэгээд бид бас нэг зүйлийг ойлголтоо бас нэг болгох хэрэгтэй. Энэ хууль өөрөө Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль биш, тэр Японд мөрддөг цахим мөрдлөгийн хууль ч биш. Энэ хууль цахим орчинд бүртгэгч, мөрдөн байцаагч ажиллуулах гээд байгаа хууль ерөөсөө биш. Энэ хууль гэмт хэрэг болохоос урьдчилан сэргийлэх хууль л гэж ойлгох ёстой. Өнөөдөр садар

самууныг сурталчилсан нэг пост нийтлэгдээд түүнийг нь санаатай, санамсаргүй байдлаар хэн нэгэн нь шэйрлээд түгээгээд, ингээд түүнийг нь иргэн өөрөө хууль хяналтын байгууллагад өгөхөд хууль хяналтын байгууллага түүнийг нь шийдэх гэж 3, 4 сар болоход аль хэдийн таны яриад байгаа сэтгэл санааны хохирол хэмжээлж тооцошгүй хохирол бий болчихсон байдаг. Энэ хууль гарснаараа үнэхээр энэ садар самууныг сурталчлаад, ийм бэлгийн хүчирхийллийг сурталчилж байна гээд тэр пост нийтлэгдэхэд энэ зөрчилтэй контентод тооцогдож байвал тэр 72 цагт нь хянан шийдвэрлээд хууль хяналтын байгууллагад нь шилжүүлээд тэр үйлчилгээ үзүүлэгч тэр фэйсбүүк бусад сүлжээ рүүгээ шилжүүлээд тэр ногоон суваг руу нь шилжүүлээд бусад хүний эрхийн комисс руу шилжүүлэхэд тухайн байгууллага зохих, зохих үүргээ биелүүлчихэд ядаж тэр үйлчилгээ үзүүлэгч байгууллага энэ зөрчилтэй контент юм байна гээд 2 хоногийн хугацаанд ч хамаагүй түр түдгэлзүүлэх юм бол тэр гэмт хэрэг түгээн дэлгэрэх, тэр сэтгэл санааны тооцож болшгүй их хохирол учрахаас урьдчилан сэргийлэхэд л үүнийг хийх гээд байгаа юм. Түүнээс хууль хяналтын байгууллагуудад шилжүүлээд прокурорын яллах дүгнэлт үйлдсэн бичгийг нь хүлээгээд фэйсбүүк нь цаанаасаа хүлээгээд тэр үнэхээр үүнийг ингээд шүүхээр шийдэж ээ гээд явуулахад аль хэдийн тэр гэмт хэрэг чинь тарна, түгэн дэлгэрээд бүр аль хэдийн тооцож болшгүй хохирол бий болчихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ процессууд өмнө нь энэ асуудлыг шийдэх ёстой.

Дээрээс нь тэр хуурамч акаунтид гээд байгаа экаунтуудыг цэгцлэхийг Фэйсбүүк компани бүр хамгийн эхний зорилтоо болгоод хиймэл оюун ухаанаар шийдвэрлээд явж байхад бид нар үүн дээр нь хамтарч туслалцаа үзүүлэх л ийм чиг шугамтай болж байгаа юм. Хурдлуулах. Тэр байгууллага бүр Монгол хэлтэй хүн хүртэл томилоод ажиллаж байхад түүн дээр нь бид нар хамтран ажиллачих юм

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

бол хуурамч тролуудтай тэмцэнэ. Хуурамч тролууд сошиал орчинд нь шийдвэр гаргадаг, сошиал орчинд нөлөөлдөг, одоо ингээд улс төрчдийн ард нэр бүхий янз бүрийн тролууд ажилладаг гэдгийг энэ хэл ам, хэрүүл шуугианаас айгаад хэдий болтол ийм эмээгээд энэ хуулийг батлахгүй өнгөрөх юм бэ гээд. Намайг энэ хуулийг ингээд оруулж ирснээрээ ЗГ-ыг оруулж ирснээрээ эрхэм тролчид над руу зүй бусаар дайрч доромжлохоос би айхгүй ээ. Би Монгол төрд ажиллаж байгаагийн хувиар би түүхэн үүргээ гүйцэтгэж байна гэж бодож байгаа. Тролчид намайг янз бүрээр барьж идэж болно. Түүнээс би буцахгүй. Тийм учраас энэ хуулиа батлаад гарна. Энэ бол Монголын ирээдүйд барьж байгаа би бас төрд зүгтэсний миний хамгийн том үүргээ би биелүүлж байна л гэж бодож байна.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Санал хураалт явуулах тул гишүүд чуулганы танхимд цуглана уу.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Байнгын хорооны саналаар олон нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд чуулганы танхимд цуглая.

ХЗБХ-ны гишүүд, Инновац, цахим бодлогын байнгын хороо санал хураалт явуулъя. Энэ олон улсын нөхцөл байдал, 2023 оны дэлхийн том эрсдэлүүдийн

нэгээр энэ хиймэл оюун ухааныг тулгуурласан нийгмийн сүлжээ зэвсэг болж ашиглагдах магадлал энэ 23 онд оргилдоо хүрнэ гэж үзсэн. Энэ хүний эрхийн зөрчил талаасаа ч тэр, нийгмийн аюулгүй байдал талаасаа ч гэсэн бүр олон улсын хэмжээний эрсдэлд тооцогдож байгаа ийм асуудал байгаа. Тэгээд үүнийг манай зарим гишүүд бас ажлын хэсэг байгуулъя гэж байгаа саналууд байж болно. Асуудалгүй. Байнгын хороогоор хэлэлцээд шийдчихвэл чуулган завсарлах хугацааг ирэх 7 хоногт болгож хойшлуулна. Яагаад гэвэл ирэх 7 хоногоос 2 дугаар сарын 20 хүртэл ард түмнээ сонсох энэ Боловсролын багц хууль, Нийгмийн даатгалын багц хууль энэ томоохон реформын хуулиуд, бас Үндсэн хуультай холбоотой ч асуудлууд яригдаж байна. Үүгээр бүх гишүүд тойрогтоо ажиллана, ард иргэдтэйгээ уулзана, гадаад томилолтуудыг хязгаарлана. Тэгээд энэ ажил зохион байгуулагдах учраас чуулганыг бас ирэх 7 хоногоос гишүүд тойрогтоо ажиллахаар төлөвлөж байгаа.

Хэрвээ ажлын хэсэг байгуулаад ирэх 7 хоногт хэлэлцье гэвэл үүнийг сунгахаас, чуулган завсарлах хугацааг ирэх 7 хоногуудад болгож хойшлуулна. Үүнийгээ тэгээд Байнгын хороогоороо хэлэлцээд шийдчихээрэй.

Ингээд чуулганы нэгдсэн хуралдаанаар төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Содномын Чинзориг сайд суудалдаа суулаа.

Санал хураалт явуулъя.

26 гишүүн дэмжиж, 60,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад

бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо хуралдаж төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, төслийг нэгдсэн хуралдаанд оруулна.

Төсвийн байнгын хороо Батжаргал дарга аа, хэдээс хуралдах билээ.

13.45 цаг

Дараагийн асуудалд орно.

Монгол Улс, Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассоциац хооронд байгуулсан “ухаалаг засаглал 2” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагч илтгэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал танилцуулна. Учрал сайдыг индэрт урьж байна.

Н.Учрал: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ. Монгол Улсын ЗГ, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциацтай хамтран хэрэгжүүлэх “Ухаалаг засаг 2” төслийн зээлийн хэлэлцээрт 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр гарын үсэг зураад байна. Нэгдсэн үндэстний байгууллагаас гаргадаг иргэдийн цахим оролцооны индексээр Монгол Улс 2022 оны байдлаар 74 дүгээр байрт, Дижитал өрсөлдөх чадварын индексээр 62 дугаар байрт, олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргадаг Кибер аюулгүй байдлын индексээр 120 дугаар байрт тус тус орсон байгаа нь манай улсын хувьд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглаж авлигыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

“Ухаалаг засаг 2” төсөл нь дараах Монгол Улсын болон урт болон дунд

хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаж байна. Үүнд:

1-д, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 5.3-т хүний хөгжлийг дэмжсэн үр дүн, үр нөлөөтэй цахим засаглалыг төлөвшүүлнэ гэж,

2-т, зорилт 7.5-д төр иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж өрсөлдөх чадварыг бий болгоно гэж,

3-т, Монгол Улсын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1-д цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ гэж,

4-т, шинэ сэргэлтийн бодлогын төрийн бүтээмжийн сэргэлтийн 6.1-д төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж төрийн хүнд суртлыг бууруулна гэж тус тус заасан.

Тус төслийн нэгдүгээр үе шат болох “ухаалаг засаг 1” төслийг хэрэгжүүлсэн бөгөөд Төрийн үйлчилгээний нэгдсэн платформ системд төрийн 62 байгууллагын 816 үйлчилгээ, хөдөө орон нутагт 1016 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, ухаалаг газрын харилцааны системийг идэвхжүүлж, 103000 гаруй иргэн үйлчилгээг хүргүүлсэн. Мөн улсын бүртгэлийн байгууллагаас 342000 иргэнд тоон гарын үсгийн гэрчилгээг иргэний үнэмлэхэд суулгаж олгосон байна. Цаашид төрийн цахим үйлчилгээний суурь зөөлөн дэд бүтэц бий болгох, үндсэн болон дэмжигч системийг өргөтгөн хөгжүүлж бүх шатны төрийн байгууллагыг холбох дундын үүлэн шийдлийг нэвтрүүлж, Үндэстний дата төвийн хүчин чадлыг нэмэгдүүлж, тоон гарын үсгийн дэд бүтцийг иж бүрнээр нь шинэчлэн хэрэглээг

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

нэмэгдүүлж, төрийн байгууллагын цахим албан бичиг солилцох, хурдасгах зорилгоор “Ухаалаг засаг 2” төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассоциацаас авч ашиглах 29.5 сая зээлжих тусгай эрхийн эх үүсвэр нь жилийн тогтмол 2 хувийн хүүтэй, эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, 30 жилийн хугацаанд эргэн төлөх нөхцөлтэй бөгөөд олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь хэсэгт заасны дагуу гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ тул УИХ-аар заавал соёрхон батлуулах шаардлагатай юм.

Энэхүү Монгол Улсын ЗГ, Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассоциацтай хамтран хэрэгжүүлэх “Ухаалаг засаг 2” төслийн зээлийн хэлэлцээр соёрхон батлах асуудлыг хэлэлцэн УИХ-ын чуулганаар дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Энхтайваны Бат-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Э.Бат-Амгалан: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас УИХ-аар нэн яаралтай хэлэлцүүлэхээр 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улс, Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассоциац хоорондын “Ухаалаг засаг 2” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 77 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны дарга Б.Энх Амгалан дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцсэн талаарх 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн тус Байнгын хорооны санал, дүгнэлтээр ЗГ-т чиглэл болгож хүргүүлсэн үүргээс 4-ийг нь тусгаагүй байгааг цаашид анхаарах нь зүйтэй гэдгийг Ажлын хэсэгт анхааруулсан болно. Тухайлбал 1. гэрээний хуваарь, номер нэг бүрэлдэхүүн хэсэг 1. Дижитал шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх гэсэн хэсэгт дараах зүйлийг нэмж тусгах. Дижитал шилжилтийн үндэс болох кибер аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Кибер аюулгүй байдлын тухай багц хуулийг дагалдан гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Кибер аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцаанд орж буй төр, хувийн хэвшлийн байгууллагуудын албан хаагчдыг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх, ялангуяа онц чухал мэдээллийн дэд бүтэц бүхий байгууллагын ажилтан, албан хаагчдад зориулсан сургалт хөтөлбөрийг шат дараатай хэрэгжүүлэх дэмжлэг үзүүлэх, 2. гэрээний хуваарь, номер 1 бүрэлдэхүүн хэсэг 2. Дижитал засгийн шилжилт гэсэн хэсэгт дараах зүйлийг нэмж тусгах. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын кибер аюулгүй байдлын түвшнийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, алба хаагчдыг сургах чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, 3. гэрээний хуваарь номер 1. бүрэлдэхүүн хэсэг 2. Дижитал засгийн шилжилт 2.3 дугаар зүйлийн А хэсэгт кибер аюулгүй байдлын тухай хуулийн 21, 22 дугаар зүйлд заасан Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх Үндэсний төв болон нэгдсэн төвийг байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, программ хангамж авах, төвүүдийн хүний нөөцийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх гэж нэмэх, 4. Гэрээний хуваарь. Номер 1. бүрэлдэхүүн хэсэг 3. Дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжих 3.1 дүгээр зүйлийн А, Б, В, Г. Д хэсэгт заасан

зүйлсийг бүхэлд нь өөрчилж Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 4.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлд заасан онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй 216 байгууллага, 4.1.17-д заасан төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдсон 166 байгууллагын ажилтан албан хаагчдыг сургах, мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэж нэмэх гэсэн асуудлуудыг тусгах хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж 81.8 хувийн саналаар соёрхон батлах нь зүйтэй гэж үзлээ.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улс, Дэлхийн Банкны Олон улсын хөгжлийн ассоциац хоорондын “Ухаалаг Засаг 2” төслийн зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Бат-Амгалан гишүүнд баярлалаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх УИХ-ын гишүүд байна уу. Алга байна.

УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу эцэслэн батлах санал хураалтыг Баасан гаргийн 10 цагт явуулна.

13.48 цаг

Дараагийн асуудалд орно.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг.

2 цаг болсон байна. Гишүүд чуулганы танхимд цуглаарай.

Сандагийн Бямбацогт сайдыг.

Хууль санаачлагчийн илтгэлийг Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Индэрт урьж байна.

Хууль санаачлагчийн илтгэлийг ЗТХ-ийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна.

С.Бямбацогт: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Төмөр замын тээврийн тухай хууль анх 2007 онд батлагдсан. Өнгөрсөн 16 жилийн хугацаанд төмөр замын салбарт олон өөрчлөлт бий болсонтой холбоотойгоор уг хуулийн төслийг үндсээр нь шинэчлэх ийм шаардлага үүссэн. Тухайлах юм бол төмөр замын салбарт өмчийн олон хэлбэр бүхий хуулийн этгээд бий болж, хэрэглэгчийн тоо эрс өссөн. 2010 оны байдлаар суурь бүтэц эзэмшигч нэг байсан бол өдгөө суурь эзэмшигч 4, тээвэрлэгч 4 суурь бүтэц барих, угсрах эрх бүхий 253, дагнасан болон салбар зам талбай хөдөлгөх бүрэлдэхүүн 250 ААН болж нэмэгдээд байна.

Зөвхөн 2022 онд үндэсний төмөр замын сүлжээний урт 2964 километр болж өмнөхөөс 40 орчим хувиар нэмэгдсэн. Тухайлбал Зүүнбаян Ханги, Таван толгой Гашуун сухайт, Таван толгой Зүүн баян чиглэлийн 876 километр төмөр замын бүтээн байгуулалтын барилгын ажил дуусаж, төмөр замаар хийх экспортын 2 болон 3 дахь гарцтай болсон. Цаашид төмөр замын сүлжээ улам өргөжих төлөвтэй байна.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нийт 11 бүлэг, 49 зүйлтэй бөгөөд ХБНГУ, ОХУ, БНХАУ, БНСУ зэрэг орны төмөр замын тээврийн хуулийг харьцуулан судалж боловсруулсан. Хуулийн төслийн гол зорилт нь төмөр замын тээврийн суурь бүтцийг шинээр барих, өргөтгөх, суурь бүтэц болон

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хөдлөх бүрэлдэхүүнийг өмчлөх, ашиглах, зорчигч, ачаа тээвэрлэх, тээврийн аюулгүй байдлыг хангах, ажилтны нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэгдсэн. Хууль батлагдсанаар төмөр замын тээвэрлэлттэй холбоотой суурь харилцаа илүү тодорхой, оновчтой зохицуулагдаж, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцогчийн тэгш оролцоог хангаж, суурь бүтэц болон хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, засвар үйлчилгээ сайжирч, хөрөнгө оруулалт, тээврийн үр ашиг нэмэгдэх юм.

Төмөр замын ажлын нийгмийн баталгаа сайжирч, тэдний тогтвортой ажиллах нөхцөл боломж бүрдэж, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй холбоотойгоор ажилтныг эрүүл мэндийн үзэлд хамруулах асуудлыг илүү тодорхой зохицуулна.

Төмөр замын тээврийн салбарт төрийн бодлого, нэгдмэл уялдааг хангах, төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг төлөвлөлтдөө хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм. Түүнчлэн төмөр замын тээврийн сүлжээг өргөжүүлэн олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний өмчлөл, эзэмшил, ашиглалтын эрх зүйн орчин илүү сайжирч, боловсронгуй болно. Олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилт техник, технологи эзэмших, инновацад нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах боломж бүрдэж, тээврийн үр ашиг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчлэн найруулга батлагдсанаар төмөр замаар хийх экспорт, импорт, транзит тээврийн хэмжээ нэмэгдэж, төмөр зам дагасан хөгжил хурдсаж, зам тээврийн салбарт шинэ сэргэлт улам эрчимжих боломж нээгдэнэ гэж үзэж байна.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Төмөр замын тээврийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Содномын Чинзориг танилцуулна.

С.Чинзориг: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцсэн.

Хууль санаачлагч төмөр замын тээврийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, суурь бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийг тасралтгүй хэвийн найдвартай үйл ажиллагааг хангуулах, үйлдвэрлэл, техникийн үйлчилгээ засварыг өргөжүүлэх, зориулалттай тусгай болон хамгаалалтын бүс, зурвас газрыг эзэмших, ашиглахтай холбоотой зохицуулалт, төмөр замын суурь бүтцийн өмчлөл, эзэмшил, төмөр замын үйлчилгээ, түүнд тавигдах шаардлагыг тодорхой болгох, хэрэглэгчдэд найдвартай аюулгүй үйлчилгээ үзүүлэх, төмөр замын суурь бүтэц, эзэмшигч болон тээврийн үйлчилгээтэй холбоотой хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагатай байх, галт тэрэгний болон сэлгээний хөдөлгөөнтэй холбоотой ажилтны эрүүл мэнд, нийгмийн баталгааг хангаснаар тогтвортой ажиллах нөхцөл бүрдэх боломжтой гэж үзсэн хуулийн төслийг боловсруулжээ.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг D Parliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Х.Булгантуяа, Д.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, Н.Ганибал, Ч.Хүрэлбаатар, О.Цогтгэрэл нар төмөр замын тээврийн үнэ тариф, төмөр замын суурь бүтцийн бүтээн байгуулалтын үр ашиг, чанар, хөрөнгө оруулалтыг хэрхэн нэмэгдүүлэх, ажилтнуудын эрүүл мэнд, дүрэмт хувцас, нийгмийн баталгаа хангах талаар гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг хэрхэн татах, хуулийн төсөлд тусгай зөвшөөрөл нэмэхээр оруулж ирсэн нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан нээлттэй сонсгол болон эрсдэлийн үнэлгээ хийсэн байх гэсэн зарчмыг хангасан эсэх талаар, Монгол, Оросын хувь нийлүүлсэн төв УБТЗ-ын нийгэмлэгийг байгуулах тухай 1949 оны хэлэлцээрээр одоо хүртэл эдэлж байгаа тарифын хөнгөлөлтүүдийн талаар асуулт асууж хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдааны хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Д.Бат-Эрдэнэ төмөр замын тээврийн тарифыг бодитоор тогтоож, олон нийтэд ил тод мэдээлэх, УИХ-ын гишүүн Б.Баттөмөр шинжлэх ухаан, технологийн дэвшлийг нэвтрүүлэх тал дээр ОХУ-тай хамтран ажиллах, төмөр замын тээврийн үнэ тариф, суурь бүтцийн асуудал дээр онцгойлон анхаарах тухай саналуудыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Төмөр замын тээврийн тухай хуулийн

шинэчилсэн найруулгын төсөл, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай шинэчилсэн найруулга хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн хэлэлцэн хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүд байна уу. Алга байна. Үг хэлэх гишүүн алга байна.

Санал хураалт явуулна. 2 Байнгын хороо хуралдаад ирцгүй болчихоод байна. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу. Алга байна.

УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14.12-т заасны дагуу санал хураалт явуулах цагийг жич зарлах болно.

2 Байнгын хороо хуралдаж байгаа учраас санал хураалт явуулах боломжгүй. Санал хураалтыг хэлэлцэх эсэх санал хураалтыг дараа явуулна. Ажлын хэсэгт баярлалаа.

Энэ “Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг Төсвийн байнгын хороо хэлэлцэж байгаа.

Хууль санаачлагч байхгүй учраас үүнийг хойшлууллаа.

Шүүхийн тухай хууль. Хууль санаачлагч байхгүй учраас Шүүхийн

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хойшлууллаа.

Үүнийг дараагийн асуудлыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хэлэлцэж байгаа. Хэлэлцээгүй орж ирээгүй байна.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн тухай хуулийг сая ХЗБХ хуралдсан, дууссан уу. Материал олшруулж байгаа юм уу?

14.07 цаг

Хууль санаачлагч алга байна, хойшлууллаа.

Ингээд **Коронавируст халдвар Ковид-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэй хэлэлцэж, хяналт тавих шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Түр хорооны ажлын дүнг танилцуулна.**

Түр хорооны ажлын дүнг УИХ-ын гишүүн, түр хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баттөмөр: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Коронавируст Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хугацаа 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсонтой холбогдуулан Монгол УИХ-ын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор байгуулагдсан Коронавирусийн халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэй хэлэлцэж хяналт тавих

шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Түр хорооноос Монгол УИХ-ын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу ажлынхаа дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

2019 оны 12 дугаар сарын сүүлээр БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хотод уушгины хатгаа өвчний дэгдэлт анх бүртгэж байсан бол 2020 оны 01 дүгээр сарын 27-нд тус өвчин нь шинэ төрлийн вирусээр үүсгэсэн болохыг тогтоосон байдаг. ДЭМБ-аас 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр коронавируст халдварыг олон улсын шинж чанартай нийгмийн эрүүл мэндийн онц байдал, 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр цар тахал хэмээн нэрлэсэн. Тухайн үеийн Дэлхийн улс орнуудын коронавируст халдварын байдлыг харгалзаж Монгол Улсад 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр коронавируст халдварын анхны зөөвөрлөгдсөн тохиолдол илэрсэнтэй холбогдуулан Монгол УИХ-аас шуурхай арга хэмжээ авч, 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Коронавируст халдвар, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг баталж, хуулийн биелэлтэд хяналт тавих Түр хороог 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан.

УИХ-ын 8 дахь удаагийн сонгуулиар байгуулагдсан УИХ 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 31 дүгээр тогтоолоороо түр хороог дахин байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. УИХ-аас цар тахлын эрсдэлтэй цаг үеийг даван туулах, халдварын тархалтыг сааруулах, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүндрэл, сорилт дагуулсан асуудлуудыг оновчтой шийдвэрлэх үүднээс уг хуульд нийт 8 удаа өөрчлөлт оруулснаас гадна хуулийн үйлчлэх хугацааг 2 удаа өөрчилсөн байдаг. Тухайлбал, УИХ-аас хэрэгжих хугацааг 2021 оны 7 дугаар сарын 1-нийг

хүртэл, 2022 оны 12 дугаар сарын 31-нийг дуустал гэж 2 удаа сунгасан.

Түр хороо нь уг хуулийн 6.1.3-т энэ хуулийн биелэлтийг сар тутам нээлттэй хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн биелэлт болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг сар тутам нээлттэй хэлэлцэж ирсэн болно. Тухайлбал, түр хороо тайлант хугацаанд нийт 14 удаа хуралдаж, Монгол Улсын ЗГ, Онцгой комисс, ЭМЯ, Монголбанк, СЗХ, ХЭҮК, нийслэлийн Онцгой комисс, НБГ, НЭМГ болон холбогдох бусад байгууллагуудын мэдээллийг 31 удаа сонсож, хуулийн хэрэгжилттэй холбогдуулан үүрэг, даалгавар чиглэл өгч ажиллалаа.

2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар нийтэд Коронавируст халдвар цар тахлын халдварын 671.5 сая тохиолдол бүртгэгдэж, 6.7 сая хүн харамсалтайгаар нас барсан гэдэг мэдээллийг ДЭМБ-аас гаргажээ. Манай улсад коронавирүсийн халдвар цар тахлын батлагдсан 1007843 тохиолдол бүртгэгдэж өнөөдрийн байдлаар халдварын тохиолдол батлагдсан 2136 хүн нас барсан байна. Батлагдсан тохиолдолд эзлэх нас баралтын хэмжээ дэлхийн дунджаар 1.02 хувь байгаа. Номхон далайн бүст 0.28 хувь байхад Монголд 0.21 хувь буюу харьцангуй бага байгаа нь Монгол УИХ, ЗГ, Онцгой комиссоос холбогдох арга хэмжээнүүдийг авч холбогдох шийдвэрүүдийг цаг алдалгүй гаргаж, арга хэмжээг хугацаа алдалгүй авч, ажлаа оновчтой шуурхай зохион байгуулж чадсан.

Эрүүл мэндийн болон холбогдох яамд, аймаг, НЗДТГ, мэргэжлийн байгууллагууд, ард иргэд, ААН-үүд хаана хаанаа хичээн ажиллаж, хамтран ажилласны үр дүн гэж үзэж байна. Манай улсад цар тахлын эсрэг авсан хариу арга хэмжээний талаарх эерэг үзүүлэлтийг үнэлж Дэлхий эрүүл мэндийн байгууллагаас Ковид-19 цар тахлын үед хүнд хэр нь чухал шийдвэрүүдээ гаргаж,

шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авч, бэлэн байдлаа хангасны зэрэгцээ богино хугацаанд зорилтот бүлгийн хүн амаа вакцинжуулалтад хамруулж хүн амынхаа эрүүл мэндийг хамгаалж, цар тахлын давлагаануудын үеэр өндөр эрсдэлтэй иргэдийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж, хөнгөн иргэдийг гэрийн хяналтад эмчилсэн Монгол Улсын сайн туршлагыг бүсийн зарим улсуудад нэвтрүүлж болохыг онцолсон байдаг. Ковид 19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаар Монгол Улсын ЗГ-аас хийж хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг хураангуйлан дурдвал дараах байдалтай байна. Үүнд: байгууллагуудын уялдааг хангах зорилгоор байгуулсан шуурхай штаб байгуулсан, хязгаарлалтын арга хэмжээ, хөл хориог тогтоосон, тандалт судалгааг хийсэн. Вакцинжуулалтыг хийсэн. Сэрэмжлүүлэг, мэдээллүүдийг цаг тухайд нь өгч байсан. Эмнэлгийн тусламж үйлчилгээ тогтмол явсан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ мөн явсан. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ явсан. Хүний нөөцийг дайчлах, ажиллуулах чадваржуулах сургалтууд тогтмол явж байлаа. Эрүүл мэндийн туслах үйлчилгээний санхүүжилт тасалдаагүй, коронавирүст цар тахлын судалгаа шинжилгээнүүдийг тогтмол хийсэн. Коронавирүст цар тахлын үеийн тусламж, үйлчилгээнд хийсэн хяналт үнэлгээ, дотоод аудитыг бас тогтмол хийж ирсэн.

Санхүүжилтийн хувьд ковид 19 цар тархлаас урьдчилан сэргийлэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд 20 онд 4.4 их наяд төгрөг, 21 онд 5.2 их наяд төгрөг, 22 онд 1.6 их наяд төгрөг нийт 11.2 их наяд төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж зарцуулсан байна.

Нийт эх үүсвэрийн 41.9 хувийг улсын төсвийн, 25.4 хувийг гадаад зээлийн, 7.6 хувийг нийгмийн даатгалын сангийн, 2.1 хувийг орон нутгийн төсвийн, 2.8 хувийг ЭМД-ын сангийн, 10.4 хувийг ирээдүйн хувь сангийн, 9.9

хувийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн дүн байна.

2020-22 онд төвлөрүүлсэн нийт үүсвэрийн 37.9 хувь буюу 4.2 их наяд төгрөгийг эдийн засгийг идэвхжүүлэхэд, 12.5 хувь буюу 1.4 их наяд төгрөгийг ажлын байрыг хамгаалахад, 13.2 хувь буюу 1.4 их наяд төгрөгийг эрүүл мэндийг хамгаалахад, 36.4 хувь буюу 4 их наяд төгрөгийг иргэдийн орлогыг хамгаалахад тус тус зарцуулсан дүн гарсан байна. Түүнчлэн нийт зардлын 7.5 их наяд төгрөгийн мөнгөн хэлбэртэй, үлдсэн 3.7 их наяд төгрөгийг мөнгөн бус хэлбэртэйгээр зарцуулсан байна. Мөнгөн хэлбэртэй зарцуулсан зардлын 6.1 их наяд төгрөгийг иргэдийн орлогыг хамгаалах, санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд, 1.4 их наяд төгрөгийг эрүүл мэндийн салбарт, 39.9 тэрбум төгрөгийг ЗГ-ын болон Засаг даргын нөөц сангийн бэлэн байдлыг хангахад тус тус зарцуулсан байна. Нийт мөнгөн зардлын 87.3 хувь буюу 6.5 их наяд төгрөгийг бүтцийн хувьд авч үзвэл хүүхдийн мөнгө, халамж, бусад тэтгэмж, төрөөс хариуцсан цахилгааны төлбөр, ЭМД-ын санхүүжилт, цалин зэрэг хууль тогтоомжийн хүрээнд тогтоосон зардлуудаас бүрдэж байна. Эдгээр зардалд зориулагдсан мөнгөн санхүүжилтийг зориулалтын бусаар ашиглах, шамшигдуулах боломж хязгаарлагдмал юм.

Дурдсан мөнгөн зардлууд мөнгөн бус хэлбэрээр гарсан зардалтай нийлээд нийт зардлын 91.5 хувийг эзэлж байгаа нь санхүүжилтийн эх үүсвэр нь үндсэндээ зориулалтын дагуу зарцуулагдсан гэж үзэж болно.

Эрүүл мэндийн салбарт зарцуулсан 1.4 их наяд төгрөгийн 61.5 хувийн иргэдийг вакцинжуулах, эмнэлгийн багаж тоног төхөөрөмж худалдан авах, эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг хангахад чиглэгдсэн зардлууд эзэлж байгаа нь тус салбарын худалдан авалт, санхүүжилтийг олон

нийтэд ил тод нээлттэй байлгах шаардлагатайг харуулж байна.

Үндэсний аудитын газраас Коронавируст ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөө сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд ЭМЯ-нд хандаж цар тахлын онцгой нөхцөл байдалд үүссэн харилцаатай холбоотой гарсан эрх зүйн актуудын хэрэгжилтийг үнэлэх, төсвийн болон зээл, тусламжийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах, байгууллага, иргэдээс өгсөн хандив тусламжийг санхүүгийн тайланд үнэн зөв бүртгэж, тайлагнах, зарцуулалтыг ил тод байдлыг хангаж олон нийт, иргэдэд мэдээлэх гэсэн зөвлөмжүүдийг Үндэсний аудитын газраас өгсөн байна.

Ковид-19 цар тахлын үед зарцуулсан нийт зардлыг нь 13.2 хувийг иргэдийн эрүүл мэндийг хамгаалахад зарцуулж, үлдсэн 86.8 хувийг эдийн засгийг дэмжихэд зарцуулсан байдал, эдийн засгийн өсөлт, цар тахал ид дэгдэж байсан 20, 21 онд дэлхийн улс орнуудын дундажтай харьцуулахад бага байсныг үнэлэхгүй, анхаарахгүй орхиж бас болохгүй юм. Тухайлбал Монко трейд ирээд нэртэй урт хугацааны хөрөнгө оруулагчид зориулсан тэргүүлэх судалгааны цахим сайтад дэлхийн эдийн засгийн дундаж өсөлт 2020 онд 3.7 хувь, 2021 онд 5.8 хувь байсан талаар валест трейд сэтгүүлийн мэдээгээр 2021 онд Хятад улсын эдийн засаг 8.1 хувиар өссөн, АНУ-ын эдийн засаг 2 хувиар өссөн талаар тус тус нийтэлсэн байна.

Монгол Улсын ЗГ-аас түр хороонд ирүүлсэн тайланд цар тахлын үед 72000 ажлын байрыг шинээр бий болгож, 243000 ажлын байрыг хадгалж чадсан тухай ирүүлсэн байна. Энэ яах аргагүй сайн үзүүлэлт боловч Монгол Улсын

эдийн засгийн өсөлт 2020 онд -4.6 хувь, 2021 онд 1.4 хувьд хүрснийг та бүгд мэдэж байгаа. Ковид 19-ийн цар тахал нь эдийн засагт эргэлтийн болон нийлүүлэлтийн санхүүгийн зах зээлийн, гадаад хүчин зүйлийн гэсэн 4 төрлийн сувгаар дамжин нөлөөлж байгааг Сирор коллежийн Пакистаны Сирор Коллежийн ШУА, эрдэм судлаач Мухмед Мио нотлон тайлбарлаад, цар тахлын үед дэд бүтэц, жижиг дунд бизнесийн хөгжлийг дэмжих, татварын дэмжлэг үзүүлэх, зээлийн хөнгөлөлт хойшлуулдаг, хэрэгжүүлэх, хүртээмжийг өсгөх, экспортыг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээ, зөвшөөрөл олгох, бүртгэлийг хөнгөвчлөх, ЗГ-ын хөрөнгө оруулалтын зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх, төсвийн алдагдлыг бууруулах, иргэдийн орлогыг дэмжих, ажил эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх, банк санхүүгийн байгууллагуудын төлбөрийн чадварыг хангах, Ногоон эдийн засаг, дижитал үйлчилгээг хөгжүүлэх гэсэн чиглэлүүдээр бодлого, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд чухал болохыг дурдсан байна.

Түүнчлэн эдийн засгийн бодлогын ОУВС-ийн шинжээчид дэлхийн эдийн засаг 2-3 жилийн дотор цар тахлын өмнөх байдалд эргэж орно гэсэн дүгнэлтийг гаргахын сацуу цар тахалтай тэмцэх, цар тахлын нийгмийн эдийн засагт сөрөг нөлөөллийг бууруулахад зарцуулсан төсөв хөрөнгө, зээлийн эргэн төлөлтэй холбоотой хүндрэлүүд нь эдийн засгийн өсөлтийн хурдыг сааруулна гэж үзсэн байна.

Иймд гадаад зээл өндөртэй уул уурхайн салбараас хамааралтай гэхдээ эдийн засагтай манай улс экспортыг төрөлжүүлэх, нэмэгдүүлэх, цахим үйлчилгээг хөгжүүлэх, төрийн үйлчилгээний зөвшөөрөл олгох, бүртгэлийг хөнгөвчлөх чиглэлүүдээр тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх зайлшгүй цар тахлыг тааварлах боломжгүй эрсдэлүүдийг даван

туулахад цаг ямагт бэлтгэлтэй байх нь чухал байна.

Өнөөдөр цар тахлын нөхцөл байдал бүрэн арилаагүй, мутацлагдсан шинэ хувилбарууд өнөөдөр дэлхийг түгшээсэн хэвээр байна. Коронавируст цар тахал ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Монгол УИХ-ын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуулиас бусад хуулийн дагуу олон нийтийг биечлэн хамруулах арга хэмжээг зохион байгуулах, албан тушаалтныг сонгон шалгаруулахаар хуульчилсан зохицуулалтыг энэ хуулийн үйлчлэл зогссон өдрөөс эхлэн тухайн хуульд заасан хугацааг баримтлан хэрэгжүүлнэ гэж заасан. 2020-22 онд тус хуулийн хүрээнд 2808 албан хаагч байгаагийн 380 буюу 13.5 хувь нь албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага хангаагүй байгааг 2023 оны ЗГ, ТАЗ бас анхаарч тодорхой шийдвэрүүдийг гаргаж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

Цар тахалтай холбоотой түр хорооноос хийсэн ажлыг товч танилцуулахад ийм байна. Анхаарал хандуулсан та бүхэнд баярлалаа.

Г.Занданшатар: Баттөмөр даргад баярлалаа.

Монгол УИХ-ын тухай хуулийн 29.4-т түр хороо ажлынхаа дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулснаар түүнийг татан буугдсанд тооцно гэж заасан. Коронавируст халдвар ковид-19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам хэлэлцэж, шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлт гаргах үүрэг

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

бүхий Түр хороог татан буугдсанд тооцлоо.

Ковидын хууль ч гэсэн хүчингүй болсон учраас. Танилцуулаад л бол оо юм байна лээ. Түр хороо ажлынхаа дүнг. Түр хороог байнгын хороогоор л хэлэлцэж байгаа юм.

14.24 цаг

Дараагийн асуудал.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулгыг УИХ-ын гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан танилцуулна. Энхтайваны Бат- Амгалан гишүүн танилцуулна.

Э.Бат-Амгалан: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг УИХ 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн билээ.

ХЗБХ 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авсан болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төсөлд нэмж тусган, төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс

дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ХЗБХ-ны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийг танилцуулъя.

Дорждэрэмийн Цолмон ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Бямбабаярын Анхбаяр тус яамны Хууль зүйн бодлогын газрын БХЗГ-ын ахлах мэргэжилтэн, Дотоодын цэргийн штабын дарга, бригадын генерал Рэнцэндоржийн Чингис, ЦЕГ-ын захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа Лхамдоржийн Нямдаваа, ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Идэрийн Батчулуун, Дотоодын цэргийн штабын орлогч, харуул хамгаалалтын хэлтсийн дарга дэд хурандаа Нэргүйн Мөнх-Итгэл.

Эцсийн хэлэлцүүлэг явж байгаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүн байна уу? Алга байна.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол байхгүй. Маргааш 10 цагт эцэслэн батлах санал хураалт явуулна. Одоо Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

14.28 цаг

Одоо Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Энхтайваны Бат-Амгалан танилцуулна. Индэрт урьж байна.

Э.Бат-Амгалан: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг УИХ 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлсэн.

ХЗБХ 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед УИХ-ын гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гараагүй тул УИХ-ын гишүүн Нямбаатар Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасныг баримтлан хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 60 хувь нь дэмжсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсэг Дорждэрэмийн Цолмон ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, ШЕЗ-ийн дарга Рэнчиндоржийн Онончимэг, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Шагдарсүрэнгийн Цолмон.

Байнгын хорооны санал, дүгнэлтэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүн байна уу. Алга байна.

Ингэхгүй бол шүүх гацах гээд байгаа юм. Энэ чинь аль дээр л би хэлж байсан юм. Байнгын хороо Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд чуулганы танхимд цуглана уу.

Асуулт, хариултын цаг дууссан. Санал хураалт явуулахад тул гишүүд чуулганы танхимд цуглая. Танхимд цуглая.

2 Байнгын хороо хуралдаж байна. УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 43.2-т билүү, 43.2-т заасны дагуу санал хураалт өөр цагт явуулах шаардлагатай гэж үзвэл цагийг гэж тохирно гэж заасан. Санал хураалт явуулах цагийг хойшлуулж байна.

Байнгын хороодын хуралдаан явагдаж байгаа учраас Байнгын хороодын

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

хуралдааны дараа санал хураалт явуулна. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

14.32 цаг

Дараагийн асуудалд орёе.

“Нүүрсний экспорт тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг УИХ-ын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг танилцуулна. Индэрт урьж байна.

С.Чинзориг: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Ерөнхий хяналтын сонголын тайланг сонссонтой холбогдуулан “нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийг Эдийн засгийн байнгын хороо боловсруулж, УИХ-ын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгийг явуулж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хорооны 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулахад УИХ-ын гишүүн С.Чинзориг төслийн 2 дахь заалтын Б дэд заалтыг 2021 онуудад 1072 ширхэг хувьцааны ногдол ашиг авч чадаагүй иргэдэд хувьцааны ногдол ашиг нөхөн олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргасныг УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т заасныг баримтлан санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон

гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн болно.

Тогтоолын төслийн эцсийн хувилбарын төсөл болон Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, “Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж хэрэг та бүхнээс хүсэж хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух УИХ-ын гишүүд байна уу? Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 1 санал байна.

Батжаргал дарга аа. Танай байнгын хороо хуралдсан уу. Даваасүрэн гишүүн сая ирчихсэн байна лээ шүү дээ.

“Нүүрсний экспорт тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллын 1.

Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын Б дэд заалтын “нөхөн олгох” гэсний дараа “асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх” гэж нэмэх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо.

Гишүүд чуулганы танхимд цуглая.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

МАН-ын бүлгийн дэд дарга Жигжидийн Батжаргал ирцээ бүрдүүлье. Мөнхөөгийн Оюунчимэг МАН-ын бүлгийн дэр дарга ирцээ бүрдүүлье. УИХ-ын Тамгын газар Хуралдаан зохион байгуулах хэлтэс ирц.

Жавхлан сайд дараа нь танай асуудал хэлсэн. Чуулганы танхимд ирье. Болдын Жавхлан сайд, Сандагийн Бямбацогт сайд танай асуудлаар санал хураалт явуулах гэж байна, танхимд ирье. Цэрэнпилийн Даваасүрэн сайд сая энд байсан, дуудъя. Жамбалын Ганбаатар сайд тэнд сууж байна, суудалдаа сууя. Боловсролын сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, Эдийн засаг, хөгжлийн сайд Чимэдийн Хүрэлбаатар сайд байсан. Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан сайд нар чуулганы танхимд цуглая. Танай оруулж ирсэн асуудлаар чинь санал хураалт явуулах гэж байна.

Санал хураалт явуулъя. Тогтоолын төслийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын Б дэд заалтын “нөхөн олгох” гэсний дараа “асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх” гэж нэмэх. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

Энэ бүртгэлийн санал хураалт. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Сарангэрэл гишүүн, Хүрэлбаатар, Цогтбаатар, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан.

Санал хураалт явуулъя. Сая туршилтын санал хураалт явуулсан. Одоо зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт.

23 гишүүн дэмжиж, 56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Одоо тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

“Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт. Гишүүд анхааралтай санал хураалт.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Санал хураалтууд явуулна, сууж байгаарай. Гишүүд санал хураалтуудаа явуулж дуусаагүй байна.

Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулна.

Хууль санаачлагч Зам тээврийн хөгжлийн сайд байхгүй учраас хойшлууллаа.

Шүүхийн тухай хууль. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтыг явуулна. Байнгын хорооноос гаргасан горимын саналаар анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалт, анхааралтай. Санал хураалт.

Гишүүд анхааралтай байж байгаад өнөөдрийн хуралдаанаар чухал асуудлуудаа няхуур сайн үзэж хэлэлцэж батлаад.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах итгэл хангуулахаар ХЗБХ-нд шилжүүлж байна.

Маргааш 10 цагаас эдгээр хуулиудыг эцэслэн батлах санал хураалт явуулна гэдгийг зарлая. 10 цагт гишүүд өргөн бүрэлдэхүүнтэйгээр эцэслэн батална.

Одоо Төмөр замын тээврийн тухай хуулийн санал хураалтыг явуулна.

Байнгын хорооны саналаар Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуульа.

61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

14.50 цаг

“Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай. Монгол УИХ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.16 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

1.Монгол УИХ-ын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг УИХ-ын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй 2 дахь заалт.

“Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

62.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

15 цагаас Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төсвийн байнгын хороо 2 хуралдана.

“Байнгын хороонд бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” УИХ-ын тогтоолын төслийг уншиж танилцуульа.

Монгол УИХ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол УИХ-аас тогтоох нь:

1. Монгол УИХ-ын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг УИХ-ын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2013 оны 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

14.55 цаг

Дараагийн асуудалд орно.

Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Х.Нямбаатар: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Чөлөөт бүсийн тухай хууль, Алсын хараа 2050 бодлогын баримт бичиг, төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогод заасны дагуу чөлөөт бүсэд аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Казиногийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд казиног Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүсэд байгуулж болохоор заасан. Казинод Монгол Улсын иргэдийг тоглуулахыг хориглосон бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн тоглоомыг цахимаар зохион байгуулахыг мөн хориглосон. Казино эрхлэгч нь казиногийн байгууламж барих үйл ажиллагаа эрхлэхэд зориулсан 300000000 америк доллартой тэнцэх хэмжээний төгрөгөөс доошгүй хэмжээний хөрөнгө оруулалтыг тусгай зөвшөөрөл авснаас хойш 3 жилийн

дотор Монгол Улсад оруулахаар заасан. Ингэхдээ олон улсын стандарт шаардлагад нийцсэн дэд бүтэцтэй соёл амралтын цогцолборыг барьж байгуулахаар тусгасан бөгөөд төсөл сонгон шалгаруулалтыг үнэлэхдээ үнийн саналыг 60 хувь, казиногийн цогцолбор барих төслийн техникийн саналыг 40 хувь гэж үнэлэхээр тусгаж, тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион байгуулах үнэлэх журмыг ЗГ батлахаар тусгав.

Казино эрхлэгчийг ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт оруулах шаардлага тавьсан тул энэ төрлийн бизнесийг тогтвортой байдлыг хангах үүднээс казиногийн тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан компанид зөвлөлийн саналыг үндэслэн ЗГ 30 жилийн хугацаагаар олгох бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болсон тохиолдолд казино эрхлэгч хувьцааныхаа 50 хувийг Монгол Улсын ЗГ-т үнэ төлбөргүй шилжүүлэхээр тусгалаа, төсөлд. Энэ болзлыг биелүүлсэн бол тусгай зөвшөөрлийн хугацааг 10 жилээр сунгаж болохоор тусгалаа.

Мөн Казиногийн хуулийн хэрэгжилтийг энэ багц хуулиудын дагуу зохион байгуулагдах мөрийтэй тоглоомын асуудал хариуцсан зөвлөлийн хариуцан зохион байгуулах бөгөөд Зөвлөлийн ажлын албанд улсын байцаагч ажиллаж хяналт тавина. Татварын хувьд бусад улс орны жишгийг болон улсын төсөвт татварын орлого тасралтгүй, тогтвортой төвлөрөх байдлыг харгалзан казиногийн онцгой албан татварыг дараах хувь хэмжээний аль өндрөөр нь буюу улсын төсөвт ашигтай байдлаар нь хувилбарыг сонгож 7 хоног бүр төрийн санд төвлөрүүлж байхаар тусгалаа. Үүнд:

1 дүгээрт, казиногийн үйл ажиллагаанаас олсон нийт орлогоос хонжворт олгосон дүнг хассан дүнгийн 40 хувиар, эс үгүй бол казиногийн ширээ, автомат тоглоом, тотализатор

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Букмекерын төвийн нэгж бүрээс 7 хоног бүр 2.5 саяас 68000000 төгрөгийн татвар ногдуулж авахаар тогтоолоо. Онцгой албан татварын хувь хэмжээг өндөр хувиар тогтоосон тул үйл ажиллагаа эрхлэгчийг ААНОАТ, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зарчмыг баримталсан бөгөөд казино эрхлэгчид өндөр татвар ногдуулсан тул тоглогчийн хонжворын орлогод ХХОАТ ногдуулахгүй байхаар тус тус тусгалаа.

Мөн казино хэрэглэгчийн төлсөн татварын зарим хэсгийг аялал жуулчлалыг Монгол Улсад хөгжүүлэх зорилгод зарцуулах нь зүйтэй гэж үзэж аялал жуулчлалыг хөгжүүлэх санд онцгой албан татвараас төвлөрүүлсэн орлогын зарим хувийг хуваарилахаар тусгасан.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Казиногийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцэх эсэхийн асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишигээгийн Нямбаатар танд баярлалаа.

Одоо төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Алга байна. Цэндийн Сандаг-Очир гишүүнийг индэрт урьж байна. Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулна.

Ц.Сандаг-Очир: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг ХЗБХ 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын нутаг дэвсгэрт казиногийн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндсийг тогтоох, ингэснээр казиногийн үйл ажиллагаатай

холбоотой аялал жуулчлалын цогцолбор бий болж, төсөвт төвлөрөх татварын орлого нэмэгдэх, аялал жуулчлалын салбарыг дагасан худалдаа үйлчилгээ хөгжих, ажлын байр нэмэгдэж, эдийн засгийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулна гэж үзэн хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд аливаа төрлийн зардал үүсэхгүй бөгөөд төрийн байгууллага болон тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд тодорхой зардал үүснэ гэж хууль санаачлагч үзсэн байна. Хуулийн төслийг Ди Парламент цэг. мн цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Д.Цогтбаатар хуулийн төсөлд зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт Монгол хүн нэвтэрч болохгүй бүс бий болох нь. Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүн бүр эрх тэгш байх зарчмыг зөрчиж байгаа эсэх талаар, УИХ-ын гишүүн Ц.Сандаг-Очир Казино байгуулагдсанаар эрх зүйн хувьд харьяалах байгууллага тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаагаар олгох тооцооллын талаар болон казиногийн үйл ажиллагаатай холбоотой улсын төсөвт төвлөрөх орлого, зарцуулалтын талаар, УИХ-ын гишүүн Адъяа казиногийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд 40 хувийн татвар ногдуулахаар заасан үндэслэлийн талаар, 1998 онд баталсан Казиногийн тухай хуулийн дагуу тухайн үед хөрөнгө оруулсан хүмүүс эрх зүйн хувьд маргаан үүсгэх эсэх талаар, УИХ-ын гишүүн Э.Бат-Амгалан казиногийн үйл ажиллагаа эрхлэхэд зориулсан хөрөнгө оруулалтыг 300000000 америк доллар гэж заасан шалтгаан, казиногийн орлогоос төсөвт төвлөрөх хөрөнгө болон дотоодын хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх боломж байгаа эсэх, үүнийг дагаад ажлын байр нэмэгдэх эсэх талаар, УИХ-ын гишүүн Б.Пүрэвдорж

Казино байгуулах нэг тусгай зөвшөөрөл олгож, монополь эрх олгох нь зөв эсэх талаар, УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил казиног дагасан ажлын байр хэрхэн нэмэгдэх, казиногийн үйл ажиллагаатай холбоотой бий болох орлого борлуулалтын баримжаа байгаа эсэх, цахимаар бооцоот тоглоом тоглож байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх, хөрөнгө оруулалтыг 300000000 америк доллар гэж төсөлд тусгасан нь харьцангуй ойлголт бөгөөд шууд төсөл сонгон шалгаруулж, шийдвэрлэх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 54.5 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Казино байгуулах, ажиллуулахыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Дорждэрэмийн Цолмон ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Лувсанцэрэнгийн Пүрэвсүрэн ХЗДХЯ-ны

Хууль зүйн ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын шинжээч.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух УИХ-ын гишүүд байна уу.

Лхагвын Мөнхбаатар гишүүнээр тасаллаа. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Энэ хуулийг аль дээр үеэс л, миний мэдэхээс л сүүлийн 10 жил ярьж байгаа хэр нь ингээд зориглоод оруулж ирж чаддаггүй, улс төржилт эсвэл хэл амнаас айгаад л ингээд байгаад байдаг. Гэтэл өнөөдөр манай Монгол Улс энд яг гадаад нөхцөл байдал үүнийг харахад ямар ч байсан бас гаднаас хууль, эрх зүйн хүрээнд нь таатай орчин бүрдүүлээд хөрөнгө оруулалт татах энэ чухал байгаа. Тэгээд энэ дээр бас Нямбаатар сайд ингээд оруулж ирж байгаа нь маш зөв өө, дэмжиж байна.

Хамгийн гол нь бид нар харин энэ нь өөрөө яг Монгол иргэддээ сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин хөрөнгө оруулалт татах, аялал жуулчлалыг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх ирж байгаа жуулчдыг бүхий л талаар Монголд нэг тавтай аялаад буцах нөхцөлийг бүрдүүлэх нэг зүйл нь казино гээд харж байгаа учраас энэ хуулийг ингээд аялал жуулчлалын хуулийн хүрээнд багцаар нь оруулж ирж байна гэж би ойлгож байгаа. Зүгээр энэ дэх заалтуудаас нь харахад казино өөрөө бас маш олон ажлын байрыг бий болгодог гэж ярьдаг, тийм ээ, олон улсын жишгээс харахад Макао энэ Сингапур гээд л харахад үүнийг дагасан ажлын байр нэмэгддэг, иргэдийн орлого нэмэгдэх энэ гэрт нөлөө үзүүлдэг гэдэг л дээ. Тэгэхээр энэ боловсон хүчин бэлтгэх бусад татаж байгаа хөрөнгө оруулалт дээр яаж хамтарч ажиллаж байгаа вэ, тийм ээ, бусад аль хэр туршлага судалсан байгаа вэ гэдэг асуудлууд байна.

Дээрээс нь энэ хөрөнгө оруулалтыг 300000000 ам. Долларын гэж тусгасан нь яг энэ нөхцөл байдлыг яаж үнэлсэн бэ 300000000 гэдэг. Өнөөдөр бас гаднын хөрөнгө оруулалт татах нэлээд амаргүй байгааг бид нар бас мэдэж байгаа. Тэгээд манайд бас дэд бүтэц хөгжих тийм ээ, үүнийг хаана байрших вэ? тэнд өнөөдөр дэд бүтэц маань очсон, очоогүй байгаа гээд л асуудал маш их байгаа үед бид өндөр босго тавьж байна уу эсвэл энэ ер нь бололцоотой гэж үзэж байгаа юу? Тэгээд энэ хөрөнгө мөнгөтэй холбоотой асуудал дээр бас тодорхой хариулт авъя гэж бодож байна.

Тэгэхээр энэ дээр нөгөө Монгол иргэдээ оруулахгүй гээд сая Цогтбаатар гишүүний асуусан нь бас нэг талаасаа яах вэ, хүний эрх гэж бодож байгаа ч гэсэн эхний ээлжид ямар хүмүүс энд орохгүй байх вэ тийм ээ. Түүн дээр үндэслэл нь ийм гээд тэрийг энэ тэрээ бас анхнаас нь иргэддээ маш зөв ойлголт өгөх нь хэрэгтэй болов уу гэж бодож байгаа. Ер нь та нарын тооцоо судалгаагаар бидний барих энэ казино ч гэдэг юм уу энэ Зүүн өмнөд Азийн улс орнуудтай өрсөлдөх хэмжээнд хүрэхийн тулд зайлшгүй юуг эхний ээлжид хийх нь чухал гэсэн тийм тооцоо судалгаа та нарын энэ хийж байхад гарсан ба энэ дээр хариулт авъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Хишигээгийн Нямбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд хариулна.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би Оюунчимэг гишүүний асуултад товчхон хариулахыг бодъё. Дэлхий дээр 154 улсад казиногийн үйл ажиллагаа явагдаж байна, 154 улсад 5825 казино үйл ажиллагаагаа явуулж байна. Хувьчилж авч үзэх юм бол дэлхийн бооцоот тоглоомын 10 том зах зээлийг эзэмшиж байгаа бүс нутаг байна. 1 дүгээрт, 38 хувийг Макао, 21 хувийг Австрали, 13 хувийг Сингапур, 12 хувийг Филиппин, Өмнөд Солонгос бас нэг 5 хувьтай байна. Лас вегас 4 хувьтай байна, Атлантик сити 3 хувьтай байна. Камбож 2

хувьтай байна. Малайз 2 хувьтай байна. Хамгийн сүүлд Казиногийн хууль, эрх зүйн орчноо бүрдүүлсэн орон Япон Улс байна. Япон улсын казиногийн тэр нөгөө зөвшөөрөл, лиценз олгогдох процесс яг ид үргэлжилж байна. Нэлээн удаан хугацаанд хэлэлцсэн.

Бидний хуулийн төслөө боловсруулахдаа нэлээн том жишиг болгож харж үзсэн улсын туршлага Макаогийн туршлага байгаа. Макао улс 2002 онд одоогийн энэ казиногийнхоо салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчилж, либералчилсан. 2006 онд дэлхийн номер нэг зах зээлийг эзэмшдэг ийм улс болсон байгаа. Макаогийн казиногоос олдог орлого гэхэд 2020 оны байдлаар 7.6 тэрбум америк долларын борлуулалтын орлого хийсэн байх жишээтэй. Үүгээрээ үндсэндээ энэ улсын улсын төсвийн орлогын бараг 100 хувь энэ казиногийн салбараас бүрддэг ээ гэдгийг албаныхан бид нарт танилцуулж байсан.

Монгол Улсад ирж байгаа аялал жуулчлалын тоог нэмэгдүүлэх, Монгол Улсад аялах жил бид нар 3 жил зарлаж байгаа. Тэгэхээр бид нар аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн гаргахын тулд ийм цэнгээнт аялал жуулчлалын нэг төрөл хэлбэрийг зайлшгүй казиногийн салбар юм гэж судлаачид хэлдэг. Тэр утгаараа казиногийн хууль, эрх зүйн орчныг бий болгож хөрөнгө оруулалтыг татах шаардлага зүй ёсоор үүсэж байгаа.

300000000 америк долларыг ямар агуулгаар тогтоосон бэ гэхээр жишээлбэл, Макаод 6 ширхэг казиногийн лицензийг эзэмшдэг ААН-үүд эзэмшдэг. Эдгээрийн нэг лиценз эзэмшигчид тавьж байгаа босго нь 500 сая орчим америк доллароор эхний босгыг тавьдаг. Тэгэхээр бид нар эхний ээлжид өөрийн орны онцлогтой нийцүүлээд яг бодит ийм хөрс шороон дээр бодит хөрөнгө оруулалтыг бий болгоё. Аль нэг байгууллагын бэлэн бий болгочихсон объект дээр түрээслээд эргээд гараад явах биш бодит ийм хөрөнгө

оруулалтыг үүнээс доошгүй мөнгөөр дээш үнийн санал хэлсэн ААН-д нь бодит тэр 2 итгэлцүүрээр сонгон шалгаруулалт хийж зөвшөөрөл өгөхөөр энэ төсөлдөө тусгасан гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулья.

М.Оюунчимэг: Энэ хөрөнгө оруулалт дээр зөвхөн гадаадын хөрөнгө оруулагчид гэж байгаа юу? Эсвэл дотоод гадаад хамаагүй тийм ээ. Энэ дээр бас нэг тодорхой тийм шалгуур тавиагүй байгаа юу? Энэ дээр харахад зүгээр хөрөнгө оруулалтыг 300000000 ярьж байна. Тэгэхээр дотоодын томоохон компаниуд жишээ нь орох нь энэ нээлттэй байгаа юу гэдэг дээр нэгд хариулт авъя.

2-т нь, маш зөв, казиног бид бас яг хуулийн хүрээнд яг тэр хатуу хяналт дор үйл ажиллагаа нь явуулаад ингээд явах нь цаг хугацааны хувьд болсон гэж харж байгаа. Нөгөө талаасаа энэ казиног дагаад нөгөө бохир мөнгө угаах явдал дээрээ бусад улс орнууд маш том хяналт тавьдаг. Яагаад гэвэл үүнийг дагаад бас бохир мөнгө угаах ч гэдэг юм уу хууль бус үйл ажиллагаа, хар тамхи, мансууруулах бодис ч гэдэг юм уу тийм зүйлүүд бас дагаж орж ирэх эрсдэл өндөр байдаг. Үүнийг хууль дээрээ хэд хэр харгалзаж үзсэн бэ?

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулна.

Х.Нямбаатар: Бид нар мөнгө угаахтай тэмцэх Палермогийн конвенцод нэгдэж орсон. Мөнгө угаах терроризмтой тэмцэх олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага болох ФАТФ-ын зөвлөмжийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ утгаараа дээрх олон улсын нэгдэн орсон гэрээ, конвенц Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжуудын хүрээнд казиногийн үйл ажиллагааг явуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчид тэр чиглэлийн үүрэг ногдож ажиллана гэсэн

ийм агуулгатай байгаа. Зүгээр нэг зүйлийг нэмээд мэдээлээд хэлэхэд бид нар олон улсын санхүүгийн хориг арга хэмжээ авагдсан ийм зөрчилтэй иргэдийг Монгол Улсад нэвтрүүлэхгүй байх, Гөүтрейвэл гэдэг аяллын программ хангамжид Монгол Улс бас сая үнэ төлбөргүй программ хангамжаа авч байгаа. Тэгэхээр манай улсад хориглогдсон орж ирэх хориотой иргэдийн тухайд Монгол Улсын хилээр орохоос бүр өмнө нь өөр олон улсын онгоцны буудлууд дээрээс шууд тэр хүний наашаа нисэх нислэгийг хязгаарладаг ийм зохицуулалт бий.

Дээр нь нэмээд хэлэхэд саяын таны хэлж байгаа тэр юуны санхүүгийн хориг арга хэмжээнүүд авагдахуйц ийм нөхцөл байдал үүсэхээс урьдчилан сэргийлсэн бүхий л шалгуур үзүүлэлтийг казиногийнхоо тэр сонгон шалгаруулалт тавина. Нийт барих цогцолборын 80 хувь нь иргэдийн зугаацаж амарч цэнгэх ийм орчин байна. Нийт байгууламжийн 20 хувьд нь зөвхөн казиногийн үйл ажиллагааны талбай ноогдоно оо гэдэг ийм олон улсын шалгуураар тавигдаж байгаа. Жишээлбэл Сингапур улсын Марина Бэй Сентс казиногийн сонгон шалгаруулалтыг хийсэн бас туршлагыг бид нар энэ хуулийн төсөл дээрээ төсөл сонгон шалгаруулалтын 40 хувьд нь шалгуур үзүүлэлт болгож бас авч байгаа гэдгийг хэлье. Тэгээд үүнийг би нэлээн нарийн задаргааг бас ажлын хэсэг хэлэлцэх эсэхээ шийдвэл нэлээн том танилцуулгуудыг хийхэд бэлэн байгаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Даваажанцангийн Сарангэрэл асуулт асууна.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Аливаа хуулийн төслийг боловсруулж хэлэлцэж батлах, бүтээн байгуулалт хийхдээ эдийн засгийн үр өгөөжийг нь урьдчилж тооцсон байх учиртай. Хэрвээ манайд казино байгуулагдах юм эдийн засгийн үр өгөөж нь ямар байх юм бэ. Энэ тооцоог та бүхэн маань яаж хийсэн бэ гэдэг нэгдүгээр асуулт.

2 дугаар асуултын тухайд энэ хууль яригдаж байгаатай холбогдуулан зөвшөөрлийг нэг субъектэд өгөх тухай асуудал яригдсан л даа. Хэрвээ үнэн бол яагаад энэ шийдэл гарах болсон юм бэ? Энэ дээр тодруулга авмаар байна.

3 дугаарт, ер нь олон жилийн турш яригдсан гэдэг нь үнэн л дээ. Хамгийн гол нь нийгмийн зүгээс нэлээн эсэргүүцэлтэй тулгарч байсан. Казиног дагаад олон сөрөг үр дагаврууд гарна гэдэг, одоо гарахгүй болчихсон гэж тооцоод энэ хуулийн төслийг оруулж ирж байна уу гэдэг ийм асуулт байна.

4 дүгээрт, казиног хаана байгуулахаар төлөвлөж байгаа вэ. Энэ 4 асуултад хариулт аваад тодруулъя.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд асуултад хариулна.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би сүүлийнхээс нь хариулъя. Бид нар яагаад нэг лиценз олгоё гэж үзсэн гэхээр 1 дүгээрт, энэ төслийг нөгөө филтэрдэхгүй байх үүднээс ийм хамгийн боломжит нэг хувилбар дээр эхний ээлжид явуулъя, тэгээд хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангаж бид нар дараагийн 5 жилээс байгуулагдсанаас хойш 5 жилийн дараа шинэ лиценз олгох эсэх асуудлыг Их Хурал шийдэхээр хууль дээрээ тусгаж үлдээж байгаа юм.

Одоо байршлын хувьд энэ хууль дээр шууд бичсэнээр Хөшигийн хөндийн чөлөөт бүсэд төр газрыг нь шийдэж өгнө. Дэд бүтцээр нь хангана. Түүн дээр 300000000 доллараас дээш хэмжээний үнийн дүнтэй бодит хөрөнгө оруулалтыг оруулах ийм санал өгсөн ААН-д өгнө өө гэдэг ийм зүйл байж байгаа. Түүрүүн Оюунчимэг гишүүний асуултад би бас дутуу хариулчхаж. Миний хариултыг нэмээд хугацааг маань нэмээд өгөөрэй.

Монгол Улсын иргэд ААН-үүд авч болох уу гээд. Энэ ерөнхийдөө дэлхий

дээр нэг 3-4 том энэ казиногийн ийм бизнес эрхэлдэг том группүүд байдаг. Эдгээрт нь өөрсдөд нь технологи, ноу хау бусад тоног төхөөрөмж, бусад зүйлүүд нь хадгалагддаг. Энэ маш их нарийн деталь ойлголт байна лээ. Тэр казиногийн хөзрийг үйлдвэрлэхээс авхуулаад аюулгүй байдал, хясаа читоныг үйлдвэрлэхээс авхуулаад аюулгүй байдалтай холбоотой бүр нарийн технологиуд байдаг учраас энэ тодорхой дэлхийн хэмжээний тоглогчид л манайхыг сонирхож орж ирэх боломжтой гэж бодож байгаа юм. Би үүнийг яаралтай явахгүй бол улс орнууд ар араасаа аялал жуулчлалынхаа салбарт өргөтгөл хийх зорилгоор энэ хууль тогтоомжид би сая хэлсэн шүү дээ. Дэлхийн 154 оронд байна. Одоо Тайланд улс яг энэ хуулийнхаа төслийг бас боловсруулах ажлаа хийгээд явж байна. Сүүлд бид нарын бас тийм сайн биш жишээ авч судалгааны явцад гарч ирсэн энэ Зүүн өмнөд Азийн орон болох юу Камбож гэхэд өнөөдөр энэ казиногийн зах зээлийн 2 хувийг өнөөдөр эзэмшиж байна. Тэгэхээр бид нар өнөөдөр юу юунаас түүрүүнд аялал жуулчлалыг хөгжүүлэе л гэж байгаа бол казиногийн зах зээл энэ бизнесийг эхлүүлэх энэ зоригоо гаргамаар байгаа юм. Ингэж байж бид нар бусад улс орнуудтай аялал жуулчлалын тодорхой бүтээгдэхүүнүүд дээр бас өрсөлдөх, өөрийнхөө энэ аялал жуулчлалын салбарыг өргөжүүлэх ийм боломж бүрдэж байгаа.

Анх төслөөрөө 4 газар хийе гэж төлөвлөж байсан. Өөрөөр хэлбэл бүс нутгийн хөгжлийг хангах зорилгоор жишээлэхэд, 1-ийг нь баруун талд Ховд, Говь-Алтайн зааг дээр Дөргөн нуурын хөвөөн дээр хийвэл яасан юм гэж судалгаа хийсэн. Сүүлд нэмээд Буйр нуурын эрэг дээр 1-ийг хийвэл Хятадын зүүн хойд бүс нутгийн аялал жуулчлалыг татах ийм урсгал байж болзошгүй гэж үзсэн. 1-ийг Дорноговь аймгийн Замын-Үүд сумын чөлөөт бүсэд хийе гэж үзсэн. Тэгээд эцэст нь бид нар судалгааны дүн харж байгаад ерөөсөө эхний ээлжид энэ төслийг явуулах нь юу юунаас чухал юм байна

гээд. Тэгээд Өмнөд Солонгос улс жишээлбэл 2 янзын казиногийн зөвшөөрөл олгож байгаа юм. Кванду гэдэг муж Кан вон гэдэг муждаа хуучин нүүрсний уурхай олборлож байсан орхигдсон уурхайнуудыг түшиглэж тэр хавийн 2-3 аймгийг нийлүүлээд консорциум байгуулаад гадаад дотоодын иргэдээ ордог Казино аялал жуулчлалын цогцолборыг байгуулах эрхийг хуулийн этгээд байгуулж өгсөн байгаа. Гэтэл БНСУ-ын татварын орлогын 2,36 их наяд вонын орлогыг Солонгос улсад зөвхөн казиногийн салбараас оруулж байгаа юм. Түүний 1.48 их наяд вон буюу 63 хувийг Канвон лэнд гэдэг тэр бүс нутгийн казиногийн салбар төсөвтөө төвлөрүүлж байх жишээтэй. Тэгэхээр бид нарт өнөөдөр бас энэ бүс нутагтаа өөрийн хэмжээний тийм маш ашигтай загварын төслийг бий болгох зах зээл орчин байна.

Манай 2 хөршид энэ чиглэлийн бизнес хориотой байдаг. Тэгэхээр үүнийг бид нар бас ашиглаж манай энэ бүс нутагтаа бид нар казиногийн бизнесийг эрхлүүлэх, ийм эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор миний бие энэ хуулийн төслийг одоогоос 4, 5 жилийн өмнөөс өөрөө боловсруулах ажлыг эхлүүлээд ингээд явсан. Өмнөх төслийн ажлын хэсэгт байж байгаад энэ төсөл рүү шилжиж орсон. Шилжилт хийсний гол шалтгаан бол шууд энэ хамгийн дэлхий дээр либералчлал өндөртэй өндөр либералчилсан энэ Макаогийн тэргүүн туршлагуудыг оруулж ирэх ийм агуулгаар энэ хуулийн төсөл үндсэндээ бичигдсэн гэдгийг хэлье.

Г.Занданшатар:

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн тодруулж асууна.

Д.Сарангэрэл: Нямбаатар сайд, би нөгөө эдийн засгийн үр өгөөжийн талаар асуугаад байгаа юм. Казино байгуулах ер нь ямар шаардлага нөхцөл үүссэн бэ? Байгуулчихвал эдийн засгийн үр өгөөж нь юу вэ? 1 дүгээрт.

2 дугаарт, Монгол хүн орж болно, болохгүй гэдэг нэг ийм 2 талтай яриа нэлээн өрнөж байна. Энэ нь аль талдаа шийдэгдэж байгаа вэ? Энэ хуулиар.

3 дугаарт, зөвшөөрлийг нь өгөх төрийн төв байгууллага нь аль яам, аль байгууллага байх юм бэ гэдэг ийм тодруулга байна.

Г.Занданшатар: Нямбаатар сайд тодруулгад хариулъя.

Х.Нямбаатар: Журмаараа ЗГ зөвлөл байгуулаад сонгон шалгаруулалтаа зарлаж өгөхөөр хуулийн төсөлд туссан байгаа. Эдийн засгийн үр өгөөжийн хувьд ийм байгаа Сарангэрэл гишүүн ээ, Монгол Улс нэг 2023 оноос эхлээд 1 сая жуулчин авна гэдэг ийм зорилт тавьж байгаа юм, 2024 онд 1.5 сая жуулчин гэх мэтчилэнгээр ингээд зорилт тавьж байгаа юм. Тэгээд манайд ирж байгаа аялал жуулчлалын тодорхой хувь нь зөвхөн тал хээр нутгийг үзэх зорилготой ийм аялал жуулчлал. 30 орчим хувь нь Монголын түүх, Их эзэнт гүрний үеийн түүх, түүнтэй холбоотой их түүхийг үзэж судлах, бусад аялал жуулчлал нь зүгээр өөр улс орныг үзэж сонирхох гээд бид нар ингээд нэлээн судалгаанууд гаргасан юм. Тэгэхээр би танд хэлэхэд манай урд хөрш нийт казиногийн салбараар үйлчлүүлэгчдийн 97 хувийг эзэлж байгаа юм. Би зүгээр үүнээс илүү тоо хэлмээргүй байгаа. Казиног Макао жилд 7.6 тэрбум америк долларын орлого олсон байгаа юм. Тэгэхээр энэ улсын үйлчлүүлэгчдийн 97 хувь нь манай урд хөрш байх жишээтэй. Тэгэхээр бид нар энэ дээр одоо нарийвчилсан бас тооцоо гаргахад эрт байгаа. Энэ сонгон шалгаруулалтад өрсөлдөхөөр оролцож ирж байгаа ААН-үүд бол өөрсдөө төсөл дээрээ эдийн засгийн үр өгөөж, ТЭЗҮ-үүдээ нэлээн тодорхой дурдана. Бид нар аялал жуулчлалынхаа нэг шинэ бүтээгдэхүүн болгож, цэнгээн тийм аялал жуулчлалыг гаргаж ирэхийг зорьж байгаа.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тэгээд казиногийн аялал жуулчлалын их тийм сонирхолтой статистикууд байдаг юм байна лээ. Нийт орлогынх нь нэг 33 орчим хувь нь бооцооноос, 33 орчим хувь нь зочид буудлын орлогоос, 33 орчим хувь нь нөгөө бусад үйлчилгээнээс олсон гэх ийм статистикууд байдаг. Сая би танд Солонгосын жишээг хэлсэн. Дэлхий дээр тэр 10 том зах зээл эзэмшиж байгаа улс орнуудын жишээг ... /минут дуусав/

Г.Занданшатар: Гүйцэж хариулъя. Нямбаатар сайд гүйцээж хариулъя. Монгол хүн орохгүй гээд байсан.

Х.Нямбаатар: Тийм Монгол хүн орохыг хуулиар хориглож байгаа юм. Бид нарт өмнө нь гашуун туршлагауд бий. 1998 онд Казиногийн хууль батлагдаад хэрэгжиж эхлэлгүй хүчингүй болсон. УИХ-ын 3 гишүүн уг Казиногийн хуулийг батлахад авлига авсан гэдэг үндэслэлээр албан тушаалын хэргээр шийтгүүлж ял эдэлж байсан гашуун туршлага бий. 2004 онд ХЗДХЯ-наас бооцоот төлбөр тааварт тоглоомын тусгай зөвшөөрлөөр казиногийн үйл ажиллагаа Улаанбаатар хот, Дархан, Эрдэнэт, бусад газруудад бүр борооны дараах мөөг шиг дэлгэрсэн. Үүнээс болж маш олон залуучууд ажил амьдралаа алдсан, өр ширэнд орсон ийм тохиолдлууд бий. Тэр байтугай Монгол Улсын ЗГ-ын нэгэн яамны ТНБД яамныхаа төсвийн хөрөнгөөр тоглоод шоронд орж ял эдэлсэн ийм тохиолдлууд бий. Тийм учраас эхний ээлжид бид нар бас энэ бизнесийг цэгцэрч жигдэртэл дотоодын иргэдээ оруулахыг хуулиар хориглоё оо гэдэг ийм агуулгыг оруулж ирсэн.

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

Х.Ганхуяг: Энэ хуулийг хэлэлцэхийг дэмжиж байгаа юм. Яах вэ, хэдэн асуулт байна. Та ер нь бид нар энэ казино байгуулах цаг хугацаа нь ер нь болчихсон. Энэ нэлээн дээр ч байгуулах

ёстой байсан байх. Яах вэ, 1 дүгээрт, яг нийгэм, эдийн засгийн нөлөөллийн ер нь судалгаа хийгдсэн талаар тодруулмаар байна. Яг эдийн засагт ямар ямар эерэг нөлөөллүүд гарч ирэх вэ?

2 дугаарт, уг нь энэ казиногийн хууль аялал жуулчлалын хууль яах вэ, аялал жуулчлалаа бол би өөрөө ахлаад байгаа юм. Тэгээд энэ дээр опен скайтай холбоотой энэ зохицуулалтууд харагдахгүй байгаад байгаа юм л даа. Тэгэхээр бид нар энэ нэлээн том хэмжээний хөрөнгө оруулалт татчихдаг. Нөгөө жуулчид нь наашаа орж ирэх гэхээр энэ нислэг нь үнэтэй гэсэн нэлээн юмнууд яригддаг. Тэгээд Роснефтьтэй ярьж байгаад л энд нөгөө түлшний үнийг бууруулна гээд л тогтоол хуульд өөрчлөлт оруулсан мөртөө билетийн үнэ буурахгүй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр энэ нислэгийн юун дээр энэ опен скай болгоод энд чөлөөтэй болгохгүй бол либералчлал явагдахгүй бол болохгүй л байгаад байгаа юм л даа. Тэд уг нь опен скай хийгдэнэ гэж яригдаж байсан. Тэгээд тэр нь аль хуулиар яаж зохицуулагдахыг тодруулчихмаар байна.

Дээрээс нь нэлээн өндөр шалгууртай юм байна шүү дээ, сайд аа, тийм ээ. Тэгэхээр энэ дээр яг энэ нөхцөлөөр энэ орж ирэх ААН-үүд нь хэр их байдаг юм бол. Та ер нь уулзалт эд нар хийж үзсэн үү? Манай энэ тавигдаж байгаа нөхцөлүүд ер нь өндөр талдаа орж байна уу эсвэл байдаг л тэр зарчмын дагуу явагдаж байна уу гэдэг нэг асуулт асуумаар байна.

Мөн нэлэнхүүдээ энэ чинь тэгээд л бараг зөвшөөрлийн хуультай нэлээн холбоотой л байна л даа. Тэгээд энэ тал дээр бас яах вэ, яг сонгон шалгаруулалтын эсэх нь журмаар зохицуулна гэсэн юм байна. Үүнийгээ сонгон шалгаруулалтын журмыг нь яах вэ, зөвшөөрлийн хуулиар бол журмаар зохицуулах боломжгүй байгаа. Тэгээд үүнийгээ болж өгвөл хуульд нь сайн шигтгээд оруулбал гэдэг санал бас гаргачихмаар байна.

Сүүлийн асуулт болохоор энэ хилийн бүсүүдэд таны сая ярьж байгаа тэр Буйр нуур ч гэдэг юм уу Замын-Үүд ч гэдэг юм уу тэр цэгүүдээр аль нэг дээр нь уг нь хамтад нь шийдээд явчихсан бол уг нь зүгээр байсан юм болов уу гэж бодсон юм. Яагаад гэхээр тэр чинь тэр тухайн орон нутагт амьдардаг урд хөршийн иргэд ч юм уу виз авахгүйгээр цагаан хуудсаар орж ирээд л тоглоод л манайд бас ингээд мөнгөө тушаагаад яваад байх боломжтой байсан юм биш үү л гэж харагдаад байгаа юм л даа. Тэгээд энэ асуултауд дээр хариулт авчхаад тодруулъя даа.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Баярлалаа. Бид нар мэдээж хэрэг 1 дүгээрт, эдийн засгийн үр өгөөжийг бодит мөнгөн илэрхийллээр шууд тусгай зөвшөөрөл олгоходоо Монголд оруулж ирэх бодит хөрөнгө оруулалтын хэмжээг тавьж байгаа юм. Үүнийгээ дагаад энэ үйл ажиллагааны орлогоос бид нар 40 хувийн татвар ногдуулна. 7 хоног болгон нөгөө хяналт шалгалт, татварын манай үндэсний татварын алба татваруудаа хурааж байна гэдэг ийм агуулгаар орж ирж байгаа. Энэ бид нар яг урьдаас манай улсад байгуулагдах казиногийн үйл ажиллагаа эрхэлж байгаа казиногоор жилд тэдээс доошгүй жуулчин орж ирнэ гэдгийг урьдчилан тооцоолоход нэлээн хүндрэлтэй байгаа. Таны хэлдэг open скай энэ зарчмыг ЗГ угаасаа л дэмжиж байгаа юм. Таны ахалж байгаа аялал жуулчлалын тухай хууль дотор аялал жуулчлалыг дэмжих сан байгаа. Аялал жуулчлалыг дэмжих сан нь Монгол Улсад ирж байгаа ирэгчийг ирүүлэхэд иргэний нисэхийн байгууллагуудад дэмжлэг үзүүлбэ ээ гэдэг ийм агуулга шууд туссан. Өөрөөр хэлбэл, казиногийн орлогоос 40 хувь төвлөрсөн орлогоос тодорхой хувийг таны ахалж байгаа аялал жуулчлалыг дэмжих санд төвлөрүүлбэ. Аялал жуулчлалыг дэмжих сан нь 1 дүгээрт, дэд бүтцийн асуудал 2 дугаарт, наашаа ирж байгаа иргэний агаарын тээврээр ирж байгаа хүмүүсийн

суудал дээр нь тухайн иргэний нисэхийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх ийм агуулгаар ирүүлбэ. Монголд ирэхэд хамгийн хямд, ирсэн хойноо саатаж үзэж харах юмтай болох энэ зарчим аялал жуулчлалын хууль болон энэ бусад дагалдуулан өргөн барьж байгаа 3 хууль дээр үндсэндээ орж ирж байгаа л гэсэн агуулгыг ойлгооч ээ л гэж хэлэх гэсэн юм.

Дээр нь сая Монгол Улсын ЗГ нийтдээ 64 улсын иргэнийг Монгол Улсад визгүй зорчих, улс орны ангилалтад оруулсан. Дээр нь нэмээд тодорхой тооны улсуудыг цахим визээр ирэх тэр боломжийг нээж өгсөн. Дээр нь нэмээд хил орчмын бүлэг жуулчдыг визгүй нэвтрүүлэх ийм хууль, эрх зүйн орчныг бий болгочихсон. Одоо энэ нөгөө автор ковит гэх юм уу пост ковит гэх юм уу үүний дараа эффектүүд нь илэрч гарна гэдэг ийм хүлээлттэй байгаа. Иргэний нисэхийн байгууллага дээр сая нөгөө энэ нефтийн компаниудаас шалтгаалж байгаа нөгөө нислэгийн тарифыг бууруулах чиглэлээр сая ЗГ шинээр компани байгуулаад хамгийн хямд нислэгийн бензин шатахуун нийлүүлэх энэ ажлууд тусдаа хийгдэж байгаа.

Шалгуурын хувьд бид нэлээн өндөр талдаа тавьж байгаа, өндөр талдаа. Өөрөөр хэлбэл шалгуур өөрөөр хэлбэл 1 их наядаас дээш хэмжээний хөрөнгө оруулалт оруулна гэдэг бол 1 дүгээр өндөр шалгуур, 2 дугаарт, тэр комплексыг яг архитектурын хувьд иргэд тэр аялал жуулчлалаар ирж байгаа хүмүүст тэр сэтгэл ханамжтай байх. Энэ шалгуураар бид нар бас 2 дахь шалгуур хийж байгаа юм. Би дээр хэлсэн, тэр нөгөө Сингапурын Марина би Сентсийг бүр Сингапурчууд тэр аяараа сонгон шалгаруулалтад нь санал өгсөн гэдэг ийм шалгууруудыг бид нар давхар тавьж байгаа гэдгийг хэлбэ.

Зөвшөөрлийн хуультай үүнийг холимооргүй байгаа юм. Энэ өөрөө онцгой эрх ... /минут дуусав/

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Л.Мөнхбаатар: Гүйцээж явуулах юм уу, Нямбаатар сайд гүйцээгээд хариулъя.

Х.Нямбаатар: Энэ юуны хувьд Зөвшөөрлийн хуульдаа үүнтэй холбоод явчих юм бол нийтлэг нөгөө байнга олгодог зөвшөөрлүүд биш энэ нэг удаа л олгогддог зөвшөөрөл учраас ЗГ өөрөө тэр журмаа батлаад нэг удаа сонгон шалгаруулалтаа хийх тэр агуулга нь байя. Хүний хүчин зүйл шалтгаалахгүй, тавьж байгаа тэр мөнгөний дүн нийт үнэлгээнийх нь 60 хувь болно. Үлдсэн 40 хувь дээр нь олон нийтээс тэр төслийн концепц, үзэл баримтлал дээр нь бид нар саналууд авах энэ боломж нээлттэй.

Үр өгөөжийн хувьд би танд нэг 2, 3 тоо хэлье. БНСУ 2.6 тэрбум долларыг энэ бооцоот тоглоомоосоо татвар хэлбэрээр авч байна. Сингапур улс 6 тэрбум америк долларыг авч байна. 12-22 хувийн татвартай. Макао улс 38-39 хувийн татвартай. Нийтдээ 30 тэрбум америк долларыг татвар хэлбэрээр улсдаа авч байна. Франц улс 10-аас дээш хувийн татвартай байна. АНУ 8-5 хувийн татвартай. АНУ нийт энэ татварын орлогоороо 38.6 хувийг бүрдүүлж байх жишээтэй. Тэгэхээр энэ бол бид нарын бүр нэлээн тааруу гэсэн нэг жишээ. Би бас гадаад улс орнуудын нэр хэлмээргүй байна. Зүүн Өмнөд Азийн нэг орон гэхэд нийт зах зээлийн бараг 2 хувийг өнөөдөр эзлээд явж байна. Тийм учраас байгуулагдсан улс орон болгонд энэ төсөл нь зөв үр өгөөжөө өгсөн ийм сайн туршлагауд байна гэдгийг танд хэлье.

Л.Мөнхбаатар: Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууя.

Г.Ганболд: Бид нар ч яах вэ, казино гэж нэг хадны мангаа гэж 24, 5 жил болсоор байтал дэлхийн бүх улсууд л байгуулчихлаа л даа. Бид нарын нөгөө дуурайх дуртай өндөр ёс зүйтэй Япон байгуулахгүй байгаа юм чинь нэг асуудал байдаг байх гэж бодсоор байтал Япон улс хүртэл арга буюу байгуулж байна л даа.

Японы иргэд нь ойр хавийнхаа Солонгос, Өмнөд Азийн улсууд руу тоглож хамаг мөнгийг нь гаргасаар байгаад. Тийм учраас энэ буруу зүйл биш юм шиг байгаа юм. Сая Хөгжлийн банкны сонсгол харж байхад л ингээд л Монголын бизнесийнхэн ч л өчнөөн мөнгөөр тоглож л байна. Тэгвэл Монголд байгуулаад Монгол иргэд орохгүй, гаднынхан ирэх тэр тоглоомын 40 хувийг нь ч гэсэн орлогоор улсын төсөвтөө 5 төгрөг олж суувал хэрэгтэй ч юм шиг л санагдаж байна л даа. Зүгээр асуух гээд байгаа зүйл бол яг түрүүн гишүүдийн асууж байгаатай адилхан. Орж ирэх сонирхол байгаа юм байна гэж хүмүүс ойлгож байна. Хэн ирж тоглох вэ? Хэдэн хүн ирэх вэ? Эндээс жилд улсын төсөвт яг хэдэн төгрөг орно гэж тооцоолж байгаа вэ? Энэ дээр мэдээж тооцоолол хийсэн байх.

Гэхдээ би зүгээр ингэж хараад байгаа юм л даа. Яг хаана байгуулах вэ гэдгийг бас бид нар бодох ёстой л доо. Хөшигийн хөндийд байгуулах нь зөв үү, буруу юу? Энэ бол өөрөө Нямбаатар сайдын хэлж байгаагаар аялал жуулчлалын бас гол салбар гэж ойлгож байгаа юм. Тэр казинод чинь яг зорьж тоглох гэж очихоосоо илүүтэй гэр бүлээрээ аялж амарч яваад амралтынхаа нэг 2 хоногийг өнгөрөөдөг хүмүүс нь илүү байдаг юм болов уу. Тийм учраас аялал жуулчлалын энэ эвент арга хэмжээнүүдээ яг үүнтэйгээ уях ёстой. Тоглох гэж ирсэн хүмүүсийн гэр бүлд нь ганц нэг хоног Монгол ахуйтай, гэр баазууд байдаг юм уу? Монгол ахуй соёлтой танилцаж нэг ганц нэг өдрийг өнгөрөөх энэ арга хэмжээнүүдээ уяна гэх юм бол Хөшигийн хөндий нь зохимжгүй юм шиг. Тэгээд үүнийг бас уялдуулж үзсэн зүйл байна уу гэдгийг асуух гээд байгаа юм, танаас.

Дараагийн асуудал нь 30 жил гээд энэ 30 жилийн хугацаа бол урт хугацаа л даа. 30 жилийн хугацаанд гэхдээ мэдээж хэд хэдэн удаагийн үе шаттай нөгөө гэрээнүүдээ дүгнээд үр дүн байна уу, эерэг тал нь юу байна, сөрөг тал нь юу байна гэдэг дээр 30 жилийн хугацаан

дотроо гэрээгээ өөрчлөх ч юм уу зөвшөөрлөө цуцлах ийм боломжууд байгаа биз дээ, ер нь. Тэгэхгүй бол тэгээд 30 жилийн хугацаанд хатуу гэрээ хийчихдэг. Янз бүрийн сөрөг зүйлүүд гараад улсын төсөвт ашиг байдаггүй, мөнгө ордоггүй. Тэгээд ийм зүйлүүд болоод ирэх юм бол бид нар тэр гэрээгээрээ олон улсын арбитрын өмнө бас нэг баахан алдагдал торгууль хүлээнэ гээд ингээд гацаж ордог ийм юм руу явчихгүй байх тал дээр бас анхаарч байгаа байх гэж бодож байна. Энэ дээр таны хариултыг сонсьё оо гэж ингэж бодож байна.

Ер нь казино дээр нийгмээрээ л сөрөг л гэж ярьдаг. Яг сөрөг зүйлүүд яг юу байдаг юм бэ? Олон улсын жишгээс харахад яг ямар ямар сөрөг зүйл байдаг юм? Энэ дээр бас улс орны жишгүүд, үүнийг байгуулснаараа бас тухайн улс оронд нь алдагдал хүлээсэн юм уу? Та бол дандаа сайн сайхан жишээ хэлж байна л даа. Бүгдээрээ ингээд л өндөр олон тэрбумаар ашиг олсон ийм л жишээнүүд ярьж байна л даа. Муу жишээ ер нь байна уу? Үүнийг байгуулаад баларсан юм уу. Төсвийн орлого олоогүй гэрээгээ цуцалсан чадахаа байсан юм уу, тийм улс орон байна уу гэдгийг бас бид нар харах ёстой л доо. Тэгэхээр та зүгээр яг энэ дээр нэг тодорхой хариулт хэлээч ээ. Тэгэхээр би бол аялал жуулчлалынхаа хуультай уялдуулж тэр мэдээж аялах гэж ирсэн хүмүүсийн чинь ар гэрийнхэн нь нэг дэлгүүр хоршоо хэсдэг, ахуй соёлтой танилцдаг, аялал жуулчлалын 2, 3 хоногийг өнгөрөөдөг ийм юмаа уяж явах тал дээр бас энэ улс өөрөө төсөв хөрөнгө гаргаж хийх ийм зохицол байдлаар юм хийхгүй хөндий газар нэг битүү одоо Монголчууд орохгүй төмөр хашаатай ч юм уу, 1 ийм байшин барьчхаад тэрийг казино гээд тэгээд мундаг аялал жуулчлал ирнэ гэж бодож байгаа би бас үүнийг зөрүүтэй л ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүний асуултад Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Яах вэ, эхнээс нь би хариулъя. Монгол хүн яагаад оруулахыг хориглох вэ? Монголчууд чинь гадна талд тоглоод байна гэдэг асуудал ярьж байна. Яах вэ, энэ мэдээж хэрэг хууль хэлэлцэх явцад Их Хурлын гишүүдийн зарчмын зөрүүтэй санал гаргах эрх нь та бүгдийн эрхийн асуудал байгаа. Жишээлэхэд Солонгос улс дотоодын иргэдээ казинод тоглохыг хориглодог. Тэр нөгөө Кан Вон Лэндээс бусад газар. Казинод нэвтрэхийн тулд 19 насанд хүрсэн гадаад хүн гэдгээ нотолж паспортоо үзүүлж оруулдаг. Шаардлагатай тохиолдолд казиногийн операторын асуултад зөв бас хариулах ийм үүрэг хүлээж ингээд ордог. Дотоодын иргэд ордог газар нь өөр гээд би түрүүн хэлчихсэн. Сингапур улс 21 нас хүрсэн хүн бүр тоглогч байх хэрэгтэй. Гэхдээ Сингапурт нэг ийм хуульд нэг өөр зүйл байгаа. Донтолтын цаг гэж байгаа юм. Тэгээд тэр хүний нөгөө татвар төлдөг болон бусад тэр бүх зүйлүүдийг ингээд шалгуур үзүүлэлт бий болгодог. Сингапур нөгөө иргэн бүрийн нөгөө мэдээлэл их нарийн тийм мэдээллийн юу бааз сайтай учраас үүнийгээ нэлээн нягтлаад явдаг. 24 цаг орох эрх нь 100 синга доллар, 1 жилийнх нь 2000 синга доллар ч гэдэг юм уу ийм тарифтай байх жишээтэй.

Макаод төрийн албан хаагч казино тоглох хориотой бөгөөд Хятадын шинэ жилийн баярын хоногуудад зөвхөн энд хориглогдсон эрх нь нээгддэг. Ийм улс орон болгонд их өөр өөр зохицуулалтууд байна. Зүгээр яах вэ манай хувьд бид энэ саяхны л жишээ л дээ. Тэр 2005, 6 онд маш олон ХЗХ-дууд дампуурсан. Маш олон хүмүүс ажил амьдралаа алдсан. Ийм жишээнүүд байдаг учраас иргэдийн дунд энэ бид нар хууль хийхдээ бас хэд хэдэн удаагийн том хэлэлцүүлгүүд зохион байгуулсан. Хэлэлцүүлэг дээр дийлэнх нь Монгол иргэд орох шаардлагагүй ээ л гэдэг ийм байр суурийг илэрхийлсэн учраас бид нар энэ хуулийн төсөл дээрээ Монгол иргэн орохыг хориглосон агуулгаар оруулж ирсэн. Хэлэлцүүлгийн явцад бас өөр саналууд яригдах байх гэж бодож байна.

30 жил гэдэг ерөөсөө л бид нар нөгөө нөгөө хөрөнгө оруулагчийг татах гол мотивац нь гэж ойлгож болно. Макаод жишээлбэл 25 жил гээд юугаа лицензээ өгч байгаа юм. Тэгэхээр бид нар Сингапураас байршил юу билээ. Наашаа дэд бүтэц юу билээ. Ерөнхийдөө бас бид нар чинь мухар улс шүү дээ. Тийм учраас тогтвортой ийм хөрөнгө оруулалт орох ийм боломжийг нээх үүднээс энэ бүс нутагтаа бид нар бас энэ бизнесийг амжилттай зохион байгуулах үүднээс ийм мотивац хөшүүрэг оруулж ирсэн.

Байршлын хувьд яг таны хэлж байгаагаар бид нар бас засаг дээр ярьж хийхээр төлөвлөсөн. Өөрөөр хэлбэл Хөшигийн хөндийн чөлөөт бүсэд бид нар энэ казино байгуулья. Чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөлт хийгдэж байгаа, чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөлтийн талаар Оюунхорол дарга танилцуулах байх ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулья. 81 дүгээр микрофон Оюунхорол дарга хариулья.

Д.Оюунхорол: Ганболд гишүүний асуултад хариулья. Ер нь аялал жуулчлалын салбарт өгөх үр өгөөжийн хувьд нэлээн өндөр хэмжээний ийм үр ашиг боломж гарна гэж бид тооцож байгаа. Жишээлбэл 2019 онд Монгол Улсад 5570 орчим мянган жуулчин орж ирсэн. Энэ бол манай эдийн засагт үр өгөөжийнхөө хувьд нэг 607 орчим сая доллар байсан. Энэ нь Монгол төгрөгт шилжүүлбэл нэг 1.7 их наяд төгрөг. Өөрөөр хэлбэл нэг 570000 жуулчин орж ирэхэд эдийн засгийн үр өгөөж нь нэг 1.7 их наяд буюу нийт экспортын 6.8 хувь, хөдөлмөр эрхлэлтийн нэг 7.6 хувийг эзэлж байсан. Энэ бол 19 оны статистик байсан.

20 оны байдлаар бид нар 58900 жуулчин авсан. Энэ ковидын жилүүдэд аялал жуулчлалын салбар ер нь бүхэлдээ ингээд хямарч эхэлсэн. 2021 онд бид нар 31 мянган жуулчин авсан. Энэ бүр их

уналттай болсон. Ингэснээрээ бид нар эдийн засгийн үр өгөөжийн хувьд 1.7 их наяд төгрөгийг алдсан. Тэгэхээр бид нар эдийн засгийн үр өгөөжийн хувьд казино байгуулагдсанаар Монгол Улс бол зөвхөн манай эдийн засаг ийм 3 хөлтэй байна. 1 дүгээрт, хүрэн эдийн засаг уул уурхайн салбарын орлоготой 2 дугаарт, МАА-н салбараас ордог орлоготой байна. 3 дугаарт, бид нар аялал жуулчлалын салбараасаа орлого олох. Ийм бүрэн боломж байгаа учраас энэ эдийн засгаа солонгоруулахад нэлээн үр дүнтэй юм гэж ингэж үзэж байгаа. Тийм учраас Нямбаатар сайдын саяын тайлбаруудыг хийж байгаа энэ үр дүн гарна гэж бид үзэж байгаа.

Бид нар ядаж нэг сая жуулчин авахад бид нарт өгөх эдийн засгийн үр өгөөжийн нэг 10 орчим хувьтай болно. Биднийг тойроод нэг 2 цагийн нислэгийн зайнд 302 сая хүн амьдарч байна. Үүнээс ядаж нэг 0.5 хувийг авахад бид нар ядаж ингээд Монгол Улсыг сонирхдог ийм жуулчдын тоо нэмэгдэх ийм боломжтой юм гэж үзэж байгаа.

Өнөөдрийн байдлаар бид нар Монголын энэ өргөн уудам сайхан байгаль дэлхийг үзэхээр ирнэ ээ гэж ярьдаг боловч манай аялал жуулчлалын салбарын дэд бүтэц тийм үр дүнтэй, өгөөжтэй хөгжиж чадаагүй. Нөгөө талаас үзэж харах юм багатай. Дэлхийн аялал жуулчлалын байгууллагаас гаргасан судалгаагаар өнөөдөр дэлхийн 193 орноос 155 оронд казино байгуулагдсан. Аялал жуулчлалын салбарын үндсэн гол бүтээгдэхүүн өнөөдөр казино байгуулагдсанаараа тухайн улс орны жуулчдын тоо нэмэгдэж байна гэсэн ийм судалгааны дүнгүүд гарсан байгаа. Тийм учраас улс орон болгон байгуулж байгаа учраас манайх байгуулах тийм бүрэн боломжтой юм гэж үзсэн.

Нөгөө талаас манай Хөшигийн хөндийд барих шалтгаан нь юу байгаа вэ гэвэл 1 дүгээрт, ер нь казино байгуулбал Монгол Улсын эдийн засгийн үр өгөөж нь

ямар болох юм бэ гэдгийг нэг казино байгуулж харья гэж үзэж байгаа. 2 дугаарт, өнөөдөр Монгол Улсыг дэлхийтэй холбож байгаа гол гүүр бол өнөөдөр нисэх онгоцны буудал. Тийм учраас онгоцныхоо буудлын ойролцоо ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Оюунхорол дарга аа, гүйцээгээд хариулчихъя. 81 дүгээр микрофон өгье.

Д.Оюунхорол: Онгоц буудлынхаа ойролцоо казиног байгуулах нь зөв юм. Ирж байгаа жуулчид бол хангалттай ирэх боломжтой. Дэд бүтцээ бид нар эвтэйхэн хөгжүүлье. Ер нь казино гэдгээс айх сүрдэх юм байдаггүй ээ гэдгийг дэлхийн олон улсын туршлагауд нотолж харуулсан. Олон судалгааны дүнгүүд байдаг. Энэ казино байгуулагдсанаар тухайн бүс нутагт үйлчилгээний аялал жуулчлалын томоохон цогцолбор бий болно. Сая Нямбаатар сайдын хэлж байгаа бид нар энтертайнмент тийм шоу бизнесийн нэг ийм том цогцолбор бий болно оо гэж үзэж байгаа. Энд олон мянган ажлын байр бий болно. Эдийн засгийн үр өгөөжийн хувьд бид нар ямар ч байсан нэг 15000 орчим ажлын байрыг шинээр бий болгох ийм боломж бүрдэнэ ээ гэж үзэж байгаа.

Худалдаа үйлчилгээний төвүүд байгуулагдана, соёлын бүтээлч үйлдвэрлэлүүд байгуулагдана. Эрүүл мэндийн ухаалаг хотхон байгуулагдах ёстой гэж үзэж байгаа. Мэдээлэл технологийн төв байгуулагдана. Цаашдаа олон улсын санхүүгийн төв байгуулах гэсэн ийм том бүтээн босголтууд хийгдсэнээр энэ аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүн маань илүү өргөн агуулгаараа эдийн засгийн үр өгөөжтэй Монгол Улсад бас ийм эдийн засгийн том үр өгөөж өгөх ийм боломж бололцоо бүрдэнэ ээ гэж үзэж байгаа юм.

Одоогоор бид нар яг ийм мэдээлэлтэйгээр энэ материалуудыг бэлдсэн. Ямар ч байсан эдийн засгийн үр

өгөөжөө бид нар нэг цаашилбал нэг 15 лүү наад зах нь ядаж нэг 10 хувь эдийн засагт үр өгөөжийг нь өгдөг ийм боломжтой болгоё оо гэж бодож байгаа. Ер нь дэлхийн олон улс оронд казиногийн орлогоос ордог татваруудыг тодорхой ийм зүйлүүдэд зарцуулдаг. Жишээлбэл, Солонгос улс аялал жуулчлалыг хөгжүүлэх сандаа 10 хувийн онцгой албан татвар авдаг. Боловсролын салбартаа зориулж 4 хувийн онцгой албан татвар авч байна. 1 хувийг эрүүл мэнд боловсролын салбартаа зориулж ийм татваруудыг авдаг ийм туршлагауд байгаа. Тийм учраас манайх бас ерөнхийдөө энэ хуулиа боловсруулахдаа манай Хууль зүйн яам нэлээн хамгийн өнөөдөр дэлхийд байгаа, гайгүй загварын туршлагатай Макаогийн туршлагыг авсан. Зарим нэг гишүүдийн ярьж байгаа асуудлууд, саналуудыг зохицуулах өөрчлөх асуудал манай УИХ-ын гишүүдийн ажлын хэсэг дээр яриад шийдвэрлэж болох ийм боломжтой асуудлууд байгаа гэж үзэж байгаа.

Л.Мөнхбаатар: Нямбаатар сайдаас бас нэг хэдэн зүйлийг тодруулаад асуучихъя. Тэгээд түүн дээр бас хариулах явцдаа Нямбаатар сайд бас үлдсэн асуудал байвал нэмээд харуулчхаарай.

Ер нь казино байгуулж, аялал жуулчлалыг татах мөн нэмэлт орлого олох энэ боломжийг улс орон болгон ашиглаж байгаа. Нийтдээ 154 улс казино байгуулж үйл ажиллагаа явуулж байгаа орлого олж байгаа юм. Монголд байгуулах бас тийм шаардлага бий болоод энэ хуулийн төслийг өргөн бариад байгаа.

Би 2, 3 зүйл тодруулаад асуучихъя. Ер нь энэ казино байгуулснаар энэ жилд ер нь хэд орчим төгрөгийн орлого орж ирнэ гэж үзэж байгаа вэ? Орж ирж төсөөлөл гаргасан байгаа байх. Нөгөөтээгүүр энэ орж ирсэн орлогоо хэрхэн зарцуулах вэ. Хэрхэн зарцуулах вэ? Одоо ингээд нэг төсвийн алдагдалд ингээд оруулаад л яваад байх юм бол алдагдлыг хаах маягаар яваад байх юм урсгал зардал засварт явсаар байгаад

дуусаж байна шүү дээ. Тийм учраас нэгэнт л нэмэлт орлого гэж ойлгож байгаа бол энэ орлогыг цаашдаа бусад улс оронд ингэдэг юм байна лээ дээ. Том бүтээн байгуулалтуудад зарцуулдаг. Одоо ёстой л нөгөө том театруудаа барьдаг, эмнэлгүүд барьдаг, Дуурийн театр гэдэг юм уу. Бусад энэ томоохон зүйлүүдээ хийж хэрэгжүүлдэг ийм туршлагатай орнууд байдаг юм байна лээ. Сингапур гэх чинь л бооцоот морь уралдааныхаа орлогоос тэр томоохон бүтээн байгуулалтуудыг бас жил болгон заавал нэг хийгээд явдаг ийм жишээтэй байх жишээтэй. Тийм учраас ийм байдлаар ер нь та бүхэн орлогоо ер нь хэрхэн яаж төлөвлөж байна, зарцуулах талаараа.

Нөгөөтээгүүр яах вэ, ер нь Хөшигтийн хөндийд эдийн засгийн чөлөөт бүсэд казиногийн салбар байгуулагдах нь байна. 1 ширхэг. Тэгээд 5 жилийн хугацаанд өөрийг байгуулахгүй гэж байгаа юм. Гэхдээ ер нь үүнийгээ бас ер нь та бүхэн маань бусад ер нь хаана байгуулахаа та бүхэн судалж үзсэн бэ. Одоо тухайлбал яг үнэндээ манай дээр орж ирж байгаа жуулчдын тоо бас гадаадын иргэдийн хилээр нэвтэрч байгаа тоогоор болчихсон бас яваад байдаг. Гэтэл яг бодит жуулчид би тухайлбал Хөвсгөл аймагт хамгийн их очиж байгаа гэж үзэж байгаа юм. Зуу гаруй мянган хүн очдог. Зөвхөн ОХУ-аас л гэхэд Ханх боомтоор 20 гаруй мянган жуулчин ирж байгаа шүү дээ. 20 гаруй мянган. Одоо олон улсын боомт болсон Ханх. Ингээд үзэхээр энэ их томоохон аялал жуулчлалын төв бол Хөвсгөл байх жишээтэй. Тэгэхээр энд дараагийн казиног байгуулаад ашиг орлого олж, эндээс олсон орлогоороо бас аймаг орон нутгаа татаасгүй авч явах энэ боломж нь бас бүтэх учиртай гэж ойлгоод байгаа юм. Тэгэхгүй бол Хөвсгөл аймагт аялал жуулчлалаас олж байгаа орлого чинь нөгөө 200-аад сая төгрөг байх жишээтэй байгаа шүү дээ. Тийм учраас энэ ялангуяа уул уурхайгүй хөгжье гэж байгаа тохиолдолд аялал жуулчлалаа хөгжүүлж хөгжье гэж байгаа бол уул нь энэ их чухал

юм гэж харагдаад байгаа. Үүнийг судалж үзсэн үү гэдгийг асууя.

Нөгөөтээгүүр энэ тодорхой хугацааны дараа юу яах нь л даа, 50 хувийг өөрийн хувьцааныхаа 50 хувийг ЗГ-т үнэ төлбөргүй шилжүүлнэ гэсэн ийм заалт байгаа. Ийм улс орнууд ер нь хэр байдаг вэ? олон улс орон байдаг юм болов уу? та бүхэн бас судалж үзсэн байх. 50 хувийг нь ЗГ эзэмшээд явчихдаг ийм тохиолдол хэр олон байдаг юм бол гэдгийг бас асуумаар байна.

Ер нь түрүүн Хассуурийн Ганхуяг гишүүн бас асуугаад байна лээ. Энэ зөвшөөрлийн тухай хуультайгаа бас уялдуулах шаардлага байгаа шүү гэдгийг бас манай хууль санаачлагчид болоод Байнгын хороогоор хэлэлцэхдээ бас та бүхэн бас анхаараарай. Үүнтэй уялдуулах ёстой энэ 7 дугаар зүйлд зөвшөөрөл олгохтой холбоотой асуудал байгаад байна. Энэ дээр энэ казиногийн бизнес эрхлэгч гээд ингээд казино эрхлэгч нь казиногийн бизнес эрхлэхэд хангалттай санхүүгийн эх үүсвэртэй байна гээд заачихсан. Хангалттай санхүүгийн эх үүсвэрүүдийг хэрхэн яаж тогтоох юм, та бүхэн тогтоох юм уу. Тэд нар өөрсдийгөө нотлох юм уу гэдэг ч юм уу Тийм ээ.

Нөгөөтээгүүр бас энэ казиногийн бизнес гэдэг үг ингээд л хууль дээр хэрэглээд яваад байх шиг байна тийм ээ. Энэ өөрөө ямар ойлголт юм бол оо гэж би харж байна. Ер нь энэ казино байгуулахдаа анх тусгай зөвшөөрлийг 30 жилээр олгох нь ээ. Тэгэнгүүтээ дараа нь 10 жилээр сунгаад явах юм байна. Ер нь тогтвортой нэгэнт 30 жилээр олгосон юм бол тогтвортой үйл ажиллагаа явуулах, магадгүй та бүгд бас тодорхой энэ саналууд хүлээж авахын тулд бас мэдээж тухайн компани нь үр дүнтэй ашигтай урт хугацааны л бизнест орох байх л даа. Энэ үүднээс нь 30 жилээр ахиад сунгаад явчхаж болоогүй юм уу? яагаад ингээд 10 жил гэсэн энэ тоо гаргаж ирсэн юм бол оо гэдгийг тодруулья.

Нөгөөтээгүүр энэ казиногийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд энэ казиногийн цогцолбор, казиногийн тоног төхөөрөмж казиногийн хамааралтай үйл ажиллагаатай хөрөнгийг ЗГ хурааж авна гэсэн байгаа юм. Гэхдээ энэ казиногийн баахан тоног төхөөрөмжийг хурааж авах нь хэр зохимжтой юм бол. Үүнийг дараа нь яах юм. Буцаагаад зарах юм уу их ойлгомжгүй байх юм. Энэ дор харин нөхөн төлбөр энэ торгууль оногдуулдаг энэ заалтаа бариад явбал илүү зүгээр байгаа юм биш үү гэж харагдаад байна. Энэ дээр бас түрүүн юу харагдчихав аа. Энэ Казиногийн зөвшөөрлийг тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохтой холбоотой энэ асуудлыг ярихдаа тэр удаа дараа гэсэн ойлголт ашиглачихсан байна лээ тийм ээ. Удаа дараа гэдэг маань нь 2 ба түүнээс дээш гээд биччихсэн байна лээ. Ер нь 2 гэдгийг энэ давтан гэдэг хууль зүйн ойлголт байгаа шүү дээ. Тийм ээ, 3-аас дээшхийг л удаа дараа гэсэн ойлголт л байдаг гэх мэтчилэн ингээд нэр томъёо энэ олон зүйлүүдээ бас анхаараарай гэдгийг хэлбэ.

Ингээд асуултдаа хариулт авчихъя. Нямбаатар сайд хариулах уу. Оюунхорол дарга хариулах уу, ажлын хэсэг. Ажлын хэсэг хариулъя. 81 дүгээр микрофон өгье. Казиногийн орлогыг хэрхэн зарцуулдаг талаар.

Д.Оюунхорол: Мөнхбаатар даргын асуултад хариулъя. Казиногийн хуульд өнөөдрийн өргөн барьсан хууль дотор аялал жуулчлалын салбараас орж ирсэн орлогын 5 хувийг Аялал жуулчлалыг хөгжүүлэх сандаа авъя. Ирээдүйн өв сандаа 10 хувийг нь авъя, 15 хувийн онцгой албан татварыг ийм зүйлд зориулъя гэж манай Монгол Улсын хуульдаа оруулж ирсэн. Бусад улс орны жишгээр боловсрол, эрүүл мэндийн салбар, нийгмийн салбартаа казиногийн орлогоос орж ирсэн орлогыг хуваарилдаг ийм ерөнхий нэг ийм жишиг байгаа юм байна лээ. Тийм учраас энд нь зориулъя гэж бид нар бодож байгаа. Тийм учраас

хэлэлцүүлгийн явцад таны саяын хэлсэн саналуудаар манай Их Хурлын гишүүд өөрсдөө санал гаргаад ямар зүйлд ер нь казиногоос орж ирэх орлогыг зарцуулах вэ гэдэг асуудлыг илүү ярих нь зүгээр байх.

Цаашдаа бид нар ер нь аялал жуулчлалын салбарынхаа дэд бүтцийг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбараа хөгжүүлэхэд зориулж хүн татах тэр хүчийг бий болгохын тулд магадгүй энэ хөрөнгө оруулалтуудыг илүү зориулах улсын төсвөөс бас тодорхой хөрөнгө оруулалт тавьж чаддаггүй энэ салбараа хөгжүүлэх тийм зайлшгүй шаардлага байж магадгүй. Энэ бол урт хугацаандаа хэрэгтэй гэж бид үзэж байгаа. Казиногийн хуулийг боловсруулах явцад яригдаж байгаа нэг гол зүйл ер нь сонгон шалгаруулалтаар олон улсын тендер зарлаад ялсан компанид лицензийг олгохдоо ямар хугацаагаар олгох вэ. Түүнийг яаж зохицуулах вэ гэдэг асуудлыг Мөнхбаатар дарга бол эргэж хараарай гэж байна. Энэ асуудал дээр бид нар 30 жилийн хугацаагаар олгоё оо гэж байгаа юм. Макаогийн хуулийг бид нар ерөнхийд нь иш үндэс буулгаж авсан. Тэгэхээр Макао бол эхний лицензийг олгохдоо 20 жилийн хугацаатайгаар олгоод 20 жилийн дараа 5, 5 жилээр ингээд сунгаад явдаг ийм тогтолцоотой юм байна лээ. Тэгэхээр бид нар бол 20 жилийг нь 30 жил болгож эхний лицензээ олгоод, түүнээс хойш 10 жилийн хугацаатай ингээд үргэлжлүүлэн сунгах ийм гэрээ хэлэлцээрүүдийг хийж түүндээ тохирсон төлбөр, хураамжуудаа төлдөг байх нь зөв юм гэж энэ удаагийн хуульдаа оруулж ирсэн байгаа.

Үнийн дүнг бид нар одоогийн байдлаар 300000000 америк доллароос дээш хөрөнгө оруулалт хийсэн ААН олон улсын зарласан тендерт оролцох боломжтой гэсэн бол нэг 1 их наяд гаруй төгрөгийн ийм хөрөнгө оруулалт хийсэн ААН оролцох ийм боломж бүрдэнэ. Нөгөө талаас ийм хотхон байгуулах энтертайнмент шоу бизнесийн хот болно

оо гэж бид нар харж байгаа юм. Тийм учраас энд нэлээд хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай учраас тухайн ажиллах ААН хөрөнгө оруулагчдыг үргээхгүйгээр тухайн бүс нутагт нь үйл ажиллагаа явуулах боломжийг олгох, нөгөө талаас манай дотоодын ААН-үүдийг ажлын байраар нь хангаж өгөх мөн дотоодын ААН-үүд маань зочид буудал барих, хоол үйлчилгээний газрууд барих, дэлгүүр үйлчилгээний төвүүдийг барих тэр боломж бололцоог нь Хөшигийн хөндийн эдийн засгийн чөлөөт бүс дээр чөлөөтэй ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Уг хэлэх гишүүн байна уу? Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан. Алга байна. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 хүртэлх гишүүн авч үг хэлж болно. Алга байна.

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу 14.12-т хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно гэж заасны дагуу санал хураалтыг түр хойшлууллаа.

2 Байнгын хороо хуралдаж байгаа учраас ирцийг бүрдүүлж санал хураалтыг явуулна.

15.51 цаг

Ингээд дараагийнхаа асуудалд орёё.

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна.

Х.Нямбаатар: УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Алсын хараа 2050 бодлогын баримт бичиг, төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлогод заасны дагуу эдийн засгийн өндөр үр өгөөжтэй, соёлын өвд түшиглэсэн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Дэлхийн жишгээр бооцоот морин уралдаан нь тодорхой хяналттайгаар эрхлэхийг зөвшөөрдөг мөрийтэй тоглоомын нэг төрөл бөгөөд улс орнуудын онцлогоос хамааран энэ төрлийн үйл ажиллагааг ашгийн болон ашгийн бус загвараар явуулдаг. Ашгийн бус загвартай улс орнууд болох Хонг Конг, Солонгос, Япон зэрэг улс орнуудад төрийн байгууллагын дэргэд төрөөс тусгайлан нэг этгээдэд олгосон эрхийн дор энэ төрлийн үйл ажиллагааг явуулдаг бөгөөд харьцангуй өндөр татвартай байдаг. Харин АНУ, Их Британи зэрэг улс орнуудад ашгийн загвартай морин тойруулга нь хувийн өмчид байхаас гадна ашиг олох зорилготой үйл ажиллагаа гэж үзэх тул бизнесийн орчин харьцангуй чөлөөтэй, татварын хувь хэмжээ бага байдаг.

Монгол Улсын тухайд бооцоот морин уралдааныг хууль ёсоор хариуцлагатай эрхлэх боломжийг бий болгох үүднээс энэ төрлийн үйл ажиллагааг ашгийн бус загвараар явуулахаар хуулийн төсөлд бооцоот морин уралдааны үйл ажиллагаа эрхлэх нийтийн эрх зүйн субъект буюу Монголын морин уралдааны холбоог хуулиар байгуулж, түүний чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоолоо.

Морин бооцоот уралдааныг олон улсын стандарт шаардлагад нийцсэн аюулгүй байдлыг хангасан зориулалтын тоног төхөөрөмж бүхий морин тойруулгын цогцолбор зохион

байгуулахаар заасан бөгөөд морин тойруулгын ажилтан нь энэ төрлийн үйл ажиллагаанд бэлтгэгдсэн байхаар тусгалаа. Морин бооцоот уралдааны үйл ажиллагаанд дагаж мөрдөх морин тойруулгын дүрэм, бооцоот уралдаан зохион байгуулах, бооцоо тавих, бооцоог тооцоолох, хуваарилах дүрэм аргачлал, бооцоот морин уралдааны ёс зүйн дүрэм зэрэг холбогдох дүрэм, аргачлалыг холбоо батлахаар заасан бөгөөд бооцоот уралдаанд уралдах морьдын ангилал, уралдааны төрөл, хэлбэрийг бооцоот морин тойруулгын дүрмээр тогтоохоор тусгасан.

Түүнчлэн хүүхдийн эрхийг хамгаалах үүднээс бооцоот морин уралдааны морийг морь уралдуулах чадвар дадлыг эзэмшүүлэх, морин уралдааны боловсрол олгох коллеж төгссөн, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий 18 насанд хүрсэн хүн унах бөгөөд тухайн шаардлагыг хангаагүй хүн бооцоот уралдааны морь унуулахыг хориглосон. Бооцоот морин уралдаанд холбооны гишүүнчлэлтэй уяач, морин тойруулгын дүрмийн дагуу морио уралдуулах боломжтой бөгөөд холбооны гишүүнчлэлийн нөхцөл шаардлага хураамжийн хэмжээг холбооны дүрмээр тогтооно. Түүнчлэн бооцоот уралдаан цугларсан нийт орлогын 60 хувиас доошгүй хувийг оролцогчдын бооцооны хонжвор, түрүүлсэн болон шагналт байранд орсон морины уяач, унаачийн шагналд олгохоор заасан.

Татварын хувьд бооцооны нийт орлогоос хонжворт олгосон дүнг хассан дүнгийн 60 хувиар онцгой албан татвар ногдуулах тул давхардуулан ААНОАТ, нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахгүй байх зарчмыг баримталсан бөгөөд тоглогчийн хонжворын орлогод ХХОАТ ногдуулахгүй байхаар тус тус тусгалаа.

Мөн холбооны төлсөн онцгой албан татвараас төвлөрүүлсэн орлогын

тодорхой хувийг аялал жуулчлалыг хөгжүүлэх санд төвлөрүүлэхээр тусгасан.

УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Нямбаатар сайдад баярлалаа.

Төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, Түр хорооны дарга Энхтайваны Бат-Амгалан танилцуулна. Бат-Амгалан гишүүнийг индэрт урьж байна.

Э.Бат-Амгалан: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг ХЗБХ 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч бооцоот уралдааны үйл ажиллагааг хууль ёсоор хариуцлагатай эрхлэх боломжийг бий болгох, бооцоот морин уралдааны үйл ажиллагааг эрхлэх, нийтийн эрх зүйн этгээд буюу Монголын морин уралдааны холбоог байгуулах, түүний чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох, бооцоот уралдааны үйл ажиллагааг нээлттэй, хариуцлагатай, ил тод байдлаар зохион байгуулах, оролцогчдод тэгш боломж олгох, бооцоот морин уралдааны оролцогч, уяач, унаачийн эрх ашгийг тэнцвэртэй хангах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд аливаа төрлийн зардал үүсэхгүй бөгөөд төрийн байгууллага болон тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

тодорхой зардал үүснэ гэж хууль санаачлагч үзсэн байна. Хуулийн төслийн D Parliament.mn цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Сандаг-Очир бооцоот морин уралдааны тусгай зөвшөөрлийг олгох байгууллага, унаачид эрсдэл гарсан тохиолдолд даатгалын асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар, УИХ-ын гишүүн Мөнх-Оргил Морин спортын нэг холбоо байгуулж, үндэсний наадам болон бооцоот морин уралдаан зохион байгуулах боломжтой эсэх, Хонг Конгийн бооцоот морин уралдааны клубтэй төстэй хувилбарыг сонгох болсон шалтгаан, давуу тал, морин тойруулга байгуулахад тооны хязгаарлалт байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 61.5 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Бооцоот морин уралдааны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаар ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга Дорждэрэмийн Цолмон, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын

мэргэжилтэн Лувсанцэрэнгийн Пүрэвсүрэн, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын шинжээч Амартүвшингийн Амармөрөн, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны дарга, ЗГ-ын Бүрэн эрхт төлөөлөгч Дуламсүрэнгийн Оюунхорол нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух УИХ-ын гишүүд нэрсээ өгье.

Ганхуяг гишүүнээр, Ганболд гишүүнээр тасаллаа. Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Зарчмын хувьд дэмжиж байгаа, энэ хуулийн төслийг. Хамгийн гол нь миний зүгээр ганц асуух гэж байгаа юм нь энэ манай Монгол морины уралдаанд мэдээж уламжлалтай энэ нүүдлийн соёл бидний бас нэг ганц бахархах зүйл гэж бид нар үздэг. Энэ ч утгаараа бас үнэн. Харин сүүлийн жилүүдэд хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхэд морин уяаны наадам энэ тэрээр морины уралдаанд оролцоод бүх насаараа тахир дутуу болсон. Тэгээд нэг удаагийн тэтгэлэг өгөөд л алга болчихдог. Харин нөгөө хүүхэд тэр хүүхдийн гэр бүл тэр чигээрээ насан туршдаа санхүүгийн хохиролд орох явдал Сүүлийн жилүүдэд их гарч байгаа. Манай Чингэлтэй дүүрэгт л гэхэд ийм айл 14 байгаа. Тэгээд нэг удаа өгсөн. Өнөөдөр хүүхэд нь хэвтэрт байдаг ч гэдэг юм уу. Ийм зүйлээс болоод нөгөө энэ морины уралдаанд хүүхэд оролцуулахдаа малгай өмсгөх, стандартын хувцастай байх, насны хязгаар тогтоох гэх мэт зүйлүүдийг бид нар бол маш их эмэгтэй гишүүдийн зүгээс гаргаж тавьж байгаа. Зарим арга хэмжээнээс ч авагдаж байгаа. Сая Нямбаатар сайдын тайлбараас харлаа. Энэ дээр насны хязгаарыг тогтоох тийм зарим нь бусад улс оронд одоо жишээ нь Англид ч гэдэг юм уу энэ морины бооцоот морин уралдаанд оролцоход энэ насны хязгаар энэ тэр гээд байдаггүй юм байна лээ.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Тэгэхээр манайд энэ хүүхэд уралдуулах гэвэл насны хязгаарыг нь тогтоож өгөх хүүхдийн аюулгүй байдал хүүхдийн эрх зөрчигдөхгүй байх тал дээр хэр онцгойлон анхаарсан бэ? Энэ дээр бид бас тодорхой хариулт авъя гэж бодож байна. Сая бол зүгээр хүүхдийн эрх зөрчигдөхгүй байх дээрээ бас хуульд анхаарсан гэсэн өгүүлбэр хэллээ. Харин ямар заалт дээр яг энэ орсон байгаа. Хэрвээ зөрчсөн тохиолдолд ямар арга хэмжээ авах вэ гэдэг дээр хариулт авахыг хүсэж байна аа. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад Нямбаатар сайд хариулъя. Баярлалаа.

Х.Нямбаатар: Энэ бид нарын нөгөө уламжлалт морин уралдаанаас шал ондоо. Энэ дэлхий нийтэд маш олон зуун жил бий болсон сонгодог морин уралдааныг Монголд нутагшуулах, энэ төрлийн бооцоо тавьдаг, бизнес эрхэлдэг, аялал жуулчлалын цогцолбор байгуулах бас тусдаа төсөл юм. Энэ төслийг бид нарын зүгээр урьдчилан харж байгаагаар сая 1 сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд энэ Хүй 7 худгийн одоогийн морь барьдаг дэнж дээр энэ цогцолборыг барьж байгуулах ийм төлөвлөгөөтэй бид нарын хуулийг боловсруулах явцад ярьж судалсан зүйл бий. 7 сарын 11, 12, 13-ны өдрүүдэд төр энэ Монголын морин уралдааны холбооны энэ стадионыг ашигладаг. Бусад цагуудад дотоодын болон гадаадын аялал жуулчлалаар очсон хүмүүс сонгодог морин уралдаан дээр бооцоо тавьдаг, зугаацдаг цэнгэдэг ийм нэг аялал жуулчлалын том бүтээгдэхүүнтэй болчихъё оо гэсэн бас зорилгоор энэ төслийг оруулж ирж байгаа. Мөн л ялгаагүй би бас 2018 онд энэ төслийг бас эхлүүлсэн гэж хэлж болно.

Тэгээд энэ саяын Оюунчимэг гишүүний асуулт би маш тодорхой хариулъя.

Энэ дэлхийн сонгодог морин уралдаан ерөөсөө Жоки гэдэг тусдаа мэргэжилтэн байдаг. Энэ 3-4 жилийн хугацаанд тусдаа коллежид яг энэ морин уралдааны чиглэлээр сургуульд сурч төгсөөд Жоки гэдэг үнэмлэх авсан 18 насанд хүрсэн хүмүүс байдаг. Дэлхийн дунджаар бол нэг 50 хэдэн килограммтай тийм эрчүүд голцуу энэ уралдааны энэ Жоки гэдэг энэ мэргэжлийг эзэмшсэн байдаг. Хэдий хөнгөн байх тусмаа төдий чинээ морь нь уралдана гэдэг ийм агуулгатай байдаг. Дэлхий дээр 2 загвар байдаг. Ашгийн төлөө загвар, ашгийн төлөө бус загвар гээд. Жишээлбэл АНУ-ын Кентаки гээд тэр мужид улсад бол ихэвчлэн энэ нөгөө хувийн морин уралдааны тэр компаниуд үйл ажиллагааг явуулдаг. Ийм чиглэл рүүгээ байдаг. Бид нарын хамгийн гол загвар болгож бичсэн газар бол Хонг Конгийн Жоки Клабын загвар буюу Хонгконгийн морин уралдааны энэ холбооны загварыг бид нар илүү баримталж үзсэн. Японд энэ уламжлалаар маш сайн хөгжиж байгаа. Солонгост бас энэ чиглэлийн морин уралдааны газрууд байгаа.

Бид нарын мэдэх Хонгконгд жишээлбэл 2 газар байгаа. Хотын төвдөө нэг 60000 хүний стадио, хойд талдаа тэр Сатин гэдэг билүү тэр газраа 100000 хүний суудалтай ийм том морин тойруулгууд байдаг. Тэгээд 7 хоногийн 2-3 өдөр бооцоо тавьдаг. Улс орон даяар үздэг. Жишээлэхэд, Австралийн Мелбурний Каф гэхэд энэ кафын үзэх гэж бараг дэлхийн өнцөг булан бүрээс хэдэн сая хүн тэр морин уралдаанд бооцоо тавьж оролцдог. Ийм нэр хүндтэй байдаг. Хүүхэд уралдахгүй.

Л.Мөнхбаатар: Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууя.

Х.Ганхуяг: Бооцоот морин уралдааны тухай хуулийн төслийг хэлэлцэж байна.

Тэгээд энэ холбоонд олгоно гэсэн байх юм. Эрхийг нь холбоонд олгоно

гэсэн байх юм. Яагаад холбоо гэдэг хувилбарыг сонгосон юм гэдэг нэгдүгээр асуулт байна. Тэгээд энэ эрхийг нь олохдоо ямар шалгуур, ямар процессор, эрхийг нь олгох гэж байгаа нь энэ хуульд бол харагдахгүй байна. Энэ бооцоот таавар гэдэг хүн нөгөө хуулиар зохицуулалтыг нь хийх гэж байгаа юм уу гэдэг нэг дүгээр асуулт байна.

Тэгээд морин тойруулга гэдгээр ингээд тусдаа явсан нь зөв байсан уу үгүй юу тийм ээ. Тэгээд нөгөө тэмээ уралдуулахаар тусад нь бооцоот тэмээний уралдааны хууль гэж гаргах юм уу гэдэг бас асуудал байх юм. Жишээлбэл нөгөө Саудын Арабын орнууд чинь бол тэмээ уралдуулж л байдаг шүү дээ. Нохой уралдуулж л байдаг тийм ээ. Тэгэхээр тэр нэг тусдаа хуулиар зохицуулагдаж явах юм уу эсвэл энүүгээр ингээд яахын дараа нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм уу гэдэг асуулт байна.

Гуравт болохоор энэ ер нь татвартай холбоотой асуудал нь ер нь яах юм. Энэ хууль батлагдсанаар энэ чинь холбоо гэдэг маань ашгийн бус байгууллага шүү дээ. Ашгийн бус байгууллага байгаад байдаг. Тэгээд ийм хонжвортой, бооцоотой ийм төрлийн бизнесийн үйл ажиллагааг холбоонд өгчихөөр татвар нь яах юм. Тэгээд тэндээ тэр нөгөө ТББ дээр чинь бол Сангийн яам, Татварын газар шалгалт хийдэггүй. Тэгээд холбоонд өгчихдөг энэ чинь нэг сайхан мөнгө угаах хэрэгсэл болчих вий дээ л гэж сан зовниж байна. Тэгээд энэ тал дээр бас нэг тодруулга авчихмаар байна. Тэгээд хяналтаа одоо энэ чинь тэгээд яг холбоо гэхээр эзэн биегүй болчихгүй юм уу гэдэг асуудал байх юм. Эд нарыг нэг тодруулчихмаар байна даа. Тэгээд ер нь энэ чинь бол яг байршлыг нь Засгийн газар зааж өгөөд эрхийг нь Засгийн газар олгоно л гэхихсэн байх юм тэгээд зөвшөөрөл хэрхэн яаж олгогдох нь ерөөсөө энэ хууль дээр байхгүй. Эсвэл нөгөө бооцоот тааврын хууль дээрээ байгаа юм уу? Би бас энэ дээр хайгаад л байна. Тэгээд процесс нь энэ дээр ерөөсөө

бичигдээгүй л байгаад байгаа юм л даа. Тэгээд сонгон шалгаруулалтын журмаар явах юм уу. Эсвэл холбоо болгонд өгөөд байх юм уу гэдэг л асуултууд байна даа тэ. Хариулт сонсчхоод тодруулъя.

Л.Мөнхбаатар: Ганхуяг гишүүний асуултад хэн хариулах вэ. Нямбаатар сайд хариулъя. Шаардлагатай бол нэмээд ажлын хэсэг хариулаарай.

Х.Нямбаатар: Баярлалаа. Энэ Ганхуяг гишүүн ээ, бид нар ерөөсөө л яг Хонг Конгийн загварыг л барьж байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ хуулиар Монголын морин уралдааны холбоо гэдэг холбоог байгуулж өгөх гэж байгаа юм. Энэ төрийн байгууллага биш. Зүгээр одоо ТББ-ын хуулиар байгуулагддаг холбоо биш. Гэхдээ сайн дурын үндсэн дээр гишүүнчлэлтэй нийтийн эрх зүйн субъект. Өөрөөр хэлбэл мемберүүд хураамжаа төлөөд энэ холбоог байгуулна. Энэ холбоонд автоматаар энэ хуулиар морин бооцоот уралдаан эрхлэх, түүнтэй холбоотой цахим мөрий бооцоо тавих тэр эрхийг зөвхөн тэр холбоонд хадгалуулна. Төр энэнтэй хутгалдахгүй. Өөрөөр хэлбэл нэлээн гишүүнчлэл нь хураамж их өндөртэй. Тэгээд өөрсдийн гишүүдийн чөлөөт тэр удирдлагаар явдаг хамгийн сайн засаглалтай ийм холбоог байгуулах гэж байг юм.

Холбоо нь өөрөө дэлхийн сонгодог морин уралдааны тэр уралдаан уралдуулах журам тэр бооцоо тавих журам түүнээсээ хэдэн хувийн оодсыг өөрс дээрээ татан төвлөрүүлэх гэх мэт энэ зохицуулалт явна. Дээр нь энд Сангийн яам, түүний Үндэсний татварын алба шалгалт оруулж болно. Оруулахдаа зөвхөн энэ нийт үйл ажиллагааны тэр нөгөө бооцоо тавиад үлдсэнээс 60 хувийг нь төр татаад авна. Би танд нэг сонин жишээ хэлье. Хонг Конг улс нийтдээ нийт улсын эдийн засгийнхаа 30 хувийг энэ бооцооны орлого дээр эргэлдүүлж байгаа юм. 2022 онд Хонг Конг-д нийтдээ 37 тэрбум америк долларын орлого энэ бооцооны морин уралдааны салбараас

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

олсон байгаа. Үүнээс татвар болгож 3.5 тэрбум төгрөгийг татвар болгож авсан долларыг татварт төвлөрүүлж авсан. Нийтийн сайн сайхны төлөө хандивт 841 сая америк доллар буюу ингээд нийтдээ жилдээ дунджаар 4.3 тэрбум төгрөгийг улсын төсөв болон сангуудад төвлөрүүлсэн байгаа.

Бид нар бол энэ бооцоот морин уралдааны салбараас олж байгаа орлогын тодорхой хувийг таны нөгөө нэг ахалж байгаа Аялал жуулчлалыг дэмжих хуулийн аялал жуулчлалын санд тодорхой хувийг төвлөрүүлж ээ. Үлдсэнийг нь Улаанбаатар хотын энэ төвлөрлийг бууруулах гэх мэт ийм хэлбэртэй тодорхой зорилтуудад зарцуулж болно оо. Хүүхдийн боловсрол, эрүүл мэндэд зарцуулж болно. Энийг бас хэлэлцүүлгийн шатанд явъя гэж. Энэ өөрөөр хэлбэл цоо шинэ байхгүй зүйлийг бид нар бий болгоё оо. Залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлдэг ийм төвтэй больё оо.

Төр хувийн хэвшлийн түншлэлээр төрийнхөө наадмыг хийдэг нэг том стадионтой больё оо. Түүнийг нь 3 өдөрт нь төр ашиглая. Үлдсэн өдрүүдэд нь урин дулаан цагт бооцоот морин уралдааны тэр төв байдлаар явъя аа. Түүнтэй холбоотой цахим платформыг энэ холбоо нь өөрөө эзэмшиж явъя л гэж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Нямбаатар сайд гүйцээгээд хариулчихъя. Энэ та яг зөв асуултыг хөндөж байгаа. Бооцоот төлбөрт тааварт хонжворт сугалааны хууль гэж одоо энэний дараа бид нар танилцуулга хийнэ. Энэ Монгол Улсад бооцоот тааварт тоглоомын төрлийн нэг нь казино байна. Нэг нь морин бооцоот уралдаан байна. Бусад нь нөгөө спорт бет болон бусад төрлийн хонжворт таавар тоглоомын хуулийг нөгөө Ерөнхий толгой хуулиар зохицуулж байгаа.

Тэгэхээр жишээлбэл морин бооцоот уралдаан зохион байгуулахад тэр хуулиар зөвшөөрлөө аваад явж болно.

Бөхийн өргөөний барилдаан дээр очоод бооцоо тавиулдаг бооцооны компаниуд үүсэж болно. Бүхий л юман дээр хуулиар тусгай зөвшөөрөл авсан ААН-үүд бооцоо тавьдаг энэ бизнесийн үйл ажиллагаа, зах зээл дэлгэрэх энэ боломжийг бид нар дараагийнх нь хуулиар нээж өгч байгаа. Зүүн өмнөд Азийн орнуудад амьтан хорхой шавж хүртэл уралдуулдаг ийм бизнесийн төрөл хэлбэрүүд байгаа шүү дээ.

Тэгэхээр бид нар бол тэмээ бусад тийм уралдаан зохион байгуулах эрх бол нөгөө бооцоот төлбөр таавар тоглоомын хуулиар зохицуулагдаад явна.

Л.Мөнхбаатар: Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя.

Х.Ганхуяг: 2 удаа тодруулж болно. Би анхны тодруулга хийж байна.

2 асуудал байна. Яг ингээд таны яриаг сонсоод дүгнээд хэлэхэд. Цоо шинэ хэлбэрийн холбоо буюу ТББ байгуулах гээд байна шүү дээ. Тэгээд яг тэрнийхээ хууль нь байхгүй. Тэгээд тэр чинь нэг жонхуу болчих вий дээ. 40 хувь нь яах вэ улсад татвар болоод ирэх юм байна. 60 хувь нь яах юм. Анхан шатны анхны хөрөнгө оруулалтыг нь яаж хийх юм. Гишүүд нь дундаас ингээд ижилхэн хэмжээний мөнгө оруулаад тэр юу билээ Морин тойруулгаа барих юм уу? Анхны хөрөнгө оруулалтыг нь хэн хийх юм гэдгийг нэг тодруулчихмаар байна. Тэгээд дараа нь тэрнээс хойш гарсан ашгаа тэр гишүүд нь тэгш хуваагаад явах юм уу гэдэг асуудал бас эндээс урган гарч ирж байна.

Гуравт яг энэ бооцоот тоглоом, бооцоот таавар, казино, морин тойруулга, энэ эдийн засгийн эффектийг л яриад байгаа шүү дээ. Та бүхэн маань сайд маань хэллээ шүү дээ. Эдийн засагт ийм үр нөлөө авчирна аа. Ийм үр нөлөө авчирна ажлын байр бий болгоно оо гээд яриад байдаг. Тэгээд яагаад энэ хуулиуд Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэгдээгүй

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

юм бэ? Манай ХЗБХ нэг ч эдийн засагч байхгүй шүү дээ. Тэгээд энэ асуудлыг бас ер нь ярилцах л ёстой юм байна. Би бас Их Хурлын дэд даргаас бас хүсмээр байна.

Та энэ чиглэл өгч энийг Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцүүлээч ээ. Эдийн засгийн байнгын хороон дээр ажлын хэсгийг байгуулж өгөөч ээ гэж хүсэлт өгмөөр байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Тодруулгад Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Ганхуяг гишүүнээ энэ хууль өөрөө Монголын Жоги клубыг байгуулах хууль юм аа. Өөрөөр хэлбэл энэ холбоо байгуулах журмыг энэ тусдаа Засгийн газар өөрөө батлаад өгнө. Холбоо нь өөрөө өөрийн удирдлагаар тэр тойруулгын уралдааны журам батална. Түүн дээр тавигдах бооцооныхоо тэр бэт тавих журмууд батална. Холбоо нь өөрийн гэсэн нийтийн эрх зүйн ийм субъект байя. Монгол Улсад анх удаагаа бид нар нийтийн эрх зүйн ийм шинэ субъектийг хуулиар нь байгуулж өгч байна. Одоогийн тэр Морин спорт уяачдын холбооноос шал ондоо байя аа. Энэ хүмүүс нь өөрсдөө яг Хонг Конгийн Жоги Клубын загвараар бид нар энэ хуулийг бичсэн. Энэ хууль өөрөө тэр холбоог байгуулж холбоо нь өөрөө бие даасан үйл ажиллагаа явуулах, хөрөнгө оруулалт татах, ашиг алдагдлаа хуваарилах ийм л агуулгатай бүх эрхийг нийтийн эрх зүйн субъект нь өгье өө л гэж байгаа юм. Өөр юмтай параллелны ийм байдлаар өөр холбоо байгуулагдахгүй. Энэ хэрвээ өөр бүс орон нутгууд хүсэлт гаргавал өөрийнхөө салбар, морин тойруулгын уралдаануудыг шинээр нэмж хийж болно.

Тавьсан олон улсын стандарт шаардлагыг хангасан тохиолдолд нэмж ийм салбар тойруулгууд байгуулж болно оо л гэж байгаа юм. Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудал дээр ерөөсөө хориглож байгаа хаалттай зүйл байхгүй. Энэ өөрөө нэг талдаа ТББ буюу

нийтийн эрх зүйн субъект буюу энэ холбоо байгууллагатай холбоотой харилцаа учраас Улсын Их Хурлын тухай хуулиар ХЗБХ-нд харьяалагддаг нэг асуудал байгаа. Нөгөө талдаа бол та бүхэн энэ хэлэлцэх эсэхээ шийдээд Улсын Их Хурлын даргын захирамжаар бүх Байнгын хороодын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулагдана гэсэн үг. Энэ чуулганы завсарлагаар ажлын хэсэг сайн ажиллая гэсэн ийм төлөвлөгөөтэй өнөөдөр хэлэлцэх эсэхээ шийдүүлье гэж оруулж ирж байгаа.

Гуравдугаарт, Эдийн засгийн байнгын хороогоор нэмж хэлэлцүүлж ХЗБХ-той давхар.

Л.Мөнхбаатар: Казинотой холбоотой багц хуулиудын төслийг бас олон талаас нь ярилцах шаардлага бол байгаа. Нэг талаас Хууль зүйн байнгын хорооны үндсэн асуудал. Эдийн засгийн байнгын хороо дээр нь бас энэ аялал жуулчлалтай холбоотой асуудал байгаа. Энэ Байгаль орчин, аялал жуулчлалын байнгын хороо гээд эдгээрээс бас хэлэлцэж болно. Ийм учраас ажлын хэсгийг бол нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй байгуулъя гэсэн бодолтой байна. Бусад Их Хурлын гишүүд оролцож болно. Их Хурлын даргын захирамжаар байгуулъя. Нөгөөтээгүүр Дэгийн хуульд зааснаар Эдийн засгийн байнгын хороо өөрсдөө хэлэлцээд санал, дүгнэлтээ ХЗБХ-нд ирүүлж болно.

Тийм учраас Эдийн засгийн байнгын хороо өөрсдөө хэлэлцээд санал дүгнэлтээ ХЗБХ-нд ирүүлэх нь зүйтэй гэж чиглэл өгье.

Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууя.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Тэгэхээр би энэ Казиногийн тухай хууль, бооцоот морин уралдааны тухай хуулийн төслүүдийг эдийн засгаа солонгоруулъя. Олон эх үүсвэрээс ашиг орлоготой болъё,

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

аялал жуулчлалын бүтээгдэхүүнийхээ төрлийг нэмэгдүүлье гэдэг ийм зорилгоор бол орж ирж байгаа гэж ойлгож байна.

Тэгэхээр ер нь эдийн засгийн үр өгөөжийн талаар бол сая Ганхуяг гишүүн асуусан. Бид нар бол эдийн засаг талаас нь л илүүтэй бас ач холбогдол өгч байгаа гэж бодож байгаа учраас эдийн засгийн үр өгөөжийн талаарх мэдээллийг дахиж авмаар байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт ер нь энэ бооцоот морин уралдааныхаа энэ бүтээгдэхүүн энэ салбарынхаа хэр том хэмжээтэй цар хүрээтэйгээр харж байгаа юм бэ? Хэчнээн ажлын байр бий болгох юм бэ гэж ач холбогдлынх нь хувьд бас нэмж хэлж өгөөч?

Гуравдугаарт бол их тийм энгийн танин мэдэхүйн чанартай байж магадгүй. Улсын баяр наадам болохоор зэрэг л морин уралдаантай холбоотой маргаан их үүсдэг. Монгол морь уралдуулна, эрлийз морь уралдуулахгүй гээд. Бооцоот морин уралдаанд ийм зүйл гарах уу. Ямар уд морьд уралдаж байх юм бэ? Энэ дээр тэр нэг гарал үүслийн үүлдрийн ялгаа байх юм уу. Үүнийгээ та бүхэн яаж тооцоолж байгаа вэ? Энэ 3 асуултад хариулт аваад тодруулъя.

Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсэг эхлээд хариулъя. Дараа нь Нямбаатар сайд нэмж хариулъя.

Д.Цолмон: Ажлын хэсгийн хэн хариулах вэ? 83 дугаар микрофоныг өгье. Албан тушаал нэрээ хэлээд асуултад тодорхой хариулаарай. Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газар Цолмон.

Сарангэрэл гишүүний сүүлийн асуултад хариулъя. Ерөнхийдөө бол бооцоот морин уралдааны холбооны дүрмээр бол энэ бооцоот морин

уралдааны үйл ажиллагаа зохицуулагдана. Ерөнхий хууль дээр бол 5.8 дээр бол бооцоот уралдаанд уралдах морьдын ангилал, уралдааны төрөл хэлбэрийг бол дүрмээрээ тогтооно оо гээд энэ бүх гишүүдийн хурлаар бол энэ дүрэм маань батлагдах ийм төсөл дээр бол тусгагдсан байгаад байгаа. Мөн адил одоо энэ бооцоот морин уралдааны үйл ажиллагааны дүрмээр бол энэхүү бооцоот уралдаантай холбоотой маргаан үүсэж байгаа тохиолдолд дүрмээрээ зохицуулагдана.

Хуулийн төсөл дээр бол энэ талаар бол тодорхой нарийвчилсан зохицуулалт бол орж ирээгүй ээ.

Л.Мөнхбаатар: Нямбаатар сайд нэмж хариулъя.

Х.Нямбаатар: Зүгээр би энэ хуулийн төслийг хийх явцдаа бас л манай томоохон татвар төлдөг, томоохон ААН-үүдийн захирлуудыг Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр урьсан. Энэ бол бид нарын нөгөө сонгодог уламжлалт морин уралдаанаас их өөр юм. Энэ бол залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлдэг, нөгөө талдаа нэр төрийн баталгаа болсон, нөгөө талдаа маш их том бизнесийн ийм цар хүрээтэй, сонгодог морин уралдааны загварыг Монголд оруулж ирэх гэж байгаа. Тэгээд энд бол гишүүнчлэлд тавигдаж байгаа нэг гишүүнчлэлд тавигдах тэр доод босго магадгүй сая доллароос эхлэхийг ч үгүйсгэхийн аргагүй юм аа. Ийм хэмжээний төлбөр мөнгөтэй хүмүүс дундаасаа нэг ёсондоо хаалттай компани хэлбэрээр энэ нийтийн эрх зүйн субьектийг байгуулаад тэгээд ТЭЗҮ энэ сонгодог морин уралдааны тэр зураг, ажлын зураг бүх юм боловсруулаад гадна зах зээл дээрээс магадгүй мөнгө татаад ингээд 5 сараас 10 сарын хоорондох цаг хугацаануудад бид нар тойруулгын уралдаан хийж байх боломж бий болно оо гэсэн агуулгаар энэ төслийг бид нар бэлдсэн.

Хоёрдугаарт би энэ төслийг хийхдээ бараг энэ 4, 5 жилийн хугацаанд 6, 7 орны морин тойруулгын уралдааныг яг өөрөө очиж биечилж үзэж тэгээд яаж тэр нөгөө бооцоо тавьдаг бүх зүйлүүдийг бас аль болох ойлгохыг хичээсэн. Тухайн улс орны тэр Аялал жуулчлалын яамдын төлөөлөгч нараар тайлбарлуулаад ингээд явж үзсэн. Тэгэхээр бид нарт өнөөдөр байна шүү дээ тэ яг ингээд амралтын өдөр зорьж очоод чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлчих газар Улаанбаатарын эргэн тойронд ер нь бараг байхгүй дээ. Тэрэлж рүү нэг явцгааж байгаа. Тэгээд ер нь бар ресторанаас өөр зүйл бол их бага байгаа.

Гэтэл бид нарыг ингээд яг очсон Хонг Конг-д гэхэд тэр улсаараа тэр өдөржингөө тэр бооцоог гар утас, ай пад дээрээ үзээд стадиондоо бүгд сууцгаагаад ингээд хороо хүчийг өнгөрөөдөг. Энд нэг их тийм хүн мөнгө алдаад их тийм хохироод байдаггүй төрлийн тааварт тоглоом нь юм байна лээ. Аль болох олон хүн оролцож байж шинэ соргог морьдыг тааж байж илүү их хонжвор хождог. Ийм их сонин төрөл байна лээ. Та боддоо Хонг Конгийн нийт эдийн засгийн бараг 30 хувь нь энд эргэлддэг гэхээр энэ бол их том тийм бизнес. Ямар морьд уралддаг вэ гэхээр сонгодог морин уралдаанд ихэвчлэн Англи, Сорбрет адуу энэ уралдаанд уралддаг. Өөрөөр хэлбэл 58 километр цаг, 59 километр цаг, 60 километр цагийн тогтмол хурд үзүүлж байж тэр дээгүүр амжилтад ордог л ийм л төрөл хэлбэр юм байна лээ. Мөн энэ дээр араб адуу бас аль зайнд нь уралддаг юм. Тэгээд энэ хоёрын эрлийз бас уралддаг.

Л.Мөнхбаатар: Тодруулах юм уу? Гүйцээгээд хариулчих юм уу? Нямбаатар сайд гүйцээгээд хариулчих.

Х.Нямбаатар: Зүгээр би өөрөө бол яг үнэнийг хэлэхэд нөгөө залаатай морь мал уяж барьдаг тийм ямар ч хоббигүй. Зүгээр надад энэ их сонирхолтой санагдсан. Их олон хүмүүс чөлөөт цагаа зөв болсон өнгөрүүлэх хүмүүс ингээд энэ

чиглэлийн бизнес рүү бас орох энэ боломжууд бүрдэж байгаа.

Дээр нь энэ морьд их сонин юм байна лээ. Бид нар чинь бол соёолон насыг их хурдан гээд байдаг бол энэ сонгодог морин уралдаан дээр ерөөсөө шүдлэн, цөөхөн тохиолдолд хязаалан нас уралдаад л тэгээд л амжилт үзүүлсэн адуунууд нь цаашаагаа үржлийнхээ бизнес рүү орчихдог. Ийм юутай байдаг юм байна лээ. Манай Монгол морьд шинэ Монгол адуутай нэлээн төстэй Чэжү уралдаан гэж бас байдаг юм байна лээ. Чэжүүд бол яг энэ нөгөө Сорбретын түвшинд хүрэхгүй мөртөө Монгол адуунаас үл ялиг өндөр эрлийзжсэн адуунууд бол бас ийм тойруулгын уралдаанд уралддаг маш олон сая воны зах зээлтэй ийм бас бооцоот морин уралдааны загварууд бас дэлхийд байдаг.

Тэгэхээр бид нар цаашид бол төр хувийн хэвшлийн түншлэл, нийтийн эрх зүйн субъектийг бий болгох ийм шаардлагууд байгаа. Төр өөрөө бизнес хийж болохгүй хувийн секторууд дангаар ийм хэмжээний том бизнесийг эрхэлж чадахааргүй байгаа тохиолдолд ийм хүмүүсийн нэгдлийг үүсгэсэн нийтийн эрх зүйн субъектийг энэ хуулиар бий болгоод өгье.

Тэгээд энэ өөрөө аялал жуулчлал, худалдаа, морины худалдаа бүх бизнес нь эндээ давхар явна. Мал эмнэлэг бүр цаашлаад Арабын орнуудаас бид нар хэрвээ бизнесийнхээ зөв загвар моделийг бий болгож чадах юм бол яг Арабын орнуудад 7 8 сард айхтар халуун болдог. Тэндээс үнэтэй морьдыг сэрүүцүүлэх бүсэд эрүүл бүсэд авчирч стрессийг нь тайлдаг ийм үйлчилгээг ч гэсэн үзүүлэх замаар энэ морин тойруулгын бизнесийг бас өргөжүүлэн зохион байгуулах ийм таатай боломжууд манай энэ бүс нутаг цаг уурын онцлогт бий гэж үзэж, бид нар энэ төслийг оруулж ирсэн.

Л.Мөнхбаатар: Сарангэрэл гишүүн тодруулж асууя.

Д.Сарангэрэл: Тэгээд бид бол ер нь энэ Бооцоот морин уралдааны тухай болон Казиногийн хуулийг бол эдийн засгийн үр ашигтай ажлын байр бий болгох.

Гуравдугаарт бол аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох, аялал жуулчлалыг татах ийм ач холбогдолтой хуулиудыг манай Хууль зүй, дотоод хэргийн яам оруулж ирж байна гэж хараад байгаа юм. Тэгээд бид нар аливаа хуулийн төслийг оруулж ирээд хэлэлцэхдээ бол эерэг үр дүн, сөрөг үр дагавар аль алиныг нь бол тооцож байх учиртай юм байгаа юм. Тэгээд эдгээрийг бас харахгүй бол дараа нь энэ уламжлалт морин уралдаан болон бооцоот морин уралдааны асуудал хэдийгээр ялгаатай ч гэсэн бас зөрчлүүд үүсэх. Хэрвээ уламжлалт уралдаанд орсон морь энэ бооцоот морин уралдаанд орох уу, үгүй юу гээд ингээд янз бүрийн асуудлууд маргаан гардаг. Энэ бүхнийг бол бас хэлэлцэх асуудалд ажлын хэсгийн түвшинд бол нэлээн сайн ярилцаж, олон нийтэд тодорхой мэдээллүүд өгч байж явахгүй бол бид нэг сайхан юм бодоод байдаг. Хууль гарчихдаг. Эргээд нийгэмд зөрчил буруу ойлголт үүсэх ийм тооцоолуудыг бас харж үзэх шаардлагатай гэдгийг л бас санах.

Л.Мөнхбаатар: Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууя.

Г.Ганболд: Хэдүүлээ сайхан өөдрөг л юм ярьж сууна. Ер нь манайх энэ бооцоот тоглоом, энэ бооцоо тавьж байгаа юмыг нь хянадаг механизм ер нь хэр байна? Одоо бол сая ингээд л хөл бөмбөгийн дэлхийн аварга гээд хэд хоногийн өмнө болсон л доо. Толгойтой болгон бооцоо тавилаа. Тэдийг хожлоо хэдийг алдлаа гэж байсан. Энийг хянасан ер нь тоо байна уу? Яг тэр үеэр Монголоос хэдий хэмжээний бооцоо гадагшаа тэр бооцооны компаниуд руу явсан юм. Хэд нь хожсон хэд нь алдсан юм гэдгийг хянаж байгаа тоо байна уу тэрийг нэг хэлж өгөөч.

Хоёрдугаарт нь бол би энийг бол зүгээр манай уламжлалт морин уралдаанаас шал өөр зүйл гэдгийг л ойлгож байгаа. Тэгээд Монголд нэг Монголын морин спорт уяачдын холбоо гэдэг шиг нэг холбоо байгуулаад энийг авч явна гэх юм бол үлгэр л дээ. Одоо манайх мэдээж энийг явуулдаг. Түрүүний Казиногийн хуулийн тусгай зөвшөөрөл шиг ийм олон улсын морин уралдаан явуулдаг тийм олон улсын байгууллагын гишүүнчлэлтэй тийм ТББ л байж байж авч байна шүү дээ. Монголчууд бид нар хоорондоо энд нэг том стадион байгуулаад, бүгдээрээ хоорондоо бооцоо тавиад уралдаан явуулаад тэрийг хөл дээр нь авч явна гэвэл хэзээ ч бүтэхгүй л дээ.

Тэгэхээр нөгөө гаднынхны морины уралдаан хүмүүсийг оруулж ирье гэж бодъё. Гэтэл нөгөө манайхыг чинь суурь нөгөө малын гоц халдварт өвчин гээд л нөгөө нэг том том үнэтэй морьдтой хүмүүс чинь орж ирэхгүй гээд л ингээд л асуудал үүснэ л дээ. Тэгээд энийг ер нь хэр судалсан юм бэ? Би түрүүний Ганхуяг гишүүний хэлээд байгаа зөвлөлдөө энэ чинь эдийн засгийн ач холбогдол байгаа юм уу? Сонирхож байгаа тийм том дэлхийн холбоод юм уу, төрийн бус байгууллагууд байгаа юм уу? Тэр холбоод судлаад яг үнэхээр Монголд ийм уралдаан зохион байгуулах юм бол дэлхийн улс орнуудаас ирээд энэ дээр бооцоо тавиад ашиг хийгээд аваад явчих тийм боломж байгаа юм уу гэдгийг эдийн засаг талаас нь ер нь судалгаа тооцоо хийсэн зүйл байна уу?

Тэгээд би Оюунхорол дарга энд суугаад байгаа учраас Хөшигийн хөндийд хийх юм байна гэж ойлгож байна. Бас тийм үү? Хөшигийн хөндийд хийх юм байна энэ морин уралдааныг. Тэгээд нэг ингээд газар заагаад байгаа нь яг ямар учиртай юм бэ? Жишээлэх юм бол казиног заавал хөшгийн хөндийд хийнэ гээд заачихдаг юм өнөөдөр. Гэтэл нөгөө сонирхож байгаа хүмүүс чинь танай энэ бүс биш байна аа. Дэд бүтцээ нь ч хийгээгүй юм байна. Юу ч төлөвлөөгүй

юм байна. Одоо бид нар хийнэ гэвэл мөдгүй юм байна. Эсвэл өөр бүс ингээд дэд бүтэц нь бэлэн бүсэд бид нар гялс ингээд яаралтай эхлүүлчихмээр байна гэвэл яах вэ? Одоо энэ морин уралдааныг яг хаана хийнэ гэж зорьж байгаа юм. Хэрэв Хөшигийн хөндийд биш бол тэгээд газар заагаад байгаа нь ингээд нэг хүмүүст эсвэл хувь хүний газар дээр хийлгэх гээд байгаа юм уу? Эсвэл яг тэрийг нь яаж судлаад тэнд хийх гээд байгаа юм гэдгийгээ ер нь бол хэдүүлээ жаахан сонголттой байлгах тал дээр нь анхаарвал зүгээр юм биш үү? Тэр хөрөнгө оруулах гэж байгаа хүмүүс чинь бас өөрсдөө судлаад газраа сонгох боломжийг нь хэдүүлээ олгоё л доо энэ чинь.

Хүмүүс хотын хүмүүс тэр салхинд гарангаа очиж үзэх газар байх нь оновчтой байдаг юм уу. Хот дотроо ойрхон байх газар нь очиж үзэх нь илүү оновчтой байдаг юм уу? Энийг бас бид нар бодох хэрэгтэй шүү дээ тийм ээ. Эсвэл онгоцны буудалтай ойрхон байдаг юм уу гээд. Тэгээд энэ талаас нь та хэд маань нэг бодож үзсэн зүйл бол ер нь хэр байна аа? Тэгээд түрүүний миний асуусан энийг яг бас л тусгай зөвшөөрөл өгөх юм байна. Монголын холбоод, ТББ юм уу нээлттэй холбоо байгуулж орж авах юм уу, эсвэл олон улсын энэ морин уралдаан явуулдаг тэр холбоод авах юм уу гэдгийг нэг жаахан тодорхой болгож хуульдаа оруулахгүй бол дотоодын нэг хэдэн хүмүүс байгуулаад л одоо нэг холбоо байгуулаад явна гэвэл энэ бол бид нар дэлхийн хэмжээний бид нарын төсөөлж бодоод байгаа шиг тийм бол олигтой зүйл бий болохгүй гэж харж байна.

Тэгээд энэ дээр нэг тодорхой хариулт авъя гэж бодож байна.

Д.Сарангэрэл: Ганболд гишүүний асуултад хэн хариулах вэ? Нямбаатар сайд хариулья.

Л.Мөнхбаатар: Яах вэ бид нар сүүлийн 30 жил ер нь шинэ юм бүтээгээгүй дээ. Тэгээд л дандаа болохгүй

бүтэхгүй гэдэг ийм өнцгөөр л хандаж ирсэн. Би энэ хуулийг бичихдээ цоо шинэ дугуй бүтээгээгүй шүү дээ. Би сая хэллээ. Жилдээ бараг 40 орчим тэрбум америк доллар эргэлдэж байгаа Хонг Конгийн Жоби клубын хууль, дүрмийг Монголын хууль тогтоомжтой нийцүүлж импортлож энэ төслийг боловсруулсан гэдгийг танд хэлье.

Хоёрдугаарт, газар байршлын хувьд ядуугийн зовлон гэж бид нарт бий шүү дээ. Сая казиног яагаад тийшээ гэж гээд байна гэхээр Хөшгийн хөндийд Монгол Улс Шинэ эдийн засгийн чөлөөт бүс байгуулахаар зарласан. Тэр бүсэд нь дулаан, цэвэр бохир ус нь байна аа. Хажууд нь шинэ нисэх онгоцны буудал нь байна аа. Хажуу талд нь Хөшгийн хөндийн чөлөөт бүсийн төлөвлөлтүүд хийгдээд дахиад дэд бүтцийн болон бусад зургууд нь зурагдаж байна аа. Мөн тэнд бусад хувийн секторуудад худалдаа үйлчилгээний болон аялал жуулчлалын бүх тэр газрыг дуудлага худалдаагаар зарж төр хувийн хэвшлийн түншлэлээр юм хийх эрх зүйн орон зайг үүсгэж байна гэж байгаа юм. Энэ морийг бол бид нар Хүй долоон худагт байвал яасан юм бэ гэдэг агуулгаар оруулж ирж байгаа юм. Яагаад гэвэл Хүй долоон худаг бол Монгол төрийн наадмын тэр морио уралдуулдаг хамгийн том төв нь. Нөгөө талд Хүй долоон худаг бол харьцангуй дэд бүтэцтэй нөгөө талд Хүй долоон худаг бол бас нэлээн орон зайтай. Тэндээ хөгжих ийм Монгол наадам цогцолбор байгуулна гэсэн зураг төлөвлөлт хийж байсан газар.

Тэгэхээр нийтийн эрх зүйн субъект нь өөрөө төр хувийн хэвшлийн түншлэлээрээ стадиноо байгуулах ийм бас боломжуудыг бид нар бий болно оо л гэж ойлгож байгаа юм. Тэгээд энэ холбооны гишүүн гэдэг эрх зүй, үнэ цэн нь юунд орших вэ гэвэл сонгодог морин уралдааны энэ тойруулгын уралдаанд морио уралдуулах, бооцоонд оролцох цаашлаад нийтийн эрх зүйн субъектийг

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

удирдах хамтын удирдлагыг хэрэгжүүлэх эрх үүснэ ээ.

Дээр нь өөрийнхөө үр удамдаа энэ холбооныхоо гишүүнчлэлийн эрхийг үе улираан өвлүүлэх энэ эрхийг бас давхар үүсгэж байгаа юм. 1990 онд Хонг Конгийн Жоки клубын эрх хэдэн 100000 доллар байсан бол өнөөдөр хэдэн сая долларын үнэ цэнэ өссөн ийм байх жишээтэй. Жи Ар гээд Японы Жоки клубын бас дүрмийг бид нар бас харсан. Яг Хонг Конгийн Жоки клубын дүрэмтэй нэлээд төстэй. Тэгээд энэ холбооны гишүүнчлэлтэй болсноороо тэр холбооны гишүүнчлэлийнх нь үнэ цэн жилээс жилд данд өсөж ирсэн ийм л агуулгатай юм байна лээ. Тэгээд бид нар бол энэ Монголиа Жоки клуб гэдэг гадаад нэршилтэй. Монголдоо бол Монголын морин уралдааны холбоо гэдэг ийм нэртэй ТББ-ыг төр өөрөө байгуулж өгөөд үйл ажиллагаанд нь.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулах уу? Ганболд гишүүний асуултад ажлын хэсэг нэмж хариулъя. 81 дүгээр микрофон Оюунхорол дарга хариулъя.

Д.Оюунхорол: Ганболд гишүүний асуултад хариулъя.

Ер нь дэлхий дахинд бол энэ шинээр бий болж байгаа эдийн засгийн чөлөөт бүс, шинэ хот төлөвлөлтийн ажлуудыг хийхдээ тухайн улс орнууд бол нисэх онгоцны буудалтайгаа уялдуулсан Аэро поли сити гэсэн ийм төслүүдийг бол маш их хэмжээгээр бий болгож эхэлсэн. Тэгэхээр бид нар өнөөдөр төрийн ажлын залгамж шинж чанараа уялдуулаад Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас гарсан шийдвэрүүд нь Хөшгийн хөндийд эдийн засгийн чөлөөт бүс байгуулах суурьшлын бүс бий болгох, агаар орчны бохирдлыг түгжрэлийг бууруулах, Улаанбаатар хотынхоо ойролцоо 150 мянган хүнтэй хотыг бий болгох гээд энэ том бодлогынхоо хүрээнд энэ ажлууд бол хийгдэж яваа.

Тэгэхээр бид нар ажлын байр шинээр бий болгохгүйгээр шинээр суурьшлын бүс үүсгэж хүн тийшээ татах тийм боломж байхгүй ээ. Тийм учраас хамгийн том ажлын байр бий болгох боломжтой эсэх нь бол бид нар эдийн засгийн чөлөөт бүсээ амжилттай хөгжүүлэх, түүн дотроо бид нар олон мянган ажлын байр бий болгох казиногийн тэнд суурьшуулж бий болгох энэ ажлыг нэг Монгол Улсад эхлүүлээд үзье ээ гэсэн ийм онцлогтойгоор энэ ажлыг эхэлсэн. Тэгэхээр аливаа ер нь эдийн засгийн чөлөөт бүс болон казиног байгуулахад хөрөнгө оруулагчид орж ирэх хамгийн том хийх сонголт, хөрөнгөө оруулах сонголт нь бол газар зүйн байршлын тухай асуудал байгаа.

Тийм учраас өнөөдөр Улаанбаатар хотоосоо ийм 60 гаран километрийн зайтай Улаанбаатар хоттойгоо ойрхон анх удаа ийм эдийн засгийн чөлөөт бүс байгуулагдаж байгаа нь Монгол Улсын эдийн засагт бол өгөх үр өгөөж, нөгөө талаас энэ хотын түгжрэлийг бууруулах, сааруулах, төвлөрлийг сааруулахад бол онцгой чухал ач холбогдолтой. Цаашдаа бол төр, хувийн хэвшлийн түншлэлийн Монгол Улсын Их Хурлаар та бүхний баталсан хуулийн дагуу Хөшгийн хүндийн корпорацыг байгуулж энэ бол хувийн хэвшил дээр түшиглэсэн магадгүй өнөөдрийн компанийн засаглалын тухай хуулиар 34, 66 гэсэн ийм харилцаатай ийм бизнесийн үйл ажиллагааг эрхлэх боломжийг хувийн хэвшлийн ААН-үүддээ өгөх ийм боломж бололцоогоор бол хангаж өгнө.

Өнөөдөр Монгол Улсын Их Хурлаар баталсан та бүхний эдийн засгийн чөлөөт сийн мянган га нийтдээ Монгол Улсын Засгийн газрын улсын тусгай харилцаанд авсан 31 мянган га газрыг бол хуваарилалт хийгээгүй. Яагаад гэвэл энэ ерөнхий төлөвлөгөө батлагдаж энэ хууль эрх зүйн орчин бүрдсэний дараа энэ үнэлгээ өртгүүдийг тогтоож газрыг дуудлага худалдаагаар өгөх. Тэр газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах ийм

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

боломж бололцоог хангаж өгнө өө гэж бид үзэж энэ юмнууд дээр бол нэлээн ийм төлөвлөгөөтэй цэгцтэй явж байгаа. Бид нар ерөнхий төлөвлөгөөгөө хийгээгүй байж байж өмнөх зарим нэг эдийн засгийн чөлөөт бүсүүдээ дээр газраа түрүүлж олгосон явдал нь өнөөдөр эдийн засгийн чөлөөт бүсийг хөгжүүлэх асуудлыг боомилсон, хаасан ийм зүйлүүд байгаа. Зөвхөн газар нь эдийн засгийн эргэлтэд орж газраа худалдах, наймаалах ийм үйл явц болсон учраас энэ алдааг давтахгүйн тулд бид ерөнхий төлөвлөгөөгөө хийж хууль, эрх зүйн орчноо бүрдүүлж, ажлаа цэгцэлсний дар тэр.

Л.Мөнхбаатар: Оюунхорол дарга бас нэлээн дэлгэрэнгүй мэдээлэл өгчихлөө. Тодруулах юм уу? Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууя?

Д.Оюунхорол: Тодруулах ч юу байх вэ дээ би зүгээр Оюунхорол даргыг суугаад байхаар нь морин тойруулгатай бас хамаатай юм байхдаа л гэж яриад байхгүй юу. Тэгсэн чинь наадах чинь юунд Хүй худагт юм байна шүү дээ тэгэхээр чинь таныхтай бол хамаагүй л юм байна л даа. Тэгэхээр нь л би таныг суугаад байхаар нь бас нөгөө морин тойруулгыг нь бас л танайхыг хариуцах юм байхдаа л гэж бодож ярьсан шүү дээ. Тэгээд хэдүүлээ энийгээ зааглаж ялга л даа. Үгүй ээ би чинь энэ чинь ганцхан бооцоот морин уралдааныг л ярьж байгаа гэж бодоод байгаа шүү дээ тийм үү? Тэгэхээр нь энэ дээрээ бас хүмүүсээ оруулах тал дээр нь ажлын хэсгээ та нар зөв оруул л даа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Батжаргал гишүүнээр тасаллаа. Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Бооцоот морин уралдааны тухай хууль орж ирчхээд байгаа юм 2, 3 зүйл нэлээн сайн. Ажлын хэсгийн түвшинд анхаарах ёстой болов уу гэж би бодоод байна. Тэгэхээр үйл

ажиллагаа явуулах эрх бүхий этгээд нь тийм нэлээн хариуцлагатай л байх тухай асуудал. Олон улсад хүлээн зөвшөөрөгдөх тухай асуудал байх болов уу гэсэн нэг ийм санаа байгаад байгаа юм.

2 дахь зүйл тэр цогцолборын стандартыг ер нь яаж батлах ёстой юм бэ хэдүүлээ гэдэг асуудал байгаад байгаа юм аа. Үнэ цэнтэй адуу ирж уралдана. Аюулгүй байдал юмнуудыг нь бид бүрэн хангасан, баталгаажсан байх тухай асуудал яригдана. Тэгж байж сая энэ асуудал өөрөө итгэл үнэмшил болж явах ийм үйл явц байх ёстой. Энэ талын асуудал тэр тусмаа тэр үндэсний стандартыг олон улсын стандарттай яаж уяж нийлүүлэх вэ гэдэг юмыг эрх зүйн зохицуулалтаар их зөв болгох болов уу гэсэн бодол байгаа.

3 дахь зүйл даатгалын тогтолцоо ер нь ямар байх болоо гэдэг асуудал байгаад байгаа юм аа. Нэгэнт үйл ажиллаг явуулж байгаа учраас үйл ажиллагаанд оролцогч бүхий л талуудын эрсдэлээс нь урьдчилан сэргийлсэн тэр даатгалын тогтолцооны асуудлыг бид эрх зүйн зохицуулалтаар нь зөв болгож өгөх тухай асуудал байх юм шиг байна. Үнэхээрийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тийм гайгүй цогцолбор байгаад үйл ажиллагаа явуулах юм бол тэр хэмжээгээр тэр даатгалынх нь асуудал өөрөө нэлээн нарийн үнэлэх, үнэлгээний өндөр бас үнэ цэнтэй байх тухай асуудал. Тэгээд тэр даатгалын байгууллагуудын үүрэг оролцооны тухай асуудал энэ тэр гээд бас тодотгох ёстой зүйлүүд байх юм болов уу гэсэн ийм зүйл харагдаж байгаа. 4 дэх зүйл бол түрүүн Сарангэрэл гишүүн юу хөндөж байна лээ.

Энэ үндэсний морин уралдаан энэ морин уралдаан хоёрын хоорондын зааг ялгааны тухай асуудал бас уралдах үйл явцын үүлдэр хооронд нь холиод байдаггүй тэр байх байдал энэ тэр гээд ингээд юмнууд нь тусгайлсан дүрмээр зохицуулагдах байх. Гэхдээ энэ хууль дотор тэр хэлэх гээд байгаа юмны суурь санаа юмнууд нь тусч орох болов уу?

Тэгж байж би тэр цаад гаргах ёстой байгууллагууд дүрэм журмаа бас тэр олон улсынхаа гаргасан дүрэм журамтай уялдсан байдлаар нь хангаж гаргах болов уу гэсэн нэг ийм 3, 4 зүйлийг илүү тодруулах ёстой болов уу гэсэн бодол байна аа.

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүн үг хэллээ. Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтыг Дэгийн хуулийн дагуу түр хойшлууллаа.

16.38 цаг

Дараагийнхаа асуудалд орёё.

Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар танилцуулна. Нямбаатар сайдыг индэрт урьж байна.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын Дэд дарга, Эрхэм гишүүд ээ,

Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалаа зохион байгуулах үйл ажиллагааг Монгол Улсад тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлж болохоор ААН-ийн тусгай зөвшөөрлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд заасан байдаг боловч тусгай зөвшөөрөл олгоход бүрдүүлэх шаардлагатай баримт бичиг, тусгай зөвшөөрөл эзэмшигчид тавих шаардлага шалгуурыг тогтоосон хууль байгаагүй бөгөөд ийм журам батлахыг зөвшөөрсөн эрх зүйн заалт байхгүй тул одоогоор ямарваа нэгэн эрх зүйн зохицуулалтгүй байна аа. Ийм тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулахыг хуулиар зөвшөөрсөн хэдий ч нарийвчилсан зохицуулалт шаардлагатай байгаа бөгөөд дээрх үйл ажиллагаануудыг

зохицуулахаар бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд казино, морин бооцоот уралдаан, бооцоот таавар, хонжворт сугалааг нийтэд нь мөрийтэй тоглоомын үйл ажиллагаанд хамруулсан бөгөөд эдгээр 4 төрлийн үйл ажиллагаанд баримтлах нийтлэг нөхцөлийг зохицуулсан. Мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэгч нь мөрийтэй тоглоомыг шударга, ил тод, хариуцлагатай явуулах, хонжворыг шударгаар тооцоолж, оролцогчид даруй олгох, нийгэмд үүсэж болзошгүй сөрөг үр дагавраас сэргийлэх, олон нийтийг мөрийтэй тоглоомд донтохоос хамгаалах зэрэг нийтлэг зарчмыг зохицуулахаар тусгалаа.

Мөн бага насны хүүхдийг мөрийтэй тоглоомын хэрэгсэл болгох нь нийгмийн дэг журамд нийцэхгүй гэж үзсэн 14 насанд хүрээгүй хүнийг оролцсон үйл ажиллагаанд уралдаан тэмцээнд бооцоот таавар зохион байгуулах, 18 насанд хүрээгүй хүнийг тоглуулах, мөрийтэй тоглоомыг олон нийтэд сурталчлах, дээрх үйл ажиллагааг сургууль, цэцэрлэгийн орчинд явуулахыг нийтлэг байдлаар хориглолоо.

Бооцоот таавар зохион байгуулах зөвшөөрлийг Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдэд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 10 жилийн хугацаагаар олгохоор, дээрх хугацаанд тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг зөрчөөгүй бол анх олгосон хугацаагаар нь сунгахаар тусгасан. Тусгай зөвшөөрөл үүсгэгч хуулийн этгээд нь нэг тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байхаар тусгалаа. Цахим бооцоот таавар зохион байгуулах бол мэдээлэл технологийн дэд бүтэц нь тасралтгүй, найдвартай ажиллах, аюулгүй байдлыг хангасан байх, Монгол Улсад байршилтай сервертэй байх, мэргэшсэн хүний нөөцтэй байх зэрэг шаардлагуудыг тавьсан.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хонжворт сугал зохион байгуулах тусгай зөвшөөрлийг Сангийн сайдаас ирүүлсэн саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдэд мөн 10 жилийн хугацаагаар олгохоор тусгасан бөгөөд хонжворт сугалаа зохион байгуулагч нь таван зуун сая төгрөгөөс доошгүй хэмжээний өөрийн хөрөнгөтэй байхаар, мөн дээрх хугацаанд тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг зөрчөөгүй, зөрчил гаргаагүй бол анх олгогдсон хугацааг сунгахаар тусгасан.

Хонжворт сугалаа зохион байгуулагчид сугалааны тасалбарыг борлуулалтын нийт орлогын 55-аас доошгүй хувийг сугалааны хонжворт олгох сугалаанд оролцогчдоос төвлөрүүлсэн орлогын хөрөнгийг тодорхой хэсгийг хонжворт сугалаа зохион байгуулагчид банкны тусгай дансанд байршуулах зэрэг шаардлагыг тусгаж, хонжворт сугалаа зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тусгалаа.

Татварын хувьд бооцоот таавар хонжворт сугалаа зохион байгуулах үйл ажиллагаанаас олсон орлогод таавар, бооцоот таавар, хонжворт сугалааны нийт орлогоос хонжворт олгосон дүнг хассан дүнгийн 30 хувиар онцгой албан татвар ногдуулах. Хожсон тоглогчид Хонжворын 30 хувьтай тэнцэх хэмжээний ХХОАТ ноогдуулахаар заалаа. Эдгээр үйл ажиллагааг хууль, журмын зохицуулалтгүйгээр эрхлэх нь нийгэмд дэг журам, нийтийн хүүхдийн эрх, оролцогчийн эрхийг зөрчих тул үйл ажиллагааг тодорхой нөхцөл шаардлага хяналтын дор онцгой татвартайгаар эрхлэх нь зохистой гэж үзэж байна.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Бооцоот таавар хонжворт сугалааны тухай хуулийн төслийг үзэл баримтлал, хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Сандаг-Очир гишүүнийг индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дэд дарга эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг ХЗБХ 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцүүлээ.

Хууль санаачлагч, мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа эрхлэх этгээдийн баримтлах нийтлэг шалгууруудыг тогтоох, бооцоот таавар болон хонжворт сугалааны үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг, хариуцлага хориглох үйл ажиллагаа, төрийн зүгээс тавих хяналтын тогтолцоо болон бооцоот таавар, хонжворт сугалаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор хуулийн төслийг боловсруулсан байна аа.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд аливаа төрлийн хүлээх үүрэг, зардал үүсэхгүй бөгөөд төрийн байгууллага болон тусгай зөвшөөрөл хүсэгч хуулийн этгээдэд тодорхой зардал үүснэ гэж хууль санаачлагч үзсэн байна.

Хуулийн төслийг D parliament.mn цахим хуудаст байршуулан олон нийтийн саналыг авч байгаа болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хонжворт сугалааг мөрийтэй тоглоом гэж томъёолох нь зөв эсэх, гэр бүл, найз нөхдийн хүрээнд мөрий тавьж тоглож байгаа нь энэ хуулийг зөрчиж байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66.7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Бооцоот таавар хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх ХЗБХ-ны санал,

дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг өмнөх хуулийн ажлын хэсэг хэвээрээ байгаа.

Ер нь Засгийн газраас өргөн барьсан энэ 3 хууль бол хоорондоо уялдаа холбоотой учраас ажлын хэсэг бол нэг байгаа. Хуулийн төслийг боловсруулахаас нь эхлээд хэлэлцүүлэх үе шатанд нэг ажлын хэсэг ажиллаж байгаа гэдгийг хэлье. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй юу? Алга байна.

Бямбацогт, Баатарбилэг гишүүнээр тасаллаа. Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууя.

С.Бямбацогт: Энэ бас иргэдэд мэдээлэл өгөх. Иргэдийн нөгөө мэдэх эрхийг хангах зорилгоор асууж байгаа юм аа. Бооцоот таавар хонжвортой сугалаа. Энэ ойлголтуудын бас зөрүүнүүд гарах ёстой байх. Ер нь бол бооцоотой тоглоом дээрээс нь хонжвортой сугалаа бол Монгол даяар хавтгай болчихсон. Айл өрхийн хүрээнд тийм үү, авгай нөхөр, үр хүүхэдтэйгээ бооцоотой тоглодог, найз нөхдөөрөө тоглодог. Хөдөө гадаа явахдаа тоглодог гээд л юу гэдэг юм тэгээд л бас нэг хэдэн төгрөг тавих нь тавьдаг. Ажил хийхээр тоглох нь тоглодог. Тэгээд энэ тоглоомуудыг тэгээд энэ ямархуу байдлаар яаж зохицуулагдах юм бол? Гэртээ тоглож байгаа хүмүүс найз нөхдөөрөө юу гэдэг юм энд тэнд тоглож байгаа хүмүүс хэдий хэр бооцоо тавьснаас болоод хууль зөрчсөн болох уу, бусад үед энгийн тоглосон болох уу? Энэ дээр ямар нэгэн ялгаа зааг байг юу? Энийг яаж ялгаж салгаж зааглах юм. Яах аргагүй их хэмжээний мөнгө тавиад тодорхой зорилготой зохион байгуулаад бооцоотой тоглоом хийж байгаа бол бас зөвшөөрлөө аваагүй бол тэр хууль зөрчих л байх. Яаж ямархуу байдлаар зөвшөөрөл өгч байгаа

юм. Бас өнөөдөр өгч байгаа юу? Өгөхгүй байгаа юу? Хэдэн бооцоотой тоглоомын газар үйл ажиллагаа явуулж байна? Зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа ямархуу иргэд, ААН-үүд ямархуу хариуцлага тооцов.

Ер нь цаашдаа ингээд хууль батлагдсаны дараа иргэд энд тэнд тоглож байвал хуулийн ямар хариуцлага хүлээх юм. Ямар үйлдлийг нь тийм ээ, хууль зөрчсөн гэж үзэх юм. Энэ талаар нэг мэдээлэл өгөөч?

2 дугаарт нь, хонжвортой сугалаа бас ялгаа байхгүй. Монгол даяар л сугалааны улс болчихсон. Ерөөсөө иргэдтэй уулзалт хийсэн сугалаа явж л байдаг. Телевизээр ч том том сугалаа явж л байдаг. Өвчин зовлон тохиолдсон үед хандивын сугалаа хийж л байдаг. Энэ бүхэн чинь заавал бүртгэгдэх ёстой л болох гэж байх шиг байна л даа. Хэрвээ бүртгэлгүй хандивын сугалаа зохион байгуулаад л өвчин зовлон тохиолдоод мөнгө босгох гээд ийм арга хэмжээ зохион байгуулбал зуд турхан болоод малчдад туслах аян зохион байгуулаад сугалаа хийвэл хууль зөрчих үү, зөрчихгүй юу? Энэ телевизээр явж байгаа олон том том сугалаанууд байж байгаа. Бас юу гэдэг юм сум, суманд бас нэг авто машины хонжвортой сугалаанууд явдаг. Энэ сугалаанууд нь хэрхэн яаж бүртгэгдэж байгаа өнөөдөр ямар хуулийн хүчинд яаж бүртгэгдэж улсын хэмжээнд хэдэн сугалаа бүртгэлтэй явагдав.

Түүнээс улсын төсөвт хэдий хэмжээний орлого оров. Хууль зөрчөөд бас сугалаа явуулсан бол ямархуу хариуцлага хүлээлгэсэн ийм тохиолдлууд байна уу? Өнгөрсөн онуудад. Цаашдаа энэ хууль батлагдсанаар яг ямархуу зааг ялгаатай болох юм бэ? Энийг нь хариулахгүй бол юу гэдэг юм иргэдийг хууль алагчилж ялгавартай үйлчилдэг. Зарим тохиолдолд хууль үйлчилдэггүй, зарим тохиолдолд хууль үйлчилдэг. Заримдаа иргэд хохирдог, аж ахуйн нэгж байгууллага. Зарим нь юу гэдэг юм

хуулийн цоорхойгоор завшиж байдаг ийм болчих вий. Энийг хэрхэн яаж хүн болгонд хууль жигд үйлчлэх байлгах юм бэ? Энэ тал дээр бас иргэдэд мэдээлэл өгөх хэрэгтэй байх. Энийг нэг хариулж өгөөч.

Л.Мөнхбаатар: Бямбацогт гишүүн бол нэлээн чухал асуудлыг хөндөж асууж байгаа юм. Энэний ойлголтыг бол бас нэг мөр болгоод өгчих нь зүйтэй. Яах вэ айлд хэдүүлээ цуглаад бас тоглох ийм тохиолдлууд бас амьдрал дээр гарч байдаг. Ер нь бол мөрийтэй тоглох гэдэг зүйл анги бол Эрүүгийн хуульд байсан. Түүнийг 2017 онд Зөрчлийн хуульд оруулсан. Эргээгээд энэ саяхан Эрүүгийн хуульд оруулсан өөрчлөлтөөр Эрүүгийн хуульд оруулчихсан байгаа шүү дээ. Тийм ээ. Тийм учраас энэ талаар бол нэгдсэн ойлголтыг өгөх нь зүйтэй.

Бямбацогт гишүүний саяын асуусан асуултад Нямбаатар сайд хариулья.

Х.Нямбаатар: Бямбацогт сайдыг Хууль зүй, дотоод хэргийн сайд байхад боловсруулж өргөн барьсан Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд мөрийтэй тоглох гэдэг зөрчлийг хуульчилсан. Би тухайн үед ажлын хэсгийг ахлаад бид хууль зүйн салбарын тодорхой эрдэмтэд, судлаачидтай цуг бид нар бараг 2 сар гаран вакумжиж энэ ажил ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. Энэ үедээ бид нар мөрийтэй тоглоом ахуйн хүрэн дэх тоглоом наргиа, наадмыг хэрхэн зааглаж ялгаж ойлгох вэ гэдэг ийм тодорхойлолт дээр нэлээн сууж ажилласны эцэст зохион байгуулалтын шинжтэй хясаа бэлдэж, зохион байгуулалт хийж өөр хооронд нь бооцоо тавиулах, энэ төрөл хэлбэрийн тоглоомыг зохион байгуулсныг мөрийтэй тоглоом зохион байгуулах гэдгээр шийтгэл ноогдуулья аа. Үүнээс биш ахуйн хүрээнд өөр хоорондоо муушиг тоглож байгаа юу гэдэг юм сүүлийн үед тэр 13 гэж бараг хүн болгон тоглодог гээд байгаа юм.

Энэ зүйлүүдийг л мөрийтэй тоглоом гэдэг тэр ангилалд оруулахгүй байна аа. Тэрнээс биш яг ингээд зохион байгуулалтын тоглоомын газар байгуулаад ширээ нээгээд хясаа читонууд өгөөд тэгээд дунд нь үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэрийг олоод тоглуулсных төлөө тодорхой дундаас нь хувь ашиг хүртэж байгаа Энэ үйлдэл үйл ажиллагааг л мөрийтэй тоглоом гэдэг агуулгаар ойлгоё гэж бид нар тэр тодорхойлолт юмнуудаа гаргаж хийсэн гэдгийг хэлье ээ. Зөвшөөрлийн тухай хуулиар бооцоот тавар тоглоомын тусгай зөвшөөрлийг Хууль зүй, дотоод хэргийн яам хонжворт суглааны эрхийг Сангийн яам өгөхөөр байгаа.

Сангийн яамнаас угаас одоо хонжворт сугалааны өмнө нь өгөгдсөн хэд хэдэн эрхүүд өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа хэрэгжүүлээд явж байгаа. Харамсалтай нь нарийвчилсан зохицуулалт байхгүй учраас тэр хонжвор сугалаанд оролцогчдын эрх ашиг хөндөгдөөд байгаа юм. Саяхан бас Ганболд гишүүн ярьж байсан. Ланд Крузер 300 гэдэг машин хожсон хожигч хонжворт сугалааных хожлыг авахаар очиход нөгөөх нь хуучин хэрэглэж байсан машин ашиглаж байсан машин байгаа. Шинэ машин өг гэхээр тэгвэл дахиад шинээр 103 сая төгрөгийг нэмээд нөгөө татварын мөнгө төлөөд хүн амын орлогын албан татвар төл гээд. Нэг ёсондоо ингээд хонжворт сугалаанд оролцогчдод зарласан нөгөө PR сурталчилгаанаас тэнгэр газар шиг ийм хонжвор сугалааны асуудал үүсэж байгаа.

Дээр нь телевизээр хонжворт сугалаа зохион байгуулахад булхайцсан үйлдлүүд нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ил болж байсан тохиолдлууд ч бий.

Тэгэхээр энэ удаагийн хуулиар энийг цэгцлээд, хонжворт сугалаа зохион байгуулж байгаа хүмүүс нийт орлогынхоо 55 хувийг тусгай санд байршуулаад.

Л.Мөнхбаатар: Баатарбилэг гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимд байраа эзлээрэй. Зохион байгуулалтынхан гишүүдэд зохион байгуулж, санал хураалтад бэлтгээрэй. Улсын Их Хурлын гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг асуулт асууя.

Ё.Баатарбилэг: Энэ бооцоот таавар тоглоом гээд сүүлийн үед бол манайхны дунд нэг тийм азад найддаг. Зүгээр сууж байгаад нэг ашиг орлого олох гэдэг ерөнхийдөө нэг тийм бэлэнчлэх ийм юм руу л их хавтгайрч явж байна л даа. Хүүхэд хөгшидгүй л ийм юм болж байна. Ерөөсөө л нэг хаана ямар аз ивээчих вэ, хаана ямар сугалаа хонжвор байна, ямар юманд нэг ёндоогоо үзчих үү гэцгээсэн улсууд л байна шүү дээ. Сая тэр нэг бит койн энэ тэр гээд нэг баахан юм явлаа. Үгүй ээ мөн ёстой мундаг ашиг орлого хийж байна аа. Ёстой цөм хийж байна гээд л баахан залуучууд хөгшин хөвөөгүй хошуурч байгаад баахан залилангийн юм руу орчихсон л сураг байна. Сүүлийн үед ингээд Монголчууд маань өөрсдөө ингээд нэг сугалаа хонжвор таавар гэсэн ийм юмнууд руу нийтээрээ, нийгмээрээ хавтгайрч энэ орж ингэж орж байгаа нь өөрөө нийгмийн оюун санаанд маш сөргөөр нөлөөлж энэ хүүхэд багачуудаас өгсүүлээд энэ утсан дээрээ янз бүрийн тоглоомоор тоглодгоос өгсүүлээд ингээд багаасаа одоо бүр ийм юм болоод эхэлж байна шүү дээ.

Тэгэхээр энэ энэ хуульд би 2, 3 зүйл асуугаадахъя. Энэ хуульд нэгдүгээрт энэ телевиз олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явж байгаа энэ бооцоот таавар тоглоом, уралдаан юмнуудыг ерөнхийдөө яая гэж орж ирж байгаа юм. Ерөнхий энэ хуулийн концепц нь ер нь энийг нэг тийм цэгцэлж хумьж бас нэг орлого, зарлага нь тодорхой байвал татвар хураамжаа төлдөг энэ тэр байлгая гэж явж байна уу.

Хоёрдугаарт энэ бооцоот таавар тоглоом, уралдаан ийм юм руу хошуураад

байгаа нь нийгмийн сэтгэл зүйг ер нь энэ Монголын төр засгаас яаж ингээд зөв залуурдаж, энийг нь бууруулж багасгаж, ажиллаж хөдөлмөрлөж орлого олдог энэ үнэнч шударгаар хөдөлмөрлөж байж олсон орлогоороо ингэж амьдралаа залгуулдаг энэ юм руу нь энэ залуу үеийг оруулья барья гэдэг юм руу явах гэж байна уу. Эсвэл ерөөсөө ингээд нэг бооцоот таавар тоглоом уралдааныг ерөнхийдөө хуульчилчихсан гээд л цааш нь ингээд зөнд нь тавих гээд байна уу гэдэг нэг ийм асуулт байна концепцын хувьд.

Хоёрдугаарт энэ нөгөө нэг зарим нь спорт тоглоом гээд энэ нөгөө компьютер дээр тоглодог энэ нэг багаар тоглодог дэлхийн аварга болдог гээд энэ рүү залуучууд маш их орлоо. Хоорондоо бооцоотой тоглож байна гээд тэр ямар юм гэлээ нэг багаараа ингээд дэлхийн тийм цахим орчин дахь нэг тийм тоглоом юмнууд руу их залуучууд их ороод байна шүү дээ. Тэгээд хоорондоо бооцоотой мөрийтэй тоглоцгоодог гээд байх юм. Энэ юм хум чинь энэнд орж байна уу үгүй юу? Тэгээд энэний чинь нэг хэсэг нь болохоор тэр нөгөө цахим покер гээд цахим орчинд тоглож байгаа дэлхийн спорт болчихсон. Энэ бол одоо хууль бус зүйл биш юм. Энэ бол оюуны спорт юм уу энэ тэр гээд л нэг хэсэг нь тэгэх юм. Энэ цахим компьютер дээр явж байгаа юмнуудыг.

Тэгэхээр энэ бол яг аль талд явж байг юм. Би сайн мэдэхгүй байна юуг нь.

Гурав дугаар нэг асуудал Сангийн сайд байж байгаа учраас энэ нөгөө нэг НӨАТ-ын нөгөө татвар төлөгчдийн нэг сугалаатай хонжворын юмнууд жил болгон явж байгаа. Одоо энийгээ боливол яадаг юм гэх гээд байхгүй юу. Одоо харьцангуй хүмүүс НӨАТ, НӨАТ-ын юмыг төлдөг яадаг болчихсон. Үгүй ээ тэгээд ингээд нэг угаасаа л тэр НӨАТ-ын чинь буцаан олголт нь яадаг НӨАТ төлдөг л байх ёстой шүү дээ. Тэгээд энэ дунд нь би бол тэр юуг нь ач холбогдлыг нь бол буруу дутуу үнэлж байж магадгүй. Дахиад

ингээд нэг бас төр татвар төлөгчдийнхөө дунд бас нэг ийм сугалаа. Өөр маягаар зохион байгуулах юм уу? Ингээд л нэг төр нь хүртэл ийм нэг татварынх нь юман дээр сугалаа хонжвор явуулаад байхаар чинь энэ төрийн бус байгууллагууд, ААН, хувь хүмүүс янз бүрийн сугалаа бооцоо юм явуулах нь дамжиггүй шүү дээ.

Тэгэхээр ийм нэг 3 зүйл дээр тодруулга аваадахъя.

Л.Мөнхбаатар: Баатарбилэг гишүүний асуултад хэн хариулах вэ? Сангийн сайд Болдын Жавхлан хариулья.

Дараа нь Нямбаатар сайд хариулья.

Б.Жавхлан: Баатарбилэг гишүүний асуултад хариулья.

Гишүүн ээ тэр ёстой болохгүй шүү. Тэр ёстой болохгүй шүү дээ. Энэ сугалааны чинь зорилго нь бүр шал өөр юм байгаа юм. Одоо энэ хуулиараа зохицуулагдаж байгаа нь бол энэ ашгийн төлөө ийм бооцоот хонжворт сугалаа ийм юм. Энэ НӨАТ-ын сугалаа бол шал өөр шүү. Энэ бол буцаан олголтын нэг хэлбэр.

Дээрээс нь энэ НӨАТ урамшуулах системийг урамшуулж байгаа нэг бас ийм хэлбэр юм байгаа юм. Бид 5 сард энэ НӨАТ -ын сугалаагаа больсон больсон. Гэтэл бид 7 жилийн туршид хүрсэн энэ НӨАТ уншуулдаг хувь хэмжээ маань нэг 70 руу дөхөж ирж байсан юм. Дөрөвхөн сарын дотор 40 хувь унасан. 40 хувь НӨАТ-ын баримтыг уншуулахаа больсон гэсэн үг. Өөрөөр хэлбэл буцаад ингээд далд эдийн засгаа дэмжээд ирсэн. Ингээд бид 9 сараас энэ НӨАТ-ын сугалаагаа илүү цахимжуулаад илүү ил тод болгоод хамрагдах хүрээг нь их ойлгомжтой болгосон. Урьд нь бол ингээд НӨАТ-ын баримт хэвлэгдэж гарсан бүх сериалууд сугалаанд ордог. Өөрөөр хэлбэл эргүүлээд уншуулсан уншуулаагүй бүгд орчихдог байсан. Тэгээд л зарим сард нь нөгөө супер азтан таарсангүй гээд л ингээд

тэгдэг байсан. Одоо тийм зүйл байхгүй. Уншуулсан баримт болгон сугалаанд орно. Хэчнээн их баримт уншуулна тэр хэмжээгээр сугалаанд хожих магадлал нь нэмэгддэг. Тэр хэмжээгээр сугалааны хонжвор нь нэмэгддэг. Энд бол ямар нэг ашгийн төлөө биш харин ч буцаан олголтыг сугалааны хэлбэрээр нэмж дахиж гаргаж байгаа. Ийм зүйл байдаг юм аа. Энэ нь бол өөрөө энэ НӨАТ хамрагдалт дээрээс нь энэ НӨАТ-аас НӨАТ-ын падаан хуурамчаар бичдэг НӨАТ бичиж өгдөггүй. Ийм далд явдаг энэ бүртгэлийн татварын энэ системийг илүү ил тод болгож байгаа. Татварынхаа суурийг тэлж байгаа, бүртгэлийг нь сайжруулж байгаа ийм хөшүүргийн систем учраас энийг өөр хонжворт сугалааны энэ системтэй битгий жишиж үзээч ээ гэж хэлж байна.

Ер нь 2 хүүхэд бид нар чинь буцаан олголттой шүү дээ. Буцаан олголт маш бага байдаг. Буцаан олголттой цөөхөн улсын нэг. Ер нь 10 гаруйхан улс байдаг. Энэ НӨАТ-ын системүүд энэ сонгодог татварын системтэй 150 гаран улсаас ерөөсөө 20 хүрэхгүй улс нь буцаан олголттой. Тэрнийх нь нэг нь манай улс байдаг. Харин энэ хонжворын систем бол маш түгээмэл байдаг.

Л.Мөнхбаатар: Нямбаатар сайд нэмж хариулъя. Би Баатарбилэг гишүүний асуултад хариулъя. Баатарбилэг гишүүн одоо нөгөө Зөвшөөрлийн хуулиар ер нь бол энэ 2 төрлийн зөвшөөрлийг энэ 2 яам өг гээд л ингэчихсэн. Тэгээд ямар процессоор ямар шаардлага хангасан ААН энэ зөвшөөрлийг авах юм бэ гэдэг ямар ч шалгуур байхгүй байгаа. Хэрэглэгчийг хохироовол яах юм. Ямар хэмжээний мөнгийг цаана нь тусад нь тусгай дансанд байршуулж байгаад сонгууль сугалааны тохирол болохоор тэндээс нь гаргаж өгөх юм энэ тэр гээд ямар ч зохицуулалтгүй байгаад байгаа юм.

Тийм учраас телевизийн камерын ар талд ингээд нөгөө араар бөмбөгөө

шидээд оноогоо шалгаруулаад байгаа байхгүй юу. Гаднын улс орнууд бол лотерейны асуудал гээд л байж байдаг. Хонжворт сугалааны асуудал энэ тэр гээд өөрийн гэсэн тогтчихсон ийм дүрэм журамтай байдаг. Тэгэхээр бид нар тэндээс загвар гаргаж ирээд энэ юуг оруулж ирж байгаа юм. Яг нийтдээ нэг тэрбум төгрөгийн өөрийн үндсэн хөрөнгөтэй ААН-д Монголын дотоодын ААН-д энэ бооцоот тааварт тоглоом явуулах эрхийг өгч байгаа юм. Энэ сонгон шалгаруулалтаар өгнө.

Дээр нь цахим хэлбэрээр бооцоот нөгөө бэт тавиулах тохиолдолд өөрийн гэсэн Монгол Улсад сервертэй байх тэдэнд нэг тэрбум төгрөгийн хөрөнгөтэй байх гээд шалгуур тавьж байгаа юм. Сугалаа явуулах тохиолдолд өөрийн гэсэн хамгийн багадаа 500 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгөтэй. Тэгээд нийт сугалааны тохирлын 55 хувийг тусгай санд байршуулж, түүнээс нь бэлнээр өгдөг байх гэх мэт ийм шалгууруудыг тавьж өгч байгаа юм. Тэгээд сүүлийн жилүүдэд энэ спорт Бэтинг гэж гарч ирсэн. Онлайн, цахим казинонууд бий болсонтой холбоотойгоор эцэг эхчүүд, иргэдээс маш их хэмжээний гомдол Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэр дээр ирж байгаа юм. Жишээлэхэд энэ ОХУ-аас гаралтай нэг сайт гэхэд манай улсаас ойролцоогоор бараг сард 30 гаран нэг тэрбум төгрөг энэ сайт руу гарч байна гэдэг ийм харамсалтай мэдээлэл байгаа юм. Бид нар хандалт хийх асуудлыг кибер аюулгүй байдлын алба ЦЕГ-ын кибер аюулгүй байдлын албанд хандаад манай энэ домэйн хаягууд руу хандахгүй ээ гээд хандалтыг нь хаалгачхаж байг юм. Тэгэнгүүт өөр байдлаар вейпен үүсгээд ингээд дахиад тийшээ нэвтрэлт хийчихнэ. Тэгэнгүүт Монголын арилжааны банкнуудаас тийшээ төлбөр тооцоо хийх юуг нь хаачхаж байгаа юм. Хаангуут дахиад дилерүүд гэдэг шинэ ийм хүн гарч ирээд Монгол банк хоорондоо дансны гүйлгээ хийгээд нөгөө хүн нь тэнд цэнэглэлт хийгээд түүнээсээ тодорхой

хувийг цаад компаниудаас авч байх жишээтэй.

Тэгэхээр энийг бид нар цахим орчинд энэ донтолт гемленгийг бий болгохгүйн үүднээс цахим аюулгүй байдал, кибер аюулгүй байдлын чиглэл дээр тодорхой чиглэл дээр тодорхой программ хангамжийн хөгжүүлэлтийг хийх ажлууд хүртэл хийгдээд явж байгаа. Тантай бол санал зуун хувь нэг байна. Аль болох ажил хөдөлмөр эрхлэх, аз одонд найдахаас илүүтэй өөрөө өөрийнхөө хөдөлмөрөөр амьдрах ийм хүсэл эрмэлзлийг бий болгох чиглэлээр бас Соёлын яам тодорхой ажлуудыг хийж байг гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Тэр бооцоотой тааврын энэ хонжворт сугалааны хуулийг хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараа ажлын хэсэг дээрээ нэлээн сайн яримаар юм байна лээ. Ер нь бол сая энэ Нямбаатар сайдын хариулж байгаа Баатарбилэг гишүүн асуусан. Энэ асуултуудын хооронд энэ бол яг бодит байдал нь болчихоод байгаа юм. Хүүхэд залуучууд маш ихээр бет тавьдаг. Тэр сайтад тэгэнгүүт нийтдээ Монголоос жилд 400 орчим тэрбум төгрөгөөр тавьж байна гэж байгаа шүү дээ. Тэр хэмжээний мөнгө гадагш гарч байгаа. Ийм учраас энэний хууль эрх зүйн орчныг нь бий болгоод энэ дээр тодорхой хяналт тогтоох энэ ажлыг бол энэ хуулиар бий болгох нь зүйтэй.

Тийм учраас энэ хуулийг бол хэлэлцэх эсэхээ шийдээд, ажлын хэсэг дээрээ яриад явах нь зүйтэй байх гэж бодож байна. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Санал хураалтуудыг явуулна аа. Аюулгүй байдлын байнгын хороо хуралдаж дууссан уу? Аюулгүй байдлын байнгын хороо дуусангуут санал хураалтуудаа явуулъя. Санал хураах бэлтгэл ажлыг хангаарай.

Аюулгүй байдал, Аюулгүй байдал, газар бодлогын байнгын хороо хуралдаж дууссан байна. Энэ хооронд эцсийн найруулгуудыг сонсож байя. Баталсан хууль, тогтоолуудын эцсийн найруулгыг сонсьё.

1.Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гэсэн юм байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Холбогдуулан боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаж дууссан учир гишүүд танхимд байраа эзэлье. Одоо санал хураалтууд явагдана. Гишүүд танхимдаа цугларъя.

Гишүүд суудлаа эзэлье. Санал хураалт явуулья. Санал хураалт бэлэн болсон уу? Бүртгэлийн санал хураалт явуулах уу? Бүртгэлийн санал хураалт. Саналын томъёоллыг уншиж танилцуулья.

Байнгын хорооны саналаар Бооцоот таавар хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

Гишүүд ээ, санал хураалт.

54.8 хувиар санал дэмжигдлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүллээ.

Дараагийн санал хураалтыг явуулья.

Дараагийн санал хураалт. Байнгын хорооны саналаар Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Бооцоот морин уралдааны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая.

Санал хураалт. 57.1 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн санал хураалт. Казиногийн тухай хуулиар санал хураана.

Ер нь энэ Казиногийн хуулийг бид өнөөдөр хэлэлцэх эсэх асуудлыг ярьж байна. Ер нь ажлын хэсэг гараад хэлэлцэх явцад бас манай ажлын хэсгийнхэн нийт ажлын хэсгийнхэн нэлээн сайн мэдээлэлтэй болмоор юм байна лээ. 1998 онд анхны Казиногийн хуулийг батлан гаргасны 1 сард баталж байгаад дараа нь удалгүй хүчингүй болгосон. Энэ үед бас нэгдсэн ойлголт их багатай байсан. Дараа нь 2000 оноос хойш энэ бооцоот таавартай холбоотой зөвшөөрлүүдийг бас Хууль зүйн яамнаас олгож эхэлсэн. Энийг олгож эхлэх үед бас тухайн олгож байсан ажил хариуцаж байсан албан тушаалтнуудын хувьд бас тодорхой мэдээлэл багатай, мэдлэг багатай байсан учраас ерөнхийдөө

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

үндсэндээ казиногийн зөвшөөрлүүдийг ер нь олгоод байсан юм байна лээ. Тухайн үед бол рүлет, энэ Казинод байдаг бүхий л төхөөрөмжүүдийн зөвшөөрлийг олгоод явж байсан. Тэр битгий хэл мянган рүлетний зөвшөөрлийг хүртэл тухайн үед олгосон байсан шүү дээ. Мянган рүлеттэй казино гэж бол дэлхийд бол байхгүй байх тийм ээ. 100 орчим байдаг болов уу. Зөвхөн Монголд л байсан байх жишээтэй.

Ийм учраас энэ мэдээлэлтэй болох үүднээс энэ чуулганы завсарлагын энэ хугацаанд бол ажлын хэсгийн гишүүд, дэд ажлын хэсгүүд сайтар судалж явж үзэж энэ талаар бол нэгдсэн ойлголттой болох нь зүйтэй шүү гэдгийг бас хэлбэ.

Ингээд санал хуулалт явуулна аа. Байнгын хорооны саналаар Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Казино байгуулах ажиллуулахыг хориглох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт.

59.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ХЗБХ-нд шилжүүлээ.

17.10 цаг

Дараагийнхаа асуудлыг хэлэлцье.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Амартүвшин танилцуулъя. Амартүвшин гишүүнийг индэрт урж байна.

Г.Амартүвшин: Улсын Их Хурлын Дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн энэ хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Баделхан, Баттөмөр нар асуулт асууж, хариулт авсан болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Баделхан Ганбаатар, Пүрэвдорж нар тогтоолын төслийн 3 дахь заалтыг хасах зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд уг санал дэмжигдсэнтэй холбогдуулан тогтоолын төслийн заалт хоорондын уялдааг хангуулах зорилгоор Улсын Их Хурлын гишүүн Батжаргал тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах 4, 5 дахь

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

заалтыг өөрчлөн найруулах санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ер нь ерөөл тавьчихлаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Жамбалын Ганбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Болдбаатарын Анхбаяр, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Чулууны Хишигдалай нар оролцож байна.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Гишүүд асуулт алга байна. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. Байнгын хорооноос гаргасан засгийн зөрөөтэй саналын томьёоллоор санал хураая.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна.

Тогтоолын төслийн 3 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын

гишүүн Х.Баделхан, С.Ганбаатар, Б.Пүрэвдорж.

Санал хураалт.

54.8 хувиар санал дэмжигдлээ.

Дээрх зарчмын зөрөөтэй санал дэмжигдсэнтэй холбогдуулан хураалгасан саналыг хураалгая.

Тогтоолын төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал.

Санал хураалт.

52.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

4.Энэ тогтоолыг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдсүгэй. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал.

Санал хураалт.

54.8 хувиар санал дэмжигдлээ.

4.Тогтоолын төслийн 5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

Энэ тогтоолыг 2023 оны 1 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн байна. Энэ 23 гэдэг чинь энэ тооцоолол чинь хэр зөв юм бэ? Нэлээн хэдэн үе шаттай шүү дээ? Тийм ээ.

Энэ угаасаа дэгийн хуулиар чинь тодорхой заалт байгаа шүү дээ. Учрал даргаа. Их Хурлын эцсийн найруулгыг сонссоноос хойш Их Хурлын дарга ажлын 3 өдрийн дотор зурж, гарын үсэг зурж ёсчилно гэж байгаа. Энэ бол 23 орчим хугацаа гэж бол үзэж болно. Тамгын газар ажлын 2 хоногийн дотор Монгол Улсын

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Ерөнхийлөгчид уг хуулийн төслийг Тамгын газарт илгээнэ гэж байгаа. Энэ бол 25 болно. Хамгийн наад талын хугацаа нь. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээн авснаас хойш ажлын тав хоногийн дотор багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хууль, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ ээ гэж байгаа. Энэ бол ажлын 5 хоног. Ингэхээр 30 болж байгаа юм. Хамгийн наад талын хугацаа 30, үгүй бол 2 сарын 20 байгаа. Тэгээд 30-аараа явчих уу? Тэгэхгүй бол 23 гэдэг чинь зөвхөн эндээс ёсчлох хугацаа чинь болчхоод байна шүү дээ тийм ээ. Болж байна уу? Энэ дээр хэн санал гаргах вэ? Эцсийн хэлэлцүүлэг дээр чиглэл өгье.

Эцсийн хэлэлцүүлэг дээр энийгээ оруулж ирээрэй. Эцсийн хэлэлцүүлэг дээр чиглэл өгчихье тийм ээ. Ингээд эцсийн хэлэлцүүлэг дээрээ та бүхэн Байнгын хороо энэ асуудлаа 30 болгоод ороод ирээрэй. Энэ дээр чинь бас санал авахгүй явж болно биз дээ тийм ээ. Тэгээд гүйцээн боловсруулах чиглэл өглөө.

Дараагийнхаа асуудалд орно.

Энэ тогтоолын төсөлтэй холбоотой асуудлыг Төсвийн байнгын хороо эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр шилжүүлээ.

Төсвийн байнгын хороо хуралдаад эцсийн хэлэлцүүлгээ хийж, нэгдсэн хуралдаанд танилцуулахыг чиглэл болгож байна.

Дараагийнхаа асуудалд орно. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооныхон хуралдаж дууссан бол асуудлаа оруулж ирье.

Гишүүд танхимдаа орёё.

Өнөөдөр хэлэлцэх асуудлын сүүлийн асуудлыг хэлэлцэж эхэлнэ.

Манай хурал зохион байгуулах хэлтсийнхэн гишүүдийг танхимдаа оруулаарай.

17.27 цаг

Хэлэлцэх асуудалдаа орёё.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Пүрэв-Очирын Анужин танилцуулна. Анужин гишүүнийг индэрт урьж байна.

Гишүүд танхимд ороорой.

П.Анужин: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийх үед УИХ-ын гишүүд хууль санаачлагчаас төслийн талаар асуулт асуугаагүй болно.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн бөгөөд дээрх төслүүдтэй холбогдуулан УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалан, Б.Бат-Амгалан, Д.Цогтбаатар нар хууль хоорондын уялдааг хангах, давхцал, хийдлийг арилгах, хэл найруулга, хууль зүй, техникийн засварыг тусгасан зарчмын зөрүүтэй саналуудыг тус тус гаргаж, санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Олон нийтийн сүлжээнд Хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Анужин гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг оруулъя. Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийн гишүүд ороорой.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Алга байна.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана.

Зарчмын зөрүүтэй саналын томъёолол бэлэн болж байгаа юу.

Гишүүд танхимдаа орё.

Санал хураалт явагдана.

Ажлын хэсгийн гишүүдээ танилцуулъя. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал, Цахим хөгжил, харилцаа холбооны дэд сайд Жаргалцэнгэлийн Эрхэмбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Сүхээгийн Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга Хаш-Эрдэнийн Сүрэнхорол, ХЭҮК-ын дарга Жаргалсайханы Хунан, ХЭҮК-ын гишүүн Ганбатын Нарантуяа нар оролцож байна.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Гишүүд танхимдаа орж ирье. Ирцээ бүрдүүлээрэй.

МАН-ын дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг, дэд дарга Жигжидийн Батжаргал нар ирцээ бүрдүүлье. АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл мөн ирцээ бүрдүүлье.

Санах хураалт явуулъя.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “хууль тогтоомжийн” гэсний өмнө “хүний эрхийг хангах асуудлаарх” гэж тус тус нэмэх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Э.Бат-Амгалан. Санал хураалт.

53.7 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын “залилсан” гэсний дараа “, залилахыг завдсан” гэж нэмэх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

56.1 хувиар санал дэмжигдлээ.

3. Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.5 дахь заалтын “хүнийг” гэсний өмнө “хүний нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон,” гэж нэмэх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан.

Үг байгаа юм уу. Учрал сайд үг хэлье.

Н.Учрал: Энэ 6.1.5, дээрээс нь 6.1.8 хоёр нөгөө хувь хүн буюу тодорхой бүлгийг үндэс угсаа, арьсны өнгө, нийгмийн гарал байдал буюу нөгөө салан тусгаарлахыг ухуулсан, ялгаварлан гадуурхсан, дайсагнуулах гээд нөгөө цахим гадуурхалтай холбоотой заалттай нэгтгээд энэ заналхийлэх, амиа хорлох энэ тэрийг нэгдсэн байдлаар зохицуулахгүй бол яг ийм нэг давхцал бас үүсээд байгаа учраас 6.1.5, 6.1.8 2-ыг нэгтгэн боловсруулаад гүйцээн боловсруулах чиглэл бас аваад нэгтгээд оруулаад ирье ээ гэсэн саналтай байна. Тэгээд Сандаг-Очир гишүүний саналыг хүндэтгэж байна. Тэгээд энэ 8 дээр нэгтгэхгүй бол ийм давхцалууд үүсээд байна.

Л.Мөнхбаатар: Учрал гишүүний саналаар 6.1.5, 6.1.8 дахь саналуудыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

4. Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах гэсэн байна.

“6.1.8.хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхсан;” гэсэн ийм саналыг Бат-Амгалан гишүүн гаргасан. Энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

5.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.8 дахь заалтыг хасаж, үүнтэй уялдуулан 7.1.2 дахь заалтын “бууруулах” гэсний дараа “, хэрэглэгчийн хаягийг баталгаажуулах” гэж нэмэх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

58.5 хувиар санал дэмжигдлээ.

6 Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.1.олон нийтийн сүлжээний зохисгүй хэрэглээ, зан үйл, хор аюул учруулж болзошгүй шалтгаан, нөхцөлийг судлах, түүнээс урьдчилан сэргийлэх арга барилд сургах чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах;

11.1.2.олон нийтийн сүлжээний зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр мэдээ, мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэх;” Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

56.1 хувиар санал дэмжигдлээ.

7. Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж

мөрдөнө.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

51.2 хувиар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “үзэл бодлоо” гэсний дараа “чөлөөтэй” гэж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “соён гэгээрүүлэхтэй” гэсний өмнө, 5.1.7 дахь заалтын “соён гэгээрүүлэх” гэсний өмнө “олон нийтийг” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “агуулсан хэрэглэгчийн” гэсний дараа “мэдээллийг гаргуулах” гэж, 7.1.3 дахь заалтын “шийдвэрлэсэн” гэсний өмнө “түүнийг хянан” гэж, 7.1.5 дахь заалтын “утасны” гэсний өмнө “харилцах” гэж, 10.2 дахь хэсгийн “харгалзан” гэсний дараа “хүсэлтийг” гэж тус тус нэмэх; Санал хураалт. 2 дугаар зүйлийг нь уншихъя. Хамтад нь санал хураачихъя.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “бусдын” гэснийг “хүний” гэж, “зөрчихгүй байх” гэснийг “хүндэтгэх” гэж, 5.1.6 дахь заалтын “байдал, нийгмийн хэв журмыг хангах” гэснийг “байдлыг хангах, нийтийн хэв журмыг хамгаалахад чиглэх” гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “түгээх зорилгоор” гэснийг “хүргэхээр” гэж, 6.1.7 дахь заалтын “хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг болон үндэсний” гэснийг “үндэсний болон хүн төрөлхтний” гэж, 6.1.10 дахь заалтын “хэрэг, зөрчлийн” гэснийг “хэрэг болон зөрчилд тооцогдох” гэж, 6.2.2 дахь заалтын “хувь хүн” гэснийг “хүн” гэж, 6.2.4 дэх заалтын “контентын үүсгэсэн” гэснийг “контентыг нийтэлсэн” гэж, 6.2.5 дахь заалтын “сонирхол,” гэснийг “сонирхолд болон” гэж, 7.1.2 дахь заалтын “хүсэлт шийдвэрийг” гэснийг “хүсэлтийг” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “зөрчилтэй контент нийтэлсэн” гэснийг “зөрчилтэй контентыг олон нийтийн сүлжээнд нийтэлсэн” гэж, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “хүнд” гэснийг “этгээдэд” гэж, 11.1 дэх хэсгийн “хохироох” гэснийг “үүсэх” гэж,

мөн хэсгийн “хүн, хуулийн этгээдийг” гэснийг “олон нийтийг” гэж, мөн хэсгийн “нөлөөллийн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ” гэснийг “арга хэмжээг авч хэрэгжүүлнэ” гэж тус тус өөрчлөх;

3.Төслийн 7.1.1 дэх заалт, 10.4 дэх хэсгийн “, тайлбар” гэснийг, 7.1.3 дахь заалтын “байдлын талаарх” гэснийг тус тус хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

Учрал гишүүн үг хэлье. Энд бас үг, үсгийн алдаа байна шүү. Үүнийгээ засаарай.

Н.Учрал: Энэ найруулгын саналын 6.1.7 дахь заалт дээр тэр хүн төрөлхтний аюулгүй байдлын эсрэг болон үндэсний болон хүн төрөлхтний гэсэн дээр яг агуулгын хувьд 6.1.1 дэх Монгол Улсын төрийн бэлгэ тэмдэг гэсэн энэ 6.1.1 дэх заалттай бас найруулгын хувьд бас зөрчилдөөд байгаа учраас яг энэ 6.1.7, 6.1.1 дэх заалт дээр бас гүйцээн боловсруулах чиглэл авъя.

Бусад заалтын хувьд найруулга нь дэмжигдэж байна. Зөвхөн 6.1.7 дахь заалтын тэр хэсэг, 6.1.1-тэй зөрчилдөж байгаа учраас үүнийг найруулгын хувьд бас эцсийн хэлэлцүүлэг дээр анхааръя гэсэн гүйцээн боловсруулах чиглэл өгөөч ээ. 6.1.1, 1.7

Л.Мөнхбаатар: Учрал гишүүний гаргасан саналаар хууль хоорондын уялдааг хангах зүйл заалтын уялдааг хангах зорилгоор 6.1.1, 6.1.7 дахь заалтыг гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна.

Хамт өргөн мэдүүлсэн хуулиуд дээр санал хураана.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж танилцуулъя.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дэмжсэн санал байна.

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Төслийн нэрийн “өөрчлөлт” гэснийг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

53.7 хувиар санал дэмжигдсэн байна.

Өмнө нь гаргасан найруулгын саналыг мөн санал хураах ёстой. Гүйцээн боловсруулах 2 чиглэл өгсөн. Томьёоллыг уншиж танилцуулсан найруулгын санал дээр санал хураалт явуулъя. Санал хураалт.

56.1 хувиар санал дэмжигдлээ.

Дагасан хуулиудын санал хураалтыг явуулъя.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 23.2 дахь хэсгийн “нийтийн төв” гэснийг “нийтийн төвийн саналыг үндэслэн” гэж өөрчлөх. Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

61 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3. Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл. Энэ хуулийг Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

58.5 хувиар санал дэмжигдлээ.

Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 21.2.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.2.8.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн 6.1.7-д заасан агуулга бүхий зөрчилтэй контентыг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор хуульд заасан зохих арга хэмжээ авах бөгөөд уг арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн Кибер аюулгүй байдлын зөвлөл тогтоох.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Дамдины Цогтбаатар. Санал хураалт.

58.5 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт буюу 22.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.2.5.Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн 6.1.7-д зааснаас бусад агуулга бүхий зөрчилтэй контентын талаарх хүсэлтийг хүлээн авч, хянан шийдвэрлэхдээ хуульд заасны дагуу зохих арга хэмжээ авах.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Дамдины Цогтбаатар. Санал хураалт.

Учрал гишүүнд үг өгье.

Н.Учрал: Энэ хууль дээр Монгол Улсад иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэлтэй байх эрх, иргэдэд үйлчилдэг, чөлөөт, хараат бус сэтгүүл зүйг бид ямар нэгэн байдлаар түүний эрхэнд огт халдаагүй. Тэгэхээр иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт хүний эрхийн холбогдолтой үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын бас явуулж байгаа саналуудыг бас хүндэтгэн үзэж байгаа учраас энэ 6 дугаар зүйл дээр бас холбогдох өөрчлөлтүүдийг бас хийж байгаа. Тийм учраас эцсийн хэлэлцүүлэг дээр энэ асуудлуудыг бас анхаарч үзнэ ээ. Мөн ХЭҮК бас ажлын хэсгийн холбогдох саналуудыг үндэслээд энэ холбогдох журмуудыг авахад хүний эрхийн

комиссын саналыг үндэслэнэ ээ гэдэг саналуудыг бас тодорхой түвшинд ажлын хэсэг ажиллаад оруулж ирсэн. Үүнтэй холбогдуулаад 22.2.8 дээр энэ журмын талаар ХЭҮК-ын саналыг үндэслээд Кибер аюулгүй байдлын зөвлөл тогтооно гэсний дагуу нийтийн төв ч гэсэн 6.1.7-д зааснаас бусад агуулга бүхий зөрчилтэй контентын талаар хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэхдээ хуульд заасны дагуу мөн зохих арга хэмжээ авна. Энэ зохих арга хэмжээ авах журмыг мөн Кибер аюулгүй байдлын зөвлөл тогтооно гэсэн 21.2.8-тай ижилсүүлж энэ 22.2.5 бол бас адилхан өөрчлөлт орох ёстой гэсэн ийм саналтай байна. Тэгэхээр бас энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя.

Л.Мөнхбаатар: Тэгэхээр Учрал гишүүн ийм үү. 22.8, 22.5 хоёр дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя гэж байгаа юм байна, тийм ээ. Төслийн 22.5 дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

3. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

51.2 хувийн саналаар санал дэмжигдсэн байна.

Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

1. Төслийн нэрийн “ӨӨРЧЛӨЛТ” гэснийг хасах. Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

58.5 хувиар санал дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

56.1 хувиар санал дэмжигдлээ.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Төслийн нэрийн “НЭМЭЛТ” гэснийг хасах. УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

58.5 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Энэ хуулийг Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан УИХ-ын гишүүн Бат-Амгалан. Санал хураалт.

58.5 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд шилжүүллээ.

Маргааш өглөө Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдана. Төсвийн байнгын хороо мөн адил 9 цагаас хуралдана гэдгийг гишүүдэд хэлье.

Мөн 10 цагаас нэгдсэн чуулганаар хуулийн төслүүдийг эцэслэн батлах санал хураалт явуулна.

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 19-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

Ийм учраас гишүүд цагтаа ирж санал хураалтдаа оролцоорой гэдгийг хэлье.

Ингээд өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн чуулганыг өндөрлөснийг мэдэгдье.

18.27 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ